^A Насны бүлэг дэх үр хөндөлтийн коэффициент (НБҮХК)-ыг тодорхой насны бүлгийн эмэгтэйчүүдийн нийт үр хөндүүлсэн тоог тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж тооцдог бөгөөд 1000 эмэгтэйд ногдох үзүүлэлтээр илэрхийлдэг. Үр хөндөлтийн нийлбэр коэффициент (ҮХНК)-ыг 15-49 насны эмэгтэйчүүдийн хувьд НБҮХК-ийг 5 насаар тооцсоны нийлбэрээр тодорхойлдог. Хэрэв одоогийн үр хөндөлтийн түвшин хэвээр хадгалагдана гэж үзвэл ҮХНК нь нэг эмэгтэй амьдралынхаа турш (нөхөн үржихүйн насаа дуустал буюу 50 хүртэл насандаа) үр хөндүүлэх дундаж

ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ

НҮТС-ны үзүүлэлт	Үзүүлэлт	Тайлбар	Утга
6.4	Аливааг танин мэдэхэд эхийн зүгээс үзүүлсэн дэмжлэг	Судалгаанаас өмнөх 3 хоногийн хугацаанд төрсөн ээж нь 4 ба түүнээс олон төрлөөр аливааг сурах, танин мэдэх болон сургуульд бэлтгэхэд нь цаг гаргасан 36-59 сартай хүүхдийн хувь	30.9
6.5	3 ба түүнээс олон хүүхдийн номтой хүүхэд	3 ба түүнээс олон хүүхдийн номтой 5 хүртэлх насны хүүхдийн хувь	32.8
6.6	2 ба түүнээс олон төрлийн тоглоомтой хүүхэд	2 ба түүнээс олон төрлийн тоглоомтой 5 хүртэлх насны хүүхдийн хувь	55.8
6.7	Насанд хүрэгчдийн хараа хяналтгүй үлдсэн хүүхэд	Судалгаанаас өмнөх 7 хоногийн хугацаанд 1 цагаас илүү хугацаагаар ганцааранг нь эсвэл 10 хүртэлх насны хүүхдээр харуулж үлдээсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь	10.0
6.8	Бага насны хүүхдийн хөгжлийн индекс	Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар, бие бялдрын хөгжил, нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх болон сурах чадвараас 3 нь зохих хэмжээнд байгаа 36-59 сартай хүүхдийн хувь	76.0
CS8.1	Бага насны хүүхдийн хөгжлийн индекс (өөрийн улс орны онцлогт суурилж тооцсон)	Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар, бие бялдрын хөгжил, нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх болон сурах чадвараас 3 нь зохих хэмжээнд байгаа 36-59 сартай хүүхдийн хувь (өөрийн улс орны онцлогт суурилж тооцсон)	93.1

БИЧИГ ҮСЭГ ТАЙЛАГДАЛТ БА БОЛОВСРОЛ

НҮТС-ны үзүүлэлт	Үзүүлэлт	Тайлбар	Утга
7.1	МХЗ 2.3 Залуучуудын бичиг үсгийн мэдлэг	Өдөр тутмын амьдралын тухай энгийн богино хэмжээний өгүүлбэрийг унших чадвартай эсвэл дунд болон түүнээс дээш боловсролтой 15-24 насны залуучуудын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	97.5 95.2
7.2	Сургуульд бэлтгэгдсэн байдал	Судалгаа явагдах үед 1-р ангид суралцаж байсан бөгөөд өмнөх хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байсан хүүхдийн хувь	78.8
7.3	1-р ангид элсэлтийн түвшин	Судалгаа явагдах хичээлийн жилд 1-р ангид элсэн орсон сургуульд орох насны (6 нас) хүүхдийн хувь	94.5
7.4	МХЗ 2.1 Бага ангийн хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)	Бага болон дунд ангид хамрагдаж байгаа бага ангид сурах насны хүүхдийн хувь	98.1
7.5	Дунд ангийн хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)	Дунд болон ахлах ангид хамрагдаж байгаа дунд ангид сурах насны хүүхдийн хувь	91.4
CS5.2	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)	Суурь (бага болон дунд анги) болон түүнээс дээш боловсролд хамрагдаж байгаа суурь боловсрол эзэмших насны хүүхдийн хувь	98.1
7.6	МХЗ 2.2 1-р ангид элсээд 5-р анги хүртлээ тасралтгүй анги дэвшин суралцсан хүүхэд	1-р ангид элсээд 5-р анги хүртлээ тасралтгүй анги дэвшин суралцаж байгаа хүүхдийн хувь	98.1
7.7	Бага боловсрол эзэмшилтийн хувь	Судалгааны үед бага боловсролын төгсөх буюу 5-р ангид сурч байсан (улиран суралцагчдыг оруулаагүй) хүүхдийн тоог 5-р ангид сурах нас (бага боловсролын төгсөх ангид байвал зохих нас)-ны хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа	109.7

7.8		Дунд ангид дэвшин суралцсан хүүхэд	Судалгааны үед дунд ангийн эхний буюу 6-р ангид суралцаж байсан бөгөөд өмнөх хичээлийн жилд 5-р ангид (бага боловсролын төгсөх анги) суралцсан хүүхдийн тоог өмнөх хичээлийн жилд 5-р ангид суралцсан нийт хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа	98.4
7.9	МХЗ 3.1	Хүйсийн тэгш байдлын индекс (бага анги)	Охидын бага ангид хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)-г хөвгүүдийн бага ангид хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)-д харьцуулсан харьцаа	1.01
7.10	МХЗ 3.1	Хүйсийн тэгш байдлын индекс (дунд анги)	Охидын дунд ангид хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)-г хөвгүүдийн дунд ангид хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)-д харьцуулсан харьцаа	1.06

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

Төрсний бүртгэл			
НҮТС-ны үзүүлэлт	Үзүүлэлт	Тайлбар	Утга
8.1	Төрсний бүртгэл	Төрсний гэрчилгээтэй 5 хүртэлх насны хүүхдийн хувь	99.3
Хүүхдийн хөдөлмөр			
8.2	Хүүхдийн хөдөлмөр	Хөдөлмөр эрхэлдэг 5-17 насны хүүхдийн хувь	17.3
Хүүхдийн хүмүүжил			
8.3	Сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэл хүлээсэн хүүхэд	Судалгаанаас өмнөх 1 сарын хугацаанд сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэл хүлээсэн 1-14 насны хүүхдийн хувь	49.3
Эрт гэрлэлт			
8.4	15 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн хүн ам	15 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай болсон 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	0.4 0.2
8.5	18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн хүн ам	18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай болсон 20-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	6.2 2.4
8.6	Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай 15-19 насны залуучууд	Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай 15-19 насны залуучуудын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	5.3 1.2
8.8a	Насны зөрүүтэй хосууд	10 ба түүнээс олон насаар ах нөхөр эсвэл хамтран амьдрагчтай залуу эмэгтэйчүүдийн хувь	3.4
8.8b		(a) 15-19 нас (b) 20-24 нас	3.0
Хүүхдийн амьдарч буй орчин			
8.13	Төрсөн эцэг, эхийнхээ хэн нэгэнтэй эсвэл хоёулангтай нь хамт амьдардаггүй хүүхэд	Төрсөн эцэг, эхийнхээ хэн нэгэнтэй эсвэл хоёулангтай нь хамт амьдардаггүй 0-17 насны хүүхдийн хувь	6.4
8.14	Өнчин, хагас өнчин хүүхэд	0-17 насны хагас эсвэл бүтэн өнчин хүүхдийн хувь	6.7
8.15	Эцэг, эх нь гадаадад амьдардаг хүүхэд	Төрсөн эцэг, эхийнх нь хэн нэг нь эсвэл хоёулаа гадаадад амьдардаг 0-17 насны хүүхдийн хувь	1.5

ХДХВ/ ДОХ, бэлгийн зан үйл

ХДХВ/ ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага			
НҮТС-ны үзүүлэлт	Үзүүлэлт	Тайлбар	Утга

-	ДОХ-ын талаар сонссон байдал	ДОХ-ын талаар сонсож байсан 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	91.6 91.2
9.1	MDG 6.3 ХДХВ-ийн халдвараас сэргийлэх талаарх залуучуудын мэдлэг	ХДХВ-ийн халдвар бэлгийн замаар дамжихаас сэргийлэх аргыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн 15-24 насны залуучуудын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	22.8 20.7
9.2	ХДХВ-ийн халдвар эхээс ураг эсвэл нярайд дамжих боломжтой гэдгийг мэддэг	ХДХВ-ийн халдвар эхээс ураг эсвэл нярайд дамжих 3 замыг зөв тодорхойлсон 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	33.5 21.0
9.3	ХДХВ-ийн халдвартай хүнд хандах эерэг хандлага	ХДХВ-ийн халдвартай хүнд хандах хандлагын 4 асуултад бүгдэд нь зөвшөөрсөн хариулт өгсөн 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	2.5 4.8
ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ			
9.4	ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгөх газрын талаарх мэдлэг	ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгөх газрыг мэддэг 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	75.8 64.3
9.5	ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	24.7 15.3
9.6	Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн харьцаанд орсон бөгөөд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан залуучууд	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон бөгөөд энэ хугацаанд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгч, хариугаа авсан 15-24 насны залуучуудын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	36.0 18.0
9.7	Жирэмсний хяналтын хүрээнд ХДХВ-ийн халдварын талаар зөвлөгөө авсан	Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн (энэ хугацааны хамгийн сүүлийн хүүхэд) бөгөөд жирэмсний хяналтад хамрагдахдаа ХДХВ-ийн халдварын талаар зөвлөгөө авсан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь	32.1
9.8	Жирэмсний хяналтын хүрээнд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгсөн	Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн (энэ хугацааны хамгийн сүүлийн хүүхэд) бөгөөд жирэмсний хяналтад хамрагдахдаа ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний талаар зөвлөгөө авсан бөгөөд шинжилгээ өгч, хариугаа авсан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь	68.6
Бэлгийн зан үйл			
9.9	Бэлгийн хавьталд орж байгаагүй залуучууд	Огт гэрлээгүй бөгөөд бэлгийн хавьталд орж байгаагүй 15-24 насны залуучуудын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	70.3 43.0

9.10	15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон залуучууд	15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон 15-24 насны залуучуудын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	0.6 4.2
9.11	Насны хэт зөрүүтэй хүнтэй бэлгийн хавьталд орсон эмэгтэйчүүд	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд 10 ба түүнээс олон насаар ах хүнтэй бэлгийн хавьталд орсон 15-24 насны залуу эмэгтэйчүүдийн хувь	2.9
9.12	Бэлгийн олон хавьтагчтай хүн ам	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орсон 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	1.5 10.0
9.13	Олон хүнтэй бэлгийн хавьталд орсон бөгөөд хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн хүн ам	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орсон бөгөөд хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	30.8 44.7
9.14	Тохиолдлын бэлгийн хавьтал	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд тохиолдлын бэлгийн хавьталд (эхнэр/ нөхөр эсвэл хамтрагчаасаа өөр хүнтэй) орсон 15-24 насны залуучуудын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	19.0 45.2
9.15	Тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд тохиолдлын бэлгийн хавьталд (эхнэр/ нөхөр эсвэл хамтрагчаасаа өөр хүнтэй) орсон бөгөөд хамгийн сүүлд тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн 15-24 насны залуучуудын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	46.1 69.0
	МХЗ 6.2		
CS17.1	БЗДХ-ын талаар сонсож байсан хүн ам	БЗДХ-ын талаар сонсож байсан 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	77.9 75.6
CS17.2	БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн хүн ам	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	11.4 2.8
CS17.3	БЗДХ-ын шинжилгээ өгсөн хүн ам	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд БЗДХ-ын шинжилгээ өгсөн 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	45.1 33.9
CS17.4	БЗДХ-ын эмчилгээ хийлгэсэн хүн ам	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд БЗДХ-ын шинжилгээ өгсөн бөгөөд эмчилгээ хийлгэсэн 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	2.4 1.0

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦААНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ

НҮТС-ны үзүүлэлт	Үзүүлэлт	Тайлбар	Утга
10.1	Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ	Долоо хоногт наад зах нь 1 удаа сонин, сэтгүүл уншиж, радио, ФМ сонсож, телевиз үздэг 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	9.5 13.1

Мэдээлэл, харилцааны технологийн хэрэглээ			
10.2	Компьютерийн хэрэглээ	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд компьютер хэрэглэсэн 15-24 насны залуучуудын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	80.1 79.0
10.3	Интернэтийн хэрэглээ	Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд интернэт хэрэглэсэн 15-24 насны залуучуудын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	74.2 71.6

ТАМХИ, АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ			
Тамхины хэрэглээ			
НҮТС-ны үзүүлэлт	Үзүүлэлт	Тайлбар	Утга
12.1	Тамхины хэрэглээ	Судалгаанаас өмнөх 1 сарын хугацаанд янжуур, бусад төрлийн утаатай болон утаагүй тамхи татсан 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	7.8 56.1
12.2	15 нас хүрэхээсээ өмнө тамхи татаж үзсэн хүн ам	15 нас хүрэхээсээ өмнө ширхэг янжуурыг бүтнээр нь татаж үзсэн 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	0.8 17.2
Архи, согтууруулах ундааны хэрэглээ			
12.3	Архи, согтууруулах ундааны хэрэглээ	Судалгаанаас өмнөх 1 сарын хугацаанд архи, согтууруулах ундаа уусан 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	29.5 52.1
12.4	15 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа ууж үзсэн хүн ам	15 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа ууж үзсэн 15-49 насны хүн амын хувь (a) Эмэгтэй (b) Эрэгтэй	0.8 3.6

Монгол Улсын “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2013” судалгаа нь өрх, 15-49 насны эмэгтэйчүүд, 15-54 насны эрэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдийн үндэсний төлөөлөл бүхий түүвэр судалгаа юм. “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2013” судалгааг Үндэсний статистикийн хороо Монгол Улсын Засгийн Газар, НҮБХС, НҮБХАС-ийн санхүү, техникийн тусламжтайгаар зохион байгуулж явууллаа. Судалгааны үр дүн нь мэдээлэл цуглуулсан хугацаа болох 2013 оны 9-12 сард хамаарах бөгөөд нэгдсэн үр дүнг танилцуулъя.

Ус, ариун цэврийн байгууламж

- Монгол Улсын нийт хүн амын 68.1 хувь нь ундны усны сайжруулсан эх үүсвэр ашиглаж байна. Ундны усны сайжруулсан эх үүсвэрийн хэрэглээ хөдөөд (58.7 хувь) хотынхоос (73.5 хувь) доогуур түвшинд байна.
- Хангайн бүсийн хувьд бусад бүстэй харьцуулахад хамгийн доогуур түвшинд буюу хүн амын тал буюу 52.2 хувь нь ундны усны сайжруулсан эх үүсвэр ашиглаж байна.
- Монгол Улсын нийт хүн амын 58.3 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагджээ. Хотын хүн амын 69.1 хувь, хөдөөгийн хүн амын 39.4 хувь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж байна.

Бичиг үсэг тайлагдалт ба боловсрол

- Судалгааны үед 1-р ангид сурч байсан хүүхдүүдийн 78.8 хувь өмнөх хичээлийн жилд цэцэрлэг эсвэл хувилбарт сургалтад хамрагдаж, сургуульд бэлтгэгджээ.
- Сургуульд бэлтгэгдсэн байдал охид, хөвгүүдийн хувьд төдийлөн ялгаагүй боловч хот, хөдөө, бүс болон өрхийн аж байдлаар ялгаатай юм.
- Бага боловсролын хамран сургалт 98.1 хувь бөгөөд охид, хөвгүүдийн хувьд бараг ялгаагүй байна.
- Бүрэн дунд боловсролд хамран сургалт буюу 11-17 насны хүүхдүүдийн 91.4 хувь нь зохих шатны сургуульд суралцав.
- Бага сургуулийн 1-р ангид элсэн орсон хүүхдүүдийн 98.1 хувь нь 5-р анги хүртэл тасралтгүй анги дэвшин суралцсан бөгөөд хотод 98.6 хувь, хөдөөд 97.6 хувь байна.
- 15-24 насны эмэгтэйчүүдийн 97.5 хувь, эрэгтэйчүүдийн 95.2 хувь бичиг үсэг тайлагджээ.

Хүүхдийн эрүүл мэнд

- 12-23 сартай хүүхдүүдийн 93.0 хувь нь бүх вакцинд хамрагдсанаас 78.1 хувь нь 1 нас хүрэхээсээ өмнө, 24-35 сартай хүүхдүүдийн 91.8 хувь нь бүх вакцинд хамрагдсаны 67.5 хувь нь 1 нас хүрэхээсээ өмнө хамрагджээ.
- Судалгааны өмнөх 14 хоногийн хугацаанд тав хүртэлх насны хүүхдийн 8.2 хувь суулгасан бөгөөд хөдөөд илүү өндөр, бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн бага, Хангайн бүсэд хамгийн өндөр байна. Суулгалтаар өвдсөн хүүхдүүдийн 41.8 хувь үйлдвэрийн аргаар бэлтгэсэн шингэн сэлбэх давсны уусмал, 13.3 хувь гэрийн нөхцөлд бэлтгэсэн шингэн сэлбэх уусмал, 9.2 хувь цайрын бэлдмэл уужээ.
- 5 хүртэлх насны хүүхдийн 4.1 хувьд судалгааны өмнөх 2 долоо хоногийн хугацаанд амьсгалын замын цочмог халдвар (АЗЦХ) илэрсэн бол 11.4 хувьд халуурах шинж тэмдэг илэрчээ. Хүн амын төвлөрөл ихтэй газар өөрөөр хэлбэл, Улаанбаатарын хүүхдүүдийн дунд АЗЦХ-ын шинж ихээр тохиолдсон байна. Эдгээр хүүхдүүдийн 74.0 хувь нь зохих эмнэлэгт хандан, эмнэлгийн мэргэжилтний зөвлөгөө, тусламж авч, 63.4 хувь нь антибиотик эмчилгээ хийлгэжээ.
- Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 55.5 хувь хоол, ундаа болгохдоо хатуу түлш хэрэглэж байна. Хотын өрхүүдийн 36.6 хувь хатуу түлш хэрэглэж байхад хөдөөд хатуу түлшний хэрэглээ маш өндөр буюу 88.3 хувь байна.

Бага жинтэй төрөлт

- Улсын хэмжээнд судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд төрсөн нийт хүүхдийн 99.3 хувийг төрөх үед нь жинлэсэн бөгөөд тэдний 5.2 хувь нь 2500 граммаас бага жинтэй төржээ.

Хоол тэжээлийн байдал

- Монгол Улсын 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн байдал сайжирч байна. Тодруулбал, 5 хүртэлх насны хүүхдийн 1.6 хувь тураалтай, 10.8 хувь өсөлт хоцролттой, 1.0 хувь туранхай, 10.5 хувь илүүдэл жинтэй байв.
- Өсөлт хоцролттой хүүхдийн хувь нийгэм, эдийн засгийн шинж байдлаар нэлээд ялгаатай байлаа. Тухайлбал, Баруун, Зүүн болон Хангайн бүсийн хүүхдүүд өсөлт хоцролтод өртөх магадлал хамгийн өндөр байна. Түүнчлэн, хөдөөд өсөлт хоцролттой (14.5 хувь) хүүхдийн эзлэх хувь хотынхоос бараг 2 дахин (8.4 хувь) их юм.

Эхийн сүүгээр хооллолт

- Хүүхдийг 6 сар хүртэл дан эхийн сүүгээр хооллохыг зөвлөдөг боловч уг үзүүлэлт буурах хандлагатай бөгөөд энэ удаагийн судалгаагаар 6 хүртэл сартай нийт хүүхдийн ердөө тал хувь (47.1 хувь) нь эхийн сүүгээр дагнан хооллож байна.
- Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 10 эмэгтэй тутмын 7 нь төрсний дараах 1 цагийн дотор хүүхэддээ ангир уургаа амлуулжээ.
- 12-15 сартай хүүхдийн 82.5 хувь, 20-23 сартай хүүхдийн 52.9 хувь нь эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байна. Тус үзүүлэлт өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай бөгөөд 1 болон 2 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллох нь дээгүүр аж байдалтай өрхөд хамгийн бага бол дундаж аж байдалтай өрхөд хамгийн өндөр байна.
- Эхийн сүүгээр хооллодог 6-23 сартай 10 хүүхэд тутмын 5 (47.7 хувь) нь нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулж, 7 (69.2 хувь) нь нэмэгдэл хоол, хүнсийг өдөрт идвэл зохих хамгийн бага давтамжаар, 4 (37.6 хувь) нь зохистой байдлаар хооллож байна. Харин эхийн сүүгээр хооллодоггүй 6-23 сартай хүүхдийн 56.3 хувь өдөрт наад зах нь 2 удаа сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэжээ.

Бага насны хүүхдэд үзүүлж буй анхаарал, халамж

- Судалгааны өмнөх 3 хоногийн хугацаанд 3-4 насны 10 хүүхэд тутмын зургаад нь өрхийн насанд хүрсэн гишүүд аливаа зүйлийг танин мэдэх, сурахад нь 4 ба түүнээс олон удаа дэмжлэг үзүүлжээ. Гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдэд анхаарал тавьж, дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааны дундаж тоо 3.6 байгаа нь 2010 оны судалгаатай харьцуулахад өөрчлөлтгүй байна. Энэ тоо эцгийн хувьд 1.1 байхад эхийнх 2.3 байгаа нь эцгийн оролцоо харьцангуй бага байгааг илэрхийлж байна.
- Улсын хэмжээнд 5 хүртэлх насны 10 хүүхэд тутмын 3 нь гэртээ 3 ба түүнээс олон, харин 1 нь 10 ба түүнээс олон хүүхдийн номтой байна. Уг үзүүлэлт хот, хөдөө, бүс нутаг болон өрхийн аж байдлаар ялгаатай байв. Хотын хүүхдүүдийн 40.2 хувь, хөдөөгийн хүүхдүүдийн 21.3 хувь гурав ба түүнээс олон хүүхдийн номтой байгаа нь хөдөөгийн хүүхдүүд ном унших, уншуулах боломж хотын хүүхдүүдээс бага байгааг илэрхийлж байна.
- Судалгааны өмнөх 7 хоногт 0-59 сартай хүүхдийн 8.1 хувийг гэрт нь 10 нас хүрээгүй хүүхдийн асрамжид, 4.1 хувийг ганцааранг нь үлдээжээ. Эдгээр үзүүлэлтийг нэгтгэн тооцвол 5 хүртэлх насны хүүхдийн 10.0 хувь гэртээ насанд хүрэгчдийн хараа хяналтгүй үлджээ.

Бага насны хүүхдийн хөгжил

- Монгол Улсын 3-4 насны хүүхдийн хөгжлийн индексийг анх удаа олон улсын аргачлалын дагуу ХХС-2010-аар тооцсон бөгөөд 85.1 хувь байсан бол энэ удаагийн судалгааны мэдээллээр 76.0 хувь болж буурчээ.
- Үүнийг нарийвчлан авч үзвэл бие бялдрын хөгжил болон сурах чадвар нь зохих түвшинд байгаа хүүхдийн хувь хамгийн өндөр (99.0 ба 97.8 хувь), нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар нь зохих түвшинд байгаа хүүхдийн хувь 75.7, харин унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар нь зохих хэмжээнд байгаа хүүхдийн хувь хамгийн бага буюу ердөө 9.3 байна. Унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадварыг харуулсан үзүүлэлт бусдаасаа хамгийн бага байгаа нь Монгол Улсад мөрдөгдөж буй “Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт”-д тоо цифр таних чадвар эзэмшүүлэх тухай агуулга байдаг хэдий ч цагаан толгойн үсэг таних, энгийн үг унших байхгүйтэй холбоотой юм.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт ба сургуульд бэлтгэгдсэн байдал

- 3-4 насны хүүхдийн 68.2 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна. Сургуулийн өмнөх боловсролд хамран сургалт хот, хөдөө болон бүсээр нэлээд ялгаатай бөгөөд хөдөөгийн (57.3 хувь), Баруун бүсийн (57.3 хувь) 3-4 насны хүүхдүүдийн хувьд хамгийн бага байв. Түүнчлэн, өрхийн аж байдлын түвшин болон эхийн боловсролын түвшин дээшлэх тусам бага насны хүүхэддээ боловсрол олгоход илүү их анхаарал тавьдаг нь ажиглагдлаа.

Төрсний бүртгэл

- 5 хүртэлх насны нийт хүүхдийн 99.3 хувийнх нь төрснийг бүртгүүлжээ. Энэ нь манай улсад хүүхдийг төрсний бүртгэлд хамруулах замаар нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд бүрэн хамруулж, эрхийг нь хангах боломж бүрдсэнийг харуулж байна.

Хүүхдийн хөдөлмөр

- НҮБ-ын Хүүхдийн сангийн шинэчилсэн тодорхойлолтоор 5-17 насны хүүхдийн 17.3 хувь хөдөлмөр эрхэлж байна. Мөн насны нийт хүүхдийн 7.6 хувь аюултай нөхцөлд хөдөлмөр эрхэлдэг ажээ.
- Эрэгтэй (19.3 хувь), 12-14 насны (22.1 хувь) хүүхдүүд хүүхдийн хөдөлмөрт олноороо оролцох хандлагатай юм. Бүсээр авч үзвэл Баруун бүсийн 10 хүүхэд тутмын гурав (31.0 хувь) нь хөдөлмөр эрхэлж байхад Улаанбаатар хотын 10 хүүхэд тутмын нэг (7.2 хувь) нь хөдөлмөр эрхэлжээ. Хөдөөгийн 5-17 насны хүүхдийн 30.3 хувь нь хөдөлмөр эрхэлж байгааг хотын хүүхдүүдтэй (8.9 хувь) харьцуулахад 3.4 дахин их юм.

Хүүхдийн хүмүүжил

- Судалгааны өмнөх 1 сарын хугацаанд 1-14 насны хүүхдийн 38.0 хувь хүчирхийллийн бус, харин 49.3 хувь сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэлийн аль нэг хэлбэрээр шийтгүүлжээ.
- 1-14 насны хүүхэдтэй өрхийн насанд хүрэгчдийн 17.4 хувь хүүхэд хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэл хэрэглэж болно гэж үзжээ. Эцэг, эх/ асран хамгаалагчдын дийлэнх нь хүүхдийг бие махбодиор нь шийтгэж хүмүүжүүлэх шаардлагагүй гэж үздэг хэдий ч судалгаанд хамрагдсан гурван хүүхэд тутмын нэг (27.8 хувь) нь бие махбодийн шийтгэл амсчээ.

Хүүхдийн эндэгдэл

- Сүүлийн 15 жилийн хугацаанд хүүхдийн эндэгдлийн түвшин буурчээ. Улсын хэмжээнд судалгааны өмнөх 5 жилийн хугацаанд 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 13.8, нялхсын эндэгдэл 21.0, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 24.5 байв.
- Хүүхдийн эндэгдэл хөдөөд өндөр хэвээр бөгөөд нийслэлээс хөдөө рүү алслагдах тусам хүүхэд эндэх магадлал нэмэгдэж байна. Хүн ам зүйн зарим шинж байдлаар авч үзвэл 35-49 насандаа төрсөн эхчүүдийн, 4-6 дахь төрөлтийн, өмнөх төрөлтөөс хоёроос бага жилийн хугацаанд төрсөн хүүхдүүдийн эндэх магадлал бусадтай нь харьцуулахад өндөр юм.

Гэрлэлт, бэлгийн идэвх

- Судалгаанд хамрагдагчдын гэрлэлтийн байдлыг авч үзвэл 15-49 насны эмэгтэйчүүдийн 56.9 хувь, эрэгтэйчүүдийн 55.3 хувь гэрлэжээ.
- Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс эрт гэрлэж байна. Өөрөөр хэлбэл, анхны гэрлэлтийн голч нас эмэгтэйчүүдийн хувьд 22.0 бол эрэгтэйчүүдийн хувьд 23.7 байна.
- Эрт гэрлэлт буюу 15 насандаа гэрлэсэн хувь эмэгтэйчүүдэд 0.4, эрэгтэйчүүдэд 0.3 байгаа бол 18 насандаа гэрлэсэн хувь эмэгтэйчүүдэд 6.3, эрэгтэйчүүдэд 2.3 гарчээ.
- Мөн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс эрт бэлгийн хавьталд орох хандлагатай байна. 15-49 насны эмэгтэйчүүдийн анх бэлгийн хавьталд орсон нас 20 бол эрэгтэйчүүдийн хувьд ойролцоогоор 19 байна.

Төрөлт, түүнд нөлөөлөгч хүн ам зүйн хүчин зүйлс

- Нэг эмэгтэйн нөхөн үржихүйн насандаа (15-49 нас) төрүүлэх хүүхдийн дундаж тоо буюу төрөлтийн нийлбэр коэффициент 3.1 байна.
- 25-49 насны эмэгтэйчүүдийн анхны төрөлтийн голч нас 22.1 байна. Цаг хугацааны явцад анхны төрөлтийн голч нас бага багаар хойшилсоор байна. Тодруулбал, 45-49 насныхан 21.9 насандаа анхны хүүхдээ төрүүлж байсан бол 25-29 насны эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт 22.4 нас болжээ.
- Өмнөх хүүхдээс дараагийн хүүхдээ төрүүлэх хүртэлх голч хугацаа буюу төрөлт хоорондын зайг НҮЭМС-1998 судалгаанаас хойш дахин тооцлоо. Тус үзүүлэлт 1998 онд 34.6 сар байсан бол 2013 онд 50.7 сар болж нэмэгджээ.
- 30-49 насны эмэгтэйчүүдийн 9.1 хувь нь цэвэршжээ. Тус үзүүлэлт НҮЭМС-2008 судалгаагаар 7.4 хувь байсан юм.

Төрөлтийн төсөөлөл

- Гэрлэсэн буюу нөхөр/ хамтран амьдрагчтай 15-49 насны эмэгтэйчүүдийн 43.0 хувь ирээдүйд хүүхэд төрүүлэхээр төлөвлөж байгаагийн 13.8 хувь ойрын 2 жилийн дотор, 27.8 хувь 2 ба түүнээс дээш жилийн дараа, үлдсэн 1.4 хувь хэзээ төрүүлэхээ шийдээгүй байна.
- Гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн 51.0 хувь хүүхэд төрүүлэх хүсэлгүй байна. Хөдөөгийн эмэгтэйчүүд хотынхтой харьцуулахад хүүхэд төрүүлэхгүй гэж илүү ихээр хариулжээ. Ялангуяа, хүүхэдгүй хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд энэ хандлага хотынхоос их байна.
- Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн болон судалгааны үед жирэмсэн байсан 15-49 насны эмэгтэйчүүдийн 80.9 хувь нь жирэмслэлтээ төлөвлөсөн байжээ. Харин 12.5 хувь нь арай хожуу жирэмслэх бодолтой байсан бол үлдсэн 6.6 хувь нь огт төлөвлөөгүй байв.

Гэр бүл төлөвлөлт

- Гэрлэсэн эмэгтэйчүүдийн дийлэнх нь (99.6 хувь) жирэмслэхээс сэргийлэх ямар нэгэн арга, хэрэгслийн талаар мэдлэгтэй байна. Ялангуяа, тэд ерөндөг (97.1), эрэгтэй бэлгэвч (95.3 хувь), эм (96.5 хувь) болон тарианы (93.7 хувь) талаар бусад аргуудаас илүү мэдэж байв.
- Гэрлэсэн эмэгтэйчүүдийн 54.6 хувь нь мэдээлэл цуглуулах үед жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байв. Хамгийн түгээмэл хэрэглэдэг арга нь ерөндөг (23.5 хувь) бол дараа нь эм, эрэгтэй бэлгэвч, түр тэвчих (нийтдээ 22.9 хувь), тариа, умайн 2 талын гуурсан хоолойг боох (6.9 хувь) арга, хэрэгслүүд орж байна. Түүнчлэн, жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга, хэрэгслийн хэрэглээ эдгээр эмэгтэйн дунд 48.2 хувь, уламжлалт аргын хэрэглээ 6.4 хувь байна.
- ЖСАХ-ийн хэрэглээг бүс нутгаар авч үзвэл Хангайн бүсэд хамгийн өндөр (60.0 хувь), Төвийн бүсэд (51.0 хувь) бусад бүстэй харьцуулахад хамгийн доогуур, байршлын хувьд хөдөөгийн эмэгтэйчүүдийн хэрэглээ хотынхоос өндөр байна. Насны бүлгээр авч үзвэл өсвөр насны охидын ЖСАХ-ийн хэрэглээ хамгийн бага (29.1 хувь), 35-39 насны эмэгтэйчүүдийнх хамгийн өндөр (64.9 хувь) юм. Мөн эмэгтэйчүүд 2-3 хүүхэдтэй болсны дараа ЖСАХ-ийг түлхүү хэрэглэдэг ажээ.
- Судалгаанд хамрагдсан гэрлэсэн эмэгтэйчүүдийн 16.0 хувийнх нь ЖСАХ-ийн хэрэгцээ хангагдаагүй бөгөөд тэдний ихэнх нь дахин хүүхэд төрүүлэхгүй (9.3 хувь) гэжээ. Харин гэрлэсэн эмэгтэйчүүдийн 54.6 хувийнх нь ЖСАХ-ийн хэрэгцээ хангагдсан ба 25.1 хувь нь төрөлт хоорондын зайгаа зохицуулах, 29.5 хувь нь жирэмслэлтээ зогсоох зорилгоор ЖСАХ хэрэглэж байна.
- 15-49 насны эмэгтэйчүүдийн 52.2 хувь, мөн насны эрэгтэйчүүдийн 45.4 хувь судалгааны өмнөх 1 сарын хугацаанд гэр бүл төлөвлөлтийн (ГБТ) талаар мэдээлэл авчээ. Энэхүү мэдээллийг ихэвчлэн телевизээс (эрэгтэйчүүдийн 34.8 хувь, эмэгтэйчүүдийн 39.9 хувь) авч байгаа бол үүний дараа хэвлэмэл сонин, сэтгүүл, ном орж байна.

Жирэмсний төгсгөл, үр хөндөлт

- Улсын хэмжээнд 15-49 насны эмэгтэйчүүдийн 23.3 хувь судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд жирэмсэлжээ. Нийт жирэмсний 74.8 хувь амьд төрөлтөөр, 14.0 хувь үр хөндөлтөөр, 0.9 хувь амьгүй төрөлтөөр, 10.4 хувь зулбалтаар төгсчээ.
- 1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлт 189.1 бөгөөд хотод хөдөөтэй харьцуулбал бараг 2 дахин их байна.
- Жирэмсэнг зориудаар таслан зогсоох буюу үр хөндөлтөөр төгссөн жирэмсэн хотын эмэгтэйчүүдэд (16.3 хувь) хөдөөгийн эмэгтэйчүүдээс (9.5 хувь) бараг 2 дахин илүү байна. Эмэгтэйчүүдийн нас ахих, боловсролын түвшин нэмэгдэх, өрхийн аж байдлын түвшин сайжрахад үр хөндүүлэх нь өсөх хандлагатай юм.
- Нийт үр хөндөлтийн 97.3 хувь нь эмнэлэгт, 81.0 хувь нь эх барих эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад явагджээ. Энэ үзүүлэлт нийгэм, эдийн засгийн шинж байдлаар ялгаа багатай байна.
- Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хамгийн сүүлд үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 59.2 хувь нь гар соруураар, 14.0 хувь нь эмээр, 11.1 хувь нь багажаар цэвэрлүүлсэн байна.
- Үр хөндүүлэх үеийн жирэмсний голч хугацаа 1.6 сар байна. Хөдөөгийн, өсвөр насны (15-19 нас), боловсрол багатай, доогуур аж байдалтай өрхийн эмэгтэйчүүд арай хожуу үр хөндүүлж байна.
- Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 20.0 хувь нь эрүүл мэндийн шалтгаанаар, 18.5 хувь нь хүүхэд төрүүлэх болоогүй, 12.8 хувь нь төрөлт хоорондын зай ойрхон, 10.3 хувь нь ажил хийхийг хүссэн гэж хариулжээ.

Эх, хүүхдийн эрүүл мэнд

Жирэмсний үеийн хяналтын үйлчилгээ, зөвлөгөө

- Жирэмсний хяналтын хүрээнд мэргэжлийн эмчид (эмч, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, сувилагч) үзүүлэх нь Монголд харьцангуй өндөр бөгөөд судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 98.7 хувь наад зах нь нэг удаа, 89.6 хувь 4 ба түүнээс олон удаа мэргэжлийн эмчид үзүүлжээ.
- Судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн нийт эмэгтэйн 80.6 хувь жирэмсний эрт үедээ (жирэмсний эхний гурван сартайдаа), 14.6 хувь жирэмсний 4-5 сартайдаа, 4.0 хувь жирэмсний хожуу үедээ хяналтад (жирэмсний 6 ба түүнээс хойш сар) оржээ.
- Жирэмсний хяналтад ороход 10 орчим төрлийн үйлчилгээ, шинжилгээ авч, зөвлөгөө өгөх ёстой байдаг. Хамгийн наад зах нь цусны даралт хэмжүүлж, шээс болон цусны ерөнхий шинжилгээ өгсөн эмэгтэйчүүдийн хувь 94.7 байна. Харин бүх үйлчилгээ, шинжилгээнд хамрагдсан хувь 65.5 хувь байна. Энэ үзүүлэлт нийгэм, эдийн засгийн шинж байдлаар ихээхэн ялгаатай юм.
- Эрүүл мэндийн байгууллагын анхдагч шатлалын байгууллага буюу сум, өрхийн эмнэлгийнхээ хяналтад судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 74.5 хувь хамрагджээ.
- Жирэмснийг хянахдаа эрүүл мэндийн мэргэжилтэн 20 орчим төрлийн зөвлөгөө, мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд наад зах нь нэг төрлийн зөвлөгөөг эмэгтэйчүүдийн 96.4 хувь, бүх төрлийн зөвлөгөөг 28.7 хувь нь авчээ. Эрүүл мэндийн мэргэжилтнүүд төмрийн бэлдмэл, фолийн хүчлийн талаарх зөвлөгөөг хамгийн түгээмэл (87.8 хувь) өгч байхад гэр бүл төлөвлөлтийн талаар хамгийн бага (49.7 хувь) ярилцсан байна.
- Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 83.0 хувь нь жирэмсэн үедээ төмрийн бэлдмэл, фолийн хүчлийг дунджаар 63 хоног хэрэглэжээ. Казах тэргүүлэгчтэй өрхөд амьдардаг эмэгтэйчүүдийн дунд энэ үзүүлэлт нэлээд бага байна.

Төрөх үеийн тусламж

- Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн 98.9 хувь нь мэргэжлийн эмчийн хяналтад хүүхдээ төрүүлжээ. Нийт төрөлтийн 71.8 хувь нь эх баригч их эмчийн, 17.6 хувь нь эх баригчийн, 5.5 хувь нь өрх/ сумын их эмчийн хяналтад явагдсан байна.
- Тэдгээр эмэгтэйчүүдийн 23.4 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байна. Мэс заслын аргаар хүүхдээ төрүүлэх нь хотын эмэгтэйчүүдийн дунд хөдөөгийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү түгээмэл (26.7 ба 17.5 хувь) юм.
- Нас ахих тусам мэс заслын буюу төлөвлөгөөт төрөлтийн хувь нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 20 хүртэлх насны 10 эмэгтэй тутмын 1 нь, 20-34 насны 5 эмэгтэй тутмын 1 нь, 35-49 насны 3 эмэгтэй тутмын 1 нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлжээ.
- Хүүхдийг төрсөн даруй нярайн нэн шаардлагатай тусламжид заагдсан дулаан байлгах асаргаар авч хэрэгжүүлэх нь эх, нярайд ихээхэн тустай. Нярайг төрмөгц дулаан байлгах асаргааны аль нэг төрлийн үйлчилгээг нийт төрөлтийн 94.8 хувьд үзүүлжээ. Үүнээс малгай өмсгөх, эхийн хэвлий дээр нүцгэн хэвтүүлэх тусламжийг авч үзвэл тус тус 85.6, 73.8 хувьтай байна. Харин нярайн 64.6 хувийг дулаацуулах ширээнд байрлуулжээ.

Төрсний дараах эх, хүүхдийн хяналт

- Төрсний дараах эх, хүүхдийн хяналтын талаар мэдээллийг тус судалгаанд анх удаа цогц байдлаар тусгасан. Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн хоёр эмэгтэй тутмын нэг (51.7 хувь) нь төрснийхөө дараа 1-2 өдрийн хугацаанд эмнэлэгтээ сувилуулжээ. Хот суурин газар тэр дундаа, нийслэлд амаржсан эхчүүдийг олон хоногоор эмнэлэгт байлгах боломж муу (3 ба түүнээс олон өдөр эмнэлэгт байсан хувь 37.3) байгаа нь судалгааны дүнгээс харагдсан.
- Төрсний дараах тусгайлсан үзлэг буюу гэрийн эргэлтийг хугацаагаар нь ангилбал ихэнх нярайг

(51.4 хувь) эхний 7 хоног өнгөрсний дараа, 4 хүүхэд тутмын 1-ийг 3-6 өдрийн дотор эмнэлгийн мэргэжилтэн үзсэн бол 14.3 хувьд үзлэг огт хийгдээгүй байна. Харин гэрийн эргэлтийн үеэр эхийн эрүүл мэндийг үзсэн байдал дөнгөж 48.4 хувьтай гарсан нь эмнэлгээс гарснаас хойш эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн эхэд тавих анхаарал эрс суларч байгааг илтгэнэ.

ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадал

- Улсын хэмжээнд 15-49 насны эмэгтэйчүүдийн 91.6 хувь, эрэгтэйчүүдийн 91.2 хувь нь ХДХВ, ДОХ-ын талаар сонсчээ. Гэсэн хэдий ч ХДХВ-ийн халдвараас сэргийлэх 2 арга буюу халдваргүй, бэлгийн үнэнч нэг хавьтагчтай байх болон бэлгэвч тогтмол хэрэглэхийг мэддэг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувь харьцангуй бага буюу харгалзан 68.6 болон 69.5 хувь байв.
- Хүн амын дунд нийтлэг байдаг ХДХВ-ийн талаарх ташаа 2 ойлголт буюу шумууланд хазуулах болон ДОХ-ын халдвартай хүнтэй хоол хүнсээ хувааж хэрэглэснээр халдвар авч болохыг няцаасан, түүнчлэн, ДОХ-ын халдвартай хүн эрүүл хүн шиг харагдаж болно гэдгийг мэддэг 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь (29.0 хувь) эрэгтэйчүүдийнхээс (22.7 хувь) илүү байна.
- 15-49 насны эмэгтэйчүүдийн 23.4 хувь, эрэгтэйчүүдийн 18.8 хувь нь ХДХВ-ийн халдварын талаар цогц мэдлэгтэй байна. Цогц мэдлэгийн түвшин 15-24 насны залуу эмэгтэйчүүдийн дунд 22.8 хувь, эрэгтэйчүүдийн дунд 20.7 хувь байна.
- 15-49 насны эмэгтэйчүүдийн 80.3 хувь нь ХДХВ-ийн халдвар эхээс ураг, нярайд халдварлах боломжтой гэдгийг мэдэж байхад эрэгтэйчүүдийнх харьцангуй доогуур буюу 69.1 хувь байна.
- 15-49 насны эмэгтэйчүүдийн 2.5 хувь, эрэгтэйчүүдийн 4.8 хувь нь ХДХВ/ДОХ-ын халдвар авсан хүмүүст хандах хандлагыг тодорхойлох 4 төрлийн асуултад (гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь ДОХ-оор өвчилбөл гэртээ асарна, ДОХ-ын халдвартай худалдагчаас мах, ногоо худалдаж авна, ДОХ-оор өвчлөөгүй боловч ДОХ-ын халдвартай эмэгтэй багш сургуульдаа үргэлжлүүлэн ажиллаж болно, гэр бүлийн хэн нэг гишүүн ДОХ-ын халдвар авсан тохиолдолд нууцлахгүй) бүгдэд нь хүлээн зөвшөөрсөн хариулт өгчээ. Энэ нь тун хангалтгүй үзүүлэлт юм.
- ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгөх газрыг 15-49 насны эмэгтэйчүүдийн 75.8 хувь, эрэгтэйчүүдийн 64.3 хувь нь мэддэг ажээ. Гэсэн ч эмэгтэйчүүдийн 24.7 хувь, эрэгтэйчүүдийн 15.3 хувь нь судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд уг шинжилгээг өгч, хариугаа авсан байна.
- 15-24 насны эрэгтэйчүүдийн 13.1 хувь, эмэгтэйчүүдийн 1.6 хувь нь судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд оржээ. Нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орсон залуу эмэгтэйчүүдийн 51.0 хувь, эрэгтэйчүүдийн 64.7 хувь нь хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байна.
- 15-24 насны эрэгтэйчүүдийн 4.2 хувь, эмэгтэйчүүдийн 0.6 хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон ба сүүлийн 12 сард уг насны эмэгтэйчүүдийн 2.9 хувь нь өөрөөсөө 10 ба түүнээс олон насаар ах хүнтэй бэлгийн хавьталд оржээ.

Өвсөр үе, залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэнд

- Өвсөр насны охидын төрөлтийн түвшин (15-19 насны 1000 эмэгтэйд ногдох) 40.4, залуу эмэгтэйчүүдийн төрөлтийн түвшин (20-24 насны 1000 эмэгтэйд ногдох) 168.0 байна.
- 15-19 насны охидын 3.7 хувь нь хүүхэд төрүүлсэн, 1.6 хувь нь анхны хүүхдээ тээж байгаа жирэмсэн байна.
- Эмэгтэйчүүдийн 3.9 хувь залуудаа буюу 18 наснаас өмнө хүүхэд төрүүлжээ. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн 6.0 хувь 18 наснаас өмнө хүүхэд төрүүлсэн байхад хотын эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт 2 дахин бага буюу 2.9 хувь байна.
- Судалгаанд хамрагдсан 15-24 насны эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн 51.2 (64.3) хувь нь бэлгийн хавьталд орж байсан ба 0.6 (4.2) хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд оржээ.
- 20-24 насны эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн 28.0 (62.7) хувь нь сүүлийн 12 сард тохиолдлын бэлгийн хавьталд орсны 44.4 (69.4) хувь сүүлийн бэлгийн хавьтлын үеэр бэлгэвч хэрэглэжээ.
- 20-24 насны эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн хувьд 2.5 (22.1) хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орсны 45.1 (61.8) хувь нь сүүлийн бэлгийн хавьтлын үеэрээ

бэлгэвч хэрэглэжээ.

- 15-24 насны нийт эмэгтэйчүүдийн 95.9 хувь нь жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл (ЖСАХ)-ийн талаар мэддэг гэжээ.
- ЖСАХ-ын талаарх мэдлэг өндөр байгаа ч хэрэглээ хангалтгүй байна. Судалгаагаар 15-24 насны нийт эмэгтэйчүүдийн 18.2 хувь, гэрлэсэн эмэгтэйчүүдийн 45.6 хувь, бэлгийн идэвхтэй гэр бүлгүй эмэгтэйчүүдийн 40.5 хувь нь жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байна.
- 15-24 насны нийт эмэгтэйчүүдийн 91.2 хувь, эрэгтэйчүүдийн 89.3 хувь нь ДОХ-ын талаар сонсчээ. Гэсэн хэдий ч ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргыг мэддэг мөн насны эмэгтэйчүүдийн хувь 63.5, эрэгтэйчүүдийн хувь 66.9 байна.
- Залуу эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн ХДХВ-ийн талаарх мэдлэгийн түвшин бага ялангуяа, 15-19 насны эмэгтэйчүүд (эрэгтэйчүүдийн) хувьд 17.5 (17.3) хувьтай байна.
- 15-24 насны эмэгтэйчүүдийн 61.9 хувь, эрэгтэйчүүдийн 53.7 хувь нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хаана хийлгэхийг мэддэг ажээ. Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд тухайн насны эмэгтэйчүүдийн 19.6 хувь, эрэгтэйчүүдийн 11.3 хувь нь шинжилгээ өгч, хариугаа авсан байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл харилцааны технологийн хүртээмж

- Эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) 9.5 хувь (13.1 хувь) нь долоо хоногт наад зах нь 1 удаа сонин уншиж, 1 удаа FM, радио сонсож, 1 удаа телевиз үздэг байхад 2.2 хувь (1.7 хувь) нь алийг нь ч хэрэглэдэггүй гэжээ.
- 15-24 насны эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) 88.4 хувь (86.2 хувь) нь компьютер хэрэглэж байсан, 80.1 хувь (79.0 хувь) нь сүүлийн 1 жилд хэрэглэсэн, 67.0 хувь (66.8 хувь) нь сүүлийн 1 сарын хугацаанд долоо хоног бүр хэрэглэсэн байна. 15-24 насны эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) 80.9 хувь (76.8 хувь) нь интернэт хэрэглэж үзсэн бөгөөд сүүлийн нэг жилд 74.2 хувь (71.6 хувь) нь хэрэглэжээ. Интернэтийг сүүлийн 1 сарын хугацаанд долоо хоног бүр хэрэглэсэн залуу эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) хувь харьцангуй бага буюу 61.2 хувь (59.6 хувь) байна.

Тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ

- Судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн 37.2 хувь, эрэгтэйчүүдийн 87.0 хувь тамхи татаж үзжээ. Эмэгтэйчүүдийн 7.8 хувь, эрэгтэйчүүдийн 56.1 хувь нь судалгааны өмнөх 1 сарын хугацаанд янжуур, бусад утаатай болон утаагүй тамхийг татжээ.
- Тамхи татдаг эрэгтэйчүүд хот, хөдөөд ойролцоо байхад хотын эмэгтэйчүүдийн (9.8 хувь) тамхи татах нь хөдөөгийн эмэгтэйчүүдийнхээс (3.7 хувь) илүү буюу 2.6 дахин их байна.
- Эрэгтэйчүүдийн 3.6 хувь, эмэгтэйчүүдийн 1 хүрэхгүй хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө архи ууж үзжээ.
- 15-49 насны эрэгтэйчүүдийн 52.1 хувь, эмэгтэйчүүдийн 29.5 хувь нь сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэжээ.
- Архи, согтууруулах ундааны хэрэглээ хотын болон дээгүүр аж байдалтай өрхийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дунд их байна.

I БҮЛЭГ

ТАНИЛЦУУЛГА

I

Энэхүү тайлан нь Үндэсний статистикийн хороо НҮБ-ын Хүүхдийн сан болон НҮБ-ын Хүн амын сантай хамтран 2013 онд явуулсан Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (НҮТС)-ны үр дүнгийн тайлан юм.

Уг судалгаанаас үндэсний болон олон улсын түвшинд дэвшүүлсэн амлалт, зорилтуудын хэрэгжилтийг хянах болон баримтад суурилсан бодлого, хөтөлбөр боловсруулахад шаардлагатай статистикийн хувьд бодитой, олон улсын түвшинд харьцуулагдахуйц тоо мэдээллийг гаргасан. Олон улсын түвшинд дэвшүүлсэн Мянганы хөгжлийн зорилт (МХЗ), Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурал, Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ХДХВ/ДОХ-ын эсрэг тусгай чуулган, Бүх хүнд боловсрол олгох тунхаглал, үндэсний түвшинд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний 4 дүгээр хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд чиглэгдсэн.

Үйл ажиллагааны амлалт: Үндэсний болон олон улсын түвшинд тайлагнах үүрэг хариуцлага

“Мянганы Тунхаглал”, “Хүүхдэд Ээлтэй дэлхий ертөнц” тунхаглал, “Үйл ажиллагааны хөтөлбөр”-т нэгдэн гарын үсэг зурсан Засгийн газрууд дэвшүүлсэн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хянаж байна гэдгээ амласан. Үүнд:

“Бид үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилго, зорилтуудыг хангах чиглэлд гарч байгаа ахиц дэвшилд үндэсний түвшинд шаардлагатай тохиолдолд бүс нутгийн түвшинд байнга хяналт хийж байхаас гадна үндэсний, бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд үнэлгээ өгөх болно. Үүний тулд Үндэсний статистикийн газруудын тоо мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх түүнчлэн хүйс, нас болон ялгаатай байдал бий болгоход хүргэдэг шинж байдлаар мэдээллийг задлан харуулах мөн хүүхдэд-чиглэсэн шинжилгээ хийх статистикийн чадавхийг дээшлүүлэх болно. Бид статистикийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж, төлөвлөлт, үнэлгээ, хяналтанд оролцох олон нийтийн чадавхийг бий болгоно. (Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал, 60-р зүйл)

“...Үйл ажиллагааг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхэд учирч байгаа хүндрэлийг шийдэхийн тулд бид үндэсний болон орон нутгийн түвшинд явц байдлыг тогтмол авч үзэж байх болно ...” (Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал, 61-р зүйл)

Үйл ажиллагааны төлөвлөгөөний (61-р зүйл) явцын тайланг бэлтгэхэд НҮБ-ын Хүүхдийн Санг тусгайлан оролцохыг уриалахдаа:

Тунхаглалын болон үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллийг бэлтгэх, тархаахад

Засгийн газрууд, сан, хөтөлбөрүүд түүнчлэн НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, бусад талуудтай нягт хамтран ажиллахыг НҮБ-ын Хүүхдийн Сангаас хүүхдийн төлөө дэлхийн тэргүүлэх байгуулагынх нь хувьд хүссэн.

Үүний адилаар Мянганы тунхаглал (31-р зүйл)-д “... Бид тунхаглалын хэрэгжилтэд гарч байгаа ахиц дэвшлийг тогтмол авч үзэж байхыг Ерөнхий Ассамблейгээс хүсэхийн сацуу Ерөнхий нарийн бичгийн даргаас энэ талаар Ерөнхий Ассамблейд цаашдын үйл ажиллагааны талаар тогтмол илтгэж байхыг хүсэж байна” гэжээ.

Монгол Улс бодлогын түвшинд 2005 онд Улсын Их Хурал (УИХ)-аас “Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилтуудыг батлах тухай” тогтоолоор МХЗ-ууд, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг баталсан бөгөөд 2008-2021 оны Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ)-ын суурь болгосон. Хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавих ажлыг дэмжих, бусад олон улсын түвшний бодлого хөтөлбөр, амлалтуудыг хянах шалгуур үзүүлэлтүүдийн тоо мэдээллийн санг бүрдүүлж, тоо мэдээллийг ашиглан нөхцөл байдлыг дүгнэх, үнэлгээ өгөх ажлыг ҮСХ-ны чиг үүрэг болгосон. Энэ ажлын хүрээнд ҮСХ цахим тогтолцоонд суурилсан мэдээллийн санг статистикийн болон засаг захиргааны нэгжийн өдөр тутмын тайланд тулгуурлан бий болгож байна.

Судалгааны зорилго

Монгол Улсын "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2013"-ын үндсэн зорилго нь:

1. Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нөхцлийг үнэлэхэд шаардлагатай тоо мэдээллийг шинэчлэх, баяжуулах.
2. Нийгмийн зарим салбаруудад гарсан ахиц, дэвшлийг үнэлэх шаардлагатай тоо мэдээллийг бий болгох,
3. Мянганы тунхаглал болон бусад олон улсын болон үндэсний хэмжээний зорилго, хөтөлбөрүүдийн зорилтын хэрэгжилтийг хянахад шаардлагатай тоо мэдээллээр хангах,
4. Нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн баримтад суурилсан бодлого боловсруулахад шаардлагатай ялгаатай байдлыг тодорхойлох ангилсан мэдээлэл цуглуулах.
5. 2015 оноос хойш дэлхий нийтийн хөгжлийн зорилгуудыг тодорхойлох хөтөлбөрийн суурь мэдээллийг бий болгох.

II БҮЛЭГ

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ТҮҮВЭРЛЭЛТ

II

Монгол Улс Хүүхэд хөгжил судалгаа (ХХС)-г 1996, 2000, 2005, 2010 онуудад Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (ОУБТС)-ны аргачлалд тулгуурлан 4 удаа, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа (НҮЭМС)-г 1998, 2003, 2008 онуудад Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаа (ХАЗЭМС)-ны аргачлалыг баримтлан 3 удаа зохион байгуулсан.

ХХС, НҮЭМС-нууд хоорондоо 2 жилийн зайтайгаар ихээхэн хөрөнгө, хүн хүч, цаг хугацаа зарцуулан явагддаг, аргачлал нь зарчмын зөрүүгүй, олон ижил үзүүлэлтийг тооцож, улс, бүсийн түвшинд үр дүнгээ тархаадаг зэргээс үүдэн Үндэсний статистикийн хорооноос нэгтгэх шаардлагатай гэж үзсэн. Тиймээс "Статистикийн тухай" Монгол Улсын хуульд өөрчлөлт оруулан ХХС, НҮЭМС-г нэгтгэж, ХАЗЭМС-тай хамтатган "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг 5 жил тутам" явуулахаар хуульчилсан.

Нийгмийн үзүүлэлтийн 2013 оны түүвэр судалгаа дээрх 3 судалгааг нэгтгэж, нэгдсэн аргачлалаар явагдах болсноороо ихээхэн ач холбогдолтой болсон төдийгүй судалгааны мэдээлэл цуглуулахад анх удаа таблет төхөөрөмж ашиглан цаасан технологийг бүрэн автоматжуулсан. Судалгааг ОУБТС-ны аргачлалд тулгуурлан явууллаа.

Түүврийн зохиомж

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа өрхөд суурилсан судалгаа учраас түүврийн нэгж нь өрх юм. Тиймээс судалгааны үзэл баримтлалд мэдээлэл цуглуулах үед Монгол Улсын нутаг дэвсгэрт харьяалагдах, засаг захиргааны нэгждээ 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа эсвэл 6 сар хүрээгүй боловч цаашид 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суух өрхийг түүврийн нэгжээр тодорхойлсон.

Судалгааны үр дүнг үндэсний түвшинд, үүний дотор хот, хөдөө, бүсээр (Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар) тооцоход бодитой төлөөлөлтэй байхаар түүврийн хэмжээг тогтоолоо. Өөрөөр хэлбэл, улсын хэмжээнд 15500 өрхийг магадлалт түүврийн аргаар судалгаанд хамруулж, бүс бүрт ногдох өрхийг хувийн жингийн аргаар буюу тухайн бүсийн өрхүүдийн улсын дүнд эзлэх хувийн жингээс хамааруулж, түүврийн нэгжийг сонгохоор шийдвэрлэсэн.

Өрхүүдийг сонгохдоо хоёр шатлалт, бүлэглэсэн түүврийн аргыг ашиглав. Эхний шатанд судалгаанд хамрагдах түүврийн анхан шатын нэгжийг (баг, хэсэг) хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар тодорхойлов. Сонгогдсон баг, хэсгээс судалгаанд хамруулах өрхийн тоог 25 байхаар тооцож, өрхүүдийг системчилсэн магадлалт түүврийн аргаар сонголоо.

Хүн амын өрхийн бүртгэлийн 2012 оны жилийн эцсийн албан ёсны статистикийн мэдээг түүврийн хүрээ болгон ашиглав. Улаанбаатар хотын хувьд хорооны хэсгийг, аймгуудын хувьд сумын багийг түүврийн анхан шатны нэгж (ТАШН) болгон тодорхойлсныг өмнө дурдсан. Судалгаанд 21 аймгийн 236 сумын 384 баг, Улаанбаатар хотын 9 дүүргийн 75 хорооны 220 хэсэг хамрагдсан бөгөөд баг, хэсэг бүрээс өрхийн жагсаалтыг 2013 оны 5-7 сард шинэчлэн гаргуулав.

Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг хийхдээ түүврийн жин ашигласан. Түүврийн зохиомжтой холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт А-аас үзнэ үү.

Судалгааны асуулга, үзүүлэлт

Судалгааны асуулга, үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо судалгааны зорилго, хамрах хүрээ, ОУБТС-ны 5 дахь хөтөлбөр¹, НҮЭМС, ХАЗЭМС-ны үндсэн үзүүлэлт, загвар асуулгуудад үндэслэв.

¹ ОУБТС-ны стандарт асуулгыг http://www.childinfo.org/mics5_questionnaire.html цахим хуудаснаас харж болно.

Судалгаанд 4 бүлэг асуулгыг ашигласан:

1. Өрхийн асуулга - өрхийн гишүүдийн (суурин хүн ам) хүн ам зүйн мэдээлэл болон сууцны талаарх мэдээллийг цуглуулсан;
2. Эмэгтэйн асуулга - өрхийн 15-49 насны бүх эмэгтэйчүүдийг хамруулсан;
3. Эрэгтэйн асуулга - 2 өрх тутмын нэгэнд амьдарч байгаа 15-54 насны бүх эрэгтэйчүүдийг хамруулсан;

5 хүртэлх насны хүүхдийн асуулга - өрхөд амьдарч байгаа 5 хүртэлх насны бүх хүүхдийн эх/асран хамгаалагчийг хамруулсан.

Мөн судалгааны асуулгыг боловсруулахдаа дээр дурдсан судалгааны үзүүлэлт, асуулга хоорондын уялдааг хангаж, баяжуулах, өмнөх судалгаануудын үндсэн үр дүн харьцуулагдахуйц байх болон өөрийн улс орны онцлог, мэдээллийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзлээ.

Судалгааны асуулгын агуулгын багцыг тодорхойлбол:

Өрхийн асуулга

- Өрхийн ам бүлийн байдал, ерөнхий мэдээлэл;
- Өрхийн гишүүдийн боловсрол;
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт;
- Хүүхдийн хүмүүжил;
- Өрхийн сууц, ахуйн нөхцөл болон хөрөнгө;
- Хурдан морь унаач хүүхэд;
- Ус, ариун цэврийн байгууламжийн хангамж;
- Гар угаах газар;
- Иоджуулсан давсны хэрэглээ.

Судалгаанд хамрагдсан өрхийн 15-49 насны бүх эмэгтэйг "Эмэгтэйн асуулга"-аар ганцаарчилсан ярилцлага авсан бөгөөд асуулга нь дараах бүлгүүдтэй:

- Эмэгтэйн талаарх ерөнхий мэдээлэл;
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл, харилцааны технологийн хэрэглээ;
- Гэрлэлтийн байдал;
- Нөхөр, хамтран амьдрагчийн зарим мэдээлэл;
- Төрөлт, төрөлтийн түүх;
- Жирэмслэлт, зулбалт, амьгүй төрөлт болон үр хөндөлт;
- Төрөлтийн төлөвлөлт;
- Эх, нялхсын эрүүл мэнд;
- Төрсний дараах хяналт, үйлчилгээ;
- Хүүхдийн өвчлөлийн шинж тэмдэг;
- ЖСАХ-ийн мэдлэг, хэрэглээ;
- Төрөлтийн төсөөлөл;
- Бэлгийн харилцааны төлөвшил;
- БЗДХ, ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх мэдлэг, хандлага;
- Умайн хүзүүний хорт хавдрын талаарх мэдлэг;
- Тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ.

Судалгаанд хамрагдсан 2 өрх тутмын нэгд нь амьдардаг 15-54 насны бүх эрэгтэйчүүдээс "Эрэгтэйн асуулга"-аар ганцаарчилсан ярилцлага авсан бөгөөд асуулга нь дараах бүлгүүдтэй:

- Эрэгтэйн талаарх ерөнхий мэдээлэл;
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл, харилцааны технологийн хэрэглээ;
- Нөхөн үржихүй;
- Гэрлэлтийн байдал;
- Жирэмслэлтээс сэргийлэх арга, хэрэгслийн мэдлэг, хэрэглээ;
- Гэр бүл төлөвлөлт;

- Бэлгийн харилцааны төлөвшил;
- БЗДХ, ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх мэдлэг, хандлага;
- Тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ.

"5 хүртэлх насны хүүхдийн асуулга"-д судалгаанд хамрагдсан өрхөд амьдардаг 5 хүртэлх насны² бүх хүүхдийн эх (асран хамгаалагч)-ийг хамруулсан. Тухайн хүүхэд ээжтэйгээ хамт амьдардаггүй буюу эхийнх нь нэр өрхийн гишүүдийн нэрсийн жагсаалтад байхгүй тохиолдолд асран хамгаалагчаас нь асуулга авсан бөгөөд асуулга нь дараах бүлгүүдтэй:

- Нас;
- Төрсний бүртгэл;
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил;
- Эхийн сүүгээр хооллолт, хүүхдийн хоол тэжээл;
- Дархлаажуулалт;
- Хүүхдийн өвчлөл, эмчилгээ, сувилгаа;
- Хүүхдийн жин, өндрийн хэмжилт

Асуулгын хуудсыг турших зорилгоор 2013 оны 6 сард Архангай аймгийн Эрдэнэбулган, Цэнхэр сумаас 2 баг, Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 14, 22-р хорооноос 2 хэсэг нийт 4 нэгжид туршилтын судалгааг зохион байгуулсан. Харин 2013 оны 8 сард таблетийн туршилтыг зохион байгуулж явууллаа. Туршилтын судалгааны үр дүнд суурилан асуулгын хуудсанд утга найруулгын засвар хийж, асуулт хоорондын уялдааг сайжруулсан. Судалгааны асуулгыг Хавсралт F-ээс харж болно.

Мэдээлэл цуглуулалтын багууд асуулга авахаас гадна өрхийн хоолондоо хэрэглэж буй давсны иодын агууламжийг шалгаж, гар угаах газрыг ажиглаж, 5 хүртэлх насны хүүхдийн өндөр, жингийн хэмжилтийг хийсэн. Эдгээр хэмжилт, ажиглалт нь асуулгын хуудасны холбогдох бүлгүүдэд тусгагдсан болно.


Судалгаанд ашигласан технологи

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд орчин үеийн дэвшилтэт технологи болох таблет ашигласнаараа онцлогтой болсныг өмнө дурдсан. Мэдээлэл цуглуулалтад байгаль орчинд ээлтэй технологи ашигласнаар өгөгдлийг анхан шатны нэгжээс нь цуглуулсан даруй төв сүлжээнд дамжуулж, мэдээллийн чанар, аюулгүй байдлыг хангах, хугацаа, хүн хүч болон зардал хэмнэх зэрэг олон давуу талыг бий болгосон юм. Мэдээлэл цуглуулалтын үйл явцыг Зураг SM.1-г үзүүлэв.

Судлаач нарын анхан шатнаас цуглуулсан мэдээлэл эхлээд багийн ахлагчийн түвшинд нэгтгэгдэж, шаардлагатай тодруулгыг хийсний дараа ҮСХ-ны төв сүлжээнд илгээгдсэн. Төв сүлжээнд ирүүлсэн мэдээлэлд хяналт хийж, нэмэлт тодруулгыг багийн ахлагчаар дамжуулж, анхан шатнаас авч байлаа.

² Уг тайланд "5 хүртэлх насны хүүхэд", "0-4 насны хүүхэд" болон "0-59 сартай хүүхэд" гэсэн ойлголтуудыг нэг утгаар ээлжлэн хэрэглэсэн болно.


Зураг SM.1: Судалгааны мэдээлэл цуглуулалт



Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны ерөнхий зохион байгуулалт, бэлтгэл ажил 2012 онд эхэлсэн (Зураг SM.2).

Зураг SM.2: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт



Судалгааны түүврийн хэмжээ, арга зүй 2013 оны хагас гэхэд тодорхойлогдсон байлаа. Асуулга турших ажил 2013 оны 6-8 сард хийгдсэн. 9 сард мэдээлэл цуглуулах багийн сургалтыг зохион байгуулав. Мэдээлэл цуглуулах ажиллагаа 2013 оны 4 дүгээр улиралд явагдаж, боловсруулалт, үр дүнгийн хүснэгтүүд, урьдчилсан дүн гаргаж танилцуулах ажлууд 2014 оны 6 сарын эхэнд дууссан.

Туршилтын судалгаа

Судалгааны бэлтгэлийг хангаж амжилттай явуулахад үндсэн 2 төрлийн туршилтыг явуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулахад анх удаа таблет төхөөрөмж ашигласан нь технологийн ажиллах зарчим, мэдээлэл дамжуулалт, аюулгүй байдлыг хангах зэрэг олон асуудлыг шинээр тодорхойлох шаардлагыг бий болгосон юм. Тиймээс уламжлалт цаасан асуулгын туршилтаас гадна таблет төхөөрөмжийн туршилтыг давхар хийсэн.

Баг, хорооны өрх, хүн амын бүртгэлийг үнэлэх, судалгааны асуулгын агуулга, үзүүлэлтийн уялдаа холбоо, хариулагчид ойлгомжтой байдлыг тодорхойлох, сургалтын агуулга, сэдэв болон мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт, судалгааны ерөнхий төсвийг нягталж эцэслэх зорилгоор цаасан асуулгын туршилтыг 2013 оны 6 сард Архангай аймгийн Эрдэнэбулган, Цэнхэр сумаас 2 баг, Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 14, 22 дугаар хорооноос 2 хэсэг, нийт 4 нэгжид туршилтын судалгааг зохион байгуулав. Тус туршилтаар хөдөө орон нутагт засаг захиргааны анхан шатны нэгжийн өрх, хүн амын бүртгэл харьцангуй сайн, Улаанбаатар хотод анхаарах шаардлагатай нь ажиглагдсан. Тиймээс нийслэлээс сонгогдсон ТАШН-үүдэд өрхийн жагсаалтыг дахин гаргуулж, судалгаанд ашиглахаар шийдвэрлэсэн. Түүнчлэн, асуулгын агуулга, загвар, тусгагдсан үзүүлэлт зэргийг үндсэнд нь эцэслэв.

Өмнө дурдсанчлан, судалгааны мэдээлэл цуглуулахад таблет төхөөрөмж ашиглах, электрон асуулгын програмыг турших, цуглуулсан мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг хангах алгоритмыг эцэслэх, мэдээллийг газар дээрээс нь төв сүлжээнд дамжуулах болон анхан шатанд ажиллах багийн зохион байгуулалт, ажил үүргийн хуваарийг тодорхойлох, үүнтэй холбоотойгоор ажиллах өдөр, зардлын нормативыг тооцох зорилгоор таблетийн туршилтыг 2013 оны 8 сард Төв аймгийн Мөнгөнморьт сумаас 1 баг, Сонгинохайрхан дүүргийн 21, 22 хорооноос 2 хэсэг, нийт 3 нэгжид зохион байгуулав. Туршилтын хүрээнд технологийн асуудлуудыг, тухайлбал, электрон асуулгын програм, төв сүлжээнд мэдээлэл дамжуулалт, таблет төхөөрөмжийн ашиглалт, ажлын горим, мэдээлэл цуглуулах үеийн багийн зохион байгуулалт, гишүүдийн ажил үүргийг тодорхой болгов. Уламжлалт цаасан асуулгаар мэдээлэл цуглуулахад багийн ахлагч, хянагч, 5 мэдээлэл цуглуулагч гэсэн 7 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилладаг байсан бол хянагчийн үүргийг үндсэндээ програмчилж, 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулахаар шийдвэрлэсэн. Мөн мэдээлэл цуглуулалтын баг анхан шатны нэгждээ ажиллаж дуусангуут интернэт ашиглан өгөгдлийг төв сүлжээнд илгээж байхаар ажлын зохион байгуулалт хийв.

Сургалт, мэдээлэл цуглуулалт

Мэдээлэл цуглуулах багийн сургалтыг нийт 170 орчим хүнийг хамруулж, 9 дүгээр сарын 4-25-ны өдрүүдэд явуулав. Сургалтад ярилцлага авах арга зүй болон асуулгын хуудас тус бүрд агуулгыг зааснаас гадна цаасан асуулгаар болон таблет ашиглан асуулт асууж ярилцлага хийв. Сургалтын үеэр Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт цаасан асуулгыг ашиглан 2 өдөр, Сонгинохайрхан дүүрэгт таблет ашиглан 2 өдөр дадлага хийсэн. Сургалтад хамрагдсан 140 гаруй хүнээс шалгалт авч судлаачдыг сонгосон. Мэдээлэл цуглуулахад аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын албан хаагчдыг багийн ахлагчаар сургаж ажиллуулсан нь анхан шатанд ажиллах багийн зохион байгуулалтад сайнаар нөлөөлөв.

Судалгааны мэдээлэл цуглуулах үүрэг бүхий 20 багийг тус бүр 1 ахлагч, 5 ярилцлага авагч (2 эрэгтэй нь хэмжилт хийх ажлыг хариуцан гүйцэтгэсэн), 2 жолооч гэсэн бүрэлдэхүүнтэй байхаар зохион байгуулж ажиллуулсан. Мэдээлэл цуглуулалтын ажил 2013 оны 9 сарын 30-наас Улаанбаатар хотод, 10 сарын 6-наас орон нутагт эхэлж, 2013 оны 12 дугаар сарын 28 гэхэд хамгийн сүүлийн баг Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороонд ажилласнаар дууссан. Судалгааны мэдээлэл цуглуулах явцад төв сүлжээнд ирсэн өгөгдлүүдэд хяналт, үнэлгээ хийж, тодруулах асуудлыг цаг алдалгүй багт хүргэж ажилласан нь мэдээлэл чанартай болоход нөлөөллөө.

Мэдээлэл боловсруулалт

Судалгааны мэдээллийг CSPro 5.03 програм ашиглан цахим санд орууллаа. ОУБТС-ны олон улсын хөтөлбөрийн хүрээнд боловсруулагдсан үйл ажиллагааны дараалал болон стандарт програмыг НҮТС-нд ашигласан бөгөөд асуулгын хуудастай уялдуулан өөрчилсөн. 2014 оны 1 сараас уялдаа холбооны

анхдагч засварлалт, ахисан шатны хяналтууд хийгдсэн.

2014 оны 2 сараас судалгааны үндсэн болон нэмэлт хүснэгтүүдийн алгоритм боловсруулах ажил эхэлж 4 сарын сүүлийн хагас гэхэд боловсруулж дууссан байлаа. Мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ НҮБХС-гаас судалгаанд зориулан боловсруулсан стандарт томъёолол болон үр дүнгийн хүснэгтийн загварыг өөрийн орны асуулгын хуудсанд нийцрүүлэн өөрчлөхийн зэрэгцээ нэмэлт хүснэгтүүдийг Нийгмийн шинжлэх ухаанд ашигладаг статистикийн багц програм SPSS 21.0-ийг ашиглан боловсруулсан бөгөөд хүснэгтийн бүх програм, алгоритмыг НҮБХАС болон НҮБХС, ОҮБТС-ны олон улсын багаар хянуулж эцэслэсэн.

НҮТС-ны урьдчилсан дүнг 2014 оны 6 сарын 5-нд олон нийт, хэрэглэгчдэд танилцуулсан юм.

III БҮЛЭГ

СУДАЛГААНЫ ХАМРАЛТ,
ӨРХ, ХҮН АМЫН ШИНЖ
БАЙДАЛ

III

Энэ бүлэгт НҮТС-2013-ын түүвэрт сонгогдсон болон судалгаанд өрхийн шинж байдлыг танилцуулах болно. Өрхийн гишүүдийн нас, хүйс, боловсролын түвшин, гэр бүлийн байдал, орон сууцны нөхцлийн талаарх ерөнхий мэдээллийг тодорхойлох үзүүлэлтийг өрхийн асуулгаар авсан.

Судалгааны хамралт

Судалгааны түүвэрт сонгогдсон 15500 өрхөөс 15028 нь судалгааны үед хамрагдах боломжтой байсан бөгөөд эдгээр өрхөөс 14805 нь судалгаанд бүрэн хамрагдаж, хамрагдалтын түвшин 98.5 хувь байна (Хүснэгт НН.1).

Судалгаанд хамрагдсан өрхөд 15-49 насны нийт 13457 эмэгтэй бүртгэгдсэнээс 12830 нь ганцаарчилсан ярилцлагад хамрагдаж, хамрагдалтын түвшин 95.3 хувьтай байна.

Түүвэрлэгдсэн өрхийн жагсаалтад байгаа өрх тутмын нэгээс эрэгтэйчүүдийг (15-54¹ насны) ганцаарчилсан асуулгад хамруулсан. 6883 эрэгтэй өрхийн асуулгад бүртгэгдсэнээс 6279 эрэгтэй хамрагдаж, хамрагдалтын түвшин нь 91.2 хувьтай байна.

5 хүртэлх насны 6137 хүүхэд бүртгэгдсэнээс 6054 хүүхэд судалгаанд хамрагдаж, хамрагдалтын түвшин 98.6 хувь байлаа.

Ерөнхий хамрагдалтын түвшин нь эмэгтэй, эрэгтэй, 5 хүртэлх насны хүүхдийн ганцаарчилсан асуулгад харгалзан 93.9 хувь, 89.9 хувь, 97.2 хувь байна. Хамрагдалтын түвшин бүс, хот, хөдөө болон байршлаар 90 гаруй хувьтай байв. Харин эрэгтэйчүүдийн хамрагдалтын түвшин харьцангуй доогуур байсан нь залуу эрэгтэйчүүд гэртээ эзгүй байсантай холбоотой юм. Бүс нутгаар авч үзвэл Улаанбаатар хотод бүх асуулгад хамрагдагчдын хамрагдалтын түвшин нь хамгийн бага байна.

Өрхийн шинж байдал


Хүснэгт НН.2-т судалгаанд хамрагдсан хүн амын жигнэсэн тархалтыг нас болон хүйсээр харуулсан. Уг тархалтыг Зураг НН.1 хүн амын нас, хүйсийн суваргад ашигласан болно. Судалгаагаар 14805 өрхөд амьдарч байгаа 51087 хүний талаарх мэдээллийг цуглуулсан. Эдгээрээс 24811 эрэгтэй, 26276 нь эмэгтэйчүүд байсан.

Хүснэгт НН.2-т өрхийн хүн амын нас, хүйсийн бүтцийг харууллаа. Судалгаанд хамрагдсан өрхийн хүүхэд (0-14 настай) 30.7 хувь, хөдөлмөрийн насны хүн ам (15-64 настай) 64.5 хувь, ахмад настай хүн ам (65-аас дээш настай) 4.8 хувь байна. ХХС-2010-аар энэ үзүүлэлт харгалзан 30.1 хувь, 65.2 хувь, 4.6 хувь байсан байна. 0-4 насны хүүхдийн хувь ХХС-2010-аар 11.3 хувь байсан бол энэ судалгаагаар 12.0 хувь болж нэмэгдсэн нь сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдснийг харуулж байна. Судалгаанд хамрагдсан хүн амын 100 эмэгтэйд 94 эрэгтэй ногдож байгаа нь ХХС-2010-тай (хүйсийн харьцаа 95 байсан) ижил байна.

Хүн ам зүйн ачаалал 55.0 хувь байгаа нь өмнөх ХХС-2010-аар 53.2 байснаас бага зэрэг өссөн байна. Үүний нэг адилаар, 0-17 насны хүүхдийн эзлэх хувь 35.5 хувь байгаа нь ХХС-2010-ны 35.2 хувьтай бараг ижил байна. Энэ судалгаагаар 14805 өрхөд нийт 0-17 насны 18114 хүүхэд хамрагдсан байна.

¹ Судалгааны мэдээллийн 15-54 насны эрэгтэйчүүдээс цуглуулсан боловч тайланг бичихдээ олон улсын түвшинд харьцуулах үүднээс 15-49 насны эрэгтэйчүүдийн хувьд тайлбарласан болно.

Зураг НН.1: Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амын нас, хүйсийн суварга, Монгол Улс, 2013 он



Хүснэгт НН.3, НН.4, НН.4М, НН.5-д өрхийн суурь мэдээлэл, 15-49 насны эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдүүд, 15-49 насны эрэгтэйчүүдийн судалгааны абсолют тоо (жигнээгүй) мэдээнээс гадна нийт хүн амд тархаасан (жигнэсэн) мэдээллийг харуулсан. Судалгаанд бүрэн хамрагдсан өрх, эмэгтэй, эрэгтэй, 5 хүртэлх насны хүүхдүүдийн сонгосон шинж байдлаар үзүүлсэн мэдээлэл уг тайланд оруулсан үндсэн үр дүнг тайлбарлахад маш их ач холбогдолтойгоос гадна энэ нь судалгааны төлөөлөх чадварыг харуулж байгаа юм. Үлдсэн хүснэгт нь зөвхөн жигнэгдсэн тоог харуулах бөгөөд Хавсралт А-аас хэрхэн жигнэсэн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авч болно.

Хүснэгт НН.3-г өрхийн шинж байдлыг үзүүлсэн. Хүснэгтээс өрхийн мэдээллийг өрхийн тэргүүлэгчийн хүйс, бүс, байршил, хот, хөдөө, өрхийн гишүүдийн тоо, өрхийн тэргүүлэгчийн боловсрол болон яс үндсээр нь харж болно. Уг шинж байдлууд нь энэхүү тайлангийн дараагийн хүснэгтүүдэд түгээмэл ашиглагдсан.

Хүснэгт НН.3-аас харахад Монгол улсын нийт өрхийн 22.0 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна. 10 өрх тутмын 9 нь бага боловсролоос дээш боловсролтой өрхийн тэргүүлэгчтэй байна (92.1 хувь).

Судалгаанд бүрэн хамрагдсан 14805 өрхийн 9427 өрх буюу 63.7 хувь нь хотын, 5378 өрх буюу 36.3 хувь нь хөдөөгийнх байна. ХХС-2010-аар хотын өрх арай бага буюу 60.3 хувь, хөдөөгийн өрх 39.7 хувийг эзлэж байсан байна. Нийт өрхийн тал хувь нь 3-4, 29.4 хувь нь 1-2, 23.1 хувь нь 5 ба түүнээс олон ам бүлтэй бөгөөд нэг өрхийн ам бүлийн дундаж тоо 3.5 байна. Нийт өрхийн ихэнх нь Халх өрхийн тэргүүлэгчтэй (81.6 хувь) байв.

Судалгаанд хамрагдсан 15-49 насны эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдүүдийн шинж байдал

15-49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдүүдийн ерөнхий шинж байдлыг Хүснэгт НН.4, НН.4М, НН.5-д тус тус үзүүлсэн. Стандарт түүврийн жин ашигласан тул дээрх хүснэгтүүдэд жигнэгдээгүй болон жигнэгдсэн ажиглалтын тоо тэнцүү байгаа. Учир нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдийн шинж байдлаарх шаардлагатай тоо мэдээллийг харуулсан тус хүснэгтүүдэд тухайн шинж байдал тус бүр дэх ажиглалтын утгыг харуулахыг зорьсон болно.

Хүснэгт НН.4-д 15-49 насны эмэгтэйчүүдийг шинж байдлаар нь харуулав. Бүс, хот, хөдөө, байршил, насны бүлэг, гэрлэлтийн байдал, хүүхэд төрүүлсэн эсэх, сүүлийн 2 жилийн төрөлт, боловсролын түвшин², өрхийн аж байдлын түвшин болон өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа зэрэг мэдээллийг харуулсан.

² Өөрөөр томъёолоогүй тохиолдолд энэхүү тайланд шинж байдлаар ашигласан “боловсрол” гэдэгт судалгаанд хамрагдагчийн боловсролын хүрсэн хамгийн дээд түвшинг ойлгоно.

Хүснэгт НН.4-өөс харахад нийслэл Улаанбаатар хотын эмэгтэйчүүд хамгийн их хувийг (44.4 хувь) эзлэж байна. Зүүн болон Баруун бүсийн эмэгтэйчүүд харгалзан 7.2 хувь, 12.4 хувийг эзлэж байна. Нийт эмэгтэйчүүдийн 66.5 хувь нь хот суурин газар амьдарч байна. Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйг гэрлэлтийн байдлаар нь авч үзэхэд 67.6 хувь нь гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай, 23.3 хувь нь огт гэрлээгүй, 4.9 хувь нь салсан, 2.9 хувь нь бэлбэсэн, 1.3 хувь нь тусгаарласан хүмүүс байна. Мөн нийт эмэгтэйчүүдийн 18.6 хувь нь судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлжээ. Боловсролын байдлаар нь үзвэл судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйн 3.8 хувь нь боловсролгүй, 4.4 хувь нь бага, 19.4 хувь нь суурь, 27.4 хувь нь бүрэн дунд, 11.0 хувь нь техникийн болон мэргэжлийн, 3.4 хувь нь дээд боловсролтой ажээ.

Хүснэгт НН.4М-д 15-49 насны эрэгтэйчүүдийг бүс, байршил, хот, хөдөө, насны бүлэг, гэрлэлтийн байдал, төрсөн хүүхэдтэй эсэх, боловсролын түвшин, өрхийн аж байдлын түвшин болон өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаагаар харуулсан.

Эрэгтэйчүүдийн шинж байдлыг бүс нутаг, хот хөдөөгөөр авч үзвэл эмэгтэйчүүдийн шинж байдалтай төстэй байна. Судалгаанд хамрагдсан нийт эрэгтэйн 65.1 хувь нь гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай, 30.8 хувь нь огт гэрлээгүй, үлдсэн 4.1 хувь нь гэр бүлээ цуцалсан, тусгаарласан, бэлбэсэн байна. Боловсролын байдлаар нь авч үзэхэд эмэгтэйчүүдийнхээс харьцангуй доогуур буюу 7.6 хувь нь боловсролгүй, 8.6 хувь нь бага, 25.9 хувь нь суурь, 25.6 хувь нь бүрэн дунд, 11.5 хувь нь техникийн болон мэргэжлийн, 20.8 хувь нь дээд боловсролтой эрэгтэйчүүд байна.

5 хүртэлх насны хүүхдийн зарим шинж байдлыг Хүснэгт НН.5-д хүйс, бүс, хот, хөдөө, байршил, насны бүлэг, эх/асрамжлагчийн боловсролын түвшин, өрхийн аж байдлын түвшин болон өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаагаар нь ангилж үзүүлэв. Судалгаанд 5 хүртэлх насны нийт 6054 хүүхэд хамрагдсанаас 51.3 хувь нь хөвгүүд, 48.7 хувь нь охид байв. 5 хүртэлх насны хүүхдийн эхчүүдийн 5.5 хувь нь боловсролгүй, 7.0 хувь нь бага, 8.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 14.8 хувь нь суурь, 24.9 хувь нь бүрэн дунд, 39.6 хувь нь дээд боловсролтой байна. Харин хүүхдийн амьдарч байгаа өрхийн аж байдлаар нь авч үзвэл нийт хүүхдийн 21.9 хувь нь доогуур, 20.3 хувь нь дунджаас доогуур, 19.1 хувь нь дундаж, 18.0 хувь нь дунджаас дээгүүр, үлдсэн 20.7 хувь нь дээгүүр аж байдалтай өрхөд амьдарч байна.

Орон сууцны нөхцөл, өрхийн хөрөнгө, эд зүйлс, аж байдлын түвшин

Өрхийн орон сууцны нөхцлийг судлах, өрхийн аж байдлын түвшинг тооцоолоход ашиглах зорилгоор Хүснэгт НН.7, НН.8-ийг тооцсон. Хүснэгт НН.6-д өрхийн сууц нь төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэртэй эсэх, өрхийн сууцны шал, дээвэр, ханын гаднах материал, хүн унтдаг өрөөний тоо зэрэг үзүүлэлтүүдийг хот, хөдөө, бүсээр харууллаа.

Судалгаанд хамрагдсан хотын өрхийн 2.2 хувь, хөдөөгийн өрхийн 48.0 хувь нь цахилгаангүй байна. Цахилгаантай өрхийг бүсээр авч үзвэл Баруун (63.6) болон Хангайн (64.1) бүсэд цахилгаантай өрхийн хувь бусад бүсээс бага, Улаанбаатарт хамгийн өндөр буюу нийт өрхийн 98.4 хувь нь цахилгаантай юм.

Нийт өрхийн 60 орчим хувь нь байшинд, 40 орчим хувь нь гэрт амьдарч байна. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 22.9 хувь нь, хотын өрхийн 9.7 хувь, хөдөөгийн өрхийн 46.0 хувь нь шалгүй байна. Баруун бүсэд шалгүй өрхийн хувь хамгийн өндөр буюу 38.6, Улаанбаатар хотод хамгийн бага буюу 8.6 хувь байна.

Дээврийн материалыг авч үзвэл нийт өрхийн 26.5 хувь нь давхар дээвэртэй гэр, 26.0 хувь нь хар цаас/замын хараар хийсэн дээвэртэй байшинд амьдарч байгаа нь хамгийн их хувийг эзлэж байна. Энэ үзүүлэлт хот, хөдөөгөөр ялгаатай байгаа нь хөдөөд өрхүүд ихэвчлэн гэрт амьдардагтай холбоотой.

Судалгаанд хамрагдсан хотын өрхийн 21.6 хувь нь ямар нэг тоосгон ханатай байшинд, 19.9 хувь нь бетон/цементэн ханатай байшинд, 17.5 хувь нь давхар туургатай гэрт амьдарч байна. Хөдөөгийн өрхийн 44.0 хувь нь давхар туургатай гэрт, 10.7 хувь нь мод банзан ханатай байшинд, 5.8 хувь нь бетон/цементэн ханатай байшинд амьдарч байна.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 72.9 хувь хүн унтдаг нэг, 22.8 хувь хүн унтдаг 2, 4.3 хувь хүн унтдаг 3 ба түүнээс дээш өрөөтэй байна.

Хүснэгт НН.7-т өрхийн болон өрхийн гишүүдийн эд зүйлсийг хот, хөдөө болон бүсээр харууллаа. Үүнд орон сууцны өмчлөлийг мөн хамруулсан болно.

Хотын өрх гэр ахуйн цахилгаан хэрэгсэл хөдөөгийн өрхүүдийг бодвол илүү ихээр хэрэглэж байгаа

нь хүснэгт-НН.6-т дурьдсанчлан цахилгааны хэрэглээтэй холбоотой. Харин радио, нар салхины эрчим хүчний үүсвэр, мотоцикл, ердийн хөсөг, трактор зэрэг хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд хэрэглэгддэг эд зүйлс хөдөөгийн өрхүүд хотынхоос илүү хэрэглэж байна.

Судалгаанд хамрагдсан өрхийн 10.3 хувь, хотын өрхийн 8.4 хувь, хөдөөгийн өрхийн 13.7 хувь нь тариалангийн талбайтай бол нийт өрхийн 37.7 хувь, хотын өрхийн 15.0 хувь, хөдөөгийн өрхийн 77.5 хувь нь хувийн мал, тэжээвэр амьтантай юм.

Сууцны өмчлөлийн хувьд хотын өрхийн 86.6 хувь, хөдөөгийн өрхийн 92.9 хувь нь өөрийн сууцанд амьдарч байгаа бол үлдсэн хувь нь түрээсийн болон түрээсгүйгээр бусдын сууцанд амьдардаг байна.

Өрхийн аж байдлын түвшинд хамааралтай хэрэглээний эд зүйл, сууцны нөхцөл, ус болон ариун цэврийн байгууламж, бусад үзүүлэлтийн талаарх мэдээллийг ашиглан өрхийн эд зүйл (дээр дурдсан үзүүлэлтүүд) тус бүрт тохирох хүчин зүйлийн оноо өгч, үндсэн бүрэлдэхүүний шинжилгээг хийдэг. Өрх тус бүрийн хувьд тухайн өрхийн эзэмшдэг эд зүйл, хөрөнгө болон тэдгээрийн жинд суурилан аж байдлын оноог тооцдог³. Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амыг тэдгээрийн амьдардаг өрхийн аж байдлын онооны дагуу хамгийн багаас (доогуур) хамгийн их (дээгүүр) хүртэл эрэмблэн 5 тэнцүү бүлэг болгон хуваасан.

Хүснэгт НН.8-т өрхийн аж байдлыг оршин суугаа газар болон бүсээр харуулав. Хүснэгтээс харахад аж байдлын түвшин нь хот болон хөдөөгөөр асар их ялгаатай байна. Өөрөөр хэлбэл хотын өрхийн хүн амын 2.0 хувь нь доогуур байхад энэ үзүүлэлт хөдөөд 51.3 хувь, харин дунджаас дээгүүр аж байдалтай өрх хотод 30.1 хувь байхад хөдөөд 2.5 хувь байгаагаас харж болно.

Өрхийн аж байдлыг бүсээр авч үзвэл Баруун бүсийн өрхийн 85.0 хувь, Хангайн бүсийн өрхийн хүн амын 81.5 хувь, Зүүн бүсийн 74.8 хувь, Төвийн бүсийн 65.0 хувь нь дундаж болон дунджаас доогуур аж байдалтай байна. Харин Улаанбаатарын өрхийн хүн амын 63.6 хувь нь дунджаас дээгүүр болон дээгүүр аж байдалтай байгаа нь хөдөө орон нутагт өрхийн аж байдал муу байгааг харуулж байна.

Ажил эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбар

НҮТС-2013 судалгаагаар 15-49 насны эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулснаараа бусад өмнө хийгдэж байсан Хүүхэд хөгжил болон Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаануудаас онцлог болсон. Хүснэгт НН.9-НН.11-т судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарыг харууллаа.

Эмэгтэйчүүдийн 28.9 хувь нь судалгааны өмнөх 12 сарын хугацаанд ажил эрхлээгүй гэж хариулсан бол 9.9 хувь нь судалгааны өмнөх 12 сарын хугацаанд ажил эрхэлсэн боловч одоогоор ажил эрхлээгүй байна. Хотын эмэгтэйчүүдийн 69.0 хувь, хөдөөгийн эмэгтэйчүүдийн 75.3 хувь нь судалгааны өмнөх 12 сард ажил эрхэлжээ. Сүүлийн 12 сард ажил эрхэлсэн эмэгтэйчүүдийн хувийн жинг бүсээр авч үзвэл Төвийн бүсэд хамгийн өндөр буюу 77.1 хувь, Улаанбаатар хотод хамгийн бага 67.3 хувьтай байна.

Судалгааны өмнөх 12 сарын хугацаанд ажил эрхэлсэн эмэгтэйчүүдийг боловсролын түвшингээр авч үзвэл боловсролгүй болон суурь боловсролтой эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт бага байхад дээд болон техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт харгалзан 84.5, 77.6 байна (Хүснэгт НН.9). Хүснэгтээс харахад насны бүлэг, боловсролын түвшин, өрхийн аж байдлын түвшин нэмэгдэх тусам эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт нэмэгдэж байна.

15-49 насны эрэгтэйчүүдийн 83.1 хувь нь судалгааны өмнөх 12 сард ажил эрхэлсэн, 16.9 хувь нь ажил эрхлээгүй байна. Хотын эрэгтэйчүүдийн 81.7 хувь, хөдөөгийн эрэгтэйчүүдийн 85.5 хувь нь судалгааны өмнөх 12 сард ажил эрхэлжээ. Сүүлийн 12 сард ажил эрхэлсэн эрэгтэйчүүдийн хувийн жинг бүсээр авч үзвэл үзвэл Төвийн болон Хангайн бүсэд хамгийн өндөр буюу 85.3 хувь, Улаанбаатар хотод хамгийн бага 81.3 хувьтай байна. Суурь болон бүрэн дунд боловсролтой эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт бага

³ Аж байдлын индекс тооцох талаар дэлгэрэнгүй мэдээллийг доорх эх үүсвэрүүдээс харна уу.

Filmer, D. and Pritchett, L., 2001. "Estimating wealth effects without expenditure data – or tears: An application to educational enrollments in states of India". Demography 38(1): 115-132.

Rutstein, S.O. and Johnson, K., 2004. The DHS Wealth Index. DHS Comparative Reports No. 6. Calverton, Maryland: ORC Macro
Rutstein, S.O., 2008. The DHS Wealth Index: Approaches for Rural and Urban Areas. DHS Working Papers No. 60. Calverton, Maryland: Macro International Inc.

байхад дээд болон техникийн болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт 90-ээс дээш хувьтай байна (Хүснэгт НН.9М).

Ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийг ажил мэргэжлээр нь ангилахад 25.9 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 20.2 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан, 19.6 хувь нь ямар нэг мэргэжилтэн үлдсэн хувь нь бусад төрлийн ажил эрхэлж байгааг хүснэгт НН.10-т харуулав. Түүнчлэн, байршлын хувьд хотын эмэгтэйчүүд худалдаа, үйлчилгээний ажилтан, мэргэжилтэн хийх нь хөдөөгийн эмэгтэйчүүдээс өндөр байгаа бол хөдөөд эмэгтэйчүүдийн 52.7 хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан хийж байна. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин, өрхийн аж байдлын түвшин дээшлэх тусам хөдөө аж ахуйн салбарын ажил эрхлэх нь багасч, бусад төрлийн ажил эрхлэх нь нэмэгдэж байна. Бага боловсролтой эмэгтэйчүүдийн 73.9 хувь нь хөдөө аж ахуйн мэргэжлийн ажил эрхэлж байхад дээд боловсролтой эмэгтэйчүүдийн 2.1 хувь нь хөдөө аж ахуйн мэргэшсэн ажил хийж байна. Доогуур аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн 83.2 нь хөдөө аж ахуйд ажиллаж байгаа бол дээгүүр аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн 0.3 хувь нь хөдөө аж ахуйд ажиллаж байна.


Хүснэгт НН.10М-д ажил эрхэлж буй эрэгтэйчүүдийг ажил мэргэжлээр нь ангилан харуулав. Хүснэгтээс харахад 15-49 насны ажил эрхлэж байгаа эрэгтэйчүүдийн 24.9 хувь нь хөдөө аж ахуй, ой, засаг агнуурын мэргэшсэн ажилтан, 16.2 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 14.7 хувь нь машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч хийж байгаа бол үлдсэн хувь нь бусад төрлийн ажил эрхэлж байна.

Байршлын хувьд хотын эрэгтэйчүүд үйлдвэрлэл, барилга, гар урлал, түүнд холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, худалдаа, үйлчилгээний ажилтан хийх нь илүү түгээмэл бол хөдөөгийн эрэгтэйчүүдийн 61.0 хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан хийж байна. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй адил боловсролын түвшин, өрхийн аж байдлын түвшин дээшлэх тусам хөдөө аж ахуйн салбарын ажил эрхлэх нь багасч, бусад төрлийн ажил эрхлэх нь нэмэгдэж байна боловсролгүй эрэгтэйчүүдийн 66.1 хувь нь хөдөө аж ахуйн мэргэжлийн ажил эрхэлж байхад дээд боловсролтой эрэгтэйчүүдийн 2.9 хувь нь хөдөө аж ахуйн мэргэшсэн ажил хийж байна. Доогуур аж байдалтай өрхийн эрэгтэйчүүдийн 85.6 нь хөдөө аж ахуйд ажиллаж байгаа бол дээгүүр аж байдалтай өрхийн эрэгтэйчүүдийн 0.6 хувь нь хөдөө аж ахуйд ажиллаж байна.

Ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийг эдийн засгийн идэвхээр, эрхэлж буй ажлын төрлөөр (хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус) хүснэгт НН.11-т харууллаа. Хүснэгтээс харахад хөдөө аж ахуйн ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн 58.9 хувь нь гэр бүлийн гишүүний, 37.2 хувь нь өөрийн, нийт 96.1 хувь нь өөрийн буюу гэр бүлийн ажил эрхэлж байна. Харин хөдөө аж ахуйн бус ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн 72.2 хувь нь бусад хэн нэгний ажлыг эрхэлж байна. Зураг НН.2-т харуулав.

Хөдөө аж ахуйд ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн 88.4 хувь, хөдөө аж ахуйн бус ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн 75.4 хувь нь байнгын ажилтай байгаа бол үлдсэн хувь нь улирлын болон түр ажил эрхэлж байна. (Хүснэгт НН.11)

Зураг НН.02: Эмэгтэйчүүдийн ажлын төрөл, ажил олгогчоор, Монгол Улс, 2013 он



Хүснэгт НН.1: Өрх, эмэгтэй, эрэгтэй, 5 хүртэлх насны хүүхдийн асуулгын үр дүн

Судалгаанд хамрагдвал зохих болон бүрэн хамрагдсан өрх, эмэгтэй, эрэгтэй, 5 хүртэлх насны хүүхдийн тоо, хамрагдалтын түвшин, Монгол Улс, 2013 он

	Бүгд	Хот, хөдөө		Бүс					
		Хот	Хөдөө	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
Өрх									
Түүвэрт сонгогдсон	15500	9525	5975	2000	3200	2800	2000	5500	
Хамрагдвал зохих	15028	9191	5837	1968	3118	2741	1971	5230	
Бүрэн хамрагдсан	14805	9035	5770	1959	3069	2715	1962	5100	
Хамрагдалтын түвшин	98.5	98.3	98.9	99.5	98.4	99.1	99.5	97.5	
Эмэгтэй									
Хамрагдвал зохих	13457	8533	4924	1786	2732	2262	1666	5011	
Бүрэн хамрагдсан	12830	8103	4727	1724	2628	2174	1596	4708	
Хамрагдалтын түвшин	95.3	95.0	96.0	96.5	96.2	96.1	95.8	94.0	
Ерөнхий хамрагдалтын түвшин	93.9	93.3	94.9	96.1	94.7	95.2	95.4	91.6	
Эрэгтэй									
Хамрагдвал зохих	6883	4135	2748	975	1414	1209	839	2446	
Бүрэн хамрагдсан	6279	3725	2554	909	1313	1129	782	2146	
Хамрагдалтын түвшин	91.2	90.1	92.9	93.2	92.9	93.4	93.2	87.7	
Ерөнхий хамрагдалтын түвшин	89.9	88.6	91.9	92.8	91.4	92.5	92.8	85.6	
5 хүртэлх насны хүүхэд									
Хамрагдвал зохих	6137	3574	2563	955	1262	1118	776	2026	
Бүрэн хамрагдсан	6054	3516	2538	947	1247	1109	769	1982	
Хамрагдалтын түвшин	98.6	98.4	99.0	99.2	98.8	99.2	99.1	97.8	
Ерөнхий хамрагдалтын түвшин	97.2	96.7	97.9	98.7	97.3	98.3	98.6	95.4	

Хүснэгт НН.2: Өрхийн хүн амын насны бүтэц, хүйсээр

Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амын хувийн жин, 5 насны бүлэг болон хүн ам зүйн ачааллын насны бүлгээр, хүүхэд (18 хүртэлх насны) болон насанд хүрсэн (18 ба түүнээс дээш насны) хүн амын хувийн жин, хүйсээр, Монгол Улс, 2013 он

	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Бүгд	51087	100.0	24811	100.0	26276	100.0
Насны бүлэг						
0-4	6155	12.0	3146	12.7	3009	11.5
5-9	4852	9.5	2449	9.9	2403	9.1
10-14	4669	9.1	2371	9.6	2298	8.7
15-19	3631	7.1	1938	7.8	1694	6.4
20-24	3757	7.4	1867	7.5	1890	7.2
25-29	4263	8.3	2137	8.6	2126	8.1
30-34	4080	8.0	1965	7.9	2115	8.0
35-39	4016	7.9	1906	7.7	2110	8.0
40-44	3663	7.2	1732	7.0	1931	7.4
45-49	3279	6.4	1545	6.2	1735	6.6
50-54	2891	5.7	1264	5.1	1627	6.2
55-59	2092	4.1	940	3.8	1152	4.4
60-64	1285	2.5	555	2.2	730	2.8
65-69	843	1.7	370	1.5	473	1.8
70-74	750	1.5	326	1.3	424	1.6
75-79	415	0.8	170	0.7	245	0.9
80-84	256	0.5	77	0.3	179	0.7
85+	189	0.4	54	0.2	135	0.5
Хүн ам зүйн ачааллын нас						
0-14	15676	30.7	7966	32.1	7711	29.3
15-64	32958	64.5	15849	63.9	17110	65.1
65+	2453	4.8	996	4.0	1456	5.5
Хүүхэд, насанд хүрсэн хүн ам						
Хүүхэд (0-17 нас)	18114	35.5	9233	37.2	8881	33.8
Насанд хүрэгчид (18 ба түүнээс дээш насны)	32974	64.5	15578	62.8	17396	66.2

Хүснэгт НН.3: Өрхийн бүтэц

Судалгаанд хамрагдсан өрхийн хувийн жин, сонгосон үзүүлэлтээр, Монгол Улс, 2013 он

	Жигнэсэн хувь	Өрхийн тоо	
		Жигнэсэн	Жигнээгүй
Бүгд	100.0	14805	14805
Өрхийн тэргүүлэгчийн хүйс			
Эрэгтэй	78.0	11542	11581
Эмэгтэй	22.0	3263	3224
Бүс			
Баруун	12.5	1845	1959
Хангай	20.8	3080	3069
Төв	17.7	2619	2715
Зүүн	7.8	1149	1962
Улаанбаатар	41.3	6111	5100
Хот, хөдөө			
Хот	63.7	9427	9035
Хөдөө	36.3	5378	5770
Байршил			
Нийслэл	41.3	6111	5100
Аймгийн төв	22.4	3316	3935
Сумын төв	11.9	1766	1915
Хөдөө	24.4	3613	3855
Өрхий ам бүлийн тоо			
1	10.4	1545	1549
2	19.0	2806	2832
3	23.0	3410	3431
4	24.4	3617	3585
5	14.4	2125	2114
6	5.5	817	812
7	2.1	309	308
8	0.6	96	96
9	0.3	45	43
10+	0.2	35	35
Өрхийн тэргүүлэгчийн боловсрол			
Боловсролгүй	7.9	1176	1257
Бага	13.8	2038	2145
Суурь	18.9	2805	2905
Бүрэн дунд	18.7	2762	2664
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	13.6	2011	2016
Дээд	27.0	3996	3800
Хариулаагүй/ мэдэхгүй	0.1	17	18
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа			
Халх	81.6	12088	11900
Казах	3.0	450	470
Бусад	15.1	2237	2402
Хариулаагүй/ мэдэхгүй	0.2	30	33
Өрхийн ам бүлийн дундаж тоо	3.5	14805	14805

Хүснэгт НН.4: Эмэгтэйчүүдийн шинж байдал

Судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувийн жин, сонгосон үзүүлэлтээр, Монгол Улс, 2013 он

	Жигнэсэн хувь	Эмэгтэйчүүдийн тоо	
		Жигнэсэн	Жигнээгүй
Бүгд	100.0	12830	12830
Бүс			
Баруун	12.4	1587	1724
Хангай	19.9	2557	2628
Төв	16.1	2063	2174
Зүүн	7.2	926	1596
Улаанбаатар	44.4	5696	4708
Хот, хөдөө			
Хот	66.5	8532	8103
Хөдөө	33.5	4298	4727
Байршил			
Нийслэл	44.4	5696	4708
Аймгийн төв	22.1	2836	3395
Сумын төв	10.8	1389	1555
Хөдөө	22.7	2910	3172
Насны бүлэг			
15-19	12.4	1595	1589
20-24	13.8	1765	1692
25-29	15.7	2012	2017
30-34	15.6	2002	1998
35-39	15.7	2010	2050
40-44	14.2	1816	1839
45-49	12.7	1631	1645
Гэрлэлтийн байдал			
Гэрлэсэн/ хамтран амьдрагчтай	67.6	8674	8775
Бэлбэсэн	2.9	374	382
Салсан	4.9	626	605
Тусгаарласан	1.3	171	169
Огт гэрлэж/ хамтран амьдарч байгаагүй	23.3	2985	2899
Хүүхэд төрүүлсэн эсэх			
Огт хүүхэд төрүүлж байгаагүй	24.2	3110	2992
Хүүхэд төрүүлж байсан	75.8	9720	9838
Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн	18.6	2389	2375
Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлээгүй	57.1	7331	7463
Боловсрол			
Боловсролгүй	3.8	488	532
Бага	4.4	563	595
Суурь	19.4	2488	2637
Бүрэн дунд	27.4	3520	3455
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	11.0	1408	1441
Дээд	34.0	4361	4169
Хариулаагүй/ мэдэхгүй	0.0	1	1
Өрхийн аж байдлын түвшин			
Доогуур	18.0	2311	2599
Дунджаас доогуур	18.8	2412	2486
Дундаж	19.7	2528	2559
Дунджаас дээгүүр	21.5	2753	2639
Дээгүүр	22.0	2826	2547
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа			
Халх	81.3	10435	10261
Казах	3.5	449	475
Бусад	15.0	1920	2064
Хариулаагүй/ мэдэхгүй	0.2	27	30

Хүснэгт НН.4М: Эрэгтэйчүүдийн шинж байдал

Судалгаанд хамрагдсан 15-49 насны эрэгтэйчүүдийн хувийн жин, сонгосон үзүүлэлтээр, Монгол Улс, 2013 он

	Жигнэсэн хувь	Эрэгтэйчүүдийн тоо	
		Жигнэсэн	Жигнээгүй
Бүгд	100.0	5745	5714
Бүс			
Баруун	13.4	768	834
Хангай	20.0	1150	1178
Төв	16.6	954	1010
Зүүн	7.2	411	707
Улаанбаатар	42.8	2461	1985
Хот, хөдөө			
Хот	63.2	3633	3385
Хөдөө	36.8	2112	2329
Байршил			
Нийслэл	42.8	2461	1985
Аймгийн төв	20.4	1172	1400
Сумын төв	10.5	605	680
Хөдөө	26.2	1507	1649
Насны бүлэг			
15-19	14.4	828	829
20-24	13.7	788	746
25-29	16.6	952	931
30-34	14.4	830	838
35-39	15.1	868	874
40-44	13.7	788	809
45-49	12.1	693	687
Гэрлэлтийн байдал			
Гэрлэсэн/ хамтран амьдрагчтай	65.1	3737	3741
Бэлбэсэн	0.5	28	28
Салсан	2.7	157	155
Тусгаарласан	0.9	51	50
Огт гэрлэж/ хамтран амьдарч байгаагүй	30.8	1772	1740
Төрсөн хүүхэдтэй эсэх			
Төрсөн хүүхэдтэй	65.0	3737	3743
Төрсөн хүүхэдгүй	34.9	2007	1969
Хариулаагүй/ мэдэхгүй	0.0	2	2
Боловсрол			
Боловсролгүй	7.6	434	474
Бага	8.6	493	517
Суурь	25.9	1491	1543
Бүрэн дунд	25.6	1471	1387
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	11.5	660	677
Дээд	20.8	1193	1114
Хариулаагүй/ мэдэхгүй	0.0	2	2
Өрхийн аж байдлын түвшин			
Доогуур	21.1	1212	1355
Дунджаас доогуур	19.1	1100	1121
Дундаж	18.6	1069	1080
Дунджаас дээгүүр	21.7	1245	1168
Дээгүүр	19.5	1120	990
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа			
Халх	80.3	4612	4516
Казах	3.7	212	225
Бусад	15.8	909	958
Хариулаагүй/ мэдэхгүй	0.2	11	15

Хүснэгт НН.5: 5 хүртэлх насны хүүхдийн шинж байдал

Судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхдийн хувийн жин, сонгосон үзүүлэлтээр, Монгол Улс, 2013 он

	Жигнэсэн хувь	5 хүртэлх насны хүүхдийн тоо	
		Жигнэсэн	Жигнээгүй
Бүгд	100.0	6054	6054
Хүйс			
Эрэгтэй	51.3	3103	3102
Эмэгтэй	48.7	2951	2952
Бүс			
Баруун	14.9	904	947
Хангай	20.4	1234	1247
Төв	17.5	1061	1109
Зүүн	7.5	453	769
Улаанбаатар	39.7	2402	1982
Хот, хөдөө			
Хот	61.0	3693	3516
Хөдөө	39.0	2361	2538
Байршил			
Нийслэл	39.7	2402	1982
Аймгийн төв	21.3	1291	1534
Сумын төв	12.0	727	797
Хөдөө	27.0	1634	1741
Насны бүлэг			
0-5 сартай	10.9	658	644
6-11 сартай	10.6	642	637
12-23 сартай	19.5	1180	1165
24-35 сартай	20.4	1236	1235
36-47 сартай	19.5	1180	1185
48-59 сартай	19.1	1157	1188
5 хүртэлх насны хүүхдийн асуулгад хариулагч			
Ээж	95.4	5776	5764
Асрамжлагч	4.6	278	290
Эхийн боловсрол^a			
Боловсролгүй	5.5	334	358
Бага	7.0	423	442
Суурь	14.8	894	947
Бүрэн дунд	24.9	1509	1497
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	8.2	494	508
Дээд	39.6	2398	2300
Хариулаагүй/ мэдэхгүй	0.0	1	2
Өрхийн аж байдлын түвшин			
Доогуур	21.9	1326	1458
Дунджаас доогуур	20.3	1227	1251
Дундаж	19.1	1159	1158
Дунджаас дээгүүр	18.0	1088	1045
Дээгүүр	20.7	1253	1142
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа			
Халх	79.7	4828	4744
Казах	4.2	256	265
Бусад	15.7	953	1026
Хариулаагүй/ мэдэхгүй	0.3	17	19

^a Тайлангийн бүх хүснэгтэд "Эхийн боловсрол" гэдэгт 5 хүртэлх насных хүүхдийн эхийн, хэрвээ эх нь эзгүй эсвэл нас барсан тохиолдолд хүүхдийн асуулгад хариулсан асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно.

Хүснэгт НН.6: Өрхийн шинж байдал

Судалгаанд хамрагдсан өрхийн шинж байдал, хот, хөдөө болон бүсээр, Монгол Улс, 2013 он

	Бүгд	Хот, хөдөө		Бүс				
		Хот	Хөдөө	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
Цахилгаан эрчим хүч								
Цахилгаантай	81.2	97.8	52.0	63.6	64.1	75.7	76.1	98.4
Цахилгаангүй	18.8	2.2	48.0	36.4	35.9	24.3	23.9	1.6
Шалны материал								
Байшин								
Мод, банз	26.0	28.4	21.6	21.1	23.4	30.2	35.7	25.0
Модон паркет, өнгөлсөн мод	5.6	8.0	1.3	1.7	2.3	3.8	1.0	10.1
Шахмал паркет (ламинат)	12.7	19.0	1.7	3.2	4.8	7.0	4.7	23.5
Плита	0.6	0.7	0.3	0.4	0.3	0.7	0.2	0.8
Бетон/ цемент	13.1	17.0	6.2	5.6	11.0	14.3	10.7	16.3
Бусад	1.6	0.8	2.9	9.3	0.3	0.5	0.4	0.5
Гэр								
Шалгүй	22.9	9.7	46.0	38.6	33.6	31.3	25.7	8.6
Мод, банз	15.4	13.8	18.2	18.6	22.0	9.7	20.1	12.6
Бетон/ цемент	1.9	2.3	1.3	1.2	1.8	1.9	1.2	2.3
Бусад	0.4	0.3	0.5	0.4	0.4	0.7	0.1	0.3
Дээврийн материал								
Байшин								
Метал/ төмөр	23.8	28.3	15.8	14.5	24.0	20.8	24.5	27.6
Мод, банз	1.4	1.1	1.8	2.0	2.0	1.4	0.4	1.0
Цементэн черпица	2.9	2.9	2.8	0.6	1.6	6.3	4.8	2.3
Паалан черпица (вааран)	0.9	1.1	0.7	0.3	.6	1.6	1.1	1.0
Бетон/ цемент	1.1	1.6	0.3	0.6	.2	1.0	2.1	1.7
Органик/ зөөлөн черпица	0.3	0.3	0.4	0.0	.1	0.7	.5	.3
Хар цаас/ замын хар	26.0	36.8	7.0	5.3	12.7	22.4	18.7	41.8
Бусад	3.1	1.7	5.3	17.8	.9	2.1	.7	.5
Гэрийн дээвэр								
Дан	14.1	9.0	23.1	30.1	20.2	9.4	15.7	8.0
Давхар	26.5	17.1	42.9	28.6	37.7	34.2	31.5	15.9
Гадна хана								
Байшин								
Шавартай чулуу	5.5	6.7	3.3	5.6	3.4	5.3	3.1	6.9
Түүхий тоосго	0.7	0.8	0.6	2.1	0.1	0.3	1.7	0.6
Фанер	0.1	0.1	0.1	0.0	0.1	0.1	0.2	0.0
Шпал (дахин ашигласан мод)	0.8	1.0	0.4	0.2	0.1	1.3	0.2	1.1
Бетон/ цемент	14.8	19.9	5.8	7.6	7.6	13.1	15.3	21.2
Шохойтой/ цементтэй чулуу	6.4	7.9	3.9	6.1	3.6	7.0	1.8	8.7
Блок	2.2	2.6	1.6	4.6	2.1	1.4	0.2	2.2
Өнгөлсөн түүхий тоосго	0.2	0.3	0.1	0.3	0.1	0.3	0.1	0.3
Мод, банз, дүнс	7.9	6.2	10.7	4.3	16.3	7.3	15.1	3.5
Тоосго: Өнгөлгөөний	3.3	4.7	0.8	1.3	0.7	2.3	2.0	5.8
Тоосго: Энгийн	12.2	16.9	4.1	4.5	5.4	13.4	10.3	17.8
Бусад	5.4	6.9	2.7	4.6	2.5	4.4	2.6	7.9
Гэрийн туурга								
Дан	13.4	8.5	22.0	29.3	18.8	9.0	13.8	7.7
Давхар	27.2	17.5	44.0	29.5	39.1	34.6	33.4	16.1
Хүн унтдаг өрөөний тоо								
1	72.9	64.4	87.8	77.3	85.6	74.3	83.6	62.6
2	22.8	29.8	10.5	18.2	13.0	22.4	13.7	31.0
3 ба түүнээс дээш	4.3	5.7	1.7	4.5	1.4	3.3	2.7	6.4
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өрхийн тоо	14805	9427	5378	1845	3080	2619	1149	6111
Унтлагын өрөөнд унтдаг хүний дундаж тоо	2.51	2.44	2.78	2.75	2.64	2.43	2.73	2.43

Хүснэгт НН.7: Өрхийн болон өрхийн гишүүдийн эд зүйлс

Өрхийн хувь, өрхийн болон өрхийн гишүүдийн эзэмшдэг эд зүйлс болон сууцны өмчлөлөөр, хот, хөдөө болон бүсээр, Монгол Улс, 2013 он

	Бүгд	Хот, хөдөө		Баруун	Хангай	Бүс		Улаанбаатар
		Хот	Хөдөө			Төв	Зүүн	
Өрхийн эд зүйлс								
Радио хүлээн авагч	18.1	14.4	24.5	24.9	17.6	23.5	20.1	13.5
Телевиз	94.3	98.3	87.2	87.8	90.1	94.5	92.3	98.6
Суурин телефон утас	13.2	14.5	10.9	7.6	13.5	12.0	7.1	16.3
Хөргөгч	75.1	91.8	45.8	54.1	56.4	71.8	65.7	94.0
Нар, салхины эрчим хүчний үүсвэр	19.9	1.9	51.5	46.4	36.8	23.5	25.6	.8
Компьютер	39.6	52.9	16.2	21.0	23.1	33.3	25.5	58.8
Интернетийн холболт, модем	23.9	35.0	4.4	7.1	9.7	15.5	11.3	42.1
Угаалгын машин	68.7	83.1	43.5	47.2	53.1	65.9	59.1	86.1
Тоос сорогч	46.0	59.8	21.8	27.0	29.7	44.1	32.8	63.2
Номын сан	30.6	37.4	18.6	23.2	21.8	28.5	21.8	39.8
Богино долгионы зуух	28.2	38.3	10.6	19.1	13.1	21.3	18.7	43.4
Индүү	80.4	92.6	58.9	62.0	68.2	78.7	71.7	94.4
Мотоцикл	22.8	4.8	54.5	44.0	42.7	29.1	32.9	1.8
Ердийн хөсөг	5.3	1.2	12.7	4.1	11.3	6.0	13.9	.8
Автомашин	45.2	47.9	40.5	40.9	40.4	47.2	36.4	49.7
Трактор	2.5	.9	5.3	1.5	3.2	5.3	6.5	.5
Газар, мал, тэжээвэр амьтан								
Тариалангийн талбай	10.3	8.4	13.7	12.5	10.7	16.2	16.4	5.8
Мал, тэжээвэр амьтан	37.7	15.0	77.5	70.1	61.8	48.4	51.7	8.6
Өрхийн хэн нэг гишүүний эд зүйлс								
Бугуйн цаг	53.4	63.3	36.2	39.5	41.3	48.3	38.8	68.7
Гар утас	97.0	98.8	94.0	94.0	95.4	97.4	95.8	98.9
Унадаг дугай	8.4	9.7	6.2	7.1	6.7	8.5	6.4	10.0
Видео камер, зургийн аппарат	29.1	38.1	13.3	15.8	18.8	25.6	18.5	41.7
Банкны данс	90.9	93.8	85.9	82.0	89.6	90.9	93.3	93.8
Сууцны өмчлөл								
Өөрийн сууц	88.9	86.6	92.9	93.8	93.3	88.4	87.7	85.6
Өөрийн сууц биш	11.1	13.4	7.1	6.2	6.7	11.6	12.3	14.4
Түрээсэлдэг	4.2	5.6	1.8	1.4	1.8	3.9	3.8	6.5
Бусад	6.9	7.8	5.3	4.7	5.0	7.7	8.5	7.9
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өрхийн тоо	14805	9427	5378	1845	3080	2619	1149	6111

Хүснэгт НН.8: Өрхийн аж байдлын түвшин

Өрхийн хүн амын хувь, өрхийн аж байдлын түвшингээр, хот, хөдөө болон бүсээр, Монгол Улс, 2013 он

	Өрхийн аж байдлын түвшин					Дүн	Өрхийн хүн амын тоо
	Доогуур	Дунджаас доогуур	Дундаж	Дунджаас дээгүүр	Дээгүүр		
Бүгд	20.0	20.0	20.0	20.0	20.0	100.0	51087
Хот, хөдөө							
Хот	2.0	19.1	21.8	27.0	30.1	100.0	32452
Хөдөө	51.3	21.6	16.8	7.8	2.5	100.0	18635
Бүс							
Баруун	41.1	27.0	16.9	11.2	3.7	100.0	7002
Хангай	38.9	23.1	19.5	9.9	8.6	100.0	10438
Төв	23.6	19.1	22.3	18.6	16.3	100.0	8617
Зүүн	28.4	23.1	23.4	14.3	10.9	100.0	3848
Улаанбаатар	0.7	16.0	19.7	29.5	34.1	100.0	21182

СУДАЛГААНЫ ХАМРАЛТ, ӨРХ, ХҮН АМЫН ШИНЖ БАЙДАЛ

Хүснэгт НН.9: Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт

15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, судалгааны өмнөх 12 сарын ажил эрхлэлтээр, Монгол Улс, 2013 он

	Судалгааны өмнөх 12 сард ажил эрхэлсэн		Судалгааны өмнөх 12 сард ажил эрхлээгүй	Хариулаагүй/ Мэдэхгүй	Дүн	15-49 насны эмэгтэйчүүдийн тоо
	Ажил эрхэлж байгаа*	Одоогоор ажил эрхлээгүй				
Бүгд	61.2	9.9	28.9	0.0	100.0	12830
Бүс						
Баруун	64.6	6.9	28.5	0.0	100.0	1587
Хангай	63.0	10.4	26.6	0.0	100.0	2557
Төв	67.4	9.7	22.9	0.0	100.0	2063
Зүүн	62.8	11.1	26.2	0.0	100.0	926
Улаанбаатар	57.0	10.3	32.7	0.0	100.0	5696
Хот, хөдөө						
Хот	58.7	10.3	31.0	0.0	100.0	8532
Хөдөө	66.4	8.9	24.7	0.0	100.0	4298
Байршил						
Нийслэл	57.0	10.3	32.7	0.0	100.0	5696
Аймгийн төв	61.9	10.3	27.8	0.0	100.0	2836
Сумын төв	64.7	10.1	25.2	0.0	100.0	1389
Хөдөө	67.2	8.4	24.4	0.0	100.0	2910
Насны бүлэг						
15-19	13.1	12.0	74.9	0.0	100.0	1595
20-24	48.1	12.9	39.0	0.0	100.0	1765
25-29	62.1	13.4	24.5	0.0	100.0	2012
30-34	69.4	9.6	21.0	0.0	100.0	2002
35-39	75.8	6.9	17.3	0.0	100.0	2010
40-44	76.3	8.0	15.7	0.0	100.0	1816
45-49	76.6	6.3	17.1	0.0	100.0	1631
Амьд байгаа хүүхдийн тоо						
0	37.0	12.7	50.3	0.0	100.0	3154
1	65.0	10.2	24.8	0.0	100.0	2541
2	70.6	8.7	20.7	0.0	100.0	3473
3	70.5	8.5	21.0	0.0	100.0	2285
4+	71.0	7.8	21.2	0.0	100.0	1377
Гэрлэлтийн байдал						
Гэрлэсэн	68.8	9.2	22.0	0.0	100.0	8674
Гэрлэж байсан	71.5	9.0	19.5	0.0	100.0	1171
Огт гэрлээгүй	35.1	12.1	52.8	0.0	100.0	2985
Боловсрол*						
Боловсролгүй	57.8	10.7	31.5	0.0	100.0	488
Бага	63.6	8.5	27.8	0.0	100.0	563
Суурь	44.4	9.1	46.5	0.0	100.0	2488
Бүрэн дунд	51.7	12.8	35.4	0.0	100.0	3520
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	66.8	10.9	22.4	0.0	100.0	1408
Дээд	76.8	7.6	15.5	0.0	100.0	4361
Өрхийн аж байдлын түвшин						
Доогуур	68.8	8.3	22.9	0.0	100.0	2324
Дунджаас доогуур	51.8	12.9	35.3	0.0	100.0	2368
Дундаж	56.2	11.5	32.3	0.0	100.0	2582
Дунджаас дээгүүр	62.7	9.8	27.6	0.0	100.0	2715
Дээгүүр	66.2	7.2	26.7	0.0	100.0	2842
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**						
Халх	61.6	10.1	28.3	0.0	100.0	10435
Казак	51.4	5.8	42.8	0.0	100.0	449
Бусад	61.9	9.5	28.5	0.0	100.0	1920

* "Боловсрол" нь хариулагдаагүй 1 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

** "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 30 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

а Сүүлийн 7 хоногт ямар нэг ажил эрхэлсэн. Сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй боловч ямар нэг ажил эрхэлдэг, амралтаа авсан, ажлаасаа чөлөөтэй, өвчний акттай, эсвэл улирлын чанартай ажил эрхэлдэг, эсвэл ямар нэг шалтгаанаар ажил эрхээгүй хүмүүсийг оруулсан.

Хүснэгт НН.9М: Эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт

15-49(54) насны эрэгтэйчүүдийн хувь, судалгааны өмнөх 12 сарын ажил эрхлэлтээр, Монгол Улс, 2013 он

	Судалгааны өмнөх 12 сард ажил эрхэлсэн		Судалгааны өмнөх 12 сард ажил эрхлээгүй	Хариулаагүй/ Мэдэхгүй	Дүн	Эрэгтэйчүүдийн тоо
	Ажил эрхэлж байгаа ^a	Одоогоор ажил эрхлээгүй				
Бүгд (15-49)	72.1	11.1	16.9	0.0	100.0	5745
Бүгд (15-54)	72.2	10.8	17.0	0.0	100.0	6279
Бүс						
Баруун	72.7	11.2	16.1	0.0	100.0	768
Хангай	76.6	8.8	14.7	0.0	100.0	1150
Төв	76.4	8.9	14.7	0.0	100.0	954
Зүүн	71.8	9.7	18.5	0.0	100.0	411
Улаанбаатар	68.1	13.2	18.7	0.0	100.0	2461
Хот, хөдөө						
Хот	69.4	12.3	18.3	0.0	100.0	3633
Хөдөө	76.6	8.9	14.5	0.0	100.0	2112
Байршил						
Нийслэл	68.1	13.2	18.7	0.0	100.0	2461
Аймгийн төв	72.2	10.5	17.4	0.0	100.0	1172
Сумын төв	70.2	13.2	16.6	0.0	100.0	605
Хөдөө	79.2	7.2	13.6	0.0	100.0	1507
Насны бүлэг						
15-19	25.9	17.3	56.8	0.0	100.0	828
20-24	66.0	17.4	16.6	0.0	100.0	788
25-29	82.6	9.7	7.6	0.0	100.0	952
30-34	84.2	8.7	7.1	0.0	100.0	830
35-39	84.1	8.1	7.8	0.0	100.0	868
40-44	81.8	8.5	9.8	0.0	100.0	788
45-49	78.8	7.8	13.4	0.0	100.0	693
Амьд байгаа хүүхдийн тоо						
0	51.5	15.7	32.7	0.0	100.0	2020
1	81.2	10.9	7.9	0.0	100.0	1007
2	84.3	7.8	7.9	0.0	100.0	1375
3	84.2	7.3	8.5	0.0	100.0	875
4+	82.2	8.1	9.6	0.0	100.0	468
Гэрлэлтийн байдал						
Гэрлэсэн	83.7	8.4	8.0	0.0	100.0	3737
Гэрлэж байсан	71.1	12.7	16.2	0.0	100.0	236
Огт гэрлээгүй	47.6	16.6	35.7	0.0	100.0	1772
Боловсрол*						
Боловсролгүй	80.1	7.9	12.0	0.0	100.0	434
Бага	80.7	8.9	10.3	0.0	100.0	493
Суурь	63.2	9.2	27.5	0.0	100.0	1491
Бүрэн дунд	62.6	16.4	21.0	0.0	100.0	1471
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	77.4	12.8	9.8	0.0	100.0	660
Дээд	85.3	7.9	6.8	0.0	100.0	1193
Өрхийн аж байдлын түвшин						
Доогуур	80.4	6.4	13.2	0.0	100.0	1242
Дунджаас доогуур	65.0	15.3	19.6	0.0	100.0	1067
Дундаж	68.8	13.7	17.5	0.0	100.0	1092
Дунджаас дээгүүр	71.9	11.7	16.4	0.0	100.0	1233
Дээгүүр	72.8	8.9	18.3	0.0	100.0	1111
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**						
Халх	73.0	10.7	16.3	0.0	100.0	4612
Казак	61.0	16.0	23.0	0.0	100.0	212
Бусад	69.8	12.0	18.2	0.0	100.0	909

* "Боловсрол" нь хариулагдаагүй 2 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

** "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 15 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

^a Сүүлийн 7 хоногт ямар нэг ажил эрхэлсэн. Сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй боловч ямар нэг ажил эрхэлдэг, амралтаа авсан, ажлаасаа чөлөөтэй, өвчний акттай, эсвэл улирлын чанартай ажил эрхэлдэг, эсвэл ямар нэг шалтгаанаар ажил эрхээгүй хүмүүсийг оруулсан.

Хүснэгт III.10: Эмэгтэйчүүдийн эрхэлсэн ажил

Судалгааны бичлэг 12 сарын хугацаанд ажил эрхэлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, эрхэлсэн ажил мэргэжлээр, Монгол Улс, 2013 он

	Ажил мэргэжлийн ангилал										Судалгааны бичлэг 12 сард ажил эрхэлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо		
	Мөхөөж жилтэн	Мэргэ- жилтэн	Техникийн болон туслах/дэд мэргэжилтэн	Контр- үйчилгээний ажилтан	Худалдаа, үйчилгээний ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас апуурын мэргэжлэн ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урдал, худалдах ажил, үйчилгээний ажилтан	Машин механизм, тохворомжийн операторч, устгагч	Энгийн ажил, мэргэжил	Зөвсөлт хүчний ажил, мэргэжил		Харуулаагүй	Дүн
Бүгд	5.7	19.6	6.5	4.8	25.9	20.2	9.2	1.2	6.6	0.2	0.0	100.0	9122
Бүс													
Баруун	3.0	18.8	3.4	1.6	15.5	44.3	8.7	0.7	3.9	0.0	0.0	100.0	1134
Хангай	2.7	15.7	2.8	2.0	38.1	5.2	9.9	0.8	4.2	0.1	0.0	100.0	1876
Төв	3.3	16.9	6.8	3.9	25.4	25.2	8.5	3.1	6.8	0.2	0.0	100.0	1591
Зүүн	4.3	17.9	5.9	4.0	23.5	28.9	7.8	0.3	7.3	0.0	0.0	100.0	684
Улаанбаатар	9.2	23.2	8.0	7.3	32.2	0.8	9.6	1.0	8.3	0.2	0.0	100.0	3836
Хот, хөдөө													
Хот	7.6	24.0	7.9	6.2	32.5	2.4	9.9	1.5	7.8	0.2	0.0	100.0	5884
Хөдөө	2.3	11.6	3.9	2.3	13.9	52.7	8.0	0.8	4.4	0.0	0.0	100.0	3237
Байршил													
Нийслэл	9.2	23.2	8.0	7.3	32.2	0.8	9.6	1.0	8.3	0.2	0.0	100.0	3836
Аймагийн төв	4.5	25.5	7.7	4.2	32.9	5.3	10.5	2.4	6.9	0.2	0.0	100.0	2048
Сумын төв	4.9	23.9	8.7	4.8	23.5	15.6	8.3	2.0	8.2	0.1	0.0	100.0	1039
Хөдөө	1.1	5.7	1.7	1.2	9.3	70.3	7.8	0.3	2.6	0.0	0.0	100.0	2198
Насны бүлэг													
15-19	0.9	3.9	2.9	4.0	41.7	20.9	9.1	0.5	16.1	0.0	0.0	100.0	400
20-24	6.1	21.5	6.7	7.4	29.3	14.2	8.1	0.7	6.0	0.1	0.0	100.0	1076
25-29	6.8	24.9	6.8	6.4	22.4	19.5	8.1	1.0	3.9	0.1	0.0	100.0	1518
30-34	5.5	22.2	7.6	5.3	21.6	21.9	9.9	1.4	4.7	0.0	0.0	100.0	1581
35-39	5.6	20.2	6.2	4.0	24.1	21.0	10.8	1.4	6.3	0.3	0.0	100.0	1663
40-44	6.4	15.9	5.8	3.2	30.9	20.4	9.4	1.6	6.4	0.1	0.0	100.0	1532
45-49	5.2	17.3	6.9	3.6	23.7	22.6	8.5	1.9	10.1	0.2	0.0	100.0	1351
Амьд байгаа хүүхдийн тоо													
0	6.2	23.2	6.4	6.3	29.4	12.5	7.7	0.7	7.4	0.1	0.0	100.0	1567
1	5.8	23.6	7.8	6.6	25.6	13.2	8.6	0.9	5.7	0.2	0.0	100.0	1910
2	5.9	21.6	6.7	5.0	27.3	17.7	8.6	1.3	5.7	0.2	0.0	100.0	2754
3	4.0	15.8	5.9	3.2	24.5	27.3	10.5	1.8	6.9	0.1	0.0	100.0	1805
4+	3.8	8.8	5.0	1.8	19.8	38.5	12.0	1.4	8.8	0.1	0.0	100.0	1086
Гэрээлтийн байдал													
Гэрлэж	5.8	19.7	6.3	4.1	24.3	23.2	9.5	1.3	5.6	0.2	0.0	100.0	6769
Гэрлэж байсан	5.8	16.3	8.3	7.4	30.8	9.7	9.4	1.3	10.9	0.0	0.0	100.0	943
Огт гэрлээгүй	5.4	21.4	6.2	6.7	30.1	13.0	7.8	0.8	8.4	0.2	0.0	100.0	1410
Боловсрол													
Боловсролгүй	0.0	0.0	1.8	0.0	7.4	73.9	10.4	0.0	6.5	0.0	0.0	100.0	334
Бага	0.5	0.0	2.1	0.0	10.1	68.5	11.6	1.0	6.2	0.0	0.0	100.0	407
Суурь	0.5	1.0	3.7	0.9	22.2	46.9	12.5	0.9	11.5	0.0	0.0	100.0	1331
Бүрэн дунд	2.2	4.3	6.7	3.7	40.5	18.5	12.8	2.0	9.2	0.0	0.0	100.0	2273
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	2.8	4.8	8.3	3.6	34.6	18.4	14.8	1.4	11.1	0.2	0.0	100.0	1093
Дээд	11.7	44.1	7.8	8.3	19.0	2.1	3.9	1.0	1.9	0.3	0.0	100.0	3684
Өрхийн аж байдалын түвшин													
Дотоо	0.3	1.0	0.8	0.2	4.9	83.2	6.9	0.1	2.5	0.0	0.0	100.0	1745
Дунджаа доогуур	1.4	8.5	7.9	3.2	30.9	16.5	17.2	1.0	13.6	0.0	0.0	100.0	1554
Дундаж	3.7	19.5	8.6	5.6	32.6	5.7	12.1	1.9	10.3	0.0	0.0	100.0	1755
Дунджаа дээгүүр	6.9	27.5	7.0	6.9	33.6	1.7	8.3	2.0	5.8	0.2	0.0	100.0	1992
Дээгүүр	14.0	36.1	7.9	7.3	26.6	0.3	3.7	1.2	2.5	0.4	0.0	100.0	2076
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*													
Халх	5.9	19.8	6.8	5.1	27.0	17.9	9.5	1.3	6.6	0.2	0.0	100.0	7479
Каах	2.6	23.6	4.2	2.0	17.5	33.2	9.1	1.3	6.4	0.0	0.0	100.0	257
Бусад	5.1	17.9	5.1	4.0	21.5	30.4	7.9	1.1	6.9	0.1	0.0	100.0	1372

* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь харуулагдаагүй 15 ажиллагч (жинлэггүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт 11.10.М: Эргэлтнүүдийн эрхлсэн ажил

Судалгааны өмнөх 12 сарын хугацаанд ажил эрхлсэн 15-49(54) насны эргэлтнүүдийн хувь, эрхлсэн ажил мэргэжлэр, Монгол Улс, 2013 он

	Мөнгө	Мэргэ-жилтэн	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	Комгор, үйлчилгээний ажилтан	Хуацаа, үйлчилгээний ажилтан	Ажил мэргэжлийн ангилал			Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	Энгийн ажил, мэргэжил	Зөвсөгт хүчний ажил, мэргэжил	Хариулаагүй	Дүн	Судалгааны өмнөх 12 сард ажил эрхлсэн эргэлтнүүдийн тоо
						Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан						
Бүгд (15-49)	5.5	9.4	2.6	1.1	11.8	24.9	16.2	14.7	12.7	1.1	0.0	100.0	4776	
Бүгд (15-54)	5.8	9.6	2.5	1.1	11.7	24.9	16.2	14.5	12.7	1.1	0.0	100.0	5210	
Бүс														
Баруун	2.4	6.9	1.2	0.6	5.6	47.2	8.2	9.1	18.1	0.5	0.1	100.0	644	
Хангай	2.4	6.3	2.0	1.1	5.9	50.2	13.1	9.1	9.2	0.6	0.0	100.0	982	
Төв	3.1	5.5	3.1	0.6	8.4	30.0	14.7	18.4	14.9	1.3	0.0	100.0	814	
Зүүн	2.7	4.8	1.8	0.3	8.6	36.9	16.0	15.1	12.8	1.1	0.0	100.0	335	
Улаанбаатар	9.6	14.0	3.2	1.6	18.5	1.2	20.8	17.8	11.7	1.6	0.0	100.0	2001	
Хот, хотлоо														
Хот	7.6	13.3	3.5	1.5	16.4	2.9	21.2	18.8	13.2	1.6	0.0	100.0	2969	
Хөдөө	2.2	3.0	1.1	0.4	4.2	61.0	7.8	8.1	11.7	0.4	0.0	100.0	1806	
Байршил														
Нийслэл	9.6	14.0	3.2	1.6	18.5	1.2	20.8	17.8	11.7	1.6	0.0	100.0	2001	
Аймгийн төв	3.4	11.7	4.1	1.4	12.0	6.5	22.1	20.8	16.4	1.6	0.1	100.0	968	
Сумын төв	5.1	6.3	2.9	1.4	8.1	22.8	16.2	18.7	17.4	1.1	0.0	100.0	505	
Хөдөө	1.1	1.8	0.4	0.1	2.7	75.8	4.6	4.0	9.5	0.1	0.0	100.0	1302	
Насны бүлэг														
15-19	0.0	2.5	0.4	0.5	11.8	33.6	13.5	5.0	31.3	1.3	0.0	100.0	357	
20-24	6.1	11.9	4.2	1.8	11.6	18.9	16.5	11.4	16.4	1.3	0.0	100.0	657	
25-29	7.6	15.7	3.1	1.5	11.5	20.1	16.5	11.6	10.7	1.6	0.0	100.0	879	
30-34	4.9	10.5	3.4	1.0	9.5	27.5	14.5	17.8	9.6	1.3	0.0	100.0	771	
35-39	4.7	7.8	1.3	0.6	12.3	26.9	17.4	18.2	9.6	1.1	0.0	100.0	801	
40-44	6.8	7.0	1.9	1.1	12.7	25.4	16.1	17.6	10.5	0.8	0.1	100.0	711	
45-49	5.6	5.1	2.6	1.0	13.5	26.6	17.4	16.9	10.9	0.4	0.0	100.0	600	
Амьд байгаа хүүхдийн тоо														
0	4.5	9.3	2.4	1.1	11.5	25.6	14.9	10.1	19.3	1.2	0.0	100.0	1358	
1	8.7	13.1	16.2	1.0	13.0	19.0	19.0	15.2	9.5	1.3	0.0	100.0	928	
2	5.6	9.9	3.3	1.2	12.9	20.8	16.6	19.4	9.4	1.0	0.0	100.0	1266	
3	4.2	7.6	1.2	1.4	11.3	32.7	15.4	15.5	9.1	1.3	0.1	100.0	801	
4+	4.2	3.7	2.6	0.6	7.4	39.2	13.7	13.1	14.8	0.7	0.0	100.0	423	
Гэрлэлтийн байдал														
Гэрлэсэн	6.3	9.4	2.5	1.1	12.1	25.0	16.4	16.4	9.7	1.1	0.0	100.0	3440	
Гэрлэж байсан	7.0	11.0	1.8	0.0	8.2	14.8	20.0	20.1	17.1	0.0	0.0	100.0	198	
Огт гэрлээгүй	3.1	9.0	2.8	1.2	11.5	26.5	14.9	8.9	20.9	1.4	0.0	100.0	1138	
Боловсрол*														
Боловсролгүй	0.0	0.8	0.2	0.0	2.3	66.1	9.4	6.2	14.8	0.2	0.0	100.0	382	
Бага	0.6	1.6	0.4	0.0	2.4	58.8	11.5	8.9	15.7	0.1	0.0	100.0	443	
Суурь	1.0	1.4	0.9	0.2	9.4	38.6	16.0	15.8	16.3	0.3	0.0	100.0	1080	
Бүрэн дунд	5.1	3.6	2.3	1.1	16.7	12.4	21.3	21.3	15.1	1.1	0.1	100.0	1163	
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	2.1	4.1	3.0	0.2	15.1	13.8	26.6	19.5	13.9	1.7	0.0	100.0	596	
Дээд	16.1	32.2	5.9	3.3	14.2	2.9	9.5	9.6	4.0	2.4	0.0	100.0	1112	
Өрхийн аж байдалын түвшин														
Доогуур	0.2	1.0	0.1	0.0	1.1	85.6	1.8	2.3	7.7	0.1	0.0	100.0	1043	
Дунджаас доогуур	2.2	4.0	0.8	0.6	8.9	20.7	26.2	14.7	21.3	0.6	0.0	100.0	892	
Дундаж	3.5	6.5	3.0	1.7	13.8	9.0	21.6	20.9	18.6	1.2	0.1	100.0	893	
Дунджаас дээгүүр	5.9	12.3	3.5	1.6	16.5	2.4	22.4	22.4	10.9	2.0	0.0	100.0	1030	
Дээгүүр	16.5	23.8	5.5	1.6	19.4	0.6	10.4	14.4	6.1	1.8	0.0	100.0	917	
Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа**														
Халх	5.9	9.5	2.7	1.3	12.5	22.8	17.1	15.3	11.6	1.2	0.0	100.0	3861	
Казак	2.7	10.7	0.7	0.0	9.5	29.5	7.6	9.3	30.0	0.0	0.0	100.0	164	
Бусад	4.5	8.5	2.3	0.4	8.5	34.3	13.2	13.2	14.2	1.1	0.0	100.0	744	

** "Боловсрол" нь харуулагдаагүй 1 ажиглалт (жингнээгүй)-ыг харуулаагүй.

*** "Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа" нь харуулагдаагүй 11 ажиглалт (жингнээгүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт НН.11: Эмэгтэйчүүдийн эрхэлсэн ажил, сонгосон үзүүлэлтээр

Судалгааны өмнөх 12 сарын хугацаанд ажил эрхэлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, ажил олгогч, эдийн засгийн идэвх, эрхэлж буй ажлын төрлөөр (хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус), Монгол Улс, 2013 он

	Судалгааны өмнөх 12 сард эрхэлсэн ажил		Бүгд
	Хөдөө, аж ахуйн	Хөдөө аж, ахуйн бус	
Ажил олгогч			
Гэр бүлийн гишүүн	58.9	9.6	19.6
Бусад хэн нэгэн	3.9	72.2	58.4
Өөрөө	37.2	18.2	22.0
Дүн	100.0	100.0	100.0
Эдийн засгийн идэвх			
Байнгын ажил	88.4	75.4	78.1
Улирлын чанартай	8.0	7.3	7.4
Түр ажил	3.7	17.3	14.5
Дүн	100.0	100.0	100.0
Судалгааны өмнөх 12 сард ажил эрхэлсэн эмэгтэйчүүдийн тоо	1847	7275	9122

IV БҮЛЭГ

УС БОЛОН АРИУН
ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ

IV

Аюулгүй ундны усны хэрэглээ нь хүн амын үндсэн хэрэгцээ мөн. Бохирдсон ундны ус нь нүдний халдварт өвчин, холер, гэдэсний хижиг зэрэг халдварт өвчний нянг тээж байдаг бөгөөд дээрх өвчнийг тархаах аюултай. Мөн ундны ус нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хими, физикийн болон цацраг идэвхт бодисоор бохирдсон байх нь бий. Ийнхүү ундны усны хангамжийн асуудлыг эрүүл мэндэд үзүүлэх нөлөөгөөр нь авч үзэхээс гадна хол газраас, хүнд хүчир нөхцөлд ундны усаа зөөх үндсэн үүрэг, ялангуяа, хөдөөгийн хүүхэд, эмэгтэйчүүдэд ногдох хандлагатай байдаг тул энэ асуудлыг мөн авч үзэх шаардлага тулгардаг.

Баталгаат ундны ус болон ариун цэврийн байгууламж хэрэглэх боломжгүй хүн амын хувийг 2015 он гэхэд 2 дахин бууруулах зорилтыг МХЗ-д тусгасан. Мөн “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” тунхаглалын хүрээнд уг үзүүлэлтийг гуравны нэгээр бууруулах зорилт дэвшүүлсэн.

“НҮТС-2013” судалгааны үр дүнд ус болон ариун цэврийн байгууламжийн хангамжтай холбоотой дараах үзүүлэлтийг тооцсон.

Ус хангамж:

- Ундны усны сайжруулсан эх үүсвэрийн хэрэглээ
- Ус цэвэршүүлэх тохиромжтой аргын хэрэглээ
- Ундны ус авахад зарцуулдаг дундаж хугацаа
- Ундны ус авдаг хүн

Ариун цэврийн байгууламж:

- Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хангамж
- Хүүхдийн ялгадсыг зохистой байдлаар зайлуулсан байдал

*** Өрхийн түргүүлэгчийн үндэс угсаа" нь харуулагдаагүй 33 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

V БҮЛЭГ

БИЧИГ ҮСГИЙН
ТАЙЛАГДАЛТ БА
БОЛОВСРОЛ



Залуучуудын бичиг үсэг тайлагдалт

Сүүлийн 10 жилийн хугацаанд, залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшин нь бага боловсролын үр дүнг илэрхийлж байна. Бага боловсролын системийн үр нөлөөг хэмжих талаас нь авч үзвэл уг үзүүлэлт нь нийгмийн хөгжил дэвшил болон эдийн засгийн ололт, амжилтыг төлөөлөх үзүүлэлт болдог. НҮТС-нд бичиг үсэг тайлагдалтын үзүүлэлтийг 15-24 насны залуучуудын хувьд тооцсон. Бичиг үсэг тайлагдалтыг тооцоход богино хэмжээний өгүүлбэр уншиж чадаж байгаа эсэх болон сургуульд хамрагдсан талаарх мэдээллийг ашиглав.

Бичиг үсэг тайлагдалтын хувь нь тухайн насны нийт хүн амд эзлэх бичиг үсэг тайлагдсан хүн амын хувиар илэрхийлэгддэг бөгөөд энэхүү үзүүлэлтийг Хүснэгт ED.1, ED1M-д харуулав. Монгол Улсын 15-24 насны эрэгтэйчүүдийн 95.2 хувь, эмэгтэйчүүдийн 97.5 хувь нь бичиг үсэг тайлагдсан байна. Үүнийг ХХС-2010 (эрэгтэй 95.8 хувь, эмэгтэй 97.9 хувь) харьцуулахад төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Бичиг үсэг тайлагдалт хот, хөдөө, бүс болон өрхийн аж байдлын түвшнээс хамаараад ялгаатай байна. Тухайлбал, хотын залуучууд бараг бүгд (эрэгтэй 98.4 хувь, эмэгтэй 99.2 хувь) бичиг үсэг мэддэг бол хөдөөгийн эрэгтэйчүүдийн 88.2 хувь, эмэгтэйчүүдийн 92.9 хувь нь бичиг үсэг мэддэг байна.

15-24 насны боловсролгүй залуучуудын ойролцоогоор гуравны нэг орчим нь (эмэгтэйчүүдийн 28.4 хувь, эрэгтэйчүүдийн 29.3 хувь), харин бага боловсролтой залуу эмэгтэйчүүдийн 62.9 хувь, залуу эрэгтэйчүүдийн 66.7 хувь нь бичиг үсэг мэдэж байна. Бичиг үсэг тайлагдалтыг бүсээр авч үзэхэд Баруун, Хангай, Зүүн бүсийн залуучуудын бичиг үсгийн мэдлэг бусдаасаа доогуур байна. Өрхийн аж байдлын түвшнээр авч үзвэл, дээгүүр аж байдалтай өрхийн 15-24 насны бараг бүх залуу эмэгтэйчүүд (99.7 хувь), эрэгтэйчүүд (100 хувь) бичиг үсгийн мэдлэгтэй байхад доогуур аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн 87.9 хувь, эрэгтэйчүүдийн 84.4 хувь нь бичиг үсэг мэддэг байв.

Сургуульд бэлтгэгдсэн байдал

Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-ын хөтөлбөр нь бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, тэдний сургуульд элсэн суралцах бэлтгэлийг хангахад чухал нөлөө үзүүлдэг. Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн 1 дүгээр ангийн сурагчдаас сургуульд орохын өмнөх жилд буюу өнгөрсөн хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн хувийг хүснэгт ED.2-т харуулав.

Хүснэгт ED.2-оос харахад ЕБС-ийн 1 дүгээр ангид элсэн суралцаж байгаа нийт хүүхдийн 78.8 хувь нь өмнөх хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна. Үүнийг ХХС-2010 үр дүнтэй харьцуулахад 12.2 пунктээр буурчээ. Сургуульд бэлтгэгдсэн байдал охид, хөвгүүдийн хувьд төдийлөн ялгаагүй байна. Харин хот, хөдөө, бүс болон өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай байгаа нь ажиглагдлаа. Тухайлбал, хотын 1 дүгээр ангид сурч байгаа хүүхдүүдийн 86.4 хувь нь өмнөх хичээлийн жилд СӨБ-д хамрагдсан байхад уг үзүүлэлт хөдөөд 67.9 хувь байна. Бүсээр авч үзвэл нэлээд ялгаатай байдал ажиглагдсан бөгөөд Улаанбаатар хотод уг үзүүлэлт хамгийн өндөр (86.6 хувь), Баруун бүсэд хамгийн бага (54.3 хувь) байв.

Доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдал (63.0 хувь) дээгүүр түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийнхээс (93.5 хувь) 1.5 дахин доогуур байна. Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал эхийн боловсролын түвшнээс шууд хамаарч байгаа юм. Тодруулбал, боловсролгүй эхийн хүүхдийн 61.4 хувь нь сургуульд орохоосоо өмнө СӨБ-д хамрагдсан байхад уг үзүүлэлт дээд боловсролтой эхийн хүүхдүүдийн хувьд нэмэгдээд 90.0 хувьтай байлаа. Казах өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт улсын дунджаас 37.8 пунктээр доогуур байна.

Бага, дунд, ахлах анги, дээд боловсролд хамрагдалт

Бүх нийтийн боловсролын хүртээмж, хүүхдэд суурь боловсрол олгох нь Мянганы хөгжлийн зорилт болон “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” тунхаглалын нэн чухал зорилтын нэг юм. Боловсрол нь ядуурлыг бууруулах, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах, хүүхдийг хөдөлмөр, түүний аюултай, тэвчишгүй хүнд хэлбэр болон хүчирхийллээс хамгаалах, хүний эрх, ардчиллыг хөгжүүлэх, хүн амын өсөлтийг хангах, байгаль орчноо хамгаалах зэрэг олон зүйлийн чухал нөхцөл болж өгдөг.

Судалгаанаас гарч байгаа бага, суурь боловсролд хамрагдалтыг дараах үзүүлэлтүүдээр хэмжиж болно. Үүнд:

- Элсэлтийн цэвэр жин (1 дүгээр анги)
- Бага ангийн хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)
- Дунд ангийн хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)
- Бага, бүрэн дунд боловсролд сурч буй охид, хөвгүүдийн хүйсийн харьцаа (хүйсийн тэгш байдлын индекс)

Сурах үйл явцыг дараах үзүүлэлтүүдээр хэмжиж болно. Үүнд:

- 1 дүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртлээ тасралтгүй суралцсан хүүхдийн хувь
- Бага боловсрол эзэмшилтийн бохир жин
- Бага ангиас дунд ангид шилжин суралцсан хүүхдийн хувь

Манай улсын хувьд боловсролын тогтолцоонд шинэчлэл хийгдэж байгаагай холбоотойгоор дараах үзүүлэлтийг нэмж тооцов. Үүнд:

- Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)
- Ахлах ангийн хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)
- Дээд боловсролд (их, дээд сургууль/ коллежид) хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)
- Ахлах анги, техникийн болон мэргэжлийн сургууль, дээд боловсролд (их, дээд сургууль/ коллежид) сурч буй охид, хөвгүүдийн хүйсийн харьцаа (хүйсийн тэгш байдлын индекс).

Монгол Улсын “Боловсролын тухай” хуульд 2012 онд өөрчлөлт орж бага ангид хамрагдах нас 6-10, дунд ангид хамрагдах нас 11-14, ахлах ангид хамрагдах нас 15-17 болсон. Өөрөөр хэлбэл, бага ангид орох нас 6 (2008 оноос хойш), дунд ангид орох нас 11 юм. Түүнчлэн бага анги 5 жил буюу 1-5 дугаар анги, дунд анги 4 жил 6-9 дүгээр анги байдаг. Манай улсын хувьд хичээлийн жил 9 сараас 6 сар хүртэл үргэлжилдэг билээ.

Манай улсын 1 дүгээр ангид элсэн орох насны нийт хүүхдийн 94.5 хувь нь ЕБС-ийн 1 дүгээр ангид суралцаж байна (Хүснэгт ED.3). Энэ нь 2010 оны Хүүхэд хөгжил судалгаатай харьцуулахад 13.5 хувь өссөн үр дүн юм. Сургуульд элсэлт хүйс, хот, хөдөө болон байршлаар төдийлөн ялгаагүй байгаа хэдий ч бүсээр ялгаатай дүр зураг ажиглагдлаа. Нэгдүгээр ангид элсэн орсон хүүхдийн хувь Баруун (90.0 хувь) болон Хангайн бүсэд (92.9 хувь) бусад бүсээс ялимгүй доогуур (Төвийн бүс 95.8 хувь, Зүүн бүс 96.4 хувь, Улаанбаатар хотод 96.3 хувь) байна. Доогуур аж байдалтай өрхийн хүүхдийн 89.1 хувь нь 1 дүгээр ангид элссэн нь бусад түвшний аж байдалтай өрхүүдээс 5.7-9.4 пунктээр бага байна. Эхийн боловсролын түвшнээр авч үзвэл, боловсролгүй эхчүүдийн 6 настай хүүхдүүдийн 88.7 хувь нь 1 дүгээр ангид суралцаж байгаа нь улсын түвшнээс 6 пунктээр доогуур байгаа юм. Казах тэргүүлэгчтэй өрхийн хүүхдүүдийн (78.9 хувь) дунд уг үзүүлэлт доогуур түвшинтэй байлаа.

Хүснэгт ED.4-т бага ангид сурах насны (6-10 нас) хүүхдүүдээс бага ангид сурч байгаа хүүхдийн хувь¹, СӨБ-д хамрагдаж байгаа хүүхдийн хувь болон сургуулийн гадна байгаа буюу сургуульд хамрагдаагүй хүүхдийн хувийг харуулсан. Судалгаагаар 6-10 насны нийт хүүхдийн 98.1 хувь нь бага боловсролд хамрагдаж, харин 1.8 хувь нь сургуулийн гадна байна. Сургуулийн гадна байгаа хүүхдүүдээс 0.6 хувь нь СӨБ-д хамрагдаж байгаа бол 1.2 хувь нь ЕБС болон СӨБ-ын аль алинд хамрагдаагүй дүн гарчээ. Бага боловсролд хамрагдалт охид, хөвгүүдийн хувьд бараг ялгаагүй (охид 97.7 хувь, хөвгүүд 98.5 хувь) байна. Мөн уг үзүүлэлт хот, хөдөөд ялгаагүй ижил буюу харгалзан 98.5 болон 97.5 хувь байв. Бага боловсролд хамрагдалтын түвшин нийгэм, эдийн засгийн шинж байдлаар ялгаа бага байгаа нь үндэсний

¹Энэ үзүүлэлтийг “тодотгосон” гэж тодотгож байгаа нь уг үзүүлэлтийн хуваарьт бага боловсролд сурч байгаа хүүхдүүдээс гадна бүрэн дунд боловсролд сурч байгаа хүүхдүүдийг оруулсантай холбоотой.

хэмжээнд боловсролд хамрагдалтын түвшин харьцангуй өндөр байгаатай холбоотой юм.


Дунд ангийн хамран сургалтын хувийг Хүснэгт ED.5-д харуулав. Судалгааны дүнгээс үзэхэд дунд ангид суралцах насны буюу 11-16 насны хүүхдүүдийн 92.9 хувь нь зохих шатны боловсролд, 3.0 хувь нь бага боловсролд хамрагдаж байгаа бол 4.0 хувь нь боловсролд хамрагдаагүй сургуулийн гадна байна. Хүснэгтээс харахад дунд ангийн хамран сургалтын цэвэр (тодотгосон) жин охид (95.0 хувь) хөвгүүдийн (90.2 хувь) хувьд багагүй ялгаатай байв. Ялангуяа, сургуулийн гадна байгаа хөвгүүдийн хувь (5.9 хувь) охидынхоос (2.0 хувь) харьцангуй өндөр байна. Дунд ангийн хамран сургалтын цэвэр жинг хичээлийн жил эхлэх үеийн насаар ангилж үзвэл 14 насанд 96.9 хувь байхад 11 насанд хамгийн бага буюу 85.3 хувь байлаа. Бага боловсролын хамран сургалтын цэвэр (тодотгосон) жинтэй адилаар дунд ангийн хамран сургалтын цэвэр (тодотгосон) жин эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшинтэй хамааралтай байгаа юм.

Суурь боловсролд хамрагдалтын цэвэр жин (тодотгосон)-г суурь боловсролд хамрагдах буюу 6-14 насны бага, дунд, ахлах ангид сурч байгаа хүүхдүүдийн хувиар тодорхойлж, Хүснэгт ED.5A-д үр дүнг харуулав.

Харин ахлах ангид хамрагдалтын цэвэр жин (тодотгосон)-г 15-17 насны ахлах анги түүнээс дээш түвшинд сурч байгаа хүүхдүүдийн хувиар, дээд боловсрол буюу их, дээд сургууль/ коллежид хамрагдалтын цэвэр жин (тодотгосон)-г 18-24 насны их дээд сургуульд сурч байгаа болон суралцаж төгссөн залуучуудын хувиар тодорхойлон хүснэгт ED5B, ED5C харуулав. 15-17 насны нийт хүүхдийн 84.8 хувь нь ЕБС-ийн ахлах ангид сурч байгаа бол 4.9 хувь нь дунд ангид сурч байна (Хүснэгт ED.5B). Харин 18-24 насны залуучуудын дээд боловсролд хамрагдалт 50.9 хувь байгаа боловч тухайн насныхны 13.0 хувь нь ЕБС-ийн ахлах анги болон МСҮТ-д суралцаж байгааг хүснэгт ED.5C-ээс харж болно.

Зураг ED.1-д сургуульд хамрагдалтын цэвэр жинг боловсролын шатлалаар харууллаа. Бага болон суурь боловсролд хамрагдалт 98.1 хувь, бүрэн дунд боловсролд хамрагдалт бага зэрэг бага буюу 93.5 хувь байсан бол дээд боловсролд хамрагдалт 50.9 хувь гарчээ.

Зураг ED.1A. Сургуульд хамран сургалтын цэвэр жин (хувь), боловсролын шатлалаар, Монгол Улс, 2013 он



1 дүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл тасралтгүй анги дэвшин суралцсан хүүхдийн хувийг анги бүрээр Хүснэгт ED.6-д харуулав. Судалгааны дүнгээр 1 дүгээр ангид элсэн орсон хүүхдүүдийн дийлэнх (98.1 хувь) нь 5 дугаар анги хүртэл дэвшин суралцаж байгаа бөгөөд энэ нь хотод 98.7 хувь, хөдөөд 97.6 хувьтай байна.

НҮТС-гаар нэг үе буюу үелрэл хүн амын сургуульд хамрагдаж буй байдлыг 5 жилийн хугацаанд даган судлах боломжгүй тул судалгааны үеийн болон өмнөх хичээлийн жилд сургуульд хамрагдсан эсэх асуултыг асуусан. Иймээс уг үзүүлэлтийг бага ангийн 1 дүгээр ангид орсон хүүхдүүдийг 5 дугаар анги хүрэх бодит үелрэлийг ашиглан тооцохын оронд бага ангийн 1 дүгээр ангиас сүүлийн анги хүртэл дэвшин суралцах өсөн нэмэгдэх магадлалыг ашиглан тооцож гаргадаг. Улиран сурагчдыг тооцоонд оруулаагүй, учир нь тэднийг төгсөх эсэхийг мэдэх боломжгүй. Жишээлбэл, 1 дүгээр ангиас 2 ангид

дэвшин суралцах магадлалыг 1 дүгээр ангиас 2 ангид дэвшин суралцсан (судалгаанд хамрагдсан дараалсан 2 жилийн хугацаанд) хүүхдийг 1 дүгээр ангиас 2 ангид дэвшин суралцсан болон өмнөх хичээлийн жилд 1 дүгээр ангид суралцаж байсан боловч сургуулиас завсардсан хүүхдийн тоонд харьцуулж тооцдог. Үзүүлэлтийн хүртвэр, хуваарийн аль алинд судалгааны тооцож буй 2 жилийн хугацаанд улиран суралцсан хүүхдийг оруулаагүй. Хүснэгтээс харахад уг үзүүлэлт хүйс, бүс болон өрхийн аж байдлын түвшнээр төдийлөн ялгаагүй байна.

Бага боловсрол эзэмшилтийн хувь болон дунд ангид дэвшин суралцсан хүүхдийн хувийг хүснэгт ED.7-д харуулав. Бага боловсрол эзэмшилтийн хувийг нас харгалзахгүйгээр бага боловсрол эзэмшин төгссөн хүүхдийн тоог бага сургууль төгсөх насны нийт хүүхдийн тоонд харьцуулж тооцдог.

Судалгааны дүнгээр бага боловсрол эзэмшилтийн бохир жин 109.7 хувьтай байна (Хүснэгт ED.7). Уг үзүүлэлт 100-аас нэлээд зөрүүтэй гарч байгаа нь 2008/2009 оны хичээлийн жилд 6, 7 настай хүүхдийг сургуульд элсүүлсэнтэй холбоотой юм. Энэ үзүүлэлт хүйсээр (эрэгтэй 108.8 хувь, эмэгтэй 110.7 хувь) төдийлөн ялгаагүй байна. Харин хотын (117.1 хувь) хүүхдүүдийн бага боловсрол эзэмшилт хөдөөгийн (99.0 хувь) хүүхдүүдийнхээс 18.0 пунктээр илүү байв. Бага боловсрол төгсөлтийн хувь нь бүс болон өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай байгааг хүснэгтээс харж болно.

Хүснэгт ED.7-оос харахад судалгаанаас өмнөх жилд бага боловсролын төгсөх анги буюу 5 дугаар ангид суралцаж байсан хүүхдүүдийн 98.4 хувь нь судалгааны үед дунд ангид дэвшин суралцсан байв. Хүснэгтэд бага ангийн сүүлийн ангид улиран суралцагчдыг оруулсан "үр дүнтэй" шилжилтийн хувийг мөн харуулсан. Уг үзүүлэлт нь бага ангийн сүүлийн ангид улиран суралцсан ч эцэст нь дунд ангид дэвшин суралцсан хүүхдүүдийг харуулсан. Энгийн шилжилтийн түвшин нь улиран суралцагчид нь дунд ангид хэзээ ч дэвшин сурахгүй гэж төсөөлдгөөрөө дунд ангид дэвшин суралцахыг дутуу тооцох хандлагатай байдаг. Бага ангийн сүүлийн ангид суралцаж байгаа хүүхдүүдийн 99.7 хувь нь дунд ангид дэвшин суралцахаар байгааг хүснэгтээс харж болно. Анги дэвшин суралцах нь хүүхдийн хүн ам зүй болон нийгэм эдийн засгийн шинж байдлаар төдийлөн ялгаагүй байгаа юм. Харин бүсээр авч үзэхэд Баруун бүсэд дунд ангид дэвшин суралцсан хүүхдийн хувь бусад бүстэй харьцуулахад доогуур буюу 95.6 хувь байна.

Бага, дунд ангид суралцагчдын хүйсийн харьцааг хүснэгт ED.8-д үзүүлэв. Монгол Улсын хувьд суурь боловсролын хувьд дээрх үзүүлэлтийг нэмж тооцож хүснэгтэд харуулсан бөгөөд суурь боловсрол гэдэгт бага болон дунд ангийг оруулсан. Энэхүү харьцааг хүйсийн тэгш байдлын индекс гэж нэрлэдэг. Суралцагчдын хүйсийн тэгш байдлын индексийг хамрагдалтын цэвэр жингээс тооцдог. Учир нь хамрагдалтын бохир жингээс хүйсийн тэгш байдлын индексийг тооцоход алдаа гарах магадлалтай. Тухайлбал, бага боловсролд хамрагдаж буй бага боловсролын нас хэтэрсэн хүүхдүүдийн дийлэнх нь хөвгүүд байдагтай холбоотой юм.

Хүйсийн тэгш байдлын индекс бага ангид 1.01, суурь боловсролд 1.01 байгаа бөгөөд хүйсээр ялгаагүй байгааг хүснэгтээс харж болно. Харин дунд ангид суралцагчдын хувьд дээрх үзүүлэлт 1.02 байгаа бөгөөд энэ нь дунд ангид хамрагдаж байгаа 100 хөвгүүдэд 102 охид ногдож байна гэсэн үг юм. Боловсролын шатлал нэмэгдэх тутам охидын сургуульд хамрагдалт нэмэгдэж байна.

Бага, суурь боловсролоор тооцсон жендэрийн тэгш байдлын индекс хот, хөдөө, байршил, эхийн боловсрол, өрхийн аж байдлаар төдийлөн ялгаагүй байлаа. Харин бүрэн дунд боловсролын хувьд төв суурингаас хөдөө рүү алслагдахад (1.01-1.03) индексийн утга нэмэгдэж, харин эхийн боловсролын түвшин (1.05-1.01), өрхийн аж байдал сайжрахад (1.04-1.00) буурч байлаа.

Хүснэгт ED.8A-аас харахад хүйсийн тэгш байдлын индекс ахлах ангийн хувьд 1.14, дээд боловсролын хувьд 1.40 байв. Өөрөөр хэлбэл, ахлах анги эсвэл дээд сургуульд суралцаж буй 100 эрэгтэй тутамд харгалзан 114 болон 140 эмэгтэй ногдож байна. Боловсролын түвшин ахих тутам охидын хамран сургалт нэмэгдэж байлаа. Харин техникийн болон мэргэжлийн сургуульд суралцагчдын хувьд ялгаатай дүр зураг ажиглагдсан бөгөөд 100 эрэгтэйд 73 эмэгтэй ногдож байв. Энэ нь МСҮТ-д ихэвчлэн эрэгтэйчүүд суралцаж байгааг харуулж байна. Ахлах анги, мэргэжлийн болон дээд боловсролд хамрагдаж байгаа залуучуудын дунд ч гэсэн жендэрийн тэгш байдлын индекс өрхийн аж байдлын түвшинтэй урвуу хамааралтай ажиглагдлаа.

Ахлах ангийн хувьд уг үзүүлэлт Төвийн бүсэд (1.28) нэлээд өндөр, эхийн боловсролын түвшин буурах тусам нэмэгдэж байгаа нь анхаарал татаж байна. Баруун бүсэд (1.06) техникийн болон мэргэжлийн сургуульд суралцагчдын дунд эмэгтэйчүүд илүү байгаа нь бусад бүс, улсын дунджаас эрс ялгаатай

гарчээ. Харин Хангайн бүсэд (2.21) их, дээд сургууль/ коллежид хамрагдаж байгаа, дээд боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.2 дахин илүү байна. Улаанбаатар хотод уг үзүүлэлт (1.21) хамгийн бага байна.

Бага болон дунд ангид хамрагдах насны сургуулийн гадна байгаа буюу сургуульд хамрагдаагүй хүүхдийн дунд охидын эзлэх хувийг Хүснэгт ED.9-д харууллаа. Бага ангид суралцах насны сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн 38.4 хувь нь охид бөгөөд хот хөдөөд ижил байна. Харин дунд ангид суралцах насны сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн 29.0 хувь нь охид бөгөөд энэ үзүүлэлт хөдөөд 23.1 хувь, хотод 40.9 хувь байна. Үүнээс харахад сургууль завсардаж байгаа хүүхдүүдийн дийлэнх нь хөвгүүд ажээ.

Зураг ED.1-д энэ бүлэгт орсон боловсролын үзүүлэлтүүдийг нэгтгэн хүйсээр харууллаа. Бага насны хүүхдийн хөгжил (8 дугаар) бүлгийн Хүснэгт CD.1-т орсон сургуулийн өмнөх боловсролын хамралтын хувийг мөн үзүүлсэн.

Зураг ED.1: Боловсролын үзүүлэлтүүд хүйсээр, Монгол Улс, 2013 он

Сургуульд бэлтгэгдсэн байдал									
78	80								
1-р ангид элсэлтийн түвшин		Бага боловсрол эзэмшилтийн		Дунд ангид дэвшин суралцсан					
94	95	109	111	98	99				
Сургуулийн өмнөх боловсролд		Бага ангийн хамран сургалтын хувь				Дунд ангийн хамран сургалтын хувь			
68	68	98 99				93 95			
		1-р ангид элсээд 5-р анги хүртлээ тасралтгүй анги дэвшин суралцах магадлал							
		97 99							
						Хөвгүүд Охид			

Тэмдэглэл: Бүх үзүүлэлт хувиар илэрхийлэгдсэн.

Боловсролын түвшин, суралцсан хугацаа

Боловсрол бол хувь хүний хөгжлийн болон улс үндэстний хөгжлийг хөдөлгөгч чухал хүчин зүйлсийн нэг юм. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт: "Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ" гэж заасан бол Боловсролын салбарыг 2021 он хүртэл хэрэгжүүлэх "БОЛОВСРОЛ" үндэсний хөтөлбөрт боловсролын шинэчлэлийн онцлогийг: "бүх шатны боловсролын тогтолцоог нийгмийн шинэ шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжлийг нь хангах, боловсролын үйлчилгээний хүртээмжид баримжаалсан бодлогоос чанар, үр өгөөжийг нь дээшлүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлэх бодлогод шилжих" гэж тодорхойлсон байна.

Судалгаанд өрхөд бүртгэгдсэн 5 ба түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшинг тодорхойлох асуултуудыг оруулсан. Монгол Улсын "Боловсролын тухай" хуулиар ерөнхий боловсролын сургуульд 6 настай хүүхдийг элсүүлэн сургадаг учраас Хүснэгт ED.10-д зургаа ба түүнээс дээш настай хүн амын боловсролын түвшин, суралцсан голч хугацааг тооцож харуулав. Хүн амын суралцсан голч хугацааг анх удаа тооцож байгаа бөгөөд уг үзүүлэлтийг тооцоходоо нэг түвшний боловсрол давтан суусан хугацааг оруулаагүй (улиран суралцсан эсвэл давхар мэргэжил эзэмшихээр их, дээд сургуульд суралцсан хугацааг тооцоогүй) бөгөөд хамгийн дээд түвшний боловсролыг хэдэн жил сурч эзэмшсэнийг харгалзан өмнөх түвшний боловсролын хугацааг мөрдөж байсан боловсролын тогтолцооны дагуу нэмж тооцов.

Монгол Улсын 6 ба түүнээс дээш насны хүн амын 2.9 хувь нь боловсрол эзэмшээгүй буюу аль ч шатны боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй завсардсан бол 27.2 хувь нь бага, 18.7 хувь нь суурь, 18.8 хувь нь бүрэн дунд, 9.7 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд, 22.6 хувь нь дээд

боловсролтой байна. Боловсролгүй, бага боловсролтой хүн амын хувь Баруун бүсэд харгалзан 4.8 хувь, 38.6 хувьтай байгаа нь бусад бүстэй харьцуулахад өндөр, харин Улаанбаатар хотод дээд боловсролтой хүн амын хувь (32.5 хувь) өндөр байна. Хотын хүн амын боловсролын түвшин хөдөөгийнхөөс өндөр юм. Тухайлбал, бүрэн дундаас дээш боловсролтой хүн амын хувь хотод 62.5 хувь байхад хөдөөд 30.9 хувь байна (Хүснэгт ED.10).

Хүн амын боловсролыг насны бүлгээр авч үзвэл ихээхэн ялгаа ажиглагдаж байна (Хүснэгт ED.10). Тухайлбал, боловсролгүй хүн амын хувь 65 ба түүнээс дээш насныхны дунд (15.1 хувь) хамгийн өндөр байна. Бага боловсролтой хүн амын хувь 65, түүнээс дээш насанд 41.1 хувь буюу хамгийн өндөр үзүүлэлттэй бөгөөд нас залуужих тусам буурч 40-44 насанд 3.6 хувь байсан бол 25-39 насанд эргээд өсчээ (12.4-20.2 хувь). Эдгээр насныхан нийгэм, эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдсөн шилжилтийн үед сургууль завсардсан хүмүүс юм.

Ерөнхийдөө 25-40 хүртэлх насны хүн амын дотор техникийн болон мэргэжлийн боловсролтой хүний эзлэх хувь бага байна (Хүснэгт ED.10). Харин 20-24 насанд техникийн болон мэргэжлийн боловсролтой хүний эзлэх хувь 11.2 хувь болж өссөн нь сүүлийн жилүүдэд уул уурхай, барилгын чиглэлийн боловсон хүчний эрэлт нэмэгдсэнтэй холбоотой энэ чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын үр дүн байж болох юм.

Дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувь (26.8 хувь) эрэгтэйчүүдийнхээс (18.1 хувь) өндөр байна (Хүснэгт ED.10). Хүн амын аж байдлын түвшин нэмэгдэх тусам боловсролын түвшин нэмэгдсэн дүр зураг ажиглагдаж байгаа нь зүй ёсны хэрэг юм. Казах тэргүүлэгчтэй өрхийн хүн амын дунд боловсрол эзэмших байдал бага байна. Тухайлбал, казах тэргүүлэгчтэй өрхийн хүн амын дунд дээд боловсролтой хүн амын хувь 16.1 хувь, техникийн болон мэргэжлийн дунд боловсролтой хүн амын хувь 7.4 хувь, бүрэн дунд боловсролтой хүн амын хувь 12.0 хувь байгааг улсын дундажтай харьцуулахад харгалзан 6.5, 2.3, 6.8 пунктээр бага ажээ.

Монгол Улсын 6 ба түүнээс дээш насны нэг хүн дунджаар 9.1 жил боловсролын аль нэг шатлалын сургуульд хамрагдаж, боловсрол эзэмшиж байна (Хүснэгт ED.10). Улаанбаатар хотын хүн ам дунджаар 10.3 жил сурч байгаа нь бусад бүсээс өндөр гарчээ. Энэ үзүүлэлт хотод 10.0 жил, хөдөөд 6.7 жил байна. 20 ба түүнээс дээш насныхны дунд нас ахих тусам суралцсан жил буурах хандлагатай боловч 30-39 насныхны хувьд арай онцлог юм. Эмэгтэйчүүдийн суралцсан голч жил 9.5, эрэгтэйчүүдийнх 8 жил гарчээ. Дээд боловсрол эзэмшиж байгаа хүн дунджаар 14.1 жил суралцаж байна. Өрхийн аж байдлын түвшин хүн амын суралцсан голч хугацаа эерэг хамааралтай гарчээ. Тухайлбал, доогуур аж байдалтай өрхөд амьдардаг хүн амын суралцсан голч хугацаа (6 жилээр) дээгүүр аж байдалтай өрхөд амьдардаг хүн амынхаас (12.7 жил) 2 дахин бага байна.

БИЧИГ ҮСГИЙН ТАЙЛАГДАЛТ БА БОЛОВСРОЛ

Хүснэгт ED.1: Бичиг үсэг тайлагдалт (залуу эмэгтэйчүүд)

Бичиг үсэг тайлагдсан 15-24 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Бичиг үсэг тайлагдсан эмэгтэйчүүдийн хувь ¹	Бичиг үсэг тайлагдаагүй эмэгтэйчүүдийн хувь	15-24 насны эмэгтэйчүүдийн тоо
Бүгд	97.5	0.0	3359
Бүс			
Баруун	94.2	0.0	382
Хангай	95.1	0.0	576
Төв	96.2	0.0	447
Зүүн	95.9	0.0	194
Улаанбаатар	99.5	0.0	1760
Хот, хөдөө			
Хот	99.2	0.0	2452
Хөдөө	92.9	0.0	907
Байршил			
Нийслэл	99.5	0.0	1760
Аймгийн төв	98.4	0.0	692
Сумын төв	98.7	0.0	284
Хөдөө	90.2	0.0	623
Боловсрол*			
Боловсролгүй	28.4	0.0	90
Бага	62.9	0.0	55
Суурь	100.0	0.0	1018
Бүрэн дунд	100.0	0.0	1247
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	100.0	0.0	222
Дээд	100.0	0.0	726
Насны бүлэг			
15-19	98.3	0.0	1595
20-24	96.7	0.0	1765
Өрхийн аж байдлын түвшин			
Доогуур	87.9	0.0	520
Дунджаас доогуур	98.3	0.0	656
Дундаж	98.9	0.0	683
Дунджаас дээгүүр	99.8	0.0	779
Дээгүүр	99.7	0.0	721
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**			
Халх	97.9	0.0	2715
Казах	94.0	0.0	130
Бусад	96.1	0.0	508

¹ НҮТС-ны үзүүлэлт 7.1; МХЗ-ын үзүүлэлт 2.3 - Залуу эмэгтэйчүүдийн бичиг үсэг тайлагдалтын хувь

* "Боловсрол" нь хариулагдаагүй 1 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

** "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 8 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт ED.1M: Бичиг үсэг тайлагдалт (залуу эрэгтэйчүүд)

Бичиг үсэг тайлагдсан 15-24 насны эрэгтэйчүүдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Бичиг үсэг тайлагдсан эрэгтэйчүүдийн хувь ¹	Бичиг үсэг тайлагдаагүй эрэгтэйчүүдийн хувь	15-24 насны эрэгтэйчүүдийн тоо
Бүгд	95.2	0.1	1615
Бүс			
Баруун	90.7	0.6	200
Хангай	90.9	0.2	294
Төв	93.2	0.0	228
Зүүн	91.7	0.0	97
Улаанбаатар	98.8	0.0	796
Хот, хөдөө			
Хот	98.4	0.0	1098
Хөдөө	88.2	0.4	517
Байршил			
Нийслэл	98.8	0.0	796
Аймгийн төв	97.3	0.0	302
Сумын төв	95.6	0.0	146
Хөдөө	85.3	0.5	371
Боловсрол*			
Боловсролгүй	29.3	0.9	79
Бага	66.7	1.7	67
Суурь	100.0	0.0	521
Бүрэн дунд	100.0	0.0	601
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	100.0	0.0	142
Дээд	100.0	0.0	203
Насны бүлэг			
15-19	96.6	0.0	828
20-24	93.6	0.2	788
Өрхийн аж байдлын түвшин			
Доогуур	84.4	0.2	316
Дунджаас доогуур	92.9	0.3	342
Дундаж	98.5	0.0	300
Дунджаас дээгүүр	100.0	0.0	343
Дээгүүр	100.0	0.0	313
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**			
Халх	96.1	0.1	1268
Казак	93.5	0.0	67
Бусад	91.1	0.4	277

¹ НҮТС-ны үзүүлэлт 7.1; МХЗ-ын үзүүлэлт 2.3 - Залуу эрэгтэйчүүдийн бичиг үсэг тайлагдалтын хувь^[M]

* "Боловсрол" нь хариулагдаагүй 2 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

** "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 4 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт ED.2: Сургуульд бэлтгэгдсэн байдал

ЕБС-ийн 1-р ангид сурч байгаа, өмнөх хичээлийн жилд СӨБ-д хамрагдсан хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	ЕБС-ийн 1-р ангид сурч байгаа, өмнөх хичээлийн жилд СӨБ-д хамрагдсан хүүхдийн хувь ¹	ЕБС-ийн 1-р ангид сурч байгаа хүүхдийн тоо
Бүгд	78.8	1075
Хүйс		
Эрэгтэй	77.9	546
Эмэгтэй	79.8	529
Бүс		
Баруун	54.3	169
Хангай	78.7	233
Төв	82.4	176
Зүүн	83.0	94
Улаанбаатар	86.6	403
Хот, хөдөө		
Хот	86.4	633
Хөдөө	67.9	441
Байршил		
Нийслэл	86.6	403
Аймгийн төв	86.1	231
Сумын төв	77.8	120
Хөдөө	64.2	321
Эхийн боловсрол*		
Боловсролгүй	61.4	65
Бага	62.7	114
Суурь	70.6	196
Бүрэн дунд	80.7	239
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	79.2	96
Дээд	90.0	365
Өрхийн аж байдлын түвшин		
Доогуур	63.0	235
Дунджаас доогуур	69.8	227
Дундаж	84.6	211
Дунджаас дээгүүр	86.4	195
Дээгүүр	93.5	207
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**		
Халх	82.8	854
Казак	41.0	56
Бусад	71.7	157

¹ НҮТС-ны үзүүлэлт 7.2 - Сургуульд бэлтгэгдсэн байдал

* Эхийн боловсрол гэдэгт ЕБС-ийн 1-р ангид сурч байгаа хүүхдийн эх/асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно.

** "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 8 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт ED.3: Ерөнхий боловсролын сургуульд элсэлт

ЕБС-д элсэх насны хүүхдүүдээс 1-р ангид элсэн орсон хүүхдийн хувь (элсэлтийн цэвэр жин), Монгол Улс, 2013 он

	ЕБС-д элсэх насны хүүхдүүдээс 1-р ангид элсэн орсон хүүхдийн хувь ¹	ЕБС-д элсэх насны хүүхдийн тоо
Бүгд	94.5	1007
Хүйс		
Эрэгтэй	94.2	512
Эмэгтэй	94.7	495
Бүс		
Баруун	90.0	166
Хангай	92.9	214
Төв	95.8	172
Зүүн	96.4	87
Улаанбаатар	96.3	368
Хот, хөдөө		
Хот	95.6	585
Хөдөө	92.9	422
Байршил		
Нийслэл	96.3	368
Аймгийн төв	94.5	217
Сумын төв	98.4	118
Хөдөө	90.7	304
Эхийн боловсрол*		
Боловсролгүй	88.7	55
Бага	92.2	105
Суурь	92.3	176
Бүрэн дунд	94.7	245
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	94.6	91
Дээд	97.0	335
Өрхийн аж байдлын түвшин		
Доогуур	89.1	217
Дунджаас доогуур	94.8	223
Дундаж	95.7	176
Дунджаас дээгүүр	98.5	189
Дээгүүр	95.0	202
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**		
Халх	95.2	794
Казах	78.9	54
Бусад	96.1	157

¹ НҮТС-ны үзүүлэлт 7.3 - 1-р ангид элсэлтийн цэвэр жин

* Эхийн боловсрол гэдэгт ЕБС-д элсэх насны хүүхдийн эх/ асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно.

** "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 3 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт ED-4: Бага боловсролд хамрагдалт ба сургуулийн гадна байгаа хүүхэд

Бага боловсрол эзэмших насны хүүхдүүдэд бага болон дунд боловсрол эзэмшиж байгаа хүүхдийн хувь (засварласан хамран сургалтын цэвэр жил), СӨБ-д хамрагдаж буй хүүхдийн хувь, сургуулийн гадна байгаа хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Эргэж				Эмэгтэй				Бүгд				
	Хүүхдийн хувь:		Хүүхдийн хувь:		Хүүхдийн хувь:		Хүүхдийн хувь:		Хүүхдийн хувь:		Хүүхдийн хувь:		
	Хамран сургалтын цэвэр жил (тологтосон) ¹	СӨБ-д хамрагдаж байгаа	Сургуулийн гадна байгаа ^a	Хүүхдийн тоо	Хамран сургалтын цэвэр жил (тологтосон) ¹	СӨБ-д хамрагдаж байгаа	Сургуулийн гадна байгаа ^a	Хүүхдийн тоо	Хамран сургалтын цэвэр жил (тологтосон) ¹	СӨБ-д хамрагдаж байгаа	Сургуулийн гадна байгаа ^a	Хүүхдийн тоо	
Бүгд	97.7	1.6	0.5	2.2	2355	0.8	0.7	1.5	2188	1.2	0.6	1.8	4543
Бүс													
Баруун	95.2	3.4	1.4	4.8	378	1.3	0.2	1.5	377	2.3	0.8	3.1	755
Хангай	97.4	1.9	0.5	2.4	525	0.9	0.9	1.8	446	1.4	0.7	2.1	971
Төв	98.0	1.3	0.5	1.8	403	0.9	1.2	2.1	386	1.1	0.9	2.0	789
Зүүн	99.4	0.6	0.0	0.6	199	0.7	1.2	1.9	176	0.6	0.6	1.2	375
Улаанбаатар	98.4	1.1	0.3	1.4	850	0.5	0.3	0.8	803	0.8	0.3	1.1	1653
Хот, хөдөө													
Хот	98.1	1.2	0.5	1.7	1363	0.6	0.5	1.1	1316	0.9	0.5	1.4	2679
Хөдөө	97.1	2.3	0.6	2.8	992	1.1	0.9	2.0	872	1.7	0.7	2.4	1865
Байршил													
Нийслэл	98.4	1.1	0.3	1.4	850	0.5	0.3	0.8	803	0.8	0.3	1.1	1653
Аймагтйн төв	97.7	1.3	0.9	2.2	513	0.7	0.9	1.5	513	1.0	0.9	1.8	1026
Сумын төв	99.6	0.4	0.0	0.4	283	0.3	1.0	1.4	260	0.3	0.5	0.8	543
Хөдөө	96.1	3.0	0.8	3.8	709	1.5	0.8	2.3	612	2.3	0.8	3.1	1321
Хөгжлийн жил эхлэх үеийн нас													
6	94.4	3.2	2.4	5.6	512	1.6	2.6	4.2	495	2.4	2.5	4.9	1007
7	97.7	2.0	0.2	2.2	462	1.3	0.3	1.6	453	1.7	0.2	1.9	914
8	98.4	1.3	0.0	1.3	445	0.2	0.8	1.0	411	0.8	0.0	0.8	855
9	98.7	1.3	0.0	1.3	476	0.0	0.0	0.0	421	0.7	0.0	0.7	897
10	99.6	0.2	0.0	0.2	461	0.7	0.0	0.7	409	0.4	0.0	0.4	870
Эхийн боловсрол*													
Боловсролгүй	94.9	3.9	1.2	5.1	136	0.3	1.7	2.0	126	2.2	1.5	3.6	262
Бага	96.8	2.7	0.5	3.2	237	0.4	0.0	2.6	217	2.7	0.3	2.9	455
Суурь	96.7	2.7	0.4	3.0	466	1.1	0.4	1.6	420	1.9	0.4	2.3	886
Бүрэн дунд	97.9	1.4	0.6	2.0	560	0.4	0.9	1.3	510	0.9	0.7	1.7	1070
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	97.6	1.6	0.6	2.2	240	1.6	1.0	2.6	241	1.6	0.8	2.4	481
Дээд	99.1	0.4	0.5	0.9	716	0.1	0.5	0.6	673	0.2	0.5	0.8	1389
Өрхийн аж байдалын түвшин													
Доогуур	95.6	3.6	0.5	4.2	517	2.1	1.0	3.1	465	2.9	0.8	3.7	982
Дунджаас доогуур	97.1	2.3	0.6	2.9	531	0.8	1.0	1.7	481	1.7	0.6	2.3	1012
Дундаж	98.1	1.0	0.6	1.6	473	0.3	0.5	0.8	440	0.7	0.5	1.2	913
Дунджаас дээгүүр	99.0	0.6	0.2	0.9	423	0.0	0.5	0.5	401	0.3	0.4	0.7	824
Дээгүүр	99.2	0.0	0.8	0.8	412	0.4	0.7	1.1	400	0.2	0.7	0.9	813
Өрхийн тэргүүлэгчийн үлдэц угсаа													
Халх	98.0	1.2	0.6	1.9	1850	0.7	0.8	1.5	1700	1.0	0.7	1.7	3550
Казах	92.3	6.8	0.9	7.7	124	0.0	0.8	0.8	103	3.7	0.9	4.6	227
Бусад	97.8	2.0	0.0	2.0	375	1.4	0.0	1.4	378	1.7	0.0	1.7	753

* Эхийн боловсрол гэдэгт бага боловсрол эзэмших насны хүүхдийн аж/асрамжагачийн боловсролын түвшинг ойлгоно. "Эхийн боловсрол" нь харуулагдаагүй 0, 1, 1 ажиглагч (жигнээгүй)-ыг харуулаагүй.

** "Өрхийн тэргүүлэгчийн үлдэц угсаа" нь харуулагдаагүй 8, 8, 16 ажиглагч (жигнээгүй)-ыг харуулаагүй.

^a Бага боловсролд хамрагдах насны сургуулийн гадна байгаа хүүхэд гэдэгт тухайн нас (6-10 нас)-ны сургуульд хамрагдаагүй болон СӨБ-д хамрагдсан хүүхдийг оруулна.

НУТС-ны үзүүлэлт 7.4: МХЗ-ны үзүүлэлт 2.1 - Бага боловсролд хамран сургалтын цэвэр жил (тологтосон)

Хүснэгт 6.5: Дунд ангид хамрагдаж буй сургуулийн гадна байгаа хүүхэд

Дунд ангид суралцах насны хүүхдүүдээс дунд болон түүнээс дээш ангид суралцаж байгаа хүүхдийн хувь (асварласан хамран сургалтын цэвэр жин), бага боловсрол эзэмшиж байгаа хүүхдийн хувь, сургуулийн гадна байгаа хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Эрэгтэй				Эмэгтэй				Бүгд			
	Хамран сургалтын цэвэр жин (годогтосон) ¹		Хүүхдийн тоо		Хамран сургалтын цэвэр жин (годогтосон) ¹		Хүүхдийн тоо		Хамран сургалтын цэвэр жин (годогтосон)		Хүүхдийн тоо	
	Бага боловсролд хамрагдаж байгаа	Сургуулийн гадна байгаа ²	Хүүхдийн тоо	Хүүхдийн тоо	Бага боловсролд хамрагдаж байгаа	Сургуулийн гадна байгаа ²	Хүүхдийн тоо	Хүүхдийн тоо	Бага боловсролд хамрагдаж байгаа	Сургуулийн гадна байгаа ²	Хүүхдийн тоо	Хүүхдийн тоо
Бүгд	90.8	3.1	5.9	2781	95.0	3.0	2.0	2748	92.9	3.0	4.0	5529
Бүс												
Баруун	88.4	4.9	6.3	456	92.4	4.9	2.5	452	90.4	4.9	4.4	908
Хангай	90.3	2.4	6.9	639	94.9	2.4	2.6	619	92.6	2.4	4.8	1259
Төв	89.9	2.9	7.1	470	97.6	1.0	1.4	457	93.7	2.0	4.3	927
Зүүн	88.6	2.9	8.5	225	95.8	2.0	2.3	214	92.1	2.4	5.5	440
Улаанбаатар	93.0	2.9	4.0	990	94.9	3.6	1.5	1006	94.0	3.2	2.7	1996
Хот, хөдөө												
Хот	93.4	2.7	3.7	1656	95.2	3.1	1.7	1679	94.3	2.9	2.7	3335
Хөдөө	86.8	3.8	9.1	1126	94.7	2.8	2.4	1069	90.7	3.3	5.8	2195
Байршил												
Нийслэл	93.0	2.9	4.0	990	94.9	3.6	1.5	1006	94.0	3.2	2.7	1996
Аймгийн төв	94.0	2.3	3.4	666	95.6	2.4	2.0	673	94.8	2.4	2.7	1339
Сумын төв	93.9	2.6	3.5	330	98.7	0.3	1.0	367	96.4	1.4	2.2	697
Хөдөө	83.9	4.3	11.5	796	92.6	4.2	3.1	702	88.0	4.2	7.5	1498
Хичээлийн жил эхлэх үеийн нас												
11	84.9	13.8	1.4	416	85.6	14.0	0.3	453	85.3	13.9	0.8	868
12	93.6	4.5	1.9	458	95.6	2.6	1.9	480	94.6	3.5	1.9	938
13	94.3	1.4	3.7	533	98.1	0.7	1.0	489	96.1	1.1	2.4	1022
14	95.6	0.0	4.3	494	98.2	0.4	1.4	486	96.9	0.2	2.8	979
15	89.6	0.3	9.7	447	97.3	0.2	2.5	436	93.4	0.2	6.2	883
16	84.7	0.0	15.2	434	94.7	0.0	5.3	404	89.5	0.0	10.4	838
Эхийн боловсрол*												
Боловсролгүй	78.7	9.5	10.7	100	86.2	9.9	3.9	104	82.5	9.7	7.2	203
Бага	77.7	9.9	12.2	197	92.8	3.2	3.3	179	84.9	6.7	7.9	376
Суурь	89.1	3.1	7.5	597	93.8	4.2	2.0	567	91.4	3.7	4.8	1164
Бүрэн дунд	93.3	2.8	3.7	706	95.9	2.3	1.7	677	94.6	2.6	2.8	1383
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	89.8	3.0	7.1	395	93.3	4.0	2.6	385	91.5	3.5	4.9	780
Дээд	96.6	1.1	2.1	676	97.2	1.6	1.2	713	96.9	1.3	1.7	1389
Эх нь хамт амьлардаггүй	84.4	0.0	15.6	110	98.2	0.0	1.8	123	91.7	0.0	8.3	233
Өрхийн аж байдлын түвшин												
Доогуур	80.2	4.5	14.6	604	91.0	4.4	4.4	551	85.4	4.5	9.7	1154
Дунджаас доогуур	88.9	5.3	5.5	629	92.6	5.6	1.8	585	90.7	5.4	3.7	1214
Дундаж	92.7	3.2	4.1	556	97.6	1.2	1.3	598	95.2	2.1	2.6	1154
Дунджаас дээгүүр	96.6	0.6	2.8	532	96.1	2.2	1.8	529	96.3	1.4	2.3	1061
Дээгүүр	98.0	1.2	0.8	461	98.0	1.3	0.7	485	98.0	1.3	0.7	946
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**												
Халх	91.4	2.7	5.7	2192	95.6	2.4	2.0	2153	93.5	2.5	3.8	4345
Казак	84.9	8.4	6.7	132	85.2	11.4	3.4	142	85.0	10.0	5.0	274
Бусад	89.1	3.6	7.0	450	95.2	3.0	1.5	447	92.1	3.3	4.3	897

¹ НҮТС-ны үзүүлэлт 7.5 - Дунд ангид хамран сургалтын цэвэр жин (годогтосон)

* Эхийн боловсрол гэдэгт дунд ангид суралцах насны хүүхдийн эх/асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно. "Эхийн боловсрол" нь харуулагдаагүй 1, 2 ажиглагч (жигнээгүй)-ыг харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь харуулагдаагүй 4, 3, 7 ажиглагч (жигнээгүй)-ыг харуулаагүй.

² Дунд боловсролд хамрагдах насны сургуулийн гадна байгаа хүүхэд гэдэгт тухайн нас (11-14 нас)-ны бага, дунд анги болон түүнээс дээш түвшний боловсролд хамрагдаагүй хүүхдийг оруулна.

Хүснэгт БД.5А: Суурь боловсролд хамрагдалт ба сургуулийн гална байгаа хүүхэд
 Суурь боловсрол эзэмших насны хүүхдүүдээ суурь болон түүнээс дээш боловсрол эзэмшиж байгаа хүүхдийн хувь (засварласан хамран сургалтын цэвэр жин), СӨБ-д хамрагдаж буй хүүхдийн хувь, сургуулийн гална байгаа хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Эмэгтэй				Эмэгтэй				Бүгд						
	Хамран сургалтын цэвэр жин (тологосон)	СӨБ-д хамрагдаж байгаа ^a	Хүүхдийн тоо	Хүүхдийн хувь: СӨБ болон ЕБС-д хамрагдаж байгаа	Хамран сургалтын цэвэр жин (тологосон)	СӨБ болон ЕБС-д хамрагдаж байгаа ^a	Хүүхдийн тоо	Хүүхдийн хувь: СӨБ болон ЕБС-д хамрагдаж байгаа	Хамран сургалтын цэвэр жин (тологосон)	СӨБ болон ЕБС-д хамрагдаж байгаа ^a	Хүүхдийн тоо	Хүүхдийн хувь: СӨБ-д хамрагдаж байгаа			
Бүгд	97.6	1.4	0.3	1.7	4256	98.7	0.4	0.3	0.7	4095	98.1	0.9	0.3	1.2	8351
Бүс															
Баруун	95.7	1.7	0.8	2.5	683	98.2	0.5	0.1	0.6	695	97.0	1.1	0.4	1.6	1379
Хангай	96.9	1.9	0.3	2.2	943	98.4	0.3	0.5	0.8	882	97.6	1.1	0.4	1.5	1826
Төв	97.2	2.0	0.3	2.3	748	98.4	0.2	0.7	1.3	717	97.8	1.1	0.5	1.6	1466
Зүүн	98.7	1.0	0.0	1.0	357	98.1	0.7	1.3	0.8	328	98.4	0.8	0.3	1.1	686
Улаанбаатар	98.8	0.6	0.2	0.8	1523	99.4	0.3	0.2	0.5	1472	99.1	0.2	0.2	0.7	2996
Хот, хөдөө															
Хот	98.5	0.9	0.3	1.2	2484	99.0	0.3	0.3	0.6	2443	98.7	0.6	0.3	0.9	4927
Хөдөө	96.3	2.1	0.3	2.4	1772	98.2	0.5	0.4	0.9	1652	97.2	1.3	0.4	1.7	3424
Байршил															
Нийслэл	98.8	0.6	0.2	0.8	1523	99.4	0.3	0.2	0.5	1472	99.1	0.5	0.2	0.7	2996
Аймгийн төв	98.0	1.2	0.5	1.7	960	98.5	0.2	0.5	0.7	971	98.2	0.7	0.5	1.2	1931
Сумын төв	99.6	0.1	0.0	0.1	513	98.8	0.5	0.5	1.0	516	99.2	0.3	0.3	0.6	1029
Хөдөө	95.0	2.9	0.4	3.3	1260	97.9	0.5	0.4	0.9	1136	96.4	1.7	0.4	2.2	2395
Хөгжлийн жил эхлэх үеийн нас															
6	94.4	0.9	2.4	3.3	512	95.8	0.2	2.6	2.8	495	95.1	0.6	2.5	3.1	1007
7	97.8	1.1	0.2	1.3	462	98.4	0.3	0.8	0.6	453	98.1	0.2	0.8	1.0	914
8	98.4	0.6	0.0	0.6	445	99.8	0.0	0.0	0.0	411	99.1	0.0	0.0	0.3	855
9	98.7	0.3	0.0	0.3	476	100.0	0.0	0.0	0.0	421	99.3	0.2	0.0	0.2	897
10	99.6	0.2	0.0	0.2	461	99.3	0.0	0.0	0.0	409	99.3	0.0	0.0	0.1	870
11	98.6	1.1	0.0	1.1	416	99.7	0.2	0.2	0.2	453	99.2	0.6	0.0	0.6	868
12	98.1	1.1	0.0	1.1	458	98.1	0.7	0.0	0.7	480	98.1	0.9	0.0	0.9	938
13	95.7	2.9	0.0	2.9	533	98.8	0.6	0.0	0.6	533	97.2	1.8	0.0	1.8	1022
14	97.4	3.7	0.0	3.7	494	99.0	1.0	0.0	1.0	486	98.2	2.3	0.0	2.3	979
Эхний боловсрол*															
Боловсролгүй	92.7	3.1	0.8	3.8	213	97.4	0.6	1.0	1.6	212	95.1	1.8	0.9	2.7	425
Бага	95.3	3.0	0.3	3.3	389	97.7	0.6	0.0	0.6	361	96.5	1.9	0.2	2.0	750
Суурь	96.9	1.8	0.2	2.0	885	98.6	0.6	0.2	0.8	840	97.7	1.2	0.2	1.4	1725
Бүрэн дунд	98.1	0.9	0.3	1.2	1075	98.9	0.2	0.5	0.7	979	98.5	0.6	0.4	1.0	2054
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	97.4	1.9	0.3	2.2	489	98.3	0.5	0.4	1.0	513	97.8	1.2	0.4	1.5	1002
Дээд	99.3	0.3	0.3	0.6	1193	99.4	0.1	0.3	0.4	1180	99.3	0.2	0.3	0.5	2373
Эх нь хамт амьдардаггүй	92.9	16.8	0.0	16.8	10	100.0	0.0	0.0	0.0	9	96.1	9.1	0.0	9.1	19
Өрхийн аж байдалын түвшин															
Доогуур	93.6	3.7	0.3	4.0	924	97.1	0.9	0.5	1.4	870	95.3	2.3	0.4	2.7	1794
Дунджаас доогуур	96.9	1.5	0.3	1.8	957	98.8	0.3	0.3	0.5	922	97.8	0.9	0.3	1.2	1879
Дундаж	98.6	0.6	0.3	1.0	854	99.2	0.1	0.3	0.4	849	98.9	0.4	0.3	0.7	1703
Дунджаас дээгүүр	99.2	0.4	0.1	0.6	782	99.0	0.4	0.3	0.7	732	99.1	0.4	0.2	0.6	1514
Дээгүүр	99.2	0.2	0.4	0.6	738	99.4	0.0	0.4	0.4	723	99.3	0.1	0.4	0.5	1461
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа															
Халх	97.8	1.3	0.4	1.7	3354	98.7	0.3	0.4	0.8	3200	98.3	0.8	0.4	1.2	6555
Казах	93.5	2.0	0.5	2.5	213	99.0	0.6	0.4	1.0	207	96.2	1.3	0.5	1.8	420
Бусад	97.5	1.4	0.0	1.4	679	98.6	0.4	0.0	0.4	676	98.1	0.9	0.0	0.9	1355

¹ НУТС-ны үзүүлэлт **CS5.2 - Суурь боловсролд хамран сургалтын цэвэр жин (тологосон)**
 * Эхний боловсрол гэдэгт суурь боловсрол эзэмших насны хүүхдийн эх/ асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно. Мөн "Эхний боловсрол" нь харуулагдаагүй 1, 2, 3 ажиглалт (жингээгүй)-ыг харуулаагүй.
 ** "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь харуулагдаагүй 12, 11, 23 ажиглалт (жингээгүй)-ыг харуулаагүй.
^a Суурь боловсролд хамрагдах насны сургуулийн гална байгаа хүүхэд гэдэгт тухайн нас (6-14 нас)-ны бага, дунд анги болон түүнээс дээш түвшний боловсролд хамрагдаагүй болон СӨБ-д хамрагдсан хүүхдийг оруулна.

Хүснэгт БД.5В: Ахлах ангид хамрагдагт ба сургуулийн гадна байгаа хүүхэд

Ахлах ангид суралцах насны хүүхдүүдээ ахлах болон түүнээ дээш боловсрол эзэмшиж байгаа хүүхдийн хувь (засварласан хамран сургалтын цэвэр жин), дунд ангид суралцаж байгаа хүүхдийн хувь, сургуулийн гадна байгаа хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Эргэлтэй				Эсгэлтэй				Бүгд					
	Хамран сургалтын цэвэр жин (тодотгосон) ^а		Хүүхдийн тоо		Хамран сургалтын цэвэр жин (тодотгосон) ^а		Хүүхдийн тоо		Хамран сургалтын цэвэр жин (тодотгосон) ^а		Хүүхдийн тоо		Хүүхдийн гадна байгаа ^б	
	Дунд ангид суралцаж байгаа	Сургуулийн гадна байгаа ^а	Хүүхдийн тоо	Хүүхдийн гадна байгаа ^а	Дунд ангид суралцаж байгаа	Сургуулийн гадна байгаа ^а	Хүүхдийн тоо	Хүүхдийн гадна байгаа ^а	Дунд ангид суралцаж байгаа	Сургуулийн гадна байгаа ^а	Хүүхдийн тоо	Хүүхдийн гадна байгаа ^а	Дунд ангид суралцаж байгаа	Сургуулийн гадна байгаа ^а
Бүгд	79.7	5.3	14.2	1254	90.4	4.4	5.1	1149	84.8	4.9	9.9	2403		
Бүс														
Баруун	75.5	8.8	13.7	211	87.6	7.8	3.3	181	81.1	8.3	8.9	393		
Хангай	78.9	5.0	14.9	291	89.4	3.2	6.8	239	83.7	4.2	11.2	530		
Төв	71.0	8.2	18.2	175	90.9	4.2	5.6	156	80.4	6.3	12.3	332		
Зүүн	73.0	3.3	24.5	95	89.3	2.9	8.0	80	80.4	3.1	17.0	175		
Улаанбаатар	86.4	3.1	10.6	482	92.0	4.1	4.3	492	89.2	3.6	7.4	974		
Хот, хөдөө														
Хот	86.8	3.9	8.9	769	92.0	3.8	4.6	766	89.4	3.9	6.7	1535		
Хөдөө	68.4	7.4	22.6	485	87.3	5.6	6.2	383	76.8	6.6	15.4	868		
Байршил														
Нийслэл	86.4	3.1	10.6	482	92.0	4.1	4.3	492	89.2	3.6	7.4	974		
Аймгийн төв	87.3	5.2	6.1	287	91.9	3.4	5.0	274	89.6	4.3	5.6	561		
Сумын төв	81.0	5.4	14.1	140	91.9	6.5	5.5	135	86.4	5.9	9.9	275		
Хөдөө	63.3	8.2	26.0	346	84.9	5.1	6.7	248	72.3	6.9	17.9	594		
Хичээлийн жил эхлэх үеийн нас														
15	80.0	9.5	8.2	447	87.8	9.5	1.4	436	83.9	9.5	4.9	883		
16	80.3	4.2	13.9	434	93.3	1.4	4.5	404	86.5	2.9	9.4	838		
17	78.5	1.3	21.7	374	90.4	1.2	11.1	309	83.9	1.3	16.9	682		
Эхийн боловсрол*														
Боловсролгүй	43.8	25.5	24.0	32	82.1	10.6	16.4	25	60.5	19.0	20.7	57		
Бага	63.6	8.4	23.4	55	84.1	3.8	7.3	47	73.1	6.3	15.9	102		
Суурь	70.2	7.4	21.1	234	87.8	5.8	4.6	197	78.2	6.7	13.6	432		
Бүрэн дунд	82.2	7.5	11.2	259	90.4	6.0	3.9	261	86.3	6.7	7.5	520		
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	82.8	3.7	14.0	193	87.0	6.2	7.0	157	84.7	4.8	10.8	351		
Дээд	93.8	1.2	4.7	265	95.2	2.3	2.2	258	94.5	1.7	3.5	522		
Эх нь хамт амьдардаггүй	76.4	3.3	17.3	163	95.1	2.3	4.8	158	85.6	2.8	11.1	321		
Тодорхойлох боломжгүй ^б	76.0	1.6	22.1	53	82.2	0.0	17.4	46	78.9	0.9	19.9	99		
Өрхийн аж байдалын түвшин														
Доогуур	59.3	7.6	29.4	288	82.2	4.8	9.3	204	68.8	6.5	21.1	493		
Дунджаас доогуур	75.7	8.7	14.9	283	87.9	5.5	7.9	236	81.2	7.2	11.7	519		
Дундаж	81.3	5.2	14.0	238	91.4	3.7	23.6	236	86.3	5.5	8.9	474		
Дунджаас дээгүүр	91.9	2.2	6.3	242	93.9	3.5	2.4	252	92.9	2.8	4.3	493		
Дээгүүр	97.6	0.9	1.3	204	95.7	2.5	2.9	221	96.6	1.7	2.1	425		
Өрхийн гэрүүлэгчийн үндэс үгсээ**														
Халх	80.6	4.5	14.4	979	91.9	3.0	5.2	893	86.0	3.8	10.0	1872		
Казах	67.1	18.5	14.3	59	72.5	18.3	7.0	53	69.7	18.4	10.9	111		
Бусад	78.4	5.3	13.8	212	88.4	7.2	4.3	201	83.3	6.2	9.2	413		

* НУТС-ны үзүүлэлт СС5.3 - Ахлах ангид хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)

* Эхийн боловсрол гэдэгт ахлах ангид суралцах насны хүүхдийн эх/асрамжагчгийн боловсролын түвшинг ойлгоно.

** Өрхийн гэрүүлэгчийн үндэс үгсээ* нь харуулагдаагүй 4, 2, 6 ажиглагч (жингээгүй)-ыг харуулаагүй.

^а Ахлах ангид хамрагдах насны сургуулийн гадна байгаа хүүхэд гэдэгт тухайн нас (15-17 нас)-ны аль ч шатны боловсрол хамрагдаагүй хүүхдийг оруулна.

^б 15 ба түүнээс дээш насны хүүхдийн эх/асран хамгаалагчийн боловсролын мэдээллийг цуглуулаагүй.

Хүснэгт ED.5С: Их, дээд сургууль/ коллежид хамрагдаг ба сургуулийн гадна байгаа залуучууд

Их дээд сургууль/ коллежид суралцах насныхнаас их, дээд сургууль/ коллежид суралцаж буй, суралцаж төгссөн залуучуудын хувь (засварласан хамран сургалтын цэвэр жин), ахлах ангид суралцаж байгаа залуучуудын хувь, сургуулийн гадна байгаа залуучуудын хувь, Монгол Улс, 2013 он

	Эрэгтэй				Эмэгтэй				Бүгд						
	Хамран сургалтын цэвэр жин (тодотгосон) ¹		Хүүхдийн хувь:		Хамран сургалтын цэвэр жин (тодотгосон) ¹		Хүүхдийн хувь:		Хамран сургалтын цэвэр жин (тодотгосон) ¹		Хүүхдийн хувь:				
	Ахлах ангид суралцаж байгаа	МСУТ-д суралцаж гадна байгаа*	Залуучуудын тоо	Ахлах ангид суралцаж байгаа	Ахлах ангид суралцаж байгаа	МСУТ-д суралцаж гадна байгаа*	Залуучуудын тоо	Ахлах ангид суралцаж байгаа	Ахлах ангид суралцаж байгаа	МСУТ-д суралцаж гадна байгаа*	Залуучуудын тоо				
Бүгд	42.6	0.9	13.8	65.9	2551	59.6	0.6	10.7	63.2	2424	50.9	0.7	12.3	64.6	4974
Бүс															
Баруун	24.2	4.0	13.3	74.4	281	39.2	1.7	17.2	75.1	220	30.7	3.0	15.0	74.7	501
Хангай	16.1	0.9	19.6	79.6	430	35.5	1.1	15.3	79.9	384	25.3	1.0	17.6	79.7	814
Төв	23.1	0.8	21.5	81.2	363	40.2	0.2	19.0	75.9	332	31.3	0.6	20.3	78.7	695
Зүүн	19.5	0.6	24.7	79.5	152	37.6	1.7	20.9	82.8	128	27.8	1.1	23.0	81.0	280
Улаанбаатар	63.0	0.4	8.7	53.9	1325	76.5	0.2	5.4	51.6	1359	69.8	0.3	7.0	52.7	2684
Хот, хотоо															
Хот	55.0	0.7	13.1	59.1	1755	70.7	0.4	8.9	56.4	1814	63.0	0.6	10.9	57.7	3569
Хөдөө	15.1	1.4	15.4	80.9	796	26.5	0.9	16.2	83.5	609	20.0	1.2	15.7	82.0	1405
Байршил															
Нийслэл	63.0	0.4	8.7	53.9	1325	76.5	0.2	5.4	51.6	1359	69.8	0.3	7.0	52.7	2684
Аймгийн төв	30.3	1.7	26.7	75.0	429	53.4	1.2	19.3	70.8	455	42.2	1.5	22.9	72.8	885
Сумын төв	27.2	0.4	20.3	79.9	223	41.4	0.6	19.8	83.6	181	33.6	0.5	20.1	81.5	405
Хөдөө	10.4	1.8	13.5	81.4	573	20.2	1.0	14.6	83.4	428	14.6	1.5	14.0	82.2	1001
Хичээлийн жил эхлэх үеийн нас															
18	44.9	6.0	16.2	39.2	335	65.8	4.4	12.7	23.4	256	54.0	5.3	14.7	32.4	592
19	47.2	0.0	16.9	49.6	320	59.0	0.4	15.0	35.8	260	52.5	0.2	16.0	43.4	580
20	49.3	0.4	15.5	54.7	303	58.4	0.0	16.5	43.3	262	53.5	0.2	16.0	49.4	565
21	42.0	0.0	16.0	65.9	359	61.3	0.3	11.7	63.5	337	51.3	0.2	13.9	64.7	696
22	37.9	0.2	12.7	80.5	402	59.9	0.0	10.9	75.0	388	48.7	0.1	11.8	77.8	790
23	41.9	0.3	12.3	85.2	401	60.5	0.0	7.7	85.5	460	51.8	0.1	9.9	85.4	861
24	38.0	0.0	9.0	75.2	430	54.6	0.0	6.0	79.7	461	46.6	0.0	7.4	77.5	891
Өрхийн аж байдалын түвшин															
Доогуур	6.4	1.5	14.0	81.3	499	14.6	1.0	14.8	85.0	361	9.8	1.3	14.3	82.8	861
Дунджаас доогуур	22.5	1.4	19.0	76.0	507	40.2	0.5	18.4	70.1	476	31.1	1.0	18.7	73.1	982
Дундаж	36.1	1.1	20.5	74.3	518	55.4	0.7	16.6	69.4	474	45.3	0.9	18.6	72.0	991
Дунджаас дээгүүр	62.7	0.7	10.7	51.6	537	77.1	0.7	5.7	51.8	569	70.1	0.7	8.1	51.7	1106
Дээгүүр	81.7	0.0	4.5	46.7	489	89.7	0.0	1.4	49.1	545	85.9	0.0	2.9	47.9	1034
Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа*															
Халх	45.0	0.4	13.8	66.1	2016	60.9	0.5	10.9	63.0	1996	52.9	0.4	12.4	64.6	4012
Казах	30.4	3.3	14.5	72.1	98	45.8	1.0	16.4	73.7	84	37.5	2.2	15.4	72.8	182
Бусад	34.5	2.8	13.7	63.3	433	55.7	1.0	8.0	61.2	339	43.9	2.0	11.2	62.4	772

¹ НУТС-ны үзүүлэлт CS5.4 - Их, дээд сургууль/ коллежид хамран сургалтын цэвэр жин (тодотгосон)

* "Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа" нь харуулагдаагүй 4, 7, 11 ажиглагч (жингээгүй)-ыг харуулаагүй.

^a Их, дээд сургууль/ коллежид суралцах насны сургуулийн гадна байгаа залуучууд гэдэгт тухайн нас (18-24 нас)-ны аль ч шатны сургуульд суралцаагүй залуучуудыг оруулна.

Хүснэгт ED.6: Бага боловсролын сүүлийн ангид сурч байгаа хүүхэд

1-р ангид элсэн ороод 5-р анги хүртлээ тасралтгүй дэвшин сурч байгаа хүүхдийн хувь (бага боловсролын сүүлийн анги хүртэл суралцах магадлал), Монгол Улс, 2013 он

	Өмнөх хичээлийн жилд 1-р ангид сурч байсан хүүхдүүдээс энэ хичээлийн жилд 2-р ангид сурч байгаа хүүхдийн хувь	Өмнөх хичээлийн жилд 2-р ангид сурч байсан хүүхдүүдээс энэ хичээлийн жилд 3-р ангид сурч байгаа хүүхдийн хувь	Өмнөх хичээлийн жилд 3-р ангид сурч байсан хүүхдүүдээс энэ хичээлийн жилд 4-р ангид сурч байгаа хүүхдийн хувь	Өмнөх хичээлийн жилд 4-р ангид сурч байсан хүүхдүүдээс энэ хичээлийн жилд 5-р ангид сурч байгаа хүүхдийн хувь	1-р ангид элсэн ороод 5-р анги хүртлээ тасралтгүй дэвшин сурч хүүхдийн хувь ¹
Бүгд	99.5	99.7	99.4	99.4	98.1
Хүйс					
Эрэгтэй	99.3	99.7	98.9	99.2	97.1
Эмэгтэй	99.8	99.7	100.0	99.7	99.3
Бүс					
Баруун	100.0	99.2	98.5	98.6	96.3
Хангай	99.0	99.3	98.9	100.0	97.2
Төв	100.0	100.0	99.5	100.0	99.5
Зүүн	98.9	100.0	100.0	100.0	98.9
Улаанбаатар	99.6	100.0	100.0	99.1	98.7
Хот, хөдөө					
Хот	99.6	100.0	99.7	99.3	98.6
Хөдөө	99.5	99.3	99.1	99.7	97.6
Байршил					
Нийслэл	99.6	100.0	100.0	99.1	98.7
Аймгийн төв	99.5	100.0	99.1	99.6	98.3
Сумын төв	99.3	100.0	100.0	100.0	99.3
Хөдөө	99.6	99.0	98.7	99.5	96.9
Эхийн боловсрол*					
Боловсролгүй	100.0	100.0	100.0	97.4	97.4
Бага	98.7	100.0	98.7	99.1	96.5
Суурь	99.4	99.2	99.4	100.0	98.0
Бүрэн дунд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	99.2	100.0	98.0	100.0	97.2
Дээд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өрхийн аж байдлын түвшин					
Доогуур	99.1	99.1	98.2	99.4	95.8
Дунджаас доогуур	98.8	99.7	99.2	99.7	97.3
Дундаж	100.0	100.0	100.0	99.4	99.4
Дунджаас дээгүүр	100.0	100.0	100.0	99.2	99.2
Дээгүүр	100.0	100.0	100.0	99.5	99.5
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа					
Халх	99.4	99.8	99.8	99.3	98.3
Казах	100.0	97.7	97.5	100.0	95.3
Бусад	100.0	100.0	98.6	100.0	98.6

¹ НҮТС-ны үзүүлэлт 7.6; МХЗ-ын үзүүлэлт 2.2 - 1-р ангид элсээд 5-р анги хүртлээ тасралтгүй анги дэвшин суралцсан хүүхэд

* Эхийн боловсрол гэдэгт бага боловсрол эзэмших насны хүүхдийн эх/асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно.

БИЧИГ ҮСГИЙН ТАЙЛАГДАЛТ БА БОЛОВСРОЛ

Хүснэгт ED.7: Бага боловсрол эзэмшилт болон дунд боловсролд дэвшин суралцаж буй байдал

Бага боловсрол эзэмшиж байгаа болон дунд боловсролд дэвшин сурч байгаа хувь, Монгол Улс, 2013 он

	Бага боловсрол эзэмшилтийн бохир жин ¹	Бага боловсролын төгсөх ангид суралцах насны хүүхдийн тоо	Дунд ангид дэвшин суралцаж буй хүүхдийн хувь ²	Өмнөх хичээлийн жилд бага боловсролын төгсөх ангид суралцаж байсан хүүхдийн тоо	Дунд ангид амжилттай дэвшин суралцаж буй хүүхдийн хувь	Өмнөх хичээлийн жилд бага боловсролын төгсөх ангид суралцаж байсан бөгөөд улиран суралцаагүй хүүхдийн тоо
Бүгд	109.7	870	98.4	890	99.7	878
Хүйс						
Эрэгтэй	108.8	461	97.9	431	99.5	424
Эмэгтэй	110.7	409	98.8	458	99.9	454
Бүс						
Баруун	89.5	156	95.6	136	99.5	131
Хангай	107.9	181	98.7	192	99.5	190
Төв	104.0	165	97.4	174	99.4	170
Зүүн	118.8	68	99.3	79	100.0	79
Улаанбаатар	122.5	300	99.8	309	100.0	308
Хот, хөдөө						
Хот	117.1	516	99.2	518	100.0	514
Хөдөө	99.0	354	97.2	372	99.3	364
Байршил						
Нийслэл	122.5	300	99.8	309	100.0	308
Аймгийн төв	109.5	215	98.4	209	100.0	206
Сумын төв	100.0	94	98.5	111	100.0	109
Хөдөө	98.7	260	96.7	261	99.0	255
Эхийн боловсрол*						
Боловсролгүй	95.4	45	100.0	45	100.0	45
Бага	108.3	85	96.5	75	98.8	73
Суурь	109.6	170	97.8	207	99.7	203
Бүрэн дунд	115.3	199	98.1	220	100.0	216
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	114.8	118	98.0	92	98.8	91
Дээд	106.1	252	99.5	249	100.0	247
Өрхийн аж байдлын түвшин						
Доогуур	99.1	189	95.4	187	98.6	181
Дунджаас доогуур	134.0	179	99.2	207	100.0	205
Дундаж	101.5	189	98.7	180	100.0	177
Дунджаас дээгүүр	107.8	157	98.9	152	100.0	151
Дээгүүр	106.7	157	100.0	164	100.0	164
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**						
Халх	113.2	679	98.8	727	99.6	721
Казах	86.4	47	97.4	40	100.0	39
Бусад	100.8	143	96.0	121	100.0	116

¹ НҮТС-ны үзүүлэлт 7.7 - Бага боловсрол эзэмшилтийн хувь

² НҮТС-ны үзүүлэлт 7.8 - Дунд ангид дэвшин суралцсан хүүхэд

* Эхийн боловсрол гэдэгт бага болон дунд боловсрол эзэмших насны хүүхдийн эх/ асрамжлагчийн боловсролын түвшинг ойлгоно.

** "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 1, 2, 2 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт ED.8: Боловсрол дахь хүйсийн тэгш байдал

Бага, дунд анги болон суурь боловсрол эзэмшиж буй охид, хөвгүүдийн хамран сургалтын цэвэр жингийн (засварласан) харьцаа, Монгол Улс, 2013 он

	Бага боловсрол		Дунд анги		Суурь боловсрол		Суурь боловсролын хамран сургалтын дахь жендерийн тэгш байдлын индекс ³	
	Бага боловсролд хамран сургалтын цэвэр жин (тодотгосон), охид	Бага боловсролд хамран сургалтын цэвэр жин (тодотгосон), хөвгүүд	Дунд ангийн хамран сургалтын цэвэр жин (тодотгосон), охид	Дунд ангийн хамран сургалтын цэвэр жин (тодотгосон), хөвгүүд	Суурь боловсролд хамран сургалтын цэвэр жин (тодотгосон), охид	Суурь боловсролд хамран сургалтын цэвэр жин (тодотгосон), хөвгүүд		
Бүгд	98.5	97.7	1.01	94.5	92.5	1.02	97.4	1.01
Бүс								
Баруун	98.5	95.2	1.03	90.8	88.9	1.02	98.2	1.03
Хангай	98.2	97.4	1.01	95.2	91.9	1.04	98.4	1.02
Төв	97.9	98.0	1.00	97.5	92.4	1.06	98.4	1.01
Зүүн	98.1	99.4	0.99	94.9	92.5	1.03	97.9	1.00
Улаанбаатар	99.2	98.4	1.01	94.3	94.6	1.00	99.3	1.01
Хот, хөлөө								
Хот	98.9	98.1	1.01	94.6	94.6	1.00	99.0	1.01
Хөлөө	98.0	97.1	1.01	94.5	89.6	1.05	98.2	1.02
Байршил								
Нийслэл	99.2	98.4	1.01	94.3	94.6	1.00	99.3	1.01
Аймгийн төв	98.5	97.7	1.01	95.0	94.6	1.00	98.5	1.01
Сумын төв	98.6	99.6	0.99	98.3	95.6	1.03	98.7	0.99
Бусад	8.3	61.2	88.8	78.3	16.2	7.0	17.3	4.2	2.3	0.0	0.0	3.7	4.7	2.5	8.6	90

¹ НУТС-ны үзүүлэлт 3.12 - Суулгалт өвчний үел шингэн салбх эмчилгээ хийгэхийн зэргээ хоолыг үргэлжлүүлэн өгсөн байдал
 * "Өрхийн гэрээлэгчийн үндэс угсаа" нь хариуцдаггүй 4 ажиллалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.
 (*) 25 хургалж ажиллалт (жигнээгүй) дээр үндэслэн тоолсон
 () 25-49 ажиллалт (жигнээгүй) дээр үндэслэн тоолсон

Хүснэгт СН.9: Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн шингэн сэлбэх лавсны уусмал болон цайрын бэлдмэлийн эх үүсвэр

Судалгааны өмнөх 2 долоо хоногийн хугацаанд суулгаж, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн ШСДУ болон цайрын бэлдмэл хэрэглэсэн 0-59 сартай хүүхдийн хувь, уусмал болон бэлдмэлийг олж авсан эх үүсвэрээр, Монгол Улс, 2013

	Эмчилгээ хийлгэсэн хүүхдийн хувь:			Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн ШСДУ олж авсан эх үүсвэр			Судалгааны өмнөх 2 долоо хоногийн хугацаанд суулгасан, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн ШСДУ уулгасан 0-59 сартай хүүхдийн тоо			Цайрын бэлдмэл олж авсан эх үүсвэр			Судалгааны өмнөх 2 долоо хоногийн хугацаанд суулгасан, цайрын бэлдмэл хэрэглэсэн 0-59 сартай хүүхдийн тоо
	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн ШСДУ	Цайрын бэлдмэл	Судалгааны өмнөх 2 долоо хоногийн хугацаанд суулгасан 0-59 сартай хүүхдийн тоо	Улсын	Хувийн	Бусад	Эмнэлэг ^b	Улсын	Хувийн	Эмнэлэг ^b	Улсын	Хувийн	
Бүгд	41.8	9.2	494	9.1	87.1	3.8	96.2	207	33.2	66.8	100.0	46	
Хүйс													
Эрэгтэй	45.4	10.0	252	8.3	87.7	4.0	96.0	114	(39.7)	(60.3)	(100.0)	25	
Эмэгтэй	38.1	8.4	243	10.1	86.3	3.6	96.4	92	(*)	(*)	(*)	20	
Бүс													
Баруун	(41.6)	(8.0)	(87.4)	(17.8)	(76.2)	(6.0)	(94.0)	36	(*)	(*)	(*)	7	
Хангай	47.2	8.9	141	11.1	84.5	4.5	95.5	67	(*)	(*)	(*)	13	
Төв	(32.2)	(4.9)	(88.4)	(5.8)	(94.2)	(0.0)	(100.0)	28	(*)	(*)	(*)	4	
Зүүн	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	13	(*)	(*)	(*)	4	
Улаанбаатар	42.1	12.1	148	0.0	95.6	4.4	95.6	62	(*)	(*)	(*)	18	
Хот, хөдөө													
Хот	46.1	11.7	249	2.8	94.1	3.1	96.9	115	(25.8)	(74.2)	(100.0)	29	
Хөдөө	37.5	6.8	246	16.9	78.4	4.7	95.3	92	(*)	(*)	(*)	17	
Байршил													
Нийслэл	42.1	12.1	148	0.0	95.6	4.4	95.6	62	(*)	(*)	(*)	18	
Аймгийн төв	51.9	11.1	100	6.1	92.3	1.5	98.5	52	(*)	(*)	(*)	11	
Сумын төв	(38.6)	(7.9)	(65.5)	(5.7)	(94.3)	(0.0)	(100.0)	25	(*)	(*)	(*)	5	
Хөдөө	37.1	6.4	180	21.1	72.4	6.5	93.5	67	(*)	(*)	(*)	11	
Насны бүлэг													
0-11 сартай	42.7	14.1	160	7.6	89.2	3.3	96.7	68	(*)	(*)	(*)	23	
12-23 сартай	48.3	6.4	148	7.2	86.6	6.2	93.8	71	(*)	(*)	(*)	9	
24-35 сартай	(40.6)	(6.5)	(89.4)	(9.1)	(90.9)	(0.0)	(100.0)	36	(*)	(*)	(*)	6	
36-59 сартай	(31.7)	(8.1)	(97.5)	(16.7)	(79.1)	(4.2)	(95.8)	31	(*)	(*)	(*)	8	
Эхийн боловсрол													
Суурь, түүнээс бага	43.5	5.1	151	18.5	77.4	4.2	95.8	66	(*)	(*)	(*)	8	
Бүрэн дунд, техникийн болон тусгай мэргэжлийн дунд	33.8	10.2	167	8.2	87.4	4.4	95.6	56	(*)	(*)	(*)	17	
Дээд	47.9	11.9	176	2.4	94.5	3.1	96.9	85	(*)	(*)	(*)	21	
Өрхийн аж байдалын түвшин													
Дунджаас доогуур	36.7	4.8	247	17.8	79.2	3.0	97.0	91	(*)	(*)	(*)	12	
Дундаж	51.4	16.8	89	2.4	95.1	2.4	97.6	46	(*)	(*)	(*)	15	
Дунджаас дээгүүр	44.4	12.0	159	2.2	92.0	5.8	94.2	71	(*)	(*)	(*)	19	
Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа													
Халх	42.2	9.8	389	8.1	87.7	4.2	95.8	164	(*)	(*)	(*)	38	
Бусад	(42.0)	(7.4)	(101.5)	(12.8)	(84.7)	(2.5)	(97.5)	43	(*)	(*)	(*)	8	

^b Улсын болон хувийн эмнэлгийг хамруулав.
 (*) 25 хүргэлх ажиглалт (жигнэгдэлгүй) дээр үндэслэн тооцсон
 () 25-49 ажиглалт (жигнэгдэлгүй) дээр үндэслэн тооцсон

Хүснэгт СН.10: Амьсгалын замын цочмог халдварын шинж тэмдэг илэрсэн үед мэргэжлийн эмчид хандсан болон антибиотик эмчилгээ хийлгэсэн байдал

Судалгааны өмнөх 2 долоо хоногийн хугацаанд АЗЦХ-ын шинж тэмдэг илэрч, зөвлөгөө авч, эмчилгээ хийлгэсэн болон антибиотик хэрэглэсэн 0-59 сартай хүүхдийн хувь, эмчилгээ хийлгэхээр хандсан газраар, Монгол Улс, 2013 он

	Амьсгалын замын цочмог халдварын шинж тэмдэг илэрсэн:					АЗЦХ-ын шинж тэмдэг илэрч, антибиотик эмчилгээ хийлгэсэн хүүхдийн хувь ²	Судалгааны өмнөх 2 долоо хоногийн хугацаанд АЗЦХ-ын шинж тэмдэг илэрсэн хүүхдийн тоо	Антибиотик эмчилгээ хийлгэхээр хандсан газар				Судалгааны өмнөх 2 долоо хоногийн хугацаанд АЗЦХ-ын шинж тэмдэг илрэн, антибиотик эмчилгээ хийлгэсэн хүүхдийн тоо
	Зөвлөгөө авч, эмчилгээ хийлгэсэн:				Зөвлөгөө авч, эмчилгээ хийлгээгүй			Эмнэлэг				
	Эмнэлэг							Улсын	Хувийн	Бусад	Эмнэлэг ^с	
	Улсын	Хувийн	Бусад	Эмнэлэг ^{1, б}								
Бүгд	64.6	11.0	2.5	70.3	26.0	63.4	245	10.9	89.1	0.0	100.0	156
Хүйс												
Эрэгтэй	69.3	10.6	0.0	74.3	23.9	67.8	123	11.2	88.8	0.0	100.0	83
Эмэгтэй	59.8	11.3	5.0	66.3	28.1	58.9	122	10.6	89.4	0.0	100.0	72
Бүс												
Баруун	(53.1)	(10.8)	(0.0)	(61.4)	(36.0)	(39.9)	28	(*)	(*)	(*)	(*)	11
Хангай	(57.2)	(4.3)	(0.0)	(57.2)	(40.6)	(65.0)	45	(4.4)	(95.6)	(0.0)	(100.0)	29
Төв	(75.7)	(11.8)	(2.5)	(75.7)	(19.3)	(73.4)	37	(24.6)	(75.4)	(0.0)	(100.0)	28
Зүүн	(65.7)	(5.7)	(0.0)	(68.8)	(28.6)	(70.2)	18	(*)	(*)	(*)	(*)	13
Улаанбаатар	66.3	14.1	4.4	75.9	19.7	64.1	117	6.0	94.0	0.0	100.0	75
Хот, хөдөө												
Хот	68.5	12.2	3.1	75.1	20.9	67.0	170	8.6	91.4	0.0	100.0	114
Хөдөө	55.8	8.1	1.2	59.6	37.4	55.3	76	(17.2)	(82.8)	(0.0)	(100.0)	42
Байршил												
Нийслэл	66.3	14.1	4.4	75.9	19.7	64.1	117	6.0	94.0	0.0	100.0	75
Аймгийн төв	73.3	8.2	0.0	73.3	23.4	73.5	52	(13.6)	(86.4)	(0.0)	(100.0)	39
Сумын төв	(72.4)	(10.2)	(3.3)	(74.4)	(20.7)	(69.2)	28	(*)	(*)	(*)	(*)	20
Хөдөө	(45.9)	(6.8)	(0.0)	(50.7)	(47.3)	(46.9)	47	(*)	(*)	(*)	(*)	22
Насны бүлэг												
0-11 сартай	79.0	17.6	3.7	84.8	11.0	61.7	58	(14.3)	(85.7)	(0.0)	(100.0)	36
12-23 сартай	70.0	3.6	0.0	70.0	26.4	62.4	59	(11.8)	(88.2)	(0.0)	(100.0)	37
24-35 сартай	64.4	11.9	0.0	72.8	25.7	72.7	65	(10.4)	(89.6)	(0.0)	(100.0)	48
36-59 сартай	46.2	10.7	6.3	54.5	39.7	56.1	62	(7.2)	(92.8)	(0.0)	(100.0)	35
Эхийн боловсрол												
Суурь, түүнээс бага	51.1	5.6	0.0	56.7	43.3	52.5	51	(12.3)	(87.7)	(0.0)	(100.0)	27
Бүрэн дунд, техникийн болон тусгай мэргэжлийн дунд	64.3	10.2	5.2	65.6	26.6	66.0	94	14.2	85.8	0.0	100.0	62
Дээд	71.6	14.3	1.3	81.5	16.7	66.5	101	7.3	92.7	0.0	100.0	67
Өрхийн аж байдлын түвшин												
Дунджаас доогуур	53.8	6.3	1.8	56.8	39.0	56.2	97	12.0	88.0	0.0	100.0	54
Дундаж	(78.3)	(3.8)	(2.1)	(78.3)	(20.0)	(74.9)	44	(8.9)	(91.1)	(0.0)	(100.0)	33
Дунджаас дээгүүр	68.8	18.3	3.3	79.5	16.4	65.2	105	11.0	89.0	0.0	100.0	68
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа												
Халх	66.4	12.7	3.1	72.5	22.8	67.1	194	11.4	88.6	0.0	100.0	130
Бусад	57.6	4.5	0.0	62.1	37.9	49.2	51	(8.4)	(91.6)	(0.0)	(100.0)	25

¹ НУТС-ны үзүүлэлт 3.13 - АЗЦХ-ын шинж тэмдэг илэрсэн үед мэргэжлийн эмчид хандсан байдал

² НУТС-ны үзүүлэлт 3.14 - АЗЦХ-ын шинж тэмдэг илэрсэн үед антибиотик эмчилгээ хийлгэсэн байдал

^б Улсын болон хувийн эмнэлгийг хамруулав. Харин хувийн эмийн санг хамруулаагүй болно.

^с Улсын болон хувийн эмнэлгийг хамруулав.

(*) 25 хүртэлх ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

() 25-49 ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

Хүснэгт СН.11: Амьсгалын замын ночмог халдварын аюултай 2 шинж тэмдгийн талаарх мэдлэг

5 хүртэлх насны (бага насны) хүүхдэд, 15-49 насны эмэгтэчүүд (эх/асрамжлагч)-ийн хувь, бага насны хүүхдийнхээ амьсгал олширсон/ амьсгаасан эсвэл амьсгал саадтай болсон/ янцлагасан, ярагласан үед эмнэлэгт яаралтай хандаж үзүүлэх талаар мэдлэг эх/асрамжлагчийн хувь, эмнэлэгт яаралтай хандаж үзүүлэх өвчний шинж тэмдгээр, Монгол Улс, 2013 он

Хүүхдэд дараах шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эмнэлэгт яаралтай хандаж үзүүлнэ гэж харьцсан эх/асрамжлагчийн хувь:

	Хөхөө хөхөхгүй, юм ууж, илэхгүй байх		Бие нь сульдах		Хагуурах		Амьсгал олширох/ амьсгаадах		Амьсгал саадтай болох/ янцлагасан, яраглах		Цустай баах		Шингэн уухдаа дургүй болох		Их хэмжээгээр бөөлжих		Суулгах		Ханиалгах		Тагах		Шалтгаан нь мэдэгдэхгүй уйлах		Бусад		АЗЦХ-ын 2 аюултай шинж тэмдгийг мэдлэг эх/асрамжлагчийн хувь		0-59 сартай хүүхэдтэй эх/асрамжлагчийн тоо	
	6.2	7.4	7.4	77.3	6.8	5.5	3.8	1.5	15.1	30.4	42.6	9.2	15.4	14.4	10.2	4740														
Бүгд	6.2	7.4	77.3	6.8	5.5	3.8	1.5	15.1	30.4	42.6	9.2	15.4	14.4	10.2	4740															
Бүс																														
Баруун	4.7	3.7	72.4	2.8	1.9	2.7	1.0	8.7	26.6	42.3	5.1	14.9	11.8	4.6	647															
Хангай	7.8	7.8	73.9	6.2	5.8	2.6	1.6	19.3	37.2	46.8	9.5	17.5	13.3	10.6	967															
Төв	5.7	6.1	75.0	8.3	4.7	3.6	0.9	14.8	33.9	37.1	9.0	13.6	17.9	11.4	832															
Зүүн	5.1	9.0	73.4	2.5	2.8	1.8	2.5	8.8	25.1	46.5	4.1	14.9	10.8	4.5	371															
Улаанбаатар	6.3	8.8	82.3	8.5	7.4	5.3	1.7	16.4	32.0	42.2	11.4	15.4	15.0	12.6	1923															
Хот, хөдөө																														
Хот	7.2	8.3	80.9	8.4	7.2	4.7	1.7	17.1	32.3	40.5	10.9	16.4	14.9	12.7	2934															
Хөдөө	4.6	6.1	71.3	4.1	2.8	2.4	1.1	11.9	27.2	46.0	6.4	13.8	13.6	6.1	1806															
Байршил																														
Нийслэл	6.3	8.8	82.3	8.5	7.4	5.3	1.7	16.4	32.0	42.2	11.4	15.4	15.0	12.6	1923															
Аймгийн төв	9.0	7.3	78.3	8.2	6.7	3.6	1.8	18.3	32.9	37.2	9.9	18.3	14.7	13.1	1011															
Сумын төв	5.9	8.3	72.2	6.6	3.5	2.3	1.3	13.6	27.4	41.1	7.9	12.7	15.4	8.6	557															
Хөдөө	4.0	5.1	70.9	2.9	2.5	2.4	1.1	11.1	27.1	48.2	5.7	14.2	12.8	5.0	1249															
Боловсрол																														
Боловсролгүй	5.9	6.7	68.3	2.5	1.6	1.4	1.9	8.6	21.9	55.8	5.3	12.0	8.0	4.1	242															
Бага	4.9	5.1	63.1	4.6	2.3	1.7	0.7	9.7	22.5	45.4	6.0	13.3	14.0	6.7	295															
Суурь	3.9	4.7	72.9	3.2	3.4	3.2	0.8	12.3	28.1	46.9	6.7	13.7	14.7	6.1	699															
Бүрэн дунд	5.2	8.1	81.0	6.7	6.9	3.1	1.6	15.8	31.1	40.3	10.1	16.1	13.7	11.1	1197															
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	6.0	6.8	69.9	5.9	3.7	3.6	0.4	12.4	26.9	43.5	7.2	17.6	13.3	7.9	391															
Дээд	8.0	8.6	81.3	9.2	6.8	5.2	2.0	17.8	33.7	40.2	10.8	15.8	15.8	13.0	1914															
Өрхийн аж байдлын түвшин																														
Доогуур	4.1	5.2	69.4	2.8	2.4	1.8	1.6	9.9	25.8	49.0	5.5	14.6	12.4	4.9	1000															
Дунджаас доогуур	5.2	5.9	76.0	4.9	4.3	3.5	0.9	13.0	27.8	45.2	8.3	14.8	13.1	8.7	929															
Дундаж	7.4	9.3	80.1	7.2	5.8	2.3	1.3	16.3	31.8	38.6	8.1	15.7	16.5	10.8	922															
Дунджаас дээгүүр	7.0	7.4	79.9	7.4	7.3	5.0	1.9	16.5	32.7	39.9	10.2	16.9	15.4	11.5	891															
Дээгүүр	7.5	9.4	81.3	11.6	8.0	6.4	1.9	19.8	34.0	39.8	13.7	14.9	14.8	15.4	999															
Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа*																														
Халх	6.4	8.1	77.6	7.2	6.0	4.3	1.4	15.7	32.1	42.4	9.7	16.0	15.3	11.0	3840															
Кавх	2.2	2.8	68.8	0.9	0.5	0.0	0.7	4.2	8.6	16.9	1.8	6.0	7.0	1.4	175															
Бусад	6.1	5.3	77.7	5.9	4.4	2.3	2.1	14.5	27.1	49.6	8.4	14.5	11.4	8.4	710															

* "Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа" нь харуулагдаагүй 15 ажиглагч (жигнээгүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт СН.12: Хатуу түлшний хэрэглээ

Өрхийн гишүүдийн хувь, хоолоо болгохдоо ихэвчлэн хэрэглэдэг түлшний төрлөөр, Монгол Улс, 2013 он

	Өрхийн хэрэглэдэг түлшний төрөл										Хоолоо болгохдоо хатуу түлш хэрэглэдэг ¹	Өрхийн гишүүдийн тоо
	Цахилгаан	Шингэрүүлсэн хий	Нүүрс	Шахмал түлш	Мод, бургас	Аргал, хөрзөн	Үргэс газар хооллодог	Ихэвчлэн өөр газар хооллодог	Хариулаагүй/Мэдэхгүй	Бусад/Дүн		
Бүгд	42.5	1.8	18.0	0.1	21.2	15.9	0.3	0.0	0.2	100.0	55.5	51087
Бүс												
Баруун	18.4	0.1	19.9	0.1	22.3	38.4	0.2	0.0	0.7	100.0	80.9	7002
Хангай	18.5	0.2	4.6	0.1	55.8	20.5	0.1	0.0	0.1	100.0	81.1	10438
Төв	35.2	1.8	16.5	0.0	25.2	21.0	0.2	0.0	0.2	100.0	62.8	8617
Зүүн	26.2	0.4	19.0	0.0	18.0	36.3	0.1	0.0	0.0	100.0	73.4	3848
Улаанбаатар	68.2	3.4	24.4	0.1	2.8	0.4	0.5	0.0	0.2	100.0	28.2	21182
Хот, хөдөө												
Хот	60.6	2.6	23.6	0.1	10.4	2.1	0.4	0.0	0.2	100.0	36.6	32452
Хөдөө	10.9	0.5	8.2	0.0	40.1	39.9	0.1	0.0	0.3	100.0	88.3	18635
Байршил												
Нийслэл	68.2	3.4	24.4	0.1	2.8	0.4	0.5	0.0	0.2	100.0	28.2	21182
Аймгийн төв	46.4	1.1	22.1	0.1	24.7	5.3	0.2	0.0	0.1	100.0	52.4	11270
Сумын төв	22.7	0.9	14.5	0.0	40.8	20.9	0.0	0.0	0.1	100.0	76.3	5905
Хөдөө	5.4	0.2	5.3	0.0	39.8	48.7	0.1	0.0	0.5	100.0	93.9	12730
Өрхийн тэргүүлэгчийн боловсрол*												
Боловсролгүй	10.8	0.3	15.0	0.0	35.7	37.5	0.4	0.0	0.4	100.0	88.6	4040
Бага	17.6	0.5	15.8	0.1	31.1	34.6	0.1	0.0	0.2	100.0	81.7	6679
Суурь	25.5	0.5	21.6	0.1	28.0	23.6	0.2	0.0	0.4	100.0	73.5	10405
Бүрэн дунд	50.7	2.6	19.5	0.0	18.8	7.9	0.2	0.0	0.1	100.0	46.5	9789
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	43.7	2.1	23.7	0.1	19.6	10.1	0.5	0.0	0.2	100.0	54.1	7213
Дээд	72.0	3.2	12.9	0.1	8.8	2.5	0.3	0.0	0.2	100.0	24.6	12892
Өрхийн аж байдалын түвшин												
Доогуур	0.1	0.0	2.9	0.0	35.9	60.4	0.0	0.0	0.5	100.0	99.3	10217
Дунджаас доогуур	19.0	0.2	34.4	0.1	30.8	15.0	0.3	0.0	0.1	100.0	80.7	10217
Дундаж	31.6	1.1	31.6	0.2	31.3	3.5	0.5	0.0	0.1	100.0	67.2	10221
Дунджаас дээгүүр	64.8	5.1	20.8	0.1	8.1	0.4	0.3	0.0	0.3	100.0	29.8	10215
Дээгүүр	96.9	2.5	0.2	0.0	0.1	0.0	0.2	0.0	0.1	100.0	0.5	10218
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**												
Халх	45.8	1.9	17.1	0.1	21.0	13.6	0.3	0.0	0.2	100.0	52.1	41027
Казах	14.0	0.6	44.6	0.0	8.1	32.4	0.0	0.0	0.3	100.0	85.1	1991
Бусад	32.9	1.4	16.0	0.0	25.7	23.4	0.2	0.1	0.3	100.0	65.3	7953

¹ НУТС-ны үзүүлэлт 3.15 - Хатуу түлшний хэрэглээ

* "Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин" нь хариулагддаггүй 18 ажиглагч (жигнээгүй)-ыг харуулаагүй.

** "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагддаггүй 33 ажиглагч (жигнээгүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт СН.13: Хатуу түлшний хэрэглээ, хоол хийдэг газраар

Хоолоо болгохдоо хатуу түлш хэрэглэдэг өрхийн гишүүдийн хувь, хоолоо хийдэг газраар, Монгол Улс, 2013 он

	Хоол хийдэг газар				Хоолоо болгохдоо хатуу түлш хэрэглэдэг өрхийн гишүүдийн тоо	
	Өөрийн сууцанд		Тусдаа сууцанд	Бусад газар		Дүн
	Гал тогооны тусдаа өрөөнд	Сууцны аль нэг газарт				
Бүгд	28.4	71.4	0.2	0.0	100.0	28340
Бүс						
Баруун	23.8	76.1	0.2	0.0	100.0	5663
Хангай	20.1	79.7	0.1	0.0	100.0	8468
Төв	36.8	63.0	0.1	0.0	100.0	5411
Зүүн	20.7	78.8	0.4	0.0	100.0	2824
Улаанбаатар	40.4	59.4	0.2	0.0	100.0	5976
Хот, хөдөө						
Хот	39.7	60.1	0.2	0.0	100.0	11882
Хөдөө	20.2	79.6	0.2	0.0	100.0	16458
Байршил						
Нийслэл	40.4	59.4	0.2	0.0	100.0	5976
Аймгийн төв	39.1	60.8	0.1	0.0	100.0	5906
Сумын төв	43.5	56.3	0.2	0.0	100.0	4503
Хөдөө	11.4	88.4	0.2	0.0	100.0	11955
Өрхийн тэргүүлэгчийн боловсрол*						
Боловсролгүй	11.1	88.6	0.3	0.0	100.0	3578
Бага	17.1	82.8	0.1	0.0	100.0	5454
Суурь	25.6	74.2	0.2	0.0	100.0	7648
Бүрэн дунд	36.7	63.2	0.1	0.0	100.0	4555
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	37.1	62.6	0.3	0.0	100.0	3899
Дээд	51.5	48.4	0.2	0.0	100.0	3170
Өрхийн аж байдлын түвшин						
Доогуур	2.4	97.4	0.2	0.0	100.0	10143
Дунджаас доогуур	10.1	89.7	0.2	0.0	100.0	8242
Дундаж	63.7	36.3	0.1	0.0	100.0	6866
Дунджаас дээгүүр	83.9	15.9	0.2	0.0	100.0	3042
Дээгүүр	(*)	(*)	(*)	(*)	(*)	47
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**						
Халх	28.1	71.8	0.2	0.0	100.0	21364
Казах	59.0	41.0	0.0	0.0	100.0	1695
Бусад	19.8	79.9	0.3	0.0	100.0	5195

* "Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин" нь хариулагдаагүй 10 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

** "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 25 ажиглалт (жигнээгүй)-ыг харуулаагүй.

(*) 25 хүртэлх ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

VII БҮЛЭГ

ХООЛ ТЭЖЭЭЛ

VII

Бага жинтэй төрөлт

Хүүхдийн төрөх үеийн жин зөвхөн эхийн эрүүл мэнд, хоол тэжээлийн байдлыг илтгээд зогсохгүй, нярайн эсэн мэнд торних, өсч хөгжих, удаан хугацаанд эрүүл байх, нийгэм, сэтгэл зүйн хувьд зөв хүн болж төлөвших үндэс болдог. Бага жинтэй төрөлт (2500 граммаас бага) хүүхдийн эрүүл мэндэд маш олон эрсдэлийг авчирдаг. Эхийн хэвлийд байхдаа хоол тэжээлийн дуталтай байсан хүүхэд амьдралынхаа эрт үе (эхний өдөр, сар, жилүүдэд)-д эндэх өндөр эрсдэлтэй байдаг. Эсэн мэнд амьдарч чадсан зарим нэг нь дархлааны тогтолцооны хэвийн үйл ажиллагаа алдагдах, амьдралынхаа туршид өвчлөх өндөр эрсдэлтэй, хоол тэжээлийн дуталд өртөх, булчингийн хүч багатай байх магадлалтай ажээ. Мөн ахимаг насандаа чихрийн шижин, зүрх судасны өвчнөөр өвчлөх нь элбэг тохиолддог. Түүнчлэн, бага жинтэй төрсөн хүүхдийн оюун ухаан (IQ), сэтгэн бодох чадамж нь буурдаг тул тэдний сурах ба ажиллах чадварт сөргөөр нөлөөлдөг юм.

Хөгжиж буй орнуудад тохиолдож буй бага жинтэй төрөлт нь нэн тэргүүнд эхийн эрүүл мэнд ба хоол тэжээлийн дутлаас шалтгаалж байна. Бага жинтэй төрөлтөд дараах 3 хүчин зүйл хамгийн ихээр нөлөөлдөг ажээ. Тодруулбал, эх жирэмслэхийн өмнөх хоол тэжээлийн дутал, эхийн чац бага байх явдал (ихэвчлэн хүүхэд насны тэжээлийн дутал болон өвчлөлөөс шалтгаалсан) болон жирэмсний явцад хангалтгүй хоол тэжээлтэй байснаас бага жинтэй хүүхэд төрүүлдэг. Жирэмсний явцад эхийн биеийн жин зохистой хэмжээнээс багаар нэмэгдэх нь ургийн өсөлт хоцролтын шалтгааны ихээхэн хувийг эзэлдэг юм. Харин хөгжингүй, үйлдвэржсэн орнуудад жирэмсэн эхийн тамхины хэрэглээ бага жинтэй төрөлтийн голлох шалтгаан болж байна. Мөн хөгжингүй болон хөгжиж буй орнуудад бие махбодийн өсөлт, хөгжил нь бүрэн гүйцээгүй өсвөр насны охид жирэмсэлснээр хоол тэжээлийн дуталтай ураг тээхэд хүргэж байна.

Хөгжиж буй орнуудад тулгамдаж буй дараагийн томоохон асуудлын нэг бол төрж байгаа нярайн талаас илүү хувийг төрөх үед нь жинлэхгүй байгаа явдал юм. Бага жинтэй төрөлтийн эзлэх хувийг тооцоходоо өмнө нь эрүүл мэндийн байгууллагын тоо баримтыг үндэслэн гаргадаг байв. Гэхдээ уг арга хөгжиж буй дийлэнх орнуудын хувьд алдаатай болох нь тогтоогдсон юм. Учир нь эдгээр орнуудад нярай хүүхдийн ихэнх нь гэрийн нөхцөлд төрдөг тул уг тоо баримт нийт төрөлтийг бүрэн төлөөлж чаддаггүй. Харин манай улсын хувьд бараг бүх төрөлт эмнэлэгт явагддаг бөгөөд төрсөн даруй хүүхдийн жинг хэмжих нь дадал болсон байдаг тул хөгжиж буй зарим улс орнуудтай харьцуулахад давуу талтай юм.

Зарим улс орнуудад, нэлээд олон хүхдийг төрөх үед нь жинлэдэггүй тул зөвхөн жинлэсэн хүүхдийн үзүүлэлтээр бага жинтэй төрөлтийг тооцох нь нийт төрөлтийг төлөөлж чадахгүй, алдаатай дүн гардаг тул бага жинтэй төрөлтийн тархалтыг үнэн зөв тогтоох боломжгүй юм. Иймд, НҮТС-нд 2500 граммаас бага жинтэй төрөлтийн эзлэх хувийг тогтооходоо 2 төрлийн асуултыг ашигласан. Хүүхдийн биеийн жингийн талаарх эхийн үнэлгээ (маш бага, дунджаас бага, дундаж, дунджаас их, маш их) болон хүүхдийг төрөх үед нь жинлэсэн тухай эхийн өгсөн мэдээлэл эсвэл эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дэх тэмдэглэл гэсэн 2 эх үүсвэрээс судалгааны мэдээлэл цуглуулсан.¹

Монгол Улсын хэмжээнд судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд төрсөн нийт хүүхдийн 99.3 хувийг төрөх үед нь жинлэсэн бөгөөд тэдний 5.2 хувь нь 2500 граммаас бага жинтэй төржээ (Хүснэгт NU.1). Уг үзүүлэлтийг ХХС-2010-ын үр дүнтэй (төрөх үед нь жинлэсэн хүүхэд 98.0 хувь, бага жинтэй төрөлт 4.7 хувь) харьцуулахад ижил түвшинд байна.

Бага жинтэй төрөлт болон төрөх үед нь жинлэсэн хүүхдийн эзлэх хувь бүс, хот, хөдөө, эхийн төрөх үеийн нас, төрөлт хоорондын зай болон өрхийн аж байдлын түвшнээр төдийлөн ялгаагүй байлаа (Хүснэгт NU.1). Харин эхийн боловсролын түвшин болон өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаагаар авч

¹ Тооцооллын арга зүйг дэлгэрэнгүйгээр дараах номноос харж болно. Боерма, Ж. Т., Вэйнштэйн, К. Л., Руттэйн, С.О., болон Соммерфелт, А. И., 1996. Хөгжиж байгаа орнуудын төрөх үеийн жингийн мэдээлэл: Судалгаа тусалж чадах уу? ДЭМБ-ын Бюллетень, 74(2), 209-16.

үзвэл бага жинтэй төрөлтийн түвшин бага зэргийн ялгаатай байна. Тухайлбал, казах тэргүүлэгчтэй өрхийн хүүхдүүдийн дунд бага жинтэй төрөх нь бусадтайгаа болон улсын дундажтай (5.0-5.3 хувь) харьцуулахад их буюу 10.0 хувьтай байгааг Хүснэгт NU.1-ээс харж болно.

Хоол тэжээлийн байдал

Хүүхдийн хоол тэжээлийн байдал нь тэдний эрүүл мэндийн илэрхийлэл болдог. Хэрэв хүүхэд тохиромжтой хоол хүнсээр бүрэн хангагдаж, олон дахин өвчлөхгүй, асаргаа сувилгаа сайтай байвал тэдний хоол тэжээлийн байдал сайн, өсөлт бойжилт эрчимтэй явагддаг.

Дэлхий дахинд тохиолдож буй хүүхдийн эндэгдлийн талаас илүү хувь нь хоол тэжээлийн эмгэгтэй холбоотой байна. Хоол тэжээлийн дуталтай хүүхэд түгээмэл тохиолдох хүүхдийн өвчнөөр эндэх, эсэн мэнд амьдарч чадсан зарим нь өвчлөмтгий, өсөлт бойжилтоор хоцрох эрсдэлтэй байдаг. Хоол тэжээлийн дутлын улмаас нас барсан 4 хүүхэд тутмын 3 нь хөнгөн эсвэл дунд зэргийн дуталтай байсан нь хүүхдийн эндэх эрсдэл буюу эмзэг байдал хоол тэжээлийн дутлын хүнд, хөнгөн эсэхээс хамаарахгүй болохыг илтгэж байна. Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-д өлсгөлөнг 2015 он гэхэд 1990 оны түвшнээс 50 хувиар бууруулна гэж заасан. Хоол тэжээлийн эмгэгийн тархалтыг бууруулснаар хүүхдийн эндэгдэл буурах болно.

Хоол тэжээлийн харьцангуй сайн байдалтай хүн амын мэдээнд үндэслэн тав хүртэлх насны хүүхдийн өндөр, жингийн харьцааны жишиг тархалтыг тогтоосон байдаг. Уг жишиг хүн амын тархалттай харьцуулж хоол тэжээлийн дутлыг тооцох боломжтой. Энэхүү судалгаанд ДЭМБ-ын өсөлтийн стандартад суурьлан тооцсон жишиг хүн амыг ашигласан болно². Улмаар хоол тэжээлийн байдлыг илтгэх 3 шалгуур үзүүлэлтийг жишиг хүн амын голч утгаас хэлбэлзэх стандарт хазайлт (z-оноо)-аар тодорхойлдог.

Хүүхдийн биеийн жинг насанд харьцуулсан үзүүлэлт нь цочмог ба архаг хоол тэжээлийн дутлын аль алиныг нь илэрхийлдэг. Биеийн жин, насны харьцаа нь 5 хүртэлх насны хүүхдийн голч үзүүлэлтээс 2 стандарт хазайлтаас доогуур байвал дунд эсвэл хүнд зэргийн тураалтай, харин 3 СХ-аас доогуур байвал хүнд хэлбэрийн тураалтай гэж үнэлдэг.

Биеийн өндрийг насанд харьцуулсан үзүүлэлт нь хүүхдийн хоол тэжээлийн архаг дутлыг илэрхийлэх хэмжигдэхүүн юм. Хоол тэжээлийн архаг дуталд хүүхэд өртвөл хүүхдийн өсөлт удааширч үеийнхнээсээ намхан болдог. Биеийн өндрийг насанд харьцуулсан үзүүлэлт нь 5 хүртэлх насны хүүхдийн голч утгаас 2 стандарт хазайлтаас доогуур байвал дунд эсвэл хүнд зэргийн өсөлт хоцролттой, харин 3 СХ-аас доогуур байвал хүнд хэлбэрийн өсөлт хоцролттой гэж үнэлдэг. Өсөлт хоцролт нь хүүхэд насандаа байвал зохих өндөрт хүрэхгүй буюу намхан байгааг харуулах бөгөөд энэ нь хоол тэжээлийн архаг дутлын илэрхийлэл болдог. Өсөлт хоцролт нь урт удаан хугацааны туршид хангалтгүй хооллож байсан, архаг өвчтэй болсон, олон дахин өвчилсөн зэргээс шалтгаалж үүсдэг.

Биеийн жинг өндөрт харьцуулсан үзүүлэлт нь туранхай болон илүүдэл жинтэй байдлыг илэрхийлдэг. 5 хүртэлх насны жишиг хүн амын голчоос 2 СХ доогуур байвал дунд эсвэл хүнд зэргийн туранхай, харин 3 СХ доогуур байвал хүнд хэлбэрийн туранхай гэж үнэлдэг. Хүүхэд туранхай байх нь хоол тэжээлийн хурц дутлын илэрхийлэл болно. Энэ нь ихэвчлэн улирлын байдлаас шалтгаалсан хоол хүнсний хомсдол, өвчлөлтэй холбоотой. Харин жишиг хүн амын 2 СХ дээгүүр байвал дунд болон хүнд зэргийн илүүдэл жинтэй хүүхдийг илэрхийлдэг.

НҮТС-гаар 5 хүртэлх насны хүүхдийн жин, өндрийг НҮБ-ын Хүүхдийн Сан (НҮБХС)-гаас зөвлөмж болгосон биеийн өндөр, жингийн хэмжилтийн багажийг³ ашиглан хэмжсэн. Тайлангийн энэ бүлэгт багтсан мэдээлэл нь эдгээр хэмжилтийн үр дүнд тулгуурласан юм.

Судалгааны мэдээлэл цуглуулах явцад хийсэн биеийн өндөр, жингийн хэмжилтийн үр дүнд үндэслэн тооцсон уураг илчлэг дутал (УИД)-ын тархалтыг Хүснэгт NU.2-т харуулав. Түүнчлэн, уг хүснэгтэд биеийн өндөр, жингийн хэмжилтийн 3 үзүүлэлт тус бүрийн Z-онооны дунджийг харууллаа.

Төрсөн он, сар, өдөр нь тодорхой бус хүүхэд байгаагүй (Хүснэгт DQ.8) бөгөөд биеийн өндөр, жингийн хэмжилтийн үр дүн байж болох хязгаараас хэтэрсэн хүүхдийн мэдээллийг Хүснэгт NU.2-т оруулаагүй юм. Мөн биеийн жин, өндрийн аль нэгийг нь хэмжээгүй хүүхдийн мэдээллийг хассан.

² http://www.who.int/childgrowth/standards/second_set/technical_report_2.pdf

³ ОУБТС-ны Хангамж нийлүүлэх зааврыг дараах цахим хуудаснаас харна уу. http://www.childinfo.org/mics5_planning.html

Тухайлбал, хүүхдийг жинлэсэн боловч түүний өндрийг хэмжээгүй бол уг хүүхдийн мэдээллийг тураал тооцоход ашигласан боловч өсөлт хоцролт, туранхай хүүхдийн тархалтыг тооцоход оруулаагүй болно. Судалгаанд хамрагдсан хүүхдийг насаар харьцуулж, биеийн өндөр, жингийн хэмжилтийн үр дүн байж болох хязгаараас хэтэрсэн эсвэл жин, өндрийн аль нэгийг хэмжээгүйн улмаас үр дүнгийн боловсруулалтаас хасагдсан хүүхдийн эзлэх хувийг Хүснэгт DQ.12, 13, 14-т (Хавсралт D) харууллаа. Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 4.8 хувь нь жин болон насны үзүүлэлт (Хүснэгт DQ.12), 5.2 хувь нь өндөр болон насны үзүүлэлт (Хүснэгт DQ.13), 5.4 хувь нь жин болон өндрийн үзүүлэлтийн (Хүснэгт DQ.14) тооцооноос дээрх шалтгааны улмаас хасагдсан. Харин Хүснэгт DQ.15-д биеийн хэмжилтийн үр дүнгийн тархалтыг төгсгөлийн цифрээр харуулсан. Судлаач нарын хувьд 0 болон 5-ын цифрээр хэмжилтийн үр дүнг бүхэлчлэн тэмдэглэх тохиолдлууд нэлээдгүй байдаг. Гэсэн хэдий ч энэ удаагийн судалгааны өндрийн хэмжилтүүдийн үр дүнд 0 цифрээр төгссөн тохиолдол 6.5 хувь, 5 цифрээр төгссөн тохиолдол 5.1 хувь байгаа нь 0 болон 5-ын цифр тэмдэглэхээс зайлсхийх явдал байж болзошгүйг харуулж байгаа юм.

Монгол Улсын 5 хүртэлх насны хүүхдийн 1.6 хувь нь тураалтай, 0.2 хувь нь хүнд хэлбэрийн тураалтай байна. Мөн 5 хүртэлх насны хүүхдийн 10.8 хувь нь өсөлт хоцролттой буюу намхан, 2.1 хувь нь өсөлт зогсонгишилттой (хүнд хэлбэрийн өсөлт хоцролттой), харин 1.0 хувь нь туранхай буюу хоол тэжээлийн хурц дуталтай байна (Хүснэгт NU.2). Нийт хүүхдийн 10.5 хувь нь өндөртөө тохирохгүй илүү жинтэй байв.

Хүүхдийн хоол тэжээлийн үзүүлэлтүүдийг өмнөх Хүүхэд хөгжил судалгаануудаас тооцож байсан бөгөөд 2010 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад тураалтай хүүхдийн хувь 1.7, өсөлт хоцролттой хүүхдийн хувь 4.5, туранхай хүүхдийн хувь 0.6 пунктээр тус тус буурчээ.


Баруун, Зүүн болон Хангайн бүсийн хүүхдүүд өсөлт хоцролтод өртөх магадлал бусад бүстэй харьцуулахад хамгийн өндөр байна. Тухайлбал, Баруун бүсийн 5 хүртэлх насны нийт хүүхдийн 19.5 хувь, Зүүн бүсийн нийт хүүхдийн 13.5 хувь, Хангайн бүсийн нийт хүүхдийн 12.3 хувь нь өсөлт хоцролттой байв. Түүнчлэн, хөдөөд өсөлт хоцролттой (14.5 хувь) хүүхдийн эзлэх хувь хотынхоос бараг 2 дахин (8.4 хувь) их байна.

Тав хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн байдал нь эхийн боловсролын түвшнээс хамаарч, ялгаатай байна. Бүрэн дунд эсвэл дээд боловсролтой эхчүүдийн хүүхэд тураал болон өсөлт хоцролтод өртөх эрсдэл нь боловсролгүй эсвэл бага боловсролтой эхийн хүүхэдтэй харьцуулахад бага байна.

Мөн доогуур түвшний аж байдалтай өрхөд амьдарч байгаа 5 хүртэлх насны 5 хүүхэд тутмын 1 нь буюу 18.6 хувь нь өсөлт хоцролттой байхад дээгүүр түвшний аж байдалтай өрхийн бага насны хүүхдийн ердөө 5.7 хувь нь өсөлт хоцролттой байлаа (Хүснэгт NU.2). Казах өрхийн тэргүүлэгчтэй хүүхдүүдийн дунд өсөлт хоцролт бусад хүүхдүүдтэй харьцуулахад өндөр байв.

Хүүхдийн хоол тэжээлийн байдлыг насаар авч үзэхэд 18-23 сартай хүүхдүүдийн дунд өсөлт хоцролт хамгийн өндөр (15.8 хувь) байгааг дараах зургаас харж болно (Зураг NU.1). Энэхүү дүр зураг нь энэ насны хүүхдүүд эхийн сүүгээр хооллохоо болих, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ус, хоол, хүнс, орчны сөрөг нөлөөнд өртөх эрсдэлтэй байдагтай холбоотой юм.

Зураг NU.1: 5 хүртэлх насны тураалтай, өсөлт хоцролттой, туранхай, илүүдэл жинтэй хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он



Тав хүртэлх насны нийт хүүхдийн дунд тураал болон туранхайн тархалт харьцангуй бага бөгөөд хоол тэжээлийн эдгээр дутлын тархалт бүс нутаг, өрхийн байршил, аж байдлаар төдийлөн ялгаатай бус байна (Хүснэгт NU.2).

НҮТС-нд 0-35 сартай хүүхдүүдийн эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт жин, өндрийн тэмдэглэгээ хийгдсэн эсэхийг ажигласан бөгөөд үр дүнг Хүснэгт NU.2А-д харуулсан. 0-35 сартай нийт хүүхдийн 87.9 хувийнх нь эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг судлаач үзсэн байна. Нийт 0-35 сартай хүүхдийн 43.7-44.2 хувийнх нь эрүүл мэндийн дэвтэрт сүүлийн 4 сарын хугацааны өндөр, жинг холбогдох хүснэгт тус бүрт тэмдэглэжээ. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт өндөр, жингийн тэмдэглэгээг хоёуланг нь тэмдэглэсэн 0-35 сартай хүүхдийн хувь 43.3 хувь байв. Өндөр, жингийн тэмдэглэгээ нь хүүхдийн хүйсээр төдийлөн ялгаагүй, харин өрхийн байршил, хот, хөдөө, эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай байна. Тухайлбал, боловсролгүй эхийн хүүхдүүдийн өндөр, жинг тэмдэглэсэн байдал 30.4-31.2 хувьтай байхад дээд боловсролтой эхийн хүүхдүүдийн хувьд 48.1-49.0 хувь байгаа юм. Түүнчлэн, төв суурин газраас хөдөө рүү алслагдах тусам хүүхдийн өндөр, жингийн хэмжилтийн үр дүнг эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэхгүй байх хандлага ажиглагдаж байна.

Эхийн сүүгээр хооллолт ба нялхас, бага насны хүүхдийн хооллолт

Хүүхдийг бага насанд нь тэр дундаа, амьдралынх нь эхний 2 жилийн хугацаанд зөв зохистой хооллох нь тэдний амьдрах чадварыг нэмэгдүүлэхээс гадна зохистой өсөлт, хөгжлийн суурь болдог. Хүүхдийг амьдралын эхний цөөн хэдэн жилд эхийн сүүгээр хооллох нь тэднийг халдвараас хамгаалах ба тохиромжтой шимт бодисоор хангах, түүнчлэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй хооллолт юм. Харамсалтай нь олон эхчүүд хүүхдээ хөхнөөс хэт эрт гаргах, эхийн сүү орлуулагч хэрэглэх болсон нь хүүхдийн өсөлт, хөгжил удаашрах, аминдэм эрдэс бодисын дуталд өртөх, цэвэр усан хангамж дутмаг үед хүүхэд өвчлөх зэрэг эрсдэлд хүргэдэг. Судалгаануудаас харахад эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллохын зэрэгцээ тохиромжтой, хангалттай, аюулгүй нэмэгдэл хоолыг 6 сартайгаас эхлэн өгснөөр

хүүхэд эрүүл байхаас гадна өсөлт нь хэвийн хэмжээнд явагдах, ялангуяа, хүүхдийн амьдралын эхний 2 жилийн хугацаанд өсөлт хоцролттой байх магадлалыг бууруулдаг.⁴

ДЭМБ/ НҮБХС-гаас хүүхдийг төрснөөс хойш 1 цагийн дотор эхийн сүүгээр хооллож эхлэх, эхний 6 сартайд зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллох, үргэлжлүүлэн 2 нас хүртэл нь эхийн сүүгээр хооллохыг зөвлөмж болгодог.⁵ 6 сартайгаас нь эхлэн эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ аюулгүй, насанд нь тохирсон байдлаар өтгөн, хагас өтгөн, шингэн хоол өгөх хэрэгтэй.⁶ 6-23 сартай хүүхдэд зориулсан хооллолтын үндсэн зөвлөмжийн^{7,8} нэгтгэлийг доорх хүснэгтэд харуулсан бөгөөд уг судалгаанаас тооцсон зөвлөмжийг үнэлэх төлөөний үзүүлэлтийг мөн үзүүлээ.

Төлөөний болон шалгуур үзүүлэлтэд тавигдах үндсэн зөвлөмж, зарчим нь:

1. Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллох
2. Хоолыг зохих давтамжаар идэх (гэхдээ хоол хүнснээс авах илчлэгийн хэмжээ хамаарахгүй)
3. Хоолонд байх тохиромжтой шим тэжээлийн агууламж.

Хүүхдэд тэдний насанд тохирсон давтамжаар хоол, хүнснийг (эхийн сүүгээр хооллодоггүй хүүхдийн хувьд сүүн бүтээгдэхүүн) өгч байгаа давтамж нь хоол, хүнснээс авах илчлэгийн төлөөлөх үзүүлэлт болж байгаа юм. Нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулсан гэдэг нь хэрэглэж буй хоол хүнсний (төмөр агуулсан биш) зохимжтой шимт бодисын агууламжийг тогтооход ашиглагддаг. 7 төрлийн хүнсний бүлгээс наад зах нь 4 төрлийг идсэн бол тухайн хүүхэд нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идсэн гэж үзсэн. 4 төрлийн хүнсний бүлгийн хэрэглээ гэдэгт хүүхэд наад зах нь амьтны гаралтай бүтээгдэхүүн, жимс эсвэл хүнсний ногоо болон гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн (үр тариа, үндэст болон булцуут хүнсний бүтээгдэхүүн) хэрэглэсэн байхыг ойлгоно.⁹

Зохистой хооллож байгаа хүүхдийг үнэлэхдээ хүүхдийн хооллолтын дээрх 3 ойлголтыг нэгтгэн “зохистой байдлаар хооллож байгаа хүүхэд” гэсэн үзүүлэлтийг ашигласан. Зохистой байдлаар хооллож байгаа хүүхэд дараах хоол хүнсний судалгааны өмнөх 1 өдрийн дотор идсэн байх ёстой:

1. Хоол, сүүн бүтээгдэхүүнийг зохих давтамжаар идэх
2. Нэмэгдэл хоолыг наад зах нь 4 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр баяжуулан идсэн байх
3. Эхийн сүүгээр хооллох эсвэл сүүн бүтээгдэхүүн (хярам, тараг, аарц гэх мэт) наад зах нь 2 удаа (эхийн сүүгээр хооллодоггүй хүүхдийн хувьд) хэрэглэх.

⁴Бута.З болон бусад. (2013 он). Эх, хүүхдийн хоол тэжээлийг сайжруулахын тулд баримтад суурилсан бодлого хөтөлбөр: ямар зардлаар юуг хийж чадах вэ? Лансет, 2013 оны 6 сарын 6.

⁵ДЭМБ (2003он). Нялхас болон бага насны хүүхдийн хооллолтын дэлхий нийтийн стратегийг хэрэгжүүлэх нь. Уулзалтын тайлан, Женева, 2003 оны 2 дугаар сарын 3-5.

⁶ДЭМБ (2003 он). Нялхас болон бага насны хүүхдийн хооллолтын дэлхий нийтийн стратеги.

⁷Пан Америкийн Эрүүл мэндийн байгууллага (2003 он). Эхийн сүүгээр хооллож буй хүүхдэд зориулсан нэмэгдэл хооллолтын зарчим, зөвлөмж.

⁸ДЭМБ (2005 он). 6-24 сартай эхийн сүүгээр хооллодоггүй хүүхдэд зориулсан хооллолтын зарчим, зөвлөмж.

⁹ДЭМБ (2008 он). Нялхас болон бага насны хүүхдийн хооллолтыг үнэлэх үзүүлэлтүүд. 1 дүгээр хэсэг: Тодорхойлолт.

Зөвлөмж (6-23 сартай хүүхэд)	Шууд үзүүлэлт	Хүснэгт
2 ба түүнээс дээш настай хүүхдийг хүссэн үед нь, аль болох олон удаа эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллоно.	Сүүлийн 24 цагт эхийн сүүгээр хооллосон	NU.4
Хоолны ичлэг чанар, хооллох давтамж нь хүүхдийн насанд тохирсон байна.	Эхийн сүүгээр хооллодог хүүхэд Сүүлийн 24 цагт хүүхдэд түүний насыг харгалзан нэмэгдэл хоол/хөнгөн зуушыг 2 эсвэл 3 удаа өгсөн байх	NU.6
Хоол, хүнсний шимт бодисын агууламж нь тохиромжтой байна.	Эхийн сүүгээр хооллодоггүй хүүхэд Сүүлийн 24 цагт хоол/хөнгөн зууш ба/эсвэл сүүн бүтээгдэхүүнийг (сүү, тараг, аарц гэх мэт)-ийг 4 удаа өгсөн байх Сүүлийн 24 цагт 4 бүлэг хүнсний бүтээгдэхүүнийг идсэн байх. ¹	NU.6
Хүүхдэд 1 удаад өгөх хоолны хэмжээ нь тохиромжтой байна.	Стандарт үзүүлэлт байхгүй	байхгүй
Хоолны төлөв байдал нь тохиромжтой байна.	Стандарт үзүүлэлт байхгүй	байхгүй
Эх, нэг хүртэлх насны хүүхэд аминдэм, эрдэсийн бэлдмэл (нэмэлт бүтээгдэхүүн) эсвэл баяжуулсан хүнс хэрэглэнэ.	Стандарт үзүүлэлт байхгүй	байхгүй
Эрүүл ахуйн зохистой дадал, хоол, хүнсгүй зөв харьцаа	Хөтөлбөрийн үзэл баримтлалыг бүрэн илэрхийлэх үзүүлэлтүүдийг боловсруулах боломжгүй юм. Нэг стандарт үзүүлэлт нь уг зарчмын нэг хэсгийг илэрхийлж чадахгүй: Угжаар хооллохгүй байх	NU.9
Нийгэм, сэтгэл зүйн тусламжийн зарчмыг баримтлан хүүхдийг идэвхтэй хооллоно.	Стандарт үзүүлэлт байхгүй	байхгүй

Хүснэгт NU.3-т сүүлийн 2 жилийн хугацаанд төрүүлсэн сүүлийн хүүхдийн хувьд эхийн мэдээлснээр тухайн хүүхдийн амьдралынхаа эхний өдрүүдэд уусан зүйлийн талаар харуулсан. Тодруулбал, эхийн сүүгээр хооллож байсан, төрсний дараа 1 цаг эсвэл 1 өдрийн дотор ангир уургаа амласан, ангир уургаа амлахаас өмнө ямар нэгэн зүйлээр хооллосон¹⁰ хувь юм. Эх, хүүхдийн хооронд бие махбодийн болон сэтгэл зүйн холбоо үүсгэх, эхийн сүүгээр хооллолтын хамгийн чухал үе бол эрт амлуулалт байдаг бөгөөд шинээр мэндэлсэн хүүхдүүдийн 71.1 хувь нь төрсний дараа нэг цагийн дотор, 93.7 хувь нь 1 хоногийн дотор хүүхдэдээ ангир уургаа амалжээ. Уг 2 үзүүлэлт ХХС-2010-ын түвшинтэй (харгалзан 71.4 болон 92.1 хувь) харьцуулахад үндсэндээ ижил түвшинд байна.


Ангир уургаа эрт амлуулсан байдлыг хот, хөдөө болон бүсээр авч үзэхэд ялгаа төдийлөн ажиглагдсангүй (Зураг NU.2).

Төрсний дараа 1 цаг болон 1 хоногийн дотор ангир уургаа амласан 0-23 сартай хүүхдийн эзлэх хувь өрхийн байршил, эхийн боловсрол, өрхийн аж байдлаар төдийлэн ялгаагүй, харьцангуй ижил түвшинд байгааг Хүснэгт NU.3-аас харж болно. Казак тэргүүлэгчтэй өрхийн хүүхдүүдийн 60.5 хувь, харин халх болон бусад тэргүүлэгчтэй өрхийн хүүхдүүдийн 71.1-73.7 хувь нь төрсний дараа 1 цагийн дотор ангир уургаа амласан байв (Хүснэгт NU.3).

Түүнчлэн, Хүснэгт NU.3-аас харахад ангир уургаа амлахаас өмнө эхийн сүүнээс өөр ямар нэгэн шингэнээр хооллосон хүүхэд 26.4 хувь байна. Ангир уургаа амлахаас өмнө эхийн сүүнээс өөр ямар нэгэн шингэнээр хооллох нь эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай байв. Дээгүүр аж байдалтай болон дээд боловсролтой эхийн хүүхдүүд ангир уургаа амлахаас өмнө эхийн сүүнээс өөр ямар нэгэн шингэнээр хооллох нь өндөр хувьтай байлаа.

¹⁰ Өөр шингэн зүйлээр хооллосон гэдэг нь эхийн сүү бүрэлдэж байх хугацаанд (энд амьдралын эхний 3 өдөр гэж тооцсон) хүүхдэд өгсөн эхийн сүүнээс бусад шингэн эсвэл хоол хүнсийг авч үзсэн.

Зураг NU.2: Төрсний дараах 1 цаг эсвэл 1 өдрийн дотор хүүхэддээ ангир уургаа амлуулсан эхчүүдийн хувь, Монгол Улс, 2013 он



Хүснэгт NU.4-өөс NU.8-д нялхас болон бага насны хүүхдийн хооллолтын үзүүлэлтийг харуулсан бөгөөд эдгээр нь мэдээлэл цуглуулсан өдрөөс өмнөх 1 хоногийн хугацаанд идсэн хоол болон уусан шингэний талаарх ээжийн мэдээлэлд үндэслэсэн. Бүрэн мэдээлэлгүй байдал буюу эх нь тодорхой санахгүй байх эсвэл хүүхдийг өөр хүн хооллосон тохиолдол мэдээлэл цуглуулах явцад гарсныг энд дурдах нь зүйтэй

Судалгааны өмнөх 24 цагийн хугацаанд хүүхдийн эхийн сүүгээр хооллолт, шингэн зүйлсийн хэрэглээний талаарх мэдээллийг Хүснэгт NU.4-г харууллаа. Эхийн сүүгээр дагнан хооллолт гэдэгт хүүхэд зөвхөн эхийн сүүгээр хооллосон байхыг ойлгоно (аминдэм, эрдэсийн бэлдмэл эсвэл эм хэрэглэсэн байж болно). Уг хүснэгтэд амьдралынхаа эхний 6 сар хүртлээ эхийн сүүгээр дагнан хооллосон, мөн 12-15 ба 20-23 сар хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон хүүхдийн эзлэх хувийг үзүүлэв.

Зургаа хүртэл сартай нийт хүүхдийн 47.1 хувь эхийн сүүгээр дагнан хооллосон байна. Үүнийг ХХС-2010-тай харьцуулахад (65.7 хувь) буурчээ. Судалгааны дүнгээс 6 хүртэлх сартай нийт хүүхдийн 55.7 хувь нь эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ ус, шингэн зүйлийг уусан байгаа нь ус, шингэн зүйлээр эхийн сүүг орлуулах нь элбэг байгааг харуулж байна. Түүнчлэн, 12-15 сартай хүүхдийн 82.5 хувь, 20-23 сартай хүүхдийн 52.9 хувь нь эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байв.

Эхийн сүүгээр дагнан хооллосон 0-5 сартай хүүхдийн эзлэх хувь Баруун бүсэд хамгийн өндөр (59.9 хувь), Төвийн бүсэд хамгийн бага (33.6 хувь) байна. Хөвгүүдийг (85.0 болон 53.6 хувь) охидтой харьцуулахад (80.2 болон 52.0 хувь) эхийн сүүгээр 1 ба 2 нас хүртэл үргэлжлүүлэн хооллох нь бага зэрэг илүү байх хандлагатай байна. Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолтыг бүсээр авч үзэхэд Зүүн бүсэд хамгийн доогуур (73.5 болон 44.2 хувь) байхад 1 нас хүртэл эхийн сүүгээр хооллох нь Баруун болон Хангайн бүсэд (85.9-86.3 хувь), харин 2 нас хүртэл эхийн сүүгээр хооллох нь Төвийн бүсэд (57.7 хувь) хамгийн өндөр байлаа.

Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолт нь өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай бөгөөд 1 болон 2 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллох нь дээгүүр аж байдалтай өрхийн хүүхдүүдийн дунд хамгийн бага бол дундаж аж байдалтай өрхийн хүүхдүүдийн дунд хамгийн өндөр байна. Дээрх

үзүүлэлтүүд нь өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаагаар ижил түвшинд байгааг Хүснэгт NU.4-өөс харж болно.

Хүүхдийн эхийн сүүгээр хооллолтын үргэлжлэх голч хугацааг сонгосон үзүүлэлтээр харьцуулан Хүснэгт NU.5-д харуулав. Тухайлбал, 3 хүртэлх насны хүүхдийн эхийн сүүгээр хооллох голч хугацаа 22.7 сар, эхийн сүүгээр дагнан хооллолтын голч хугацаа 2.3 сар, эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ ус, шингэн ууж байгаа голч хугацаа 3.0 сар байна. Эхийн сүүгээр хооллож байгаа голч хугацааг ХХС-2010-ны үр дүнтэй харьцуулахад 1.3-1.7 сараар буурчээ. Судалгаанд хамрагдсан 3 хүртэлх насны хүүхдийн эхийн сүүгээр дагнан хооллосон болон эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ ус, шингэн зүйл уусан голч хугацаа шинж байдлаар төдийлөн ялгаагүй байна (Хүснэгт NU.5).

24 хүртэлх сартай хүүхдийн насандаа тохирсон байдлаар хооллолтын талаарх үзүүлэлтүүдийг Хүснэгт NU.6-д харуулав. Хүүхдийн насандаа тохирсон байдлаар хооллолтыг тэдний наснаас хамаарсан харилцан адилгүй шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон. Тухайлбал, 0-5 сартай хүүхдийн хувьд эхийн сүүгээр дагнан хооллолт нь насандаа тохирсон хооллолтын үзүүлэлт болдог бол 6-23 сартай хүүхдийн хувьд эхийн сүүнээс гадна нэмэгдэл хоол (шингэн, хагас шингэн, өтгөн) хүнс хэрэглэхийг зөвлөдөг.

Бага насны хүүхдийн насандаа тохирсон хооллолтын үр дүнгээс харахад 6-23 сартай хүүхдүүдийн 73.2 хувь эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ, өтгөн, өтгөвтөр, хөнгөн хоол хүнс хэрэглэж байна. Түүнчлэн 0-23 сартай нийт хүүхдийн 66.3 хувь нь насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож байв. Эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ нэмэгдэл хоол, хүнс хэрэглэж байгаа хүүхдийн эзлэх хувь хүйс, хот, хөдөөгөөр төдийлөн ялгаагүй байгааг Хүснэгт NU.6-аас харж болно. Насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож байгаа 2 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь бүс нутгаар бага зэрэг ялгаатай буюу Төвийн бүс (61.3 хувь) болон Баруун бүсийн (71.3 хувь) хувьд 10.0 пунктын зөрүүтэй байна.

Судалгаанд хамрагдсан 6-8 сартай нийт хүүхдийн 94.8 хувь нь өтгөн, өтгөвтөр эсвэл хөнгөн нэмэгдэл хоол хүнс хэрэглэж байна. Уг үзүүлэлт эхийн сүүгээр хооллодог 6-8 сартай хүүхдийн дунд 94.4 хувьтай байна (Хүснэгт NU.7). Дээрх хүснэгтээс харахад зохих насандаа нэмэгдэл хоолонд орсон хүүхдийн эзлэх хувь хүйс, хот, хөдөө, бүс, эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшнээр төдийлөн зөрүүгүй байгаа юм. Зүүн бүсийн хувьд судалгаанд хамрагдсан 6-8 сартай нийт хүүхдийн тоо (үзүүлэлтийн хуваарь) бага байгаа тул үзүүлэлтийг шууд ашиглаж болохгүйг анхаарна уу.

Хүснэгт NU.8-д судалгааны мэдээлэл цуглуулахын өмнөх өдөр өтгөн, өтгөвтөр эсвэл хөнгөн хоол, хүнсийг зохих давтамжаар идсэн, нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идсэн болон зохистой байдлаар хооллож байгаа 6-23 сартай хүүхдийн эзлэх хувийг тэдний эхийн сүүгээр хооллолтын байдлаар харьцуулан үзүүллээ.

Нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идэж байгаа хүүхэд гэдэгт сүүлийн 24 цагийн хугацаанд 4 ба түүнээс олон төрлийн хүнсний бүтээгдэхүүний орц бүхий нэмэгдэл хоол идсэн тохиолдлыг авч үзсэн. Харин зохистой байдлаар хооллож байгаа хүүхэд гэдгийг эхийн сүүгээр хооллож байгаа болон хооллохгүй байгаа хүүхдүүдийн хувьд ялгаатай байдлаар томъёолдог. Тодруулбал, эхийн сүүгээр хооллож байгаа хүүхдийн хувьд судалгаанаас өмнөх 1 хоногт нэмэгдэл хоолыг зохих давтамжаар, зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан хэрэглэж байгаа бол, харин эхийн сүүгээр хооллохгүй байгаа хүүхдийн хувьд судалгаанаас өмнөх 1 хоногт наад зах нь 2 удаа сүү уусан бөгөөд нэмэгдэл хоолыг зохих давтамжаар, зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан (уусан сүүг оруулахгүй) хэрэглэж байгаа бол зохистой байдлаар хооллож байна гэж үзсэн.

Эхийн сүүгээр хооллодог 6-23 сартай 10 хүүхэд тутмын 5 (47.7 хувь) нь нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулж, 7 (69.2 хувь) нь нэмэгдэл хоол, хүнсийг өдөрт идвэл зохих хамгийн бага давтамжаар, 4 (37.6 хувь) нь зохистой байдлаар хооллож байна. Зохистой хооллолтын дээрх 3 үзүүлэлт нь эхийн сүүгээр хооллодог хүүхдүүдийн хувьд хүйсээр ялгаагүй байгаа боловч хот, хөдөө, өрхийн байршил болон аж байдал, эхийн боловсролын түвшнээр нэлээд ялгаатай байлаа (Хүснэгт NU.8).

Эхийн сүүгээр хооллодоггүй 6-23 сартай хүүхэд өдөрт хамгийн багадаа 2 удаа сүү, цагаан идээ өгөхөөс гадна нэмэгдэл хоол эсвэл сүү, сүүн бүтээгдэхүүнийг өдөрт 4 ба түүнээс олон удаа өгөх шаардлагатай байдаг. Судалгаанд хамрагдсан хөхөө хөхдөггүй 6-23 сартай нийт хүүхдийн 56.3 хувь нь өдөрт наад зах нь 2 удаа сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэдэг бөгөөд хүйсийн хувьд ялгаагүй байна (Хүснэгт NU.8). Эхийн сүүгээр хооллодоггүй хүүхдүүдийн хувьд нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулж (60.4 хувь) эсвэл нэмэгдэл хоол, хүнсийг өдөрт идвэл зохих хамгийн

бага давтамжаар (69.6 хувь) идэх нь эхийн сүүгээр хооллодог хүүхэдтэй ижил түвшинд байгаа юм. Харин эхийн сүүгээр хооллодоггүй хүүхдийн хувьд зохистой хооллолт нь 24.3 хувь буюу эхийн сүүгээр хооллодог хүүхэдтэй харьцуулахад 13.3 пунктээр бага байлаа. Эхийн сүүгээр хооллодоггүй хүүхдүүдийн хувьд бага насны хүүхдийн зохистой хооллолтын дээрх 3 үзүүлэлт шинж байдлаар эхийн сүүгээр хооллодог хүүхдийнхтэй ижил байгааг Хүснэгт NU.8-аас харж болно.

Манай улсад хүүхэд нэмэгдэл хоолоор зохистой хооллож чадахгүй байгаа нь 6-23 сартай 3 хүүхэд тутмын ердөө 1 нь (34.5 хувь) өдөрт идвэл зохих давтамжийн дагуу нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идсэнээс харагдана. Улсын хэмжээнд бага насны хүүхдэд хоол хүнсийг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идүүлэх нь 50.8 хувь байна. Харин нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идэж байгаа 6-23 сартай хүүхэд бусад үзүүлэлттэй харьцуулахад өндөр буюу 69.3 хувь байв. 6-23 сартай хүүхдүүдийн зохистой хооллолтын үзүүлэлтүүд хүйсээр ялгаагүй боловч хот, хөдөө, эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлаар ялгаатай байгааг Хүснэгт NU.8-аас харж болно. Тодруулбал, боловсролгүй эхийн 6-23 сартай хүүхдүүдийн дунд зохистой хооллолт ердөө 11.1 хувь байгааг дээд боловсролтой эхийн хүүхдүүдтэй (46.4 хувь) харьцуулахад 4.2 дахин бага байна. Мөн өрхийн аж байдлын түвшин дээшлэх тусам хүүхдийг зохистой байдлаар хооллох нь нэмэгдэж байлаа.

Угжаар шингэн зүйл уух нь бохирдсон ус хэрэглэх эсвэл хоол хүнс бэлтгэхдээ эрүүл ахуйн зохистой дадал баримтлаагүй тохиолдолд халдвар дамжуулах эрсдэлийг бий болгодог. 0-23 сартай хүүхдүүдийн дунд угжаар хооллолт түгээмэл байсаар байна. Хоёр хүртэлх насны бараг 3 хүүхэд тутмын 1 нь (28.9 хувь) судалгаанаас өмнөх 1 хоногт угжаар шингэн зүйл уусан байлаа. Хүснэгт NU.9-аас харахад 6-11 сартай хүүхдэд шингэнийг угжаар өгөх хандлага бусад насны хүүхэдтэй харьцуулахад өндөр (40.2 хувь) байна. Түүнчлэн, хотын 0-23 сартай хүүхдүүдэд угжаар уулгах нь (32.1 хувь) хөдөөгийн хүүхдүүдтэй (23.5 хувь) харьцуулахад мөн л их байгааг харж болно. Эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшин дээшлэх тусам 2 хүртэлх насны хүүхдийг угжаар хооллох хандлагатай байна (Хүснэгт NU.9).

Иоджуулсан давсны хэрэглээ

Иод дутлын эмгэг (ИДЭ) нь бага насны хүүхдийн дунд тохиолддог оюун ухааны хомсдол, сэтгэхүйн болон бие махбодийн хөгжил саатах эмгэгийн тэргүүлэх шалтгаан болж байгаа хэдий ч урьдчилан сэргийлж болдог онцлогтой. Нэлээд хүнд хэлбэрийн иодын дутал нь кретинизмын шалтгаан болдог. Түүнчлэн, жирэмсэн эмэгтэйчүүд иодын дуталтай байвал дутуу төрөх, зулбах эрсдэлтэй. Иод дутлын үед хамгийн түгээмэл илэрдэг шинж бол бамбай булчирхайн томролт буюу бахлуур юм. ИДЭ-ийн хамгийн гол үр дагавар нь оюун ухааны хөгжил хоцрох, улмаар сурах чадвар ба оюуны чадамж буурах, хөдөлмөрлөх чадвар алдагдах зэрэг юм. Олон улсын түвшинд 2005 он гэхэд иод дутлыг бүрэн устгах зорилт тавьсан билээ. Судалгаагаар зохистой түвшинд иоджуулагдсан давс (≥ 15 мг/кг) хэрэглэж буй өрхийн эзлэх хувийг үндсэн үзүүлэлт болгон ашигласан юм.

Манай улсын нутаг дэвсгэрийн 80 гаруй хувь нь иодын дуталтай бүс нутагт хамрагддаг тул 1992-1995 онд ИДЭ-ийн тархалтыг үндэсний түвшинд тогтоох судалгааг НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. Энэхүү судалгаагаар МУ-ын 7-12 насны хүүхдийн 29 хувь нь бахлууртай байгааг илрүүлсэн юм. Судалгааны дүнгээр зарим орон нутагт ИДЭ-ийн тархалт анхаарал татахуйц өндөр байсан тул МУ-ын Засгийн газраас “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” үндэсний анхдагч хөтөлбөрийг боловсруулж, 1996-2001 онд, 2 ба 3 дахь шатны хөтөлбөрийг 2002-2006 ба 2007-2010 онд батлан хэрэгжүүлсэн.

ИДЭ-тэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд МУ-ын Засгийн газраас иоджуулсан давсны үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хүн амын иод дутал, иоджуулсан давсны талаарх мэдлэгийг сайжруулах, иоджуулсан давс хэрэглэх хандлага, дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг хэрэгжүүлсэн.

“Иоджуулсан давсны үндэсний стандарт” (2001), “Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай” МУ-ын хууль (2003), Баяжуулсан бүтээгдэхүүнд хяналт тавих журам (2006) зэрэг эрх зүйн баримт бичгийг батлан хэрэгжүүлж, зөвхөн иоджуулсан давсыг хүнсний зориулалтаар хэрэглэж байхаар хуульчилсан

юм.


ИДЭ-тэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхлэх үе буюу 1996 оноос хүн амын хүнсний хэрэглээнд иоджуулсан давсыг анх нэвтрүүлсэн бөгөөд хөтөлбөр хэрэгжих явцад өрхийн иоджуулсан давсны хэрэглээ тасралтгүй нэмэгдэж байна.

МУ-ын үндэсний стандартад хүнсний давсыг зөвхөн кали иодатаар иоджуулахыг зөвшөөрсөн байдаг. Иймд судалгаанд хамрагдсан өрхийн давсны дээж иод агуулсан эсэхийг тодорхойлохдоо зөвхөн кали иодат (KIO_3)-ыг илрүүлэх хурдавчилсан шалгуур ашиглав. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 95 хувийнх нь хоол хүнсээ бэлтгэхдээ хэрэглэдэг давсны иодын агууламжийг кали иодатыг илрүүлэх хурдавчилсан шалгуураар шалгасан.

Хүснэгт NU.10-аас харахад маш цөөн тооны өрх (0.6 хувь) судалгааны үед давсгүй байжээ. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 74.5 хувь нь 15 мг/кг ба түүнээс их хэмжээгээр иод агуулсан буюу зохистой түвшинд иоджуулсан давс хэрэглэж байна. Үүнийг ХХС-2010-ын үр дүнтэй (69.9 хувь) харьцуулахад үндсэндээ өөрчлөлтгүй юм. Өрхийн иоджуулсан давсны хэрэглээ байршлын хувьд нэлээд ялгаатай байна. Тухайлбал, хот суурин газрын 4 өрх тутмын 3 нь (78.0 хувь), харин хөдөөгийн өрхийн 68.3 хувь нь зохистой түвшинд иоджуулсан давс хэрэглэж байв. Зохистой түвшинд иоджуулсан давсны хэрэглээ Баруун бүсэд хамгийн бага буюу 47.4 хувь байхад Зүүн бүсэд хамгийн өндөр (90.6 хувь) байлаа (Зураг NU.4).

Зохистой түвшинд иоджуулсан давсны хэрэглээ өрхийн аж байдалтай ихээхэн хамааралтай бөгөөд өрхийн аж байдал сайжрах тусам иоджуулсан давсны хэрэглээ нэмэгдэж байна. Тухайлбал, доогуур аж байдалтай өрхийн 63.8 хувь, харин бусад аж байдалтай өрхийн 74.3-79.5 хувь нь зохистой түвшинд иоджуулсан давс хэрэглэж байв (Хүснэгт NU.10).

Зураг NU.4: Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн хувь, Монгол Улс, 2013 он



А аминдэм болон баяжуулсан хоол хүнсний хэрэглээ

А аминдэм дархлааны тогтолцооны хэвийн үйл ажиллагаа болон нүдний эрүүл мэндэд зайлшгүй шаардлагатай. А аминдэм сүү, элэг, өндөг, улаан ба улбар шар жимс, улаан наргил модны тос, ногоон өнгийн навчит ногоонд арвин агуулагддаг. Эдгээр хүнс хүний бие махбодийн А аминдэмийн хэрэгцээг шууд хангах эх үүсвэр болж чадна. Хөгжиж буй орны хүн ам жимс, ногооноос А аминдэмийг авдаг боловч, тэдгээрийн 1 хүнд ногдох хэмжээ нь хоол хүнсээр авбал зохих шаардлагатай түвшинд хүрэхгүй байна. Ялангуяа 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өндөртэй хөгжиж буй орнуудад А аминдэмийн дутал нэлээд түгээмэл тохиолдож байна.

Хүүхдийн асуудлаарх 1990 онд зохион байгуулагдсан дэлхийн дээд хэмжээний уулзалтаар 2000 он

гэхэд А аминдэмийн дутал ба сохролыг бүрэн устгах зорилт тавьсан билээ. Энэхүү зорилтыг 1991 оны “Далд өлсгөлөнг устгая” бодлогын бага хурал, 1992 оны Хоол тэжээлийн Олон Улсын Хурал, НҮБ-ын Ерөнхий чуулганы 2002 оны хүүхдийн асуудлаарх тусгай хуралдаанаар хэлэлцэн баталсан. А аминдэмийн дутлыг бууруулах нь хүүхдийн эсэн мэнд амьдралыг дэмжих, түүнчлэн, 2015 он гэхэд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг гуравны хоёроор бууруулах МХЗ-ыг хангахад шийдвэрлэх үүрэгтэй юм.

А аминдэмийн дутал нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж буй улс орнуудад 6-59 сартай бүх хүүхдийг 6 сар тутамд өндөр тунт А аминдэмээр хангах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Бага насны хүүхдийг жилд 2 удаа өндөр тунт А аминдэмээр хангах нь А аминдэмийн дутлыг устгах, хүүхдийн эсэн мэнд амьдралыг дэмжих аюулгүй, эдийн засгийн үр ашигтай, үр дүнтэй арга юм. Судалгаагаар хүүхдийг А аминдэмээр хангах хөтөлбөр хэрэгжүүлж буй улс орнуудад сүүлийн 6 сарын дотор ядаж нэг удаа өндөр тунт А аминдэмийн бэлдмэл хэрэглэсэн 6-59 сартай хүүхдийн эзлэх хувийг тодорхойлсон.

ДЭМБ/ НҮБХС-гийн удирдамжид тулгуурлан МУ-ын Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-наас 6-11 сартай хүүхдийг нэг удаа, 12-59 сартай хүүхдийг 6 сар тутамд өндөр тунт А аминдэмийн бэлдмэлээр хангахыг зөвлөдөг. Манай улс бага насны хүүхдийг өндөр тунт А аминдэмээр хангах ажлыг жил бүрийн 5, 10 дугаар саруудад дархлаажуулалтын арга хэмжээтэй уялдуулан зохион байгуулж байна.

НҮТС-ны мэдээлэл цуглуулахын өмнөх 6 сарын хугацаанд 6-23 сартай хүүхдийн 82.9 хувь нь өндөр тунт А аминдэмийг хэрэглэжээ. Хот, хөдөөгийн 6-23 сартай хүүхдүүдийн өндөр тунт А аминдэмийн хэрэглээ төдийлэн ялгаагүй байгааг судалгааны дүн харуулж байна (Хүснэгт NU.12). Судалгаанаас өмнөх 6 сарын хугацаанд 6-11 сартай нийт хүүхдийн 68.6 хувь, харин 12-23 сартай хүүхдийн 90.7 хувь нь өндөр тунт А аминдэм хэрэглэжээ. Харин А аминдэмийн хэрэглээ хүүхдийн хүйс, өрхийн байршил болон аж байдлаар төдийлөн ялгаагүй байна.

Энэ удаагийн судалгаанд нэмж тооцсон бас нэг үзүүлэлт нь бага насны тэр дундаа, 6-23 сартай хүүхдүүдийн А аминдэмээр баялаг хоол хүнсний хэрэглээ юм. Хүснэгт NU.12-т 6-23 сартай хүүхдийн А аминдэмээр баялаг хоол хүнсний хэрэглээг харуулсан. А аминдэмээр баялаг хүнсний бүтээгдэхүүн гэдэгт мал, гахай, шувууны мах, дотор мах, загас, өндөг, лууван, хулуу, амтат төмс зэрэг дотроо шар, улбар шар өнгөтэй бүтээгдэхүүн болон шар өнгийн нухаш, брокколи, бууцай зэрэг ногоон өнгийн навчит хүнсний ногоо, шийгуа, жүрж, манго зэрэг А аминдэмээр баялаг жимсийг оруулсан.

Сүүлийн 24 цагийн хугацаанд А аминдэмээр баялаг хоол хүнс идсэн 6-23 сартай хүүхэд улсын хэмжээнд 92.3 хувь байлаа. Уг үзүүлэлт нь хүйс болон хот, хөдөө, өрхийн байршлаар төдийлөн ялгаагүй байв. Насны хувьд авч үзэхэд 6-11 сартай нийт хүүхдийн 85.2 хувь нь сүүлийн 24 цагт А аминдэмээр баялаг хоол, хүнс идсэн байхад 12-23 сартай хүүхдүүдийн дунд 96.1 хувьтай байв. Өрхийн аж байдлын түвшин сайжрах тусам хүүхдийн А аминдэмээр баялаг хоол хүнс хэрэглэх нь нэмэгдэх хандлагатай байгааг хүснэгт NU.12-оос харж болно.

Бага насны хүүхдийн дунд цус багадалт өвчин нэлээдгүй байдаг бөгөөд төмрийн бэлдмэл болон төмрөөр баялаг хоол хүнс хэрэглэснээр төмөр дутлын цус багадалтыг эмчлэх болон урьдчилан сэргийлэхэд тустай байдаг. Энэ удаагийн судалгаанд бага насны хүүхдийн хоол тэжээлийн асуулгаас төмрөөр баялаг хоол хүнсний хэрэглээг тооцсон.

6-23 сартай хүүхдийн хувьд төмрөөр баялаг хоол хүнсний хэрэглээг тооцохдоо сүүлийн 24 цагт мал, гахай, шувууны мах, дотор мах, загас, өндөг идсэн тохиолдлыг оруулсан. Судалгааны дүнгээс харахад 6-23 сартай нийт хүүхдийн 89.8 хувь нь сүүлийн 24 цагт төмрөөр баялаг хоол хүнс хэрэглэжээ. Бага насны хүүхдийн төмрөөр баялаг хоол хүнсний хэрэглээ шинж байдлаараа А аминдэмээр баялаг хоол хүнсний хэрэглээтэй ижил байна.

Түүнчлэн, Хүснэгт NU.12-т иоджуулсан давс хэрэглэдэг өрхөд амьдардаг 6-59 сартай хүүхдийн хувийг харуулсан. Уг үзүүлэлт нь Хүснэгт NU.10-т харуулсан иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн түвшин болон шинж байдалтай ижил байгаа юм.

Хүснэгт NU.1: Бага жинтэй төрөлт

Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд 2500 грамаас бага жинтэй төрсөн хүүхдийн хувь, төрөх үед нь жинлэсэн амьд төрөлтийн хувь, Монгол Улс, 2013 он

	Төрөлтийн хувь, төрөх үеийн хэмжээг эхийн үнэлсэнээр						Амьд төрөлтийн хувь:		Судалгаанаас өмнөх 2 жилд төрүүлсэн сүүлийн хүүхдийн тоо
	Маш бага	Дунджаас бага	Дундаж	Дунджаас том, маш том	Мэдэхгүй	Нийт	2,500 грамаас бага жинтэй ¹	Төрөх үед нь жинлэсэн ²	
Дүн	1.3	11.1	63.1	24.1	0.4	100.0	5.2	99.3	2 389
Төрөх үеийн эхийн нас									
20 хүртэл	0.3	12.5	75.4	9.8	2.1	100.0	4.9	99.7	108
20-34	1.4	11.0	62.8	24.5	0.3	100.0	5.3	99.3	1 895
35-49	1.2	10.8	61.2	26.3	0.4	100.0	5.1	98.8	386
Төрөлтийн дараалал									
1	1.3	12.2	67.0	18.5	0.9	100.0	5.5	99.6	747
2-3	0.9	10.9	62.2	25.9	0.1	100.0	4.8	99.4	1 309
4-5	2.6	8.2	58.9	29.8	0.6	100.0	5.3	97.8	299
6+	(8.0)	(16.4)	(49.3)	(26.3)	(0.0)	100.0	(12.2)	(100.0)	35
Бүс									
Баруун	1.2	17.8	59.5	20.6	1.0	100.0	7.1	98.4	336
Хангай	2.0	10.6	59.4	27.7	0.3	100.0	5.6	98.9	470
Төв	1.1	8.9	63.6	25.8	0.6	100.0	4.4	99.0	397
Зүүн	0.2	11.5	65.9	21.4	1.0	100.0	4.5	99.4	160
Улаанбаатар	1.3	9.9	65.3	23.4	0.1	100.0	4.8	99.8	1 026
Хот, хөдөө									
Хот	1.3	9.9	63.8	24.7	0.3	100.0	4.9	99.6	1 519
Хөдөө	1.3	13.1	61.9	23.0	0.7	100.0	5.8	98.6	870
Байршил									
Нийслэл	1.3	9.9	65.3	23.4	0.1	100.0	4.8	99.8	1 026
Аймгийн төв	1.4	10.0	60.6	27.5	0.6	100.0	4.9	99.2	493
Сумын төв	0.8	12.0	67.1	19.5	0.5	100.0	5.1	99.6	246
Хөдөө	1.5	13.5	59.9	24.4	0.7	100.0	6.1	98.2	624
Эхийн боловсрол									
Боловсролгүй	3.2	17.5	54.0	25.1	0.3	100.0	8.6	96.1	132
Бага	1.7	13.1	61.9	22.2	1.2	100.0	6.1	97.8	159
Суурь	0.7	12.5	63.4	22.9	0.4	100.0	5.1	98.9	309
Бүрэн дунд	1.2	12.3	65.9	20.3	0.3	100.0	5.5	99.4	616
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	2.9	9.3	61.2	26.1	0.4	100.0	6.0	100.0	180
Дээд	1.0	9.0	63.0	26.6	0.4	100.0	4.4	99.9	994
Өрхийн аж байдлын түвшин									
Доогуур	1.8	16.3	59.1	22.4	0.5	100.0	7.1	98.5	509
Дунджаас доогуур	1.0	9.3	64.1	25.3	0.2	100.0	4.5	98.4	452
Дундаж	1.2	9.2	63.3	25.4	0.9	100.0	4.6	99.8	476
Дунджаас дээгүүр	1.0	12.5	64.6	21.5	0.3	100.0	5.4	99.7	448
Дээгүүр	1.4	7.9	64.7	25.9	0.1	100.0	4.3	100.0	504
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*									
Халх	1.1	10.9	63.5	24.2	0.4	100.0	5.0	99.4	1 916
Казах	3.3	21.8	56.5	17.4	1.1	100.0	10.0	96.8	92
Бусад	2.1	9.1	63.0	25.4	0.2	100.0	5.3	99.4	372

¹ НҮТС-ны үзүүлэлт 2.20 - Бага жинтэй төрөлт

² НҮТС-ны үзүүлэлт 2.21 - Төрөх үед нь жинлэсэн хүүхэд

* Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй 9 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

() 25-49 ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

Хүснэгт NU.2: Хүүхдийн хоол тэжээлийн байдал

5 хүртэлх насны хүүхдийн хувь, хоол тэжээлийн байдлаар, биеийн хэмжилтийн 3 үзүүлэлт: насанд харьцуулсан жин, насанд харьцуулсан өндөр, өндөрт харьцуулсан жин, Монгол Улс, 2013 он

	Насанд харьцуулсан жингээс			Насанд харьцуулсан өдрөөс					Өндөрт харьцуулсан жингээс			5 хүртэлх насны хүүхдийн тоо	
	Тураалтай		Дундаж Z-оноо (CX)	5 хүртэлх насны хүүхдийн тоо	Өсөлт хоцролттой		Дундаж Z-оноо (CX)	5 хүртэлх насны хүүхдийн тоо	Туранхай		Илүүдэл жинтэй		Дундаж Z-оноо (CX)
	доогуур	- 2 CX ¹			- 3 CX ²	доогуур			- 2 CX ³	- 3 CX ⁴			
Дүн	1.6	0.2	0.2	5 744	10.8	2.1	-0.6	5 725	1.0	0.4	10.5	0.8	5 715
Хүйс													
Эрэгтэй	1.4	0.2	0.3	2 919	11.1	2.2	-0.6	2 910	1.2	0.4	10.9	0.8	2 906
Эмэгтэй	1.7	0.3	0.2	2 825	10.5	2.1	-0.6	2 814	0.8	0.4	10.0	0.8	2 809
Бүс													
Баруун	2.6	0.7	0.0	884	19.5	4.6	-1.0	876	1.1	0.6	9.1	0.8	875
Хангай	2.3	0.2	0.2	1 151	12.3	2.4	-0.7	1 151	1.2	0.2	9.9	0.8	1 147
Төв	1.6	0.1	0.3	1 037	8.7	1.0	-0.6	1 037	1.1	0.3	10.8	0.8	1 035
Зүүн	2.1	0.2	0.2	432	13.5	3.0	-0.7	428	0.7	0.3	10.6	0.9	427
Улаанбаатар	0.6	0.1	0.4	2 240	7.1	1.3	-0.3	2 233	0.8	0.4	11.2	0.8	2 231
Хот, хөдөө													
Хот	1.2	0.2	0.3	3 484	8.4	1.7	-0.4	3 475	0.9	0.3	11.1	0.8	3 469
Хөдөө	2.2	0.3	0.1	2 260	14.5	2.8	-0.9	2 250	1.1	0.4	9.6	0.8	2 246
Байршил													
Нийслэл	0.6	0.1	0.4	2 240	7.1	1.3	-0.3	2 233	0.8	0.4	11.2	0.8	2 231
Аймгийн төв	2.1	0.2	0.3	1 244	10.7	2.4	-0.5	1 241	1.1	0.2	10.8	0.8	1 238
Сумын төв	1.1	0.2	0.2	698	9.7	1.2	-0.7	695	1.1	0.5	9.6	0.8	692
Хөдөө	2.6	0.4	0.1	1 562	16.7	3.4	-0.9	1 555	1.1	0.4	9.6	0.8	1 554
Нас													
0-5 сартай	3.0	0.6	0.5	619	5.4	1.7	0.2	616	3.7	1.0	12.1	0.6	611
6-11 сартай	1.0	0.5	0.7	615	4.1	0.6	0.1	613	1.1	0.3	16.9	1.0	615
12-17 сартай	1.1	0.2	0.5	564	8.7	1.4	-0.4	561	1.0	0.5	12.7	0.9	559
18-23 сартай	1.4	0.2	0.3	554	15.8	3.3	-0.8	551	1.1	0.7	13.9	1.0	550
24-35 сартай	1.6	0.2	0.2	1 167	14.6	2.6	-0.8	1 161	0.4	0.1	11.5	0.9	1 160
36-47 сартай	1.5	0.1	0.0	1 120	12.8	3.1	-0.9	1 120	0.3	0.2	6.9	0.8	1 119
48-59 сартай	1.4	0.2	0.0	1 104	10.1	1.6	-0.8	1 103	0.7	0.3	5.8	0.6	1 101
Эхийн боловсрол*													
Боловсролгүй	4.1	0.5	0.0	318	20.3	6.9	-1.1	313	1.3	0.4	9.6	0.8	313
Бага	3.6	0.5	0.0	407	19.7	4.8	-1.1	405	1.0	0.5	9.4	0.8	405
Суурь	2.4	0.3	0.1	852	15.7	2.4	-0.8	851	1.1	0.5	9.8	0.8	849
Бүрэн дунд	0.9	0.3	0.2	1 422	9.6	1.6	-0.6	1 417	1.2	0.5	10.3	0.8	1 415
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	2.2	0.2	0.2	468	10.7	1.4	-0.7	468	1.0	0.2	6.9	0.7	467
Дээд	0.8	0.1	0.4	2 275	6.8	1.4	-0.3	2 268	0.7	0.3	11.9	0.8	2 265
Өрхийн аж байдлын түвшин													
Доогуур	3.5	0.6	0.0	1 268	18.6	4.5	-1.0	1 259	1.1	0.5	9.6	0.8	1 257
Дунджаас доогуур	1.4	0.3	0.2	1 165	12.5	1.9	-0.7	1 163	1.3	0.3	10.4	0.8	1 161
Дундаж	1.2	0.1	0.3	1 107	8.5	1.5	-0.6	1 107	0.7	0.3	9.1	0.8	1 105
Дунджаас дээгүүр	0.7	0.0	0.4	1 023	7.7	1.1	-0.4	1 017	0.9	0.2	11.7	0.8	1 014
Дээгүүр	0.7	0.1	0.5	1 182	5.7	1.4	-0.2	1 178	0.9	0.5	11.7	0.8	1 178
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**													
Халх	1.4	0.2	0.3	4 573	9.6	1.7	-0.5	4 564	1.0	0.3	10.6	0.8	4 554
Казах	1.9	1.4	0.0	250	23.2	5.7	-1.0	244	2.5	1.7	8.4	0.7	244
Бусад	2.3	0.3	0.2	904	13.8	3.3	-0.7	901	0.8	0.4	10.4	0.9	901

¹ НҮТС-ны үзүүлэлт 2.1a, МХЗ-ын үзүүлэлт 1.8 - Тураалтай хүүхдийн хувь (дунд болон хүнд хэлбэрийн)

² НҮТС-ны үзүүлэлт 2.1b - Тураалтай хүүхдийн хувь (хүнд хэлбэрийн)

³ НҮТС-ны үзүүлэлт 2.2a - Өсөлт хоцролттой хүүхдийн хувь (дунд болон хүнд хэлбэрийн)

⁴ НҮТС-ны үзүүлэлт 2.2b - Өсөлт хоцролттой хүүхдийн хувь (хүнд хэлбэрийн)

⁵ НҮТС-ны үзүүлэлт 2.3a - Туранхай хүүхдийн хувь (дунд болон хүнд хэлбэрийн)

⁶ НҮТС-ны үзүүлэлт 2.3b - Туранхай хүүхдийн хувь (хүнд хэлбэрийн)

⁷ НҮТС-ны үзүүлэлт 2.4 - Илүүдэл жинтэй хүүхдийн хувь

* Эхийн боловсролын түвшин нь хариулагдаагүй харгалзан 2, 2 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй харгалзан 18, 18, 18 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

Хүснэгт NU.2A: Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэгдсэн хүүхдийн өндөр, жингийн тэмдэглэгээ

Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг нь ярилцлага авагч үзсэн 0-35 сартай хүүхдийн хувь, эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн жин, насны болон өндөр, насны хүснэгтэд тэмдэглэгээ хийгдсэн хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг ярилцлага авагч үзсэн хүүхдийн хувь	0-35 сартай хүүхдийн тоо	Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт хүүхдийн жин, насны хүснэгтэд сүүлийн 4 сард тэмдэглэл хийгдсэн хүүхдийн хувь	Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт хүүхдийн өндөр, насны хүснэгтэд сүүлийн 4 сард тэмдэглэл хийгдсэн хүүхдийн хувь	Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт хүүхдийн жин, нас болон өндөр, насны 2 хүснэгтэд сүүлийн 4 сард тэмдэглэл хийгдсэн хүүхдийн хувь	Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг нь ярилцлага авагч үзсэн 0-35 сартай хүүхдийн тоо
Дүн	87.9	3717	44.2	43.7	43.3	3267
Хүйс						
Эрэгтэй	87.8	1928	43.5	42.8	42.5	1693
Эмэгтэй	88.0	1789	45.0	44.7	44.1	1573
Бүс						
Баруун	67.3	525	31.2	30.3	30.3	353
Хангай	89.6	733	46.0	45.0	44.6	657
Төв	91.0	637	32.7	31.8	31.0	580
Зүүн	94.2	272	38.0	38.1	37.8	256
Улаанбаатар	91.7	1550	52.5	52.3	51.9	1421
Хот, хөдөө						
Хот	91.4	2329	49.7	49.1	48.8	2129
Хөдөө	82.0	1388	34.0	33.5	33.0	1137
Байршил						
Нийслэл	91.7	1550	52.5	52.3	51.9	1421
Аймгийн төв	91.0	779	44.1	42.9	42.5	708
Сумын төв	84.4	424	30.0	29.6	28.8	358
Хөдөө	80.9	963	35.8	35.3	35.0	779
Нас						
0-5 сартай	89.7	658	56.1	56.2	55.6	590
6-11 сартай	89.7	642	52.9	52.6	51.9	576
12-23 сартай	88.0	1180	43.7	42.9	42.7	1038
24-35 сартай	85.9	1236	33.5	32.7	32.3	1062
Эхийн боловсрол*						
Боловсролгүй	75.6	188	30.4	31.2	30.4	142
Бага	79.7	246	33.2	32.2	31.8	196
Суурь	84.6	508	39.5	39.3	38.8	430
Бүрэн дунд	89.6	959	43.4	42.8	42.7	859
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	90.9	303	46.3	46.3	46.3	276
Дээд	90.2	1511	49.0	48.1	47.5	1362
Өрхийн аж байдлын түвшин						
Доогуур	80.8	781	33.6	33.0	32.8	631
Дунджаас доогуур	87.3	730	43.6	43.0	42.9	637
Дундаж	89.0	719	45.5	45.1	44.6	640
Дунджаас дээгүүр	89.7	689	48.8	48.3	47.7	618
Дээгүүр	92.9	797	49.0	48.4	47.7	741
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**						
Халх	91.1	2978	45.4	44.8	44.3	2713
Казах	39.1	141	15.7	14.4	14.4	55
Бусад	83.3	588	41.3	41.2	41.0	490

* Эхийн боловсрол нь хариулагдаагүй харгалзан 1, 1 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй харгалзан 9, 9 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

Хүснэгт NU.3: Эрт амлуулалт

Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд төрсөн эхийн сүүгээр хооллож байсан хүүхдийн хувь, төрсний дараа 1 цагийн дотор болон 1 өдрийн дотор ангир уургаа амласан хүүхдийн хувь, ангир уургаа амлахаас өмнө ямар нэг зүйлээр хооллосон хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Эхийн сүүгээр хооллож байсан ¹	Ангир уургаа амласан хүүхдийн хувь:		Ангир уургаа амлахаас өмнө ямар нэгэн зүйлээр хооллосон	Судалгаанаас өмнөх 2 жилд төрүүлсэн сүүлийн хүүхдийн тоо
		Төрсний дараах 1 цагийн дотор ²	Төрсний дараах 1 хоногийн дотор		
Дүн	98.3	71.1	93.7	26.4	2 389
Бүс					
Баруун	98.5	71.2	93.3	22.7	336
Хангай	98.2	75.8	94.5	25.6	470
Төв	97.7	68.6	93.7	24.5	397
Зүүн	97.4	76.8	95.2	27.9	160
Улаанбаатар	98.5	69.0	93.2	28.5	1 026
Хот, хөдөө					
Хот	98.3	69.0	93.1	27.9	1 519
Хөдөө	98.1	74.7	94.7	23.7	870
Байршил					
Нийслэл	98.5	69.0	93.2	28.5	1 026
Аймгийн төв	98.0	69.0	92.9	26.8	493
Сумын төв	97.8	74.7	94.2	30.2	246
Хөдөө	98.2	74.8	94.9	21.2	624
Сүүлийн хүүхдээ төрүүлснээс хойших хуацаа					
0-11 сартай	98.1	69.6	93.5	25.6	1 232
12-23 сартай	98.4	72.7	93.9	27.2	1 157
Төрөх үеийн тусламж					
Мэргэжлийн эмчийн хяналтад	98.2	71.0	93.7	26.4	2 362
Бусад	(100.0)	(78.2)	(94.7)	(29.7)	27
Хүүхдээ төрүүлсэн газар					
Эмнэлэг	98.3	71.3	93.9	26.2	2 351
Улсын	98.4	71.0	93.9	25.8	2 283
Хувийн	95.9	78.5	92.8	40.1	68
Гэр	(*)	(*)	(*)	(*)	13
Бусад/ мэдэхгүй/ хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	26
Эхийн боловсрол					
Боловсролгүй	97.6	72.5	92.5	14.1	132
Бага	97.2	72.4	96.1	20.7	159
Суурь	98.7	76.3	96.0	19.3	309
Бүрэн дунд	98.0	71.3	94.1	24.1	616
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	98.8	71.6	91.2	23.5	180
Дээд	98.4	68.9	92.9	33.1	994
Өрхийн аж байдлын түвшин					
Доогуур	98.2	75.0	95.2	19.0	509
Дунджаас доогуур	99.2	74.2	95.8	21.0	452
Дундаж	98.1	70.9	94.6	25.4	476
Дунджаас дээгүүр	98.0	67.6	90.7	31.9	448
Дээгүүр	97.8	67.8	92.0	34.7	504
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*					
Халх	98.4	71.1	93.6	27.8	1 916
Казах	96.6	60.5	88.0	17.2	92
Бусад	97.8	73.7	95.5	21.4	372

¹ НҮТС-ны үзүүлэлт 2.5 - Эхийн сүүгээр хооллолт

² НҮТС-ны үзүүлэлт 2.6 - Эрт амлуулалт

* Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй 9 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

() 25-49 ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

(*) 25 хүртэлх ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

Хүснэгт NU.4: Эхийн сүүгээр хооллолт

Хүүхдийн хувь, сонгосон насны бүлэг дэх эхийн сүүгээр хооллож байгаа байдлаар, Монгол Улс, 2013 он

	0-5 сартай хүүхэд			12-15 сартай хүүхэд		20-23 сартай хүүхэд	
	Эхийн сүүгээр дагнан хооллож байгаа ¹	Эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ ус, сүүн бус шингэн зүйл ууж байгаа ²	Хүүхдийн тоо	Эхийн сүүгээр хооллож байгаа (1 нас хүртлээ үргэлжлүүлэн) ³	Хүүхдийн тоо	Эхийн сүүгээр хооллож байгаа (2 нас хүртлээ үргэлжлүүлэн) ⁴	Хүүхдийн тоо
Дүн	47.1	55.7	658	82.5	393	52.9	385
Хүйс							
Эрэгтэй	45.2	53.3	323	85.0	192	53.6	213
Эмэгтэй	49.1	58.1	335	80.2	201	52.0	172
Бүс							
Баруун	59.9	66.9	84	86.3	50	54.1	56
Хангай	49.3	59.1	130	85.9	80	52.0	91
Төв	33.6	43.8	113	78.6	67	57.7	59
Зүүн	56.9	59.6	44	(73.5)	20	(44.2)	26
Улаанбаатар	46.3	55.1	287	82.5	176	52.6	153
Хот, хөдөө							
Хот	45.8	55.5	432	80.8	254	52.1	229
Хөдөө	49.7	56.3	227	85.8	139	54.1	156
Байршил							
Нийслэл	46.3	55.1	287	82.5	176	52.6	153
Аймгийн төв	44.8	56.2	144	76.9	77	51.0	75
Сумын төв	31.8	40.3	64	(73.3)	42	50.2	47
Хөдөө	56.8	62.5	162	91.1	97	55.7	109
Эхийн боловсрол							
Боловсролгүй	(57.4)	(59.8)	32	(*)	21	(*)	17
Бага	(52.7)	(66.8)	38	(92.7)	25	(54.3)	36
Суурь	50.2	59.7	92	(90.8)	42	(56.6)	47
Бүрэн дунд	42.9	48.3	194	81.5	98	53.5	81
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	47.2	59.5	62	(76.3)	30	(57.8)	37
Дээд	47.1	57.0	241	80.0	177	48.9	168
Өрхийн аж байдлын түвшин							
Доогуур	55.4	60.8	131	85.5	76	52.9	97
Дунджаас доогуур	51.4	64.0	153	90.6	65	49.9	64
Дундаж	43.6	50.1	132	89.4	79	74.2	61
Дунджаас дээгүүр	39.3	47.9	115	80.7	78	54.2	78
Дээгүүр	44.3	53.5	127	70.4	94	38.5	85
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*							
Халх	48.3	56.5	529	82.6	318	55.8	315
Казах	(*)	(*)	24	(*)	11	(*)	13
Бусад	40.9	52.2	100	81.9	62	37.2	56

¹ НҮТС-ны үзүүлэлт 2.7 - Эхийн сүүгээр дагнан хооллолт (6 хүртэлх сар)² НҮТС-ны үзүүлэлт 2.8 - Эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ ус, сүүн бус шингэн ууж байгаа хүүхэд (6 хүртэлх сар)³ НҮТС-ны үзүүлэлт 2.9 - 1 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолт⁴ НҮТС-ны үзүүлэлт 2.10 - 2 нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолт

* Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй харгалзан 4, 2, 1 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

() 25-49 ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

(*) 25 хүртэлх ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

Хүснэгт NU.5: Эхийн сүүгээр хооллож байгаа хугацаа

0-35 сартай хүүхдүүдийн дунд эхийн сүүгээр хооллосон, дагнан хооллосон, эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ ус, шингэн зүйлийг ууж байгаа голч хугацаа, Монгол Улс, 2013 он

	Голч хугацаа (сараар):			0-35 сартай хүүхдийн тоо
	Эхийн сүүгээр хооллосон ¹	Эхийн сүүгээр дагнан хооллосон	Эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ ус, сүүн бус шингэн зүйл уусан	
Голч хугацаа	22.7	2.3	3.0	3717
Хүйс				
Эрэгтэй	23.0	2.1	2.8	1928
Эмэгтэй	22.3	2.4	3.2	1789
Бүс				
Баруун	22.6	3.3	3.9	525
Хангай	27.3	2.4	3.3	733
Төв	24.9	1.7	2.2	637
Зүүн	18.8	3.1	3.3	272
Улаанбаатар	22.9	2.2	3.0	1550
Хот, хөдөө				
Хот	22.3	2.2	3.0	2329
Хөдөө	24.5	2.5	3.0	1388
Байршил				
Нийслэл	22.9	2.2	3.0	1550
Аймгийн төв	21.8	2.2	3.0	779
Сумын төв	20.1	1.2	1.9	424
Хөдөө	24.6	3.1	3.6	963
Эхийн боловсрол*				
Боловсролгүй	25.4	3.2	3.4	188
Бага	23.4	2.8	4.9	246
Суурь	28.2	2.5	3.4	508
Бүрэн дунд	26.8	1.9	2.4	959
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	25.0	2.3	3.2	303
Дээд	20.6	2.3	3.1	1511
Өрхийн аж байдлын түвшин				
Доогуур	23.4	3.0	3.5	781
Дунджаас доогуур	28.1	2.6	3.6	730
Дундаж	25.4	2.1	2.5	719
Дунджаас дээгүүр	24.1	1.3	2.0	689
Дээгүүр	19.2	2.0	2.8	797
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**				
Халх	24.0	2.4	3.1	2978
Казах	20.5	2.6	2.7	141
Бусад	19.6	1.9	2.7	588
Дундаж хугацаа	23.3	2.8	3.3	3717

¹ НҮТС-ны үзүүлэлт 2.11 - Эхийн сүүгээр хооллож байгаа голч хугацаа

* Эхийн боловсролын түвшин нь хариулагдаагүй 2 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй 9 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

Хүснэгт NU.6: Насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллолт

Сүүлийн 1 хоногт насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллосон 0-23 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	0-5 сартай хүүхэд		6-23 сартай хүүхэд		0-23 сартай хүүхэд	
	Эхийн сүүгээр дагнан хооллож байгаа ¹	Хүүхдийн тоо	Эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ нэмэгдэл хоол идэж байгаа	Хүүхдийн тоо	Насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллож байгаа ²	Хүүхдийн тоо
Дүн	47.1	658	73.2	1 822	66.3	2 480
Хүйс						
Эрэгтэй	45.2	323	72.0	955	65.2	1 278
Эмэгтэй	49.1	335	74.4	867	67.3	1 203
Бүс						
Баруун	59.9	84	74.9	265	71.3	349
Хангай	49.3	130	74.7	364	68.1	494
Төв	33.6	113	71.9	298	61.3	411
Зүүн	56.9	44	65.3	124	63.1	168
Улаанбаатар	46.3	287	73.6	771	66.2	1 059
Хот, хөдөө						
Хот	45.8	432	74.3	1 133	66.4	1 564
Хөдөө	49.7	227	71.4	690	66.0	916
Байршил						
Нийслэл	46.3	287	73.6	771	66.2	1 059
Аймгийн төв	44.8	144	75.7	361	66.9	506
Сумын төв	31.8	64	67.2	207	58.9	271
Хөдөө	56.8	162	73.1	482	69.0	645
Эхийн боловсрол*						
Боловсролгүй	(57.4)	32	77.3	101	72.5	132
Бага	(52.7)	38	72.9	125	68.2	162
Суурь	50.2	92	74.6	225	67.6	317
Бүрэн дунд	42.9	194	74.8	445	65.1	639
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	47.2	62	69.1	136	62.3	198
Дээд	47.1	241	72.0	790	66.2	1 031
Өрхийн аж байдлын түвшин						
Доогуур	55.4	131	72.5	396	68.3	527
Дунджаас доогуур	51.4	153	74.3	326	67.0	478
Дундаж	43.6	132	80.4	347	70.2	479
Дунджаас дээгүүр	39.3	115	72.1	347	63.9	462
Дээгүүр	44.3	127	67.6	406	62.0	533
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**						
Халх	48.3	529	73.9	1 453	67.1	1 982
Казах	(*)	24	62.7	66	59.6	91
Бусад	40.9	100	71.9	298	64.1	399

¹ НҮТС-ны үзүүлэлт 2.7 - Эхийн сүүгээр дагнан хооллолт (6 хүртэлх сар)² НҮТС-ны үзүүлэлт 2.12 - Насандаа тохирсон байдлаар эхийн сүүгээр хооллолт

* Эхийн боловсрол нь хариулагдаагүй харгалзан 0, 1, 1 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй харгалзан 4, 5, 9 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

() 25-49 ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

(*) 25 хүртэлх ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

Хүснэгт NU.7: Нэмэгдэл хоол (хагас шингэн, шингэн, өтгөн)

Сүүлийн 1 хоногт нэмэгдэл хоол (хагас шингэн, шингэн, өтгөн) идсэн 6-8 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Эхийн сүүгээр хооллож байгаа		Эхийн сүүгээр хооллохгүй байгаа		Бүгд	
	Нэмэгдэл хоол идэж байгаа	6-8 сартай хүүхдийн тоо	Нэмэгдэл хоол идэж байгаа	6-8 сартай хүүхдийн тоо	Нэмэгдэл хоол идэж байгаа ¹	6-8 сартай хүүхдийн тоо
Дүн	94.4	327	(*)	25	94.8	352
Хүйс						
Эрэгтэй	92.3	169	(*)	13	92.9	182
Эмэгтэй	96.6	158	(*)	12	96.8	170
Бүс						
Баруун	85.7	47	(*)	4	86.9	52
Хангай	94.6	67	(*)	4	94.9	71
Төв	96.9	52	(*)	3	97.1	55
Зүүн	(100.0)	18	(*)	1	(100.0)	19
Улаанбаатар	95.6	143	(*)	13	95.9	155
Хот, хөдөө						
Хот	96.2	211	(*)	13	96.5	224
Хөдөө	91.0	117	(*)	12	91.9	128
Байршил						
Нийслэл	95.6	143	(*)	13	95.9	155
Аймгийн төв	97.7	68	(*)	1	97.7	69
Сумын төв	(97.9)	39	(*)	2	(98.0)	41
Хөдөө	87.6	78	(*)	10	89.0	88
Эхийн боловсрол*						
Боловсролгүй	(*)	20	(*)	3	(*)	23
Бага	(*)	11	(*)	2	(*)	13
Суурь	(96.3)	28	(*)	7	(97.0)	35
Бүрэн дунд	90.1	102	(*)	5	90.6	107
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	(*)	15	(*)	2	(*)	17
Дээд	97.3	150	(*)	7	97.4	157
Өрхийн аж байдлын түвшин						
Доогуур	88.4	70	(*)	4	89.1	75
Дунджаас доогуур	94.6	55	(*)	9	95.3	64
Дундаж	96.2	69	(*)	5	96.4	74
Дунджаас дээгүүр	92.9	65	(*)	3	93.1	67
Дээгүүр	100.0	67	(*)	5	100.0	72
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**						
Халх	95.4	258	(*)	15	95.7	273
Казах	(*)	11	(*)	3	(*)	14
Бусад	96.9	57	(*)	7	97.2	64

¹ НҮТС-ны үзүүлэлт 2.13 - Нэмэгдэл хоолонд орсон хүүхэд

* Эхийн боловсрол нь хариулагдаагүй харгалзан 1, 0, 1 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй харгалзан 1, 0, 1 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

() 25-49 ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

(*) 25 хүртэлх ажиглалт (жигнээгүй) дээр үндэслэн тооцсон.

Хүснэгт №18: Нялх болон бага насны хүүхдийн хооллолт

Сүүлийн 1 хоногт шингэн зүйл болон нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идсэн 6-23 сартай хүүхдийн хувь, эхний сүүгээр хоолож байгаа эсхээр, Монгол Улс, 2013 он

	Эхний сүүгээр хоолож байгаа				Хүүхдийн хувь:				Бүгд				
	Хүүхдийн хувь:		Хүүхдийн хувь:		Хүүхдийн хувь:		Хүүхдийн хувь:		Хүүхдийн хувь:		Хүүхдийн хувь:		
	Нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идсэн ^a	Нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идсэн ^b	Нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идсэн ^a	Нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идсэн ^b	Наад зах нь 2 удаа сүү уусан ^c	Зохистой байдлаар хоолож байгаа ^{d,e}	Зохистой байдлаар хоолож байгаа ^{d,e}	Нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идсэн ^a	Нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идсэн ^b	6-23 сартай хүүхдийн тоо	Нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идсэн ^a	Нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идсэн ^b	6-23 сартай хүүхдийн тоо
Дүн	47.7	69.2	37.6	1 359	60.4	69.6	24.3	56.3	424	50.8	69.3	34.5	1 822
Хүйс													
Эрэгтэй	49.0	70.0	38.6	702	57.0	64.9	25.1	57.3	231	51.1	68.7	35.3	955
Эмэгтэй	46.3	68.3	36.6	657	64.4	75.1	23.4	55.1	194	50.5	69.8	33.6	867
Нас													
6-8 сартай	31.7	78.2	29.3	327	(*)	(*)	(*)	(*)	21	31.3	78.4	28.2	352
9-11 сартай	50.3	68.5	40.2	252	(53.3)	(92.4)	(28.7)	(83.7)	30	51.2	71.1	39.0	290
12-17 сартай	54.3	39.3	45.1	64.2	23.8	57.7	23.8	57.7	122	56.4	67.1	36.0	585
18-23 сартай	52.5	65.4	41.7	329	61.9	64.4	25.1	50.1	251	56.6	65.0	34.5	595
Бүс													
Баруун	28.9	61.1	20.2	205	43.2	65.1	18.6	60.1	55	31.9	62.0	19.9	265
Хангай	37.4	63.7	30.6	279	45.4	66.1	20.1	59.3	82	38.9	64.2	28.2	364
Төв	54.7	66.7	40.1	218	63.6	68.6	18.1	53.6	76	56.9	67.2	34.4	298
Зүүн	36.4	63.6	25.7	81	59.8	62.6	20.0	39.1	40	43.7	63.3	23.8	124
Улаанбаатар	58.3	76.4	48.0	575	71.9	74.7	31.9	-58.8	172	61.7	76.0	44.3	771
Хот, хөдөө													
Хот	56.8	75.9	46.7	850	72.4	74.9	29.4	55.9	255	60.5	75.7	42.7	1 133
Хөдөө	32.4	57.8	22.5	509	42.2	61.5	16.6	57.0	169	34.9	58.8	21.0	690
Байршил													
Нийслэл	58.3	76.4	48.0	575	71.9	74.7	31.9	58.8	172	61.7	76.0	44.3	771
Аймагийн төв	53.7	43.9	27.5	75.0	73.6	84	24.3	49.8	84	58.0	75.0	39.3	361
Сумын төв	45.6	67.3	32.6	143	51.7	65.1	21.5	59.1	60	47.0	66.7	29.3	207
Хөдөө	27.3	54.2	18.6	366	37.1	59.5	13.9	55.8	110	29.6	55.4	17.5	482
Эхний боловсрол*													
Боловсролгүй	18.5	53.7	12.4	81	(*)	(*)	(*)	(*)	20	20.5	51.6	11.1	101
Бага	30.1	54.8	17.5	91	(26.1)	(56.8)	(14.9)	(59.3)	34	29.0	55.3	16.8	125
Сурь	25.5	52.7	14.3	171	41.2	49.2	12.3	42.5	47	29.7	51.9	13.9	225
Бүрэн дунд	47.5	68.3	37.9	344	64.1	69.1	23.6	55.6	92	50.5	68.5	34.9	445
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	47.5	71.7	38.1	99	(49.2)	(77.5)	(14.6)	(48.4)	33	48.6	73.2	32.2	136
Өрхийн аж байдлын түвшин													
Дунд	61.4	78.6	51.2	573	74.0	78.1	32.5	60.3	199	64.7	78.5	46.4	790
Доогуур	24.6	56.3	16.3	298	35.5	52.6	12.8	52.1	94	27.5	55.4	15.4	396
Дундаас доогуур	61.4	39.6	28.4	246	51.0	64.1	16.9	51.4	74	41.4	62.1	25.7	326
Дундаж	49.7	70.6	38.4	284	60.8	63.6	21.0	55.2	59	51.4	55.2	35.4	347
Дундаас дээгүүр	57.5	72.8	44.2	256	69.2	73.2	30.4	58.1	76	60.3	72.9	41.1	347
Дээгүүр	68.7	85.1	62.2	275	79.8	86.7	35.6	62.0	121	72.4	85.6	54.1	406
Өрхийн гэрүүлэгчийн үлдэгдэл**													
Хаах	51.0	71.7	41.1	1 093	62.2	72.2	25.6	58.6	330	53.8	71.8	37.5	1 453
Казах	(30.0)	(46.6)	(17.2)	46	(*)	(*)	(*)	(*)	18	35.3	49.3	18.2	66
Бусад	35.0	61.6	25.2	216	54.0	61.0	19.5	42.5	76	40.1	61.4	23.7	298

¹ НУТС-ны үзүүлэлт 2.17а - Зохистой байдлаар хоолож байгаа хүүхэд (эхийн сүүгээр хоололдог)

² НУТС-ны үзүүлэлт 2.17б - Зохистой байдлаар хоолож байгаа хүүхэд (эхийн сүүгээр хоололдоггүй)

³ НУТС-ны үзүүлэлт 2.14 - Эхний сүүгээр хооложгүй байгаа бөгөөд сүүн шингэн зүйлийг зохих давтамжаар ууж байгаа хүүхэд

⁴ НУТС-ны үзүүлэлт 2.16 - Нэмэгдэл хоолыг зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идсэн хүүхэд

⁵ НУТС-ны үзүүлэлт 2.15 - Нэмэгдэл хоолыг зохих давтамжаар ууж байгаа хүүхэд

⁶ Дараах 7 төрлийн хүрсний бүлэгт наад зах нь 4 төрийн идсэн бол нэмэгдэл хоолыг зохих давтамжаар, зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идсэн бол зохистой байдлаар хоолож байгаа гэж үзсэн. мах, дотор мах), 5) өндөг, 6) А амьндэмээр баялаг жамс, хүнсний ногоо, 7) бусад жамс, хүнсний ногоо.

⁷ Нэмэгдэл хоолыг зохих давтамжаар идсэн гэж үзсэн: 1) ур тариагаар хийсэн хүнс, хүнсний бүтээгдэхүүн, 2) буурцаг, шол, самар, 3) сүү, сүүн бүтээгдэхүүн, 4) мах (бал, гахай, шувууны шингэн зүйл) болон нэмэгдэл хоолыг өдөрт хамгийн багадаа 4 удаа идсэн гэдгээр тодорхойлсон.

⁸ 6-23 сартай эхний сүүгээр хоолож байгаа хүүхдийн хувь, нэмэгдэл хоолыг зохих давтамжаар, зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идсэн, харин эхийн сүүгээр хооложгүй байгаа хүүхдийн хувьд хамгийн багадаа 2 удаа сүү уусан бөгөөд нэмэгдэл хоолыг зохих давтамжаар, зохих төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулан идсэн бол зохистой байдлаар хоолож байгаа гэж үзсэн.

⁹ Эхний боловсрол нь харуулагдаагүй харгалзан 1, 0, 1 ангилалтыг (жигнэжгүй) харуулаагүй.

¹⁰ ** Өрхийн гэрүүлэгчийн үлдэгдэл нь харуулагдаагүй харгалзан 4, 1, 1, 5 ангилалтыг (жигнэжгүй) харуулаагүй.

() 25-49 ажиглагч (жигнэжгүй) дээр үндэслэн тооцсон.

(*) 25 хүртэлх ажиглагч (жигнэжгүй) дээр үндэслэн тооцсон.

Хүснэгт NU.9: Угжаар шингэн зүйл уусан хүүхэд

Сүүлийн 1 хоногт угжаар шингэн зүйл уусан 0-23 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Угжаар шингэн зүйл уусан 0-23 сартай хүүхдийн хувь ¹	0-23 сартай хүүхдийн тоо
Дүн	28.9	2 480
Хүйс		
Эрэгтэй	29.4	1 278
Эмэгтэй	28.5	1 203
Нас		
0-5 сартай	27.3	658
6-11 сартай	40.2	642
12-23 сартай	23.7	1 180
Бүс		
Баруун	17.5	349
Хангай	25.8	494
Төв	28.9	411
Зүүн	26.9	168
Улаанбаатар	34.5	1 059
Хот, хөдөө		
Хот	32.1	1 564
Хөдөө	23.5	916
Байршил		
Нийслэл	34.5	1 059
Аймгийн төв	27.2	506
Сумын төв	32.4	271
Хөдөө	19.8	645
Эхийн боловсрол*		
Боловсролгүй	19.0	132
Бага	18.3	162
Суурь	23.4	317
Бүрэн дунд	32.7	639
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	26.1	198
Дээд	31.8	1 031
Өрхийн аж байдлын түвшин		
Доогуур	18.0	527
Дунджаас доогуур	23.9	478
Дундаж	28.4	479
Дунджаас дээгүүр	33.4	462
Дээгүүр	41.0	533
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**		
Халх	30.0	1 982
Казах	24.3	91
Бусад	25.1	399

¹ НҮТС-ны үзүүлэлт 2.18 - Угжаар шингэн зүйл уусан хүүхэд

* Эхийн боловсролын түвшин нь хариулагдаагүй 1 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй 9 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

Хүснэгт №1.10: Иоджуулсан давсны хэрэглээ

Өрхийн хувь, иоджуулсан давсны хэрэглээгээр, Монгол Улс, 2013 он

	Давсны подын агууламжийг шалгасан өрхийн хувь	Өрхийн тоо	Өрхийн хувь:				Бүгд	Давсны подын агууламжийг шалгасан болон давстгүй байсан өрхийн тоо
			Давсны подын агууламжийг шалгасан харьцангуй (0-15 мг/кг)		Иоджуулсан (15+ мг/кг)			
			Давстгүй	Иоджуулсан (0-15 мг/кг)	Иоджуулсан (<15 мг/кг)	Иоджуулсан (15+ мг/кг)		
Дүн	95.0	14 805	0.6	19.6	5.3	74.5	100.0	14 149
Бүс								
Баруун	95.3	1 845	0.6	46.2	5.9	47.4	100.0	1 767
Хангай	96.2	3 080	0.4	21.7	3.0	75.0	100.0	2 974
Төв	89.7	2 619	1.1	16.8	6.0	76.1	100.0	2 374
Зүүн	97.4	1 149	0.5	6.9	2.0	90.6	100.0	1 125
Улаанбаатар	96.2	6 111	0.5	14.2	6.6	78.8	100.0	5 908
Хот, хөдөө								
Хот	96.3	9 427	0.5	15.6	6.0	78.0	100.0	9 123
Хөдөө	92.8	5 378	0.7	27.0	3.9	68.3	100.0	5 025
Байршил								
Нийслэл	96.2	6 111	0.5	14.2	6.6	78.8	100.0	5 908
Аймгийн төв	96.5	3 316	0.5	18.0	4.9	76.5	100.0	3 216
Сумын төв	92.8	1 766	0.8	19.9	4.9	74.4	100.0	1 652
Хөдөө	92.7	3 613	0.7	30.5	3.5	65.3	100.0	3 373
Өрхийн гэрүүлэгчийн боловсрол*								
Боловсролгүй	95.4	1 176	0.7	27.5	4.2	67.6	100.0	1 130
Бага	93.9	2 038	0.6	27.4	3.5	68.5	100.0	1 925
Суурь	94.6	2 805	0.5	19.2	3.7	76.5	100.0	2 666
Бүрэн дунд	94.8	2 762	0.6	17.4	5.8	76.2	100.0	2 636
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	94.9	2 011	0.3	17.8	5.3	76.6	100.0	1 914
Дээд	96.1	3 996	0.6	16.2	7.1	76.0	100.0	3 863
Өрхийн аж байдлын түвшин								
Доогуур	93.4	2 974	0.5	32.6	3.2	63.8	100.0	2 791
Дунджаас доогуур	94.6	2 951	0.9	19.4	3.5	76.2	100.0	2 820
Дундаж	94.6	2 949	0.4	16.0	4.6	79.0	100.0	2 802
Дунджаас дээгүүр	94.6	2 905	0.7	13.8	6.0	79.5	100.0	2 766
Дээгүүр	97.9	3 026	0.3	16.6	8.8	74.3	100.0	2 970
Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа**								
Халх	95.0	12 088	0.6	17.9	5.5	76.1	100.0	11 542
Казах	97.5	450	0.2	15.0	6.5	78.3	100.0	440
Бусад	94.9	2 237	0.7	30.0	3.7	65.6	100.0	2 138

* НУТС-ны үзүүлэлт 2.19 - Иоджуулсан давсны хэрэглээ

* Өрхийн гэрүүлэгчийн боловсролын түвшин нь хариулагдаагүй харгалзан 18, 15 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй харгалзан 33, 32 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

Хүснэгт NU.12: Хүүхдийн эрдэс, аминдэмийн хэрэглээ

Сүүлийн 24 цагт А аминдэм болон төмрөөр баялаг хоол хүнс идсэн 6-23 сартай хүүхдийн хувь, эхтэйгээ хамт амьдардаг эсэхээр, сүүлийн 6 сард А аминдэм уусан 6-23 сартай хүүхдийн хувь, иоджуулсан (15+ мг/кг) давс хэрэглэдэг өрхөд амьдардаг хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Сүүлийн 24 цагт А аминдэмээр баялаг хоол хүнс идсэн хүүхдийн хувь ^[a]	Сүүлийн 24 цагт төмрөөр баялаг хоол хүнс идсэн хүүхдийн хувь ^[b]	6-23 сартай хүүхдийн тоо	Сүүлийн 24 цагт А аминдэмээр баялаг хоол хүнс идсэн хүүхдийн хувь ^[a]	Сүүлийн 24 цагт төмрөөр баялаг хоол хүнс идсэн хүүхдийн хувь ^[b]	Эхтэйгээ хамт амьдардаг 6-23 сартай хүүхдийн тоо	Сүүлийн 6 сард А аминдэм уусан хүүхдийн хувь ¹	6-23 сартай хүүхдийн тоо	Иоджуулсан давс хэрэглэдэг өрхөд амьдардаг хүүхдийн хувь ^[c]	6-59 сартай хүүхдийн тоо
Дүн	92.3	89.8	1822	92.0	89.5	1745	82.9	1822	75.8	5189
Хүйс										
Эрэгтэй	92.3	89.9	955	92.0	89.5	920	82.1	955	75.8	2663
Эмэгтэй	92.2	89.7	867	91.9	89.4	825	83.7	867	75.7	2526
Бүс										
Баруун	88.0	85.6	265	87.6	85.1	255	75.6	265	51.3	799
Хангай	90.8	88.9	364	90.5	88.4	343	82.2	364	78.1	1078
Төв	93.4	91.3	298	93.0	90.7	278	84.7	298	79.6	872
Зүүн	97.1	95.6	124	96.9	95.3	116	86.2	124	89.2	404
Улаанбаатар	93.2	90.2	771	93.0	90.1	753	84.5	771	79.8	2037
Хот, хөдөө										
Хот	93.4	90.5	1133	93.2	90.3	1092	84.3	1133	79.6	3155
Хөдөө	90.4	88.8	690	89.9	88.2	654	80.5	690	69.7	2035
Байршил										
Нийслэл	93.2	90.2	771	93.0	90.1	753	84.5	771	79.8	2037
Аймгийн төв	93.9	90.9	361	93.7	90.6	339	84.1	361	79.3	1117
Сумын төв	91.8	90.3	207	90.9	89.3	187	80.6	207	80.2	640
Хөдөө	89.8	88.1	482	89.4	87.7	467	80.4	482	65.0	1395
Нас										
6-11 сартай	85.2	81.7	642	84.8	81.4	625	68.6	642	73.3	613
12-23 сартай	96.1	94.2	1180	96.0	94.0	1120	90.7	1180	75.8	1144
24-35 сартай	na	na	na	na	na	na	na	na	77.2	1189
36-47 сартай	na	na	na	na	na	na	na	na	77.5	1131
48-59 сартай	na	na	na	na	na	na	na	na	73.8	1114
Эхийн боловсрол*										
Боловсролгүй	88.5	84.1	101	88.2	83.7	99	77.7	101	67.9	290
Бага	94.9	94.9	125	94.7	94.7	122	81.5	125	67.6	368
Суурь	90.3	89.1	225	89.4	88.2	207	85.5	225	74.3	767
Бүрэн дунд Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	89.3	87.4	445	88.9	86.9	427	82.9	445	76.8	1262
Дээд	91.9	89.7	136	90.7	88.2	119	83.8	136	79.4	422
Дээд	94.6	91.3	790	94.6	91.4	772	82.9	790	77.5	2078
Өрхийн аж байдлын түвшин										
Доогуур	90.9	89.2	396	90.5	88.8	382	80.5	396	62.8	1139
Дунджаас доогуур	89.7	87.3	326	89.0	86.5	305	81.0	326	79.3	1038
Дундаж	93.1	90.1	347	92.8	89.7	333	83.1	347	83.6	986
Дунджаас дээгүүр	93.5	90.6	347	93.5	90.4	334	85.1	347	80.0	929
Дээгүүр	94.0	91.5	406	93.7	91.5	391	84.7	406	75.3	1097
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**										
Халх	92.9	90.7	1453	92.6	90.3	1392	83.7	1453	77.9	4126
Казах	70.6	66.6	66	70.2	66.1	65	64.8	66	78.7	229
Бусад	93.8	90.8	298	93.8	90.9	284	82.8	298	64.2	823

¹ НҮТС-ны үзүүлэлт CS7.1 - А аминдэмийн хэрэглээ (6-23 сартай)

na = Тооцох боломжгүй

[a] А аминдэмээр баялаг хүнсний бүтээгдэхүүн гэдэгт мал, гахай, шувууны мах (BD8J), дотор мах (BD8I), загас (BD8L), өндөг (BD8K), лууван, хулуу, амтаг төмс зэрэг дотроо шар, улбар шар өнгөтэй бүтээгдэхүүн болон шар өнгийн нухаш (BD8D), брокколи, бууцай зэрэг ногоон өнгийн навчит хүнсний ногоо [BD8F], шийгуа, апильсин, манго зэрэг А аминдэмээр баялаг жимс [BD8G]-ийг оруулсан.

[b] Төмрөөр баялаг хүнсний бүтээгдэхүүн гэдэгт мал, гахай, шувууны мах (BD8J), дотор мах (BD8I), загас (BD8L), өндөг (BD8K)-ийг оруулсан.

[c] Давсны иодын агууламжийг шалгаагүй өрхөд амьдардаг хүүхдүүдийг оруулаагүй.

* Эхийн боловсролын түвшин нь хариулагдаагүй харгалзан 1, 1, 1, 2 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй харгалзан 5, 5, 5, 15 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

VIII БҮЛЭГ

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ

VIII

Бага насны хүүхдийн боловсрол

Бага насны хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нь тэдний сургуульд орох бэлтгэлийг хангахад чухал түлхэц болдог. Бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөр нь хүүхэд харахаас ялгаатай бөгөөд хүүхдэд зориулсан тусгай боловсруулсан сургах хөтөлбөрийг багтаасан байдаг.

Судалгаанд хамрагдсан 36-59 сартай хүүхдийн 68.2 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна (Хүснэгт CD.1). Үүнийг ХХС-2010-ын үр дүнтэй харьцуулбал даруй 10.3 пунктээр өсчээ. Сургуулийн өмнөх боловсролд хамран сургалт хот, хөдөө болон бүс, байршлын хувьд нэлээд ялгаатай байна. Тодруулбал, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт хөдөөд 57.3 хувь, хотод 75.9 хувьтай байна. Харин бүсээр авч үзвэл Баруун бүсийн хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамран сургалт (57.3 хувь) Төв, Зүүн бүс болон Улаанбаатар хоттой (71.9-76.2 хувь) харьцуулахад харьцангуй доогуур түвшинд байна.

Сургуулийн өмнөх боловсролд хамран сургалтын үзүүлэлт охид, хөвгүүдийн хувьд ижил (хөвгүүд 68.1 болон охид 68.2 хувь) байв. Өрхийн аж байдлын түвшин болон эхийн боловсролын түвшин дээшлэх тусам бага насны хүүхдэдээ боловсрол олгоход илүү их анхаарал тавьдаг нь ажиглагдлаа. Тодруулбал, дээгүүр түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийн 89.6 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байхад доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийн дунд ердөө 35.8 хувь буюу талаас нь бага байгаа юм. Мөн дээд боловсролтой эхийн хүүхдүүд (86.0 хувь) сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрт хамрагдах нь боловсролгүй болон бага боловсролтой эхийн хүүхдүүдээс (харгалзан 40.7 болон 40.0 хувь) бараг 2 дахин их байгааг Хүснэгт CD.1-ээс харж болно.

Насаар авч үзвэл 48-59 сартай хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 73.7 хувь буюу 36-47 сартай хүүхдүүдтэй (62.7 хувь) харьцуулахад 11.0 пунктээр дээгүүр байна. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт нь хүүхдийн настай шууд хамааралтай болох нь судалгааны үзүүлэлтээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл, хүүхдийн нас ахих тусам хамран сургалтын хувь нэмэгдэж байна.

Бага насны хүүхдэд үзүүлж буй анхаарал, халамжийн чанар

Хүүхдийн амьдралын эхний 3-4 жилийг тэдний оюун ухааны хөгжлийн хамгийн оргил үе гэж үздэг. Энэ үед аливаа зүйлийг танин мэдэхэд эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн дэмжлэг, туслалцаа, халамж, анхаарал, нь хүүхдийн хөгжлийг тодорхойлох голлох хүчин зүйлсийн нэг байдаг. Үүнтэй холбогдон насанд хүрэгчдийн зүгээс хүүхэдтэйгээ идэвхтэй харилцах, гэртээ хүүхдэд зориулсан ном зохиолуудтай байх, хүүхдийг хайрлан, асрах нөхцлийг бий болгох зэрэг нь эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдэд тавьж буй анхаарал халамжийн чанарыг хэмжих чухал үзүүлэлт болдог. Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглалд “хүүхэд бүр бие бялдрын хувьд эрүүл, оюун ухаан саруул, сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг, нийгэмшихүйн зөв хандлага, чадвартай, суралцахад бэлэн байх ёстой” гэж заасан.¹

Энэ удаагийн судалгаагаар бага насны хүүхдэд аливаа зүйлийг танин мэдэхэд нь дэмжлэг үзүүлж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээллийг цуглуулсан. Тус үйл ажиллагаа нь насанд хүрэгчид хүүхэдтэйгээ хэрхэн харилцаж, хүүхдийн хөгжлийг хангахад оролцож буй байдал, тодруулбал, ном уншиж өгөх эсвэл номын зургийг тайлбарлах, үлгэр ярих, дуу дуулах, хүүхэдтэйгээ гадуур зугаалах, цагийг хамт өнгөрөөх буюу тоглоомын газар болон цэцэрлэгт хүүхэдтэйгээ тоглох, эд юмсыг зааж нэрлэн ярилцах, тоо тоолох, зураг зурах зэргийг дурдаж болно.

¹ НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 27 дугаар тусгай чуулган, 2002 оны 5 дугаар сарын 10, хуудас 2.

Судалгааны өмнөх 3 өдөр 36-59 сартай нийт хүүхдийн 54.7 хувийнх нь гэр бүлийн хэн нэг гишүүн тэднийг аливаа зүйлийг танин мэдэхэд 4 ба түүнээс олон удаа дэмжлэг үзүүлжээ (Хүснэгт CD.2). Бага насны хүүхдэд гэр бүлийн гишүүдийн зүгээс үзүүлсэн дэмжлэгийг ХХС-2010-ын дүнтэй (57.1 хувь) харьцуулахад төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Хүснэгтээс харахад гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдэд анхаарал тавьж дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааны дундаж тоо 3.6 байна.

Хүүхдээ хөгжүүлэх, аливаа зүйлийг танин мэдэхэд эцэг, эхийн оролцоо маш чухал гэдгийг өмнө дурдсан. Судалгаанд хамрагдсан 36-59 сартай нийт хүүхдийн 83.5 хувь нь төрсөн эцэгтэйгээ, 94.6 хувь нь төрсөн эхтэйгээ хамт амьдарч байна. Судалгааны дүнгээс харахад төрсөн эцэгтэйгээ хамт амьдардаг 3-4 насны нийт хүүхдийн 9.8 хувьд эцэг нь, харин төрсөн эхтэйгээ амьдарч байгаа 3-4 насны нийт хүүхдийн 28.6 хувь эх нь хүүхдээ аливаа зүйлийг танин мэдэхэд 4 ба түүнээс олон удаа дэмжлэг үзүүлсэн байна. Мөн эцгийн дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааны дундаж тоо 1.1 байхад эхийнх 2.3 байгаа юм. Үүнээс харахад эцгийн оролцоо харьцангуй бага байна.

Хүүхдийг аливаа зүйлийг танин мэдэхэд гэр бүлийн гишүүд, насанд хүрэгчдийн зүгээс анхаарал хандуулж дэмжлэг үзүүлэх байдал хүйс болон насны бүлгээр төдийлөн ялгаагүй, харин хот, хөдөө, бүсээр нэлээд ялгаатай байв. Уг үзүүлэлт хотод 60.5 хувь, хөдөөд 46.6 хувь байлаа. Хүүхдийг сургуульд бэлтгэх, суралцахад бэлэн болоход гэр бүлийн гишүүдээс үзүүлсэн дэмжлэгийг бүсээр авч үзвэл Зүүн бүстэй харьцуулахад (42.0 хувь) Төвийн бүс болон Улаанбаатар хотын хүүхдүүдэд гэр бүлийн гишүүд илүү цаг (харгалзан 57.2 болон 61.9 хувь) гаргажээ. Хүүхдийг хөгжүүлэх, сургуульд бэлтгэхэд үзүүлж буй дэмжлэг хүүхдийн амьдарч буй өрхийн аж байдлаар нэлээд ялгаатай байна. Тухайлбал, доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийг дээгүүр түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдтэй харьцуулахад аливааг танин мэдэж, сургуульд бэлтгэхэд гэр бүлийн гишүүдийн болон эцэг, эхийн зүгээс дэмжлэг үзүүлэх нь 1.8-2.5 дахин бага байлаа.

Хүүхдэд үзүүлж буй эцэг, эхийн дэмжлэг тэдний боловсролын түвшнээс хамаарч байна (Хүснэгт CD.2). Эцэг, эхийн боловсролын түвшин дээшлэх тусам хүүхдэдээ үзүүлэх дэмжлэг нэмэгдэж байлаа. Тодруулбал, суурь боловсролтой эцгийн хүүхдийн 4.9 хувьд эцэг нь хүүхдээ аливаа зүйлийг танин мэдэхэд 4 ба түүнээс олон удаа дэмжлэг үзүүлсэн байхад дээд боловсролтой эцгийн хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 19.0 хувь байгаа юм. Эхийн боловсролын хувьд авч үзвэл дээрхийн адил хандлага ажиглагдсан.

Хүүхдийг бага наснаас нь номтой танилцуулж нөхөрлүүлэх нь тэднийг сургуульд суралцахад бэлтгэх төдийгүй оюун ухааны хөгжлийг дэмжихэд ач холбогдолтой. Энэхүү судалгаагаар 5 хүртэлх насны хүүхдийн эх, асрамжлагчаас гэртээ хүүхдийн ном (зурагтай, үлгэрийн гэх мэт), өөрсдөө хийсэн болон дэлгүүрээс худалдаж авсан тоглоом, наадгай байгаа эсэхийг асуусан.

Монгол Улсын хэмжээнд 0-59 сартай нийт хүүхдийн 32.8 хувь нь гэртээ 3 ба түүнээс олон, харин 11.7 хувь нь 10 ба түүнээс олон хүүхдийн номтой байна (Хүснэгт CD.3). Уг үзүүлэлтүүдийг ХХС-2010-ын үр дүнтэй (харгалзан 22.8 болон 6.7 хувь) харьцуулахад өсчээ. 3 ба түүнээс олон тооны хүүхдийн номтой хүүхдүүдийн хувьд хүйсийн ялгаа төдийлөн ажиглагдахгүй байгаач уг үзүүлэлт хот, хөдөө, бүс нутаг болон өрхийн аж байдлын түвшнээр нэлээд ялгаатай байна. Тухайлбал, энэ үзүүлэлт Улаанбаатар хотод хамгийн өндөр (41.3 хувь), Баруун бүсэд хамгийн бага буюу 18.9 хувьтай байв.

Мөн хотын хүүхдүүдийн 40.2 хувь, хөдөөгийн хүүхдүүдийн 21.3 хувь нь гурав ба түүнээс олон хүүхдийн номтой байгаа нь хөдөөгийн хүүхдүүд ном унших, уншуулах (харилцах) боломж хотын хүүхдүүдээс бага байгааг илэрхийлж байна. Түүнчлэн, доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийг дээгүүр түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдтэй харьцуулахад хүүхдийн номтой байх нь 8 дахин бага байгааг (3 ба түүнээс олон номтой хүүхэд харгалзан 13.0 болон 48.7 хувь) Хүснэгт CD.3-аас харж болно.

Эцэг, эхчүүд хүүхдэдээ 2 нас хүрснээс хойш өөрсдөд нь зориулсан ном авч өгөх нь илүү элбэг байна. Тодруулбал, 2 хүртэлх насны хүүхдүүдийн 11.8 хувь нь 3 ба түүнээс олон, 3.2 хувь нь 10 ба түүнээс олон номтой байхад 2-4 насны нийт хүүхдийн хувьд дээрх үзүүлэлтүүд харгалзан 47.4 болон 17.6 хувь байгаа юм.

10 ба түүнээс олон хүүхдийн болон зурагтай номтой хүүхдүүдийн ерөнхий нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн шинж байдлаарх дүр зураг адил байв.

Мөн хүснэгт CD.3-аас харахад 0-59 сартай хүүхдүүдийн 55.8 хувь нь 2 ба түүнээс олон төрлийн тоглоомоор тоглож байна. Уг үзүүлэлтийг ХХС-2010-аас тооцсон хэдий ч асуулгын загвар өөрчлөгдсөнтэй

холбогдон үр дүнг харьцуулах боломжгүй юм. Энэхүү судалгаагаар тоглоом гэдэгт өөрсдөө гар аргаар хийсэн тоглоом (хүүхэдэй, машин болон гэртээ хийсэн бусад тоглоом), дэлгүүрээс худалдаж авсан тоглоом, гэрийн эд зүйл болон гэрийн гаднах эд зүйлсийг (аяга, таваг, халбага, саваа мод, чулуу, юмны сав, навч гэх мэт) авч үзсэн болно.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 92.2 хувь нь дэлгүүрээс авсан тоглоомоор, 48.2 хувь гэрийн гаднах болон гэрийн эд зүйлээр, 25.1 хувь нь гар аргаар хийсэн тоглоомоор тоглодог байна. 2 ба түүнээс олон төрлийн тоглоомтой хүүхдүүдийг хүйсээр авч үзвэл төдийлөн ялгаагүй (хөвгүүд 56.5 хувь, охид 55.0 хувь) байлаа. Мөн хөдөөгийн хүүхдүүдийн 59.3 хувь нь 2 ба түүнээс олон төрлийн тоглоом, наадгайтай гэсэн бол энэ үзүүлэлт хотод 53.5 хувь байв.

Харин 0-23 сартай хүүхдүүдийн 43.1 хувь, 24-59 сартай хүүхдүүдийн 64.5 хувь нь 2 ба түүнээс олон төрлийн тоглоомтой байна. Харин 2 ба түүнээс олон төрлийн тоглоомтой хүүхэд Улаанбаатар хотод хамгийн бага (51.2 хувь), Төвийн бүсэд хамгийн их (65.3 хувь) байна (Хүснэгт CD.3).

Хоёр ба түүнээс олон төрлийн тоглоомтой хүүхдүүдийг эхийн боловсролын түвшин (52.8-57.3 хувь), өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаагаар (51.2-56.7 хувь) авч үзэхэд төдийлөн ялгаагүй байлаа. Өрхийн аж байдлын түвшний хувьд төдийлөн ялгаагүй хэдий ч тоглоомын төрлөөр авч үзвэл нэлээд ялгаатай дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал, доогуур түвшний аж байдалтай өрхийн хүүхдүүдийн 84.5 хувь нь дэлгүүрээс авсан тоглоомоор, 52.6 хувь нь гэрийн эд зүйл болон гэрийн гаднах эд зүйлээр, 29.9 хувь нь гар аргаар хийсэн тоглоомоор тоглодог бол дээгүүр аж байдалтай өрхийн хүүхдүүдийн хувьд дээрх 3 үзүүлэлт харгалзан 97.1, 47.1 болон 24.5 хувьтай байгаа юм.

Бага насны хүүхдийг ганцааранг нь эсвэл хүүхдээр харуулж үлдээх нь хүүхэд ахуйн осолд өртөх эрсдэлийг бий болгодог.² НҮТС-нд судалгааны өмнөх долоо хоногт 0-59 сартай хүүхдээ гэртээ ганцааранг эсвэл 10 нас хүрээгүй хүүхдийн асрамжид үлдээсэн эсэхийг хүүхдийн эх, асрамжлагчаас асууж тодруулсан.

Хүснэгт CD.4-өөс харахад судалгаанаас өмнөх 7 хоногийн хугацаанд 0-59 сартай хүүхдийн 8.2 хувийг гэрт нь 10 нас хүрээгүй хүүхдийн асрамжид, 4.2 хувийг ганцааранг нь үлдээсэн байна. Эдгээр үзүүлэлтийг нэгтгэн тооцвол 5 хүртэлх насны нийт хүүхдийн 10.2 хувь нь судалгаанаас өмнөх 7 хоногт насанд хүрэгчдийн хараа хяналтгүй үлджээ. Уг үзүүлэлтийг ХХС-2010-ын дүнтэй (8.5 хувь) харьцуулахад төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Насаар авч үзвэл 24-59 сартай хүүхдийн 11.4 хувийг, 0-23 сартай хүүхдийн 8.4 хувийг насанд хүрэгчдийн хараа хяналтгүйгээр үлдээжээ. Амьдрах орчны онцлог, нөхцөл байдал, амьдралын хэв маягаас хамаараад хүүхдийг ганцааранг нь эсвэл 10 хүртэлх насны хүүхдээр харуулж гэрт үлдээх нь хөдөөд хоттой харьцуулахад илүү (13.8 ба 7.9 хувь) байв. Бүсээр авч үзвэл хүүхдийг ганцааранг нь эсвэл өөр хүүхдээр харуулж гэрт үлдээх нь Улаанбаатар хотод хамгийн бага (6.8 хувь), Баруун бүсэд хамгийн өндөр (18.1 хувь), бусад бүсийн хувьд жигд (10.1-11.0 хувь) байлаа. Насанд хүрэгчдийн хараа хяналтгүйгээр хүүхдийг ганцааранг нь эсвэл 10 нас хүрээгүй хүүхдийн асрамжид үлдээх нь эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай байна. Тухайлбал, боловсролгүй эхчүүдийн хүүхдийн 18.0 хувь, техникийн, тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой эхчүүдийн хүүхдийн 7.6-8.1 хувь нь насанд хүрсэн хүний хараа хяналтгүй үлдсэн байв. Мөн өрхийн аж байдлын түвшин доогуур байх тусам 5 хүртэлх насны хүүхдийг зохих хараа хяналтгүй гэрт нь үлдээх хандлагатай байна.

Бага насны хүүхдийн хөгжил

Бага насны хүүхдийн хөгжлийг хүүхэд хөдөлгөөн, сэтгэн бодох, ярих, мэдрэх, бусад хүмүүстэй харилцах зэрэг үйлдлүүдийг хийж сурдаг үргэлжилсэн, дараалалтай, явцыг урьдчилан харах боломжтой үйл явц гэж тодорхойлсон байдаг. Бие бялдрын хөгжил, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх, нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, сурах чадвар зэрэг нь хүүхдийн ерөнхий хөгжлийн гол хүчин зүйлүүд бөгөөд хүний хөгжлийн суурь болдог.³

² Гроссман, Дэвид С. (2000). Осол, гэмтлийн хяналтын түүх болон хүүхэд, өсвөр насныхны осол, гэмтлийн эпидемиологи. Хүүхдийн ирээдүй, 10(1), 23-52

³ Шонкоф Ж болон Филипс Д, Нэгээс олонруу: бага насны хүүхдийн хөгжлийн шинжлэх ухаан, Бага насны хүүхдийн хөгжлийн нэгтгэсэн шинжлэх ухааны хороо, Үндэсний судалгааны зөвлөл, 2000 он.

Бага насны хүүхдийн хөгжлийн индексийг (БНХХИ) тооцохдоо 10 асуултыг хүүхдийн эх/асрамжлагчаас асуусан. БНХХИ-ийн гол зорилго нь хүүхдийн хөгжлийн байдлыг бодлого боловсруулагчдад мэдээлэх явдал юм. Энэхүү үзүүлэлт нь 3 болон 4 настай хүүхэд тухайн насны ихэнх хүүхдийн адилаар хөгжиж байгаа бол тэдний хийж чадаж байгаа зүйлийг мөн адил хийх ёстой гэсэн санаан дээр үндэслэсэн юм.

Дээр дурдсан 10 асуултыг дараах үндсэн 4 хэсэгт хуваадаг бөгөөд эдгээр нь тус бүрдээ хүүхэд тухайн хэсэгт заагдсан чадварыг эзэмшсэн эсэхийг тодорхойлох зорилготой. Үүнд:

- *Унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар:* Цагаан толгойн 10-аас доошгүй үсгийг таньж, нэрлэж чаддаг, 4-өөс доошгүй энгийн түгээмэл үгийг уншдаг, 1-10 хүртэл тоог таньж, нэрлэж чаддаг эсэхээр хөгжлийн зохих түвшинд байгаа эсэхийг тодорхойлно. Эдгээрээс наад зах нь хоёрыг чаддаг бол унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар нь зохих түвшинд байна гэж үзнэ.
- *Бие бялдрын хөгжил:* Хүүхэд аливаа зүйлийг (мод, чулуу гэх мэт) 2 хуруугаараа барьж чаддаг, мөн хүүхэд тоглохдоо дургүйцдэггүй бол тухайн хүүхэд бие бялдрын хөгжлийн зохих түвшинд байна гэж үзнэ.
- *Нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар:* Хүүхэд бусад хүүхдүүдтэй эвтэй, зөв харилцдаг, бусдыг цохиж, өшиглөж, хаздаггүй, мөн хүүхдийн анхаарал амархан сарнидаггүй гэсэн 3 үзүүлэлтээс наад зах нь 2 чадвар тухайн хүүхдэд байвал нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар нь хөгжлийн зохих түвшинд байна гэж үзнэ.
- *Сурах чадвар:* Хүүхэд энгийн зааврын дагуу ямар нэгэн зүйлийг зөв хийж, мөн хийлгэх гэж өгсөн зүйлийг зөв бөгөөд бие даан хийж, гүйцэтгэж байвал сурах чадвар нь зохих түвшинд байна гэж үздэг.

БНХХИ-ийг дээрх 4 хэсгийн 3-аас доошгүй хэсэгт хөгжлийн зохих түвшинд байгаа хүүхдийн хувиар тооцдог.

Монгол Улсын 3-4 насны хүүхдийн хөгжлийн индексийг дээрх олон улсын аргачлалын дагуу энэ удаагийн НҮТС-ны мэдээллээс тооцоход 76.0 хувь байна (Хүснэгт CD.5). Уг үзүүлэлтийг анх 2010 оны Хүүхэд хөгжил судалгаанаас тооцсон бөгөөд 85.1 хувь байсан.

Үүнийг нарийвчлан авч үзвэл бие бялдрын хөгжил болон сурах чадвар нь зохих түвшинд байгаа хүүхдийн хувь хамгийн өндөр (99.0 ба 97.8 хувь), нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар нь зохих түвшинд байгаа хүүхдийн хувь 75.7, харин унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар нь зохих хэмжээнд байгаа хүүхдийн хувь хамгийн бага буюу ердөө 9.3 байна. Унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадварыг харуулсан үзүүлэлт бусдаасаа хамгийн бага байгаа нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй “Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт”-д тоо цифр таних чадвар эзэмшүүлэх тухай агуулга байдаг хэдий ч цагаан толгойн үсэг таних, энгийн үг унших асуудал байхгүйтэй холбоотой юм.

Хүүхдийн хөгжлийг тодорхойлж байгаа аль ч үзүүлэлтийн хувьд хот, хөдөөд ялгаагүй (75.7-76.2 хувь) байна. БНХХИ охид (79.1 хувь)-ын хувьд хөвгүүд (72.9 хувь)-ийнхээс 6.2 пунктээр илүү байв. Үүнийг нарийвчлан авч үзвэл унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар, нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар нь зохих түвшинд байгаа охидын хувь хөвгүүдийнхээс 3.3-6.4 пунктээр өндөр байна. Хүүхдийн хөгжлийн индексийн үзүүлэлтүүд ерөнхийдөө эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлаас үл хамааран ижил түвшинд байгаа боловч унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар нь зохих түвшинд байгаа хүүхдүүдийн дунд ялгаатай дүр зураг ажиглагдлаа. Тухайлбал, дээгүүр түвшний болон дунджаас дээгүүр аж байдалтай өрхийн хүүхдүүдийн хувь бусдаас илүү (10.6-13.3 ба 6.7-8.7 хувь) байв.

Насаар авч үзвэл БНХХИ нэлээд ялгаатай буюу 3 настай хүүхдүүдийн хувьд 71.0 хувь буюу 4 настай хүүхдүүдтэй харьцуулахад даруй 10.1 пунктээр доогуур байна. Үүнийг нарийвчлан ажиглавал бие бялдрын хөгжил, сурах чадвар зэрэг нь зохих түвшинд байгаа 3-4 насны хүүхдүүдийн хувь насаар төдийлөн ялгаагүй боловч унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх болон нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар нь зохих түвшинд байгаа 4 настангуудын хувь 3 настангуудынхаас харьцангуй өндөр (унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар 13.4 ба 5.3 хувь, нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар 79.7 ба 71.8 хувь) байна.

СӨБ-д хамрагддаг 3-4 насны хүүхдүүдийн БНХХИ нь 78.0 хувь байхад хамрагддаггүй хүүхдүүдийн хувьд уг үзүүлэлт 71.7 хувьтай байгаа юм. СӨБ-д хамрагдсан хүүхдүүдийн унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх болон нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар нь тодорхой хэмжээнд илүү хөгжиж СӨБ-д хамрагддаггүй хүүхдийнхээс харьцангуй өндөр үзүүлэлттэй байгааг Хүснэгт CD.5-аас харж болно.

Өмнө дурдсанчлан, манай улсын хувьд "Сургуулийн өмнөх боловсролын стандарт"-д цагаан толгойн 10-аас доошгүй үсгийг таньж, нэрлэх чадвар эзэмшүүлэх асуудал байдаггүй тул бид өөрийн улс орны онцлогийг тусган нэмэлт хэд хэдэн асуултыг асуулгад оруулж өгсөн юм. Үүний дүнд БНХХИ-г тооцож үзэхэд 93.1 байгаа бөгөөд нарийвчлан авч үзвэл унших, цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар нь зохих түвшинд хөгжсөн хүүхдийн хувь 80.5 болж өссөн дүнтэй байна. Бусад үзүүлэлт олон улсын аргачлалаар тооцсонтой ижил байна (Хүснэгт CD.5A).

Хүснэгт CD.1: Сургуулийн өмнөх боловсрол

Сургуулийн өмнөх боловсролд хамрагддаг 36-59 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Сургуулийн өмнөх боловсролд хамрагддаг 36-59 сартай хүүхдийн хувь ¹	36-59 сартай хүүхдийн тоо
Дүн	68.2	2337
Хүйс		
Эрэгтэй	68.1	1175
Эмэгтэй	68.2	1162
Бүс		
Баруун	57.3	379
Хангай	63.7	501
Төв	71.9	423
Зүүн	76.2	182
Улаанбаатар	72.1	852
Хот, хөдөө		
Хот	75.9	1364
Хөдөө	57.3	973
Байршил		
Нийслэл	72.1	852
Аймгийн төв	82.3	513
Сумын төв	82.5	302
Хөдөө	45.9	671
Нас		
36-47 сартай	62.7	1180
48-59 сартай	73.7	1157
Эхийн боловсрол		
Боловсролгүй	40.7	146
Бага	40.0	177
Суурь	53.2	386
Бүрэн дунд	66.6	550
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	67.3	191
Дээд	86.0	887
Өрхийн аж байдлын түвшин		
Доогуур	35.8	545
Дунджаас доогуур	66.1	497
Дундаж	77.8	439
Дунджаас дээгүүр	79.9	399
Дээгүүр	89.6	456
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*		
Халх	71.0	1850
Казах	46.8	115
Бусад	60.9	365

¹ НҮТС-ны үзүүлэлт 6.1 - Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт

* Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй 10 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ

Хүснэгт CD.2: Аливааг танин мэдэхэд гэр бүлийн зүгээс үзүүлсэн дэмжлэг

Сүүлийн 3 хоногт гэр бүлийн насанд хүрсэн гишүүд, төрсөн эцэг болон эхийн зүгээс аливааг танин мэдэх, сурахад нь дэмжлэг үзүүлсэн 36-59 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	Аливааг танин мэдэхэд нь гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн зүгээс 4 ба түүнээс олон дэмжлэг үзүүлсэн хүүхдийн хувь ¹	Гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн зүгээс дэмжлэг дундаж тоо	Хүүхдийн хувь (хамт амьдардаг):	36-59 сартай хүүхдийн тоо	Аливааг танин мэдэхэд нь төрсөн эцгийн зүгээс 4 ба түүнээс олон дэмжлэг үзүүлсэн хүүхдийн хувь ²	Төрсөн эцгийн зүгээс дэмжлэг үзүүлсэн дундаж тоо	Төрсөн эцэгтэйгээ хамт амьдардаг 36-59 сартай хүүхдийн тоо	Аливааг танин мэдэхэд нь төрсөн эхийн зүгээс 4 ба түүнээс олон дэмжлэг үзүүлсэн хүүхдийн хувь ³	Төрсөн эхийн зүгээс дэмжлэг үзүүлсэн дундаж тоо	Төрсөн эхтэйгээ хамт амьдардаг 36-59 сартай хүүхдийн тоо	
											Төрсөн эцэгтэйгээ
Дүн	54.7	3.6	83.5	94.6	2337	9.8	1.1	1953	28.6	2.3	2211
Хүйс											
Эрэгтэй	54.8	3.6	82.8	94.2	1175	9.5	1.1	973	27.8	2.2	1107
Эмэгтэй	54.7	3.6	84.3	94.9	1162	10.2	1.1	980	29.5	2.3	1104
Бүс											
Баруун	47.8	3.2	90.7	95.5	379	8.6	1.0	344	21.6	1.9	362
Хангай	50.4	3.4	85.8	94.0	501	9.0	1.1	430	27.4	2.2	471
Төв	57.2	3.7	81.6	92.9	423	7.0	1.0	345	29.7	2.4	393
Зүүн	42.0	3.0	79.1	94.7	182	10.4	1.0	144	21.6	1.9	172
Улаанбаатар	61.9	3.9	81.0	95.3	852	12.2	1.3	690	33.4	2.5	812
Хот, хөдөө											
Хот	60.5	3.8	80.4	94.4	1364	10.7	1.2	1096	32.2	2.5	1288
Хөдөө	46.6	3.2	88.0	94.9	973	8.6	1.0	857	23.6	2.0	923
Байршил											
Нийслэл	61.9	3.9	81.0	95.3	852	12.2	1.3	690	33.4	2.5	812
Аймгийн төв	58.4	3.7	79.3	92.8	513	8.2	1.1	407	30.2	2.4	476
Сумын төв	56.8	3.5	83.1	91.6	302	11.0	1.1	251	28.6	2.3	277
Хөдөө	42.0	3.0	90.2	96.3	671	7.6	0.9	605	21.4	1.9	646
Нас											
36-47 сартай	55.9	3.6	84.2	95.8	1180	9.4	1.1	993	28.3	2.3	1131
48-59 сартай	53.5	3.5	82.9	93.3	1157	10.3	1.1	960	28.9	2.3	1080
Эхийн боловсрол^a											
Боловсролгүй	36.1	2.6	82.2	91.2	146	5.4	0.8	120	12.9	1.3	133
Бага	33.3	2.7	87.2	93.4	177	6.3	0.8	154	12.4	1.4	165
Суурь	39.2	3.0	84.8	95.1	386	5.6	0.9	327	19.4	1.9	367
Бүрэн дунд	55.3	3.6	85.5	97.1	550	9.0	1.0	471	29.1	2.3	534
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	55.7	3.5	74.4	84.1	191	7.8	0.8	142	24.3	2.0	161
Дээд	68.3	4.1	83.3	95.8	887	14.0	1.4	739	39.1	2.8	850
Эцгийн боловсрол*											
Боловсролгүй	36.5	2.7	100.0	98.8	228	7.9	0.9	228	18.2	1.8	225
Бага	38.5	2.9	100.0	99.8	245	4.9	1.0	245	20.2	1.9	244
Суурь	49.0	3.4	100.0	98.6	404	7.1	1.0	404	26.1	2.2	398
Бүрэн дунд	58.2	3.7	100.0	99.4	403	13.9	1.4	403	31.5	2.5	400
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	55.8	3.5	100.0	98.2	188	11.4	1.3	188	27.2	2.3	185
Дээд	70.7	4.2	100.0	97.7	482	19.0	1.8	482	39.6	2.8	471
Эцэг нь хамт амьдардаггүй	57.7	3.7	0.0	73.7	385	na	na	na	26.7	2.0	283
Өрхийн аж байдлын түвшин											
Доогуур	38.3	2.8	88.9	95.2	545	6.6	0.9	485	19.8	1.7	519
Дунджаас доогуур	50.8	3.4	78.8	93.8	497	6.9	0.9	392	22.1	2.0	467
Дундаж	55.7	3.6	81.3	95.4	439	8.6	1.1	357	27.9	2.3	419
Дунджаас дээгүүр	63.2	3.9	83.4	93.7	399	11.5	1.2	333	34.0	2.5	374
Дээгүүр	70.5	4.3	84.5	94.6	456	16.7	1.6	386	42.3	2.9	432
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**											
Халх	56.3	3.6	82.0	94.2	1850	10.3	1.1	1517	29.9	2.3	1743
Казах	46.3	3.1	96.5	96.6	115	4.7	0.7	111	22.2	1.8	111
Бусад	49.6	3.4	87.1	95.8	365	9.5	1.1	318	24.1	2.1	349

¹ НҮТС-ны үзүүлэлт 6.2 - Аливааг танин мэдэхэд гэр бүлийн гишүүдийн зүгээс үзүүлсэн дэмжлэг

² НҮТС-ны үзүүлэлт 6.3 - Аливааг танин мэдэхэд эцгийн зүгээс үзүүлсэн дэмжлэг

³ НҮТС-ны үзүүлэлт 6.4 - Аливааг танин мэдэхэд эхийн зүгээс үзүүлсэн дэмжлэг

na: Тооцох боломжгүй

^a "Эхийн боловсрол" гэсэн шинж байдлын үзүүлэлт нь 5 хүртэлх насны хүүхдийн асуулгад хариулсан хүний боловсролоор тодорхойлогдсон. Тодруулбал, эхийн эсвэл эх нь өрхийн гишүүдийн жагсаалтад бичигдээгүй тохиолдолд асран хамгаалагчийн боловсрол юм. Үзүүлэлт 6.4 нь аливааг танин мэдэхэд төрсөн эхийн үзүүлсэн дэмжлэг гэж байгаа тул "Эхийн боловсрол" гэдэгт зөвхөн төрсөн эхийн боловсролыг авч үзсэн.

* Эцгийн боловсролын түвшин нь хариулагдаагүй харгалзан 4, 4, 4 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй харгалзан 10, 9, 9 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

Хүснэгт CD.3: Сургалтын хэрэглэгдэхүүн

5 хүртэлх насны хүүхдийн хувь, өрхөд байгаа хүүхдийн номны тоогоор болон хүүхдийн тоглодог зүйлсээр, Монгол Улс, 2013 он

	Өрхөд амьдарч байгаа хүүхдийн хувь:		Дараах зүйлсээр тоглодог хүүхдийн хувь:				5 хүртэлх насны хүүхдийн хувь
	3 ба түүнээс олон хүүхдийн номтой ¹	10 ба түүнээс олон хүүхдийн номтой	Гэртээ хийсэн тоглоом	Дэлгүүрээс авсан/ үйлдвэрийн тоглоом	Гэрийн эд зүйл/ гэрийн гаднаас олсон эд зүйл	2 ба түүнээс олон төрлийн тоглох зүйлтэй ²	
Дүн	32.8	11.7	25.1	92.2	48.2	55.8	6054
Хүйс							
Эрэгтэй	31.5	11.0	26.1	92.7	48.4	56.5	3103
Эмэгтэй	34.2	12.3	24.1	91.6	47.9	55.0	2951
Бүс							
Баруун	18.9	5.5	27.1	87.3	50.3	55.5	904
Хангай	28.3	7.4	25.3	91.8	49.3	55.4	1234
Төв	31.6	10.9	32.4	93.2	54.4	65.3	1061
Зүүн	30.8	9.2	31.2	90.8	50.5	59.2	453
Улаанбаатар	41.3	17.0	19.9	94.1	43.5	51.2	2402
Хот, хөдөө							
Хот	40.2	15.8	21.9	94.0	45.6	53.5	3693
Хөдөө	21.3	5.2	30.2	89.4	52.1	59.3	2361
Байршил							
Нийслэл	41.3	17.0	19.9	94.1	43.5	51.2	2402
Аймгийн төв	38.1	13.6	25.5	93.9	49.5	57.8	1291
Сумын төв	32.4	9.5	29.7	93.0	52.5	62.2	727
Хөдөө	16.3	3.3	30.4	87.8	51.9	58.0	1634
Нас							
0-23 сартай	11.8	3.2	19.8	88.2	35.0	43.1	2480
24-59 сартай	47.4	17.6	28.8	95.0	57.3	64.5	3574
Эхийн боловсрол*							
Боловсролгүй	6.4	0.9	26.6	81.5	50.9	52.8	334
Бага	10.3	1.9	30.7	85.1	50.8	53.9	423
Суурь	17.8	3.1	26.8	87.8	48.3	54.6	894
Бүрэн дунд	30.3	7.9	23.7	93.4	46.4	54.8	1509
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	28.1	7.9	24.4	92.1	50.1	57.1	494
Дээд	48.7	21.3	24.3	95.8	48.0	57.3	2398
Өрхийн аж байдлын түвшин							
Доогуур	13.0	2.1	29.9	84.5	52.6	56.7	1326
Дунджаас доогуур	20.5	4.3	23.7	91.3	46.6	53.1	1227
Дундаж	32.3	8.8	23.5	93.6	43.9	53.2	1159
Дунджаас дээгүүр	43.9	15.2	23.3	95.5	50.2	58.2	1088
Дээгүүр	56.8	28.7	24.5	97.1	47.1	57.7	1253
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**							
Халх	35.3	12.6	25.4	93.4	48.7	56.7	4828
Казах	17.7	7.0	28.1	84.5	53.9	56.6	256
Бусад	24.6	8.3	22.8	88.4	44.6	51.2	953

¹ НҮТС-ны үзүүлэлт 6.5 - 3 ба түүнээс олон хүүхдийн номтой хүүхэд² НҮТС-ны үзүүлэлт 6.6 - 2 ба түүнээс олон төрлийн тоглоомтой хүүхэд

* Эхийн боловсролын түвшин нь хариулагдаагүй 2 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй 19 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

Хүснэгт CD.4: Насанд хүрэгчдийн хараа хяналтгүйгээр хүүхдээ ганцааранг нь үлдээсэн байдал

Сүүлийн 7 хоногт 1 цагаас илүү хугацаагаар ганцаараа нь эсвэл 10 хүртэлх насны хүүхдээр асруулж үлдсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь, Монгол Улс, 2013 он

	5 хүртэлх насны хүүхдийн хувь:			5 хүртэлх насны хүүхдийн хувь
	Сүүлийн 7 хоногт ганцаараа үлдсэн	Сүүлийн 7 хоногт 10 хүртэлх насны хүүхдээр асруулж үлдсэн	Сүүлийн 7 хоногт насанд хүрэгчдийн хараа хяналтгүй үлдсэн ¹	
Дүн	4.2	8.2	10.2	6054
Хүйс				
Эрэгтэй	3.8	7.5	9.4	3103
Эмэгтэй	4.6	9.0	11.0	2951
Бүс				
Баруун	6.8	15.0	18.1	904
Хангай	4.9	8.4	11.0	1234
Төв	4.7	7.1	10.1	1061
Зүүн	3.9	8.7	10.1	453
Улаанбаатар	2.6	6.0	6.8	2402
Хот, хөдөө				
Хот	3.0	6.6	7.9	3693
Хөдөө	6.0	10.8	13.8	2361
Байршил				
Нийслэл	2.6	6.0	6.8	2402
Аймгийн төв	3.6	7.7	9.8	1291
Сумын төв	4.3	10.6	11.8	727
Хөдөө	6.8	10.9	14.7	1634
Нас				
0-23 сартай	3.6	6.8	8.4	2480
24-59 сартай	4.6	9.2	11.4	3574
Эхийн боловсрол*				
Боловсролгүй	10.9	11.9	18.0	334
Бага	5.6	10.4	12.4	423
Суурь	6.7	12.5	15.7	894
Бүрэн дунд	3.7	7.7	9.4	1509
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	3.1	6.2	8.1	494
Дээд	2.6	6.5	7.6	2398
Өрхийн аж байдлын түвшин				
Доогуур	7.9	10.7	14.6	1326
Дунджаас доогуур	3.7	9.0	11.2	1227
Дундаж	3.5	8.1	9.4	1159
Дунджаас дээгүүр	2.6	6.0	7.0	1088
Дээгүүр	2.6	7.0	7.9	1253
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**				
Халх	3.6	7.2	8.9	4828
Казах	11.6	13.1	19.5	256
Бусад	5.1	12.0	14.0	953

¹ НУТС-ны үзүүлэлт 6.7 - Насанд хүрэгчдийн хараа хяналтгүй үлдсэн хүүхэд

* Эхийн боловсролын түвшин нь хариулагдаагүй 2 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй 19 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

Хүснэгт CD.5: Бага насны хүүхдийн хөгжлийн индекс

Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх, бие бялдрын, нийгэмшихүйн болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, сурах чадварууд нь зохих түвшинд байгаа 36-59 сартай хүүхдийн хувь болон бага насны хүүхдийн хөгжлийн индекс, Монгол Улс, 2013 он

	Дараах чадварууд нь зохих түвшинд байгаа 36-59 сартай хүүхдийн хувь				Бага насны хүүхдийн хөгжлийн индекс ¹	36-59 сартай хүүхдийн тоо
	Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх	Бие бялдрын	Нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх	Сурах		
Дүн	9.3	99.0	75.7	97.8	76.0	2337
Хүйс						
Эрэгтэй	7.6	98.9	72.5	97.2	72.9	1175
Эмэгтэй	10.9	99.1	78.9	98.3	79.1	1162
Бүс						
Баруун	8.9	99.5	74.4	97.1	73.8	379
Хангай	8.1	98.4	75.3	96.4	74.3	501
Төв	8.0	99.2	75.7	98.8	76.8	423
Зүүн	5.2	99.1	81.0	97.5	81.0	182
Улаанбаатар	11.6	99.0	75.3	98.4	76.5	852
Хот, хөдөө						
Хот	10.9	99.0	75.2	98.1	76.2	1364
Хөдөө	7.0	99.1	76.4	97.3	75.7	973
Байршил						
Нийслэл	11.6	99.0	75.3	98.4	76.5	852
Аймгийн төв	9.6	98.9	75.0	97.6	75.7	513
Сумын төв	7.1	99.6	75.7	98.5	75.3	302
Хөдөө	7.0	98.8	76.7	96.8	75.9	671
Нас						
36-47 сартай	5.3	98.6	71.8	96.8	71.0	1180
48-59 сартай	13.4	99.5	79.7	98.7	81.1	1157
СӨБ-д хамрагдалт						
Хамрагддаг	10.6	99.2	76.8	98.7	78.0	1594
Хамрагдаггүй	6.3	98.7	73.2	95.9	71.7	744
Эхийн боловсрол						
Боловсролгүй	7.2	100.0	84.7	95.9	81.0	146
Бага	6.0	98.3	78.4	93.9	75.8	177
Суурь	6.8	98.9	75.1	97.5	75.6	386
Бүрэн дунд	9.6	99.0	74.5	98.5	75.1	550
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	7.4	98.5	75.4	97.7	76.9	191
Дээд	11.5	99.1	74.7	98.6	75.7	887
Өрхийн аж байдлын түвшин						
Доогуур	6.7	98.9	79.1	96.2	77.5	549
Дунджаас доогуур	7.8	99.0	76.0	98.1	75.7	507
Дундаж	8.7	99.6	74.9	97.7	75.2	427
Дунджаас дээгүүр	10.6	98.7	72.2	99.2	74.1	401
Дээгүүр	13.3	98.8	75.0	98.2	76.9	452
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*						
Халх	9.1	98.9	75.3	97.8	76.0	1850
Казах	12.4	98.3	70.2	92.1	66.6	115
Бусад	9.1	99.7	79.3	99.4	78.9	365

¹ НҮТС-ны үзүүлэлт 6.8 - Бага насны хүүхдийн хөгжлийн индекс

* Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй 8 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ

Хүснэгт CD.5A: Бага насны хүүхдийн хөгжлийн индекс (өөрийн орны онцлогт суурилсан тодорхойлолтоор)

Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх, бие бялдрын, нийгэмшихүйн болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, сурах чадварууд нь зохих түвшинд байгаа 36-59 сартай хүүхдийн хувь болон бага насны хүүхдийн хөгжлийн индекс, өөрийн орны онцлогт суурилсан тодорхойлолтоор, Монгол Улс, 2013 он

	Дараах чадварууд нь зохих түвшинд байгаа 36-59 сартай хүүхдийн хувь				Бага насны хүүхдийн хөгжлийн индекс ¹ [a][b]	36-59 сартай хүүхдийн тоо
	Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх [a]	Бие бялдрын [b]	Нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх	Сурах		
Дүн	80.5	98.3	75.7	97.8	93.1	2337
Хүйс						
Эрэгтэй	79.6	98.1	72.5	97.2	91.5	1175
Эмэгтэй	81.4	98.5	78.9	98.3	94.7	1162
Бүс						
Баруун	68.8	97.6	74.4	97.1	88.3	379
Хангай	81.1	98.0	75.3	96.4	91.7	501
Төв	79.9	98.9	75.7	98.8	94.4	423
Зүүн	84.9	98.8	81.0	97.5	94.9	182
Улаанбаатар	84.8	98.4	75.3	98.4	95.0	852
Хот, хөдөө						
Хот	84.6	98.5	75.2	98.1	94.5	1364
Хөдөө	74.8	98.1	76.4	97.3	91.2	973
Байршил						
Нийслэл	84.8	98.4	75.3	98.4	95.0	852
Аймгийн төв	84.3	98.6	75.0	97.6	93.6	513
Сумын төв	84.6	98.6	75.7	98.5	96.2	302
Хөдөө	70.4	97.8	76.7	96.8	88.9	671
Нас						
36-47 сартай	70.5	97.6	71.8	96.8	89.2	1180
48-59 сартай	90.8	99.1	79.7	98.7	97.1	1157
СӨБ-д хамрагдалт						
Хамрагддаг	88.2	98.6	76.8	98.7	95.8	1594
Хамрагддаггүй	64.1	97.8	73.2	95.9	87.3	744
Эхийн боловсрол						
Боловсролгүй	63.9	100.0	84.7	95.9	89.3	146
Бага	64.4	96.5	78.4	93.9	84.3	177
Суурь	75.5	97.9	75.1	97.5	91.8	386
Бүрэн дунд	82.5	98.4	74.5	98.5	93.5	550
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	76.1	98.1	75.4	97.7	93.3	191
Дээд	88.4	98.6	74.7	98.6	95.8	887
Өрхийн аж байдлын түвшин						
Доогуур	69.0	98.1	79.1	96.2	88.5	549
Дунджаас доогуур	77.0	97.4	76.0	98.1	92.2	507
Дундаж	81.7	99.6	74.9	97.7	93.8	427
Дунджаас дээгүүр	86.4	98.4	72.2	99.2	94.9	401
Дээгүүр	92.2	98.3	75.0	98.2	97.4	452
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*						
Халх	82.1	98.5	75.3	97.8	93.8	1850
Казах	69.9	92.9	70.2	92.1	82.3	115
Бусад	75.8	99.2	79.3	99.4	93.1	365

¹ НУТС-ын үзүүлэлт CS8.1 - Бага насны хүүхдийн хөгжлийн индекс (өөрийн улс орны онцлогт суурилж тооцсон)

[a] Дараах гурваас хамгийн багадаа 2 зүйлийг нь чаддаг бол цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар нь зохих түвшинд байна гэж үзсэн: EC7A = 1 (Зарим өнгийг ялгаж чадна), EC7B = 1 (Гурвалжин, дөрвөлжин, дугуй зэрэг энгийн дүрсийг ялгаж чадна), EC9A = 1 (Тоо тоолж чадна).

[b] Дараах гурваас хамгийн багадаа 2 зүйлийг нь чаддаг бол бие бялдрын хөгжил нь зохих түвшинд байна гэж үзсэн: EC11 = 1 (Газраас ямар нэг эд зүйлийг 2 хуруугаараа чимхэн авч чадна), EC11A = 1 (Эрхий, долоовор, дунд хуруугаараа халбага, сэрээ эсвэл харандааг барьж чадна), EC12 = 2 (Тоглох чадваргүй болтлоо бие нь тавгүйрхэж, сульдаггүй)

[a][b] Монгол Улсын сургуулийн өмнөх боловсролын стандартад хүүхдэд цагаан толгойн үсэг нэрлэж сургах, энгийн нийтлэг үгийг унших, тоо таньж нэрлэхийг заах тухай байдаггүй тул өөрийн улс орны онцлогыг тусгасан зарим асуултуудыг бага насны хүүхдийн хөгжил бүлэгт оруулсан.

Хүүхдийн цагаан толгойн үсэг, тоо нэрлэх чадвар болон бие бялдрын хөгжил нь зохих түвшинд байгаа хүүхдийг дээр бичсэнээр тодорхойлсон. Харин нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, сурах чадварын тодорхойлолт нь Хүснэгт CD.5-ынхтай ижил.

* Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь харуулагдаагүй 8 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

IX БҮЛЭГ

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

IX

Төрсний бүртгэл

НҮБ-ын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай конвенцид зааснаар хүүхэд бүр төрмөгцөө нэр авах, иргэний харьяалалтай болох, хувийн онцлог байдлаа хадгалах эрхтэй байдаг. Дэлхийн хэмжээнд 5 хүртэлх насны ойролцоогоор 230 сая хүүхэд (ойролцоогоор 3 хүүхэд тутмын 1) төрсний бүртгэл хийлгээгүй байна. Ийнхүү албан ёсоор бүртгэгдээгүй байгаа нь төрсний гэрчилгээ авах боломжгүй байгааг илэрхийлдэг. Хүүхдийг төрсний бүртгэлд зохих ёсоор бүртгүүлээгүйгээс тэд эмнэлгийн тусламж авах, сургуульд сурахад хүндрэлтэй болдог. Түүнчлэн, албан ёсны бичиг баримтгүй байх нь цаашдаа хуульд заасан наснаас өмнө гэрлэх, хөдөлмөр эрхлэх, цэргийн албанд татагдах боломжийг бий болгодог билээ. Насанд хүрэгчдийн хувьд нийгмийн халамжид хамрагдах, албан секторт ажиллах, өмч худалдан авах, өвлөн авах, сонгуульд санал өгөх болон иргэний үнэмлэх, паспорт авахад төрсний гэрчилгээ шаардагддаг. Тиймээс хүүхдийн төрснийг бүртгүүлэх нь хуулийн өмнө тэднийг албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөх, эрхийг хамгаалах болон уг эрхийн эсрэг ямар нэгэн хүчирхийллийг нуун дарагдуулахгүй байхыг баталгаажуулж буй анхны алхам юм.¹

Монгол Улсын хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэхээр зорьж буй “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” тунхаглалд үндэсний хууль тогтоомж болон холбогдох олон улсын гэрээнд нийцүүлэн хүүхэд бүрийг төрснийх нь дараа бүртгүүлж байх бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх, улмаар түүний нэр авах, иргэний харьяалалтай болох эрхийг хэрэгжүүлэх зорилтыг тусгасан байдаг.

Хүүхдийг төрсний бүртгэлд бүртгэх харилцааг Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хуулиар зохицуулдаг. Энэ хуулиар эцэг, эх, хэрэв эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлэх буюу хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгааны улмаас бүртгүүлэх боломжгүй бол тэдний төрөл садны хүн эсвэл хүүхэд байгаа эмнэлгийн байгууллагын эрх бүхий ажилтан хүүхдийг төрснөөс хойш төв суурин газарт 15 хоног, алслагдсан сум, багт 30 хоногийн дотор иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгүүлэх үүргийг хүлээдэг.

Судалгаагаар 5 хүртэлх насны хүүхдийн төрсний бүртгэлд хамрагдсан байдлыг авч үзсэн. НҮТС 2013-ын үр дүнгээр 5 хүртэлх насны нийт хүүхдийн 99.3 хувь нь төрснөө бүртгүүлжээ (Хүснэгт СР.1). Насны бүлгээр авч үзэхэд 0-11 сартай хүүхдийн 96.8 хувь байхад бусад насны бүлгийн хувьд бүгд төрсний бүртгэлд хамрагдсан байна.

Хүүхдийн төрсний бүртгэлд хамрагдалтын түвшин хүйс, хот, хөдөө, бүс нутаг, эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлаар ялгаагүй байна. Төрсний бүртгэлд хамрагдалт өндөр байгаа нь нийгмийн халамжийн бодлогын хүрээнд “Хүүхдийн мөнгө хөтөлбөр” хэрэгжүүлж байсан болон эх орны хувь хишиг иргэн бүрт олгоход иргэний бүртгэл, бичиг баримтад үндэслэж байсантай холбоотой байж болох юм. Нөгөө талаас төрсний бүртгэл өндөр байгаа нь хүүхдийн эрхийг хангах боломж бүрдсэнийг харуулж байна.

Төрсний бүртгэлийг баталгаажуулах зорилгоор төрсний гэрчилгээг үзүүлэхийг хүсэхэд нийт хүүхдийн 82.6 хувийнх нь эх, асрамжлагч хүүхдийн төрсний гэрчилгээг судалгааны ажилтанд үзүүлжээ. Энэ үзүүлэлт Улаанбаатар хотод харьцангуй өндөр (87.9 хувь), Төвийн бүс (75.3 хувь), хөдөөд (74.8 хувь) харьцангуй бага байна.

Хүүхдийн хөдөлмөр

Дэлхий даяар хүүхдүүд аюулгүй, хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт тогтмол оролцож байна. Хөдөлмөр эрхлэхэд хэт бага насны эсвэл тэдний бие махбодь, оюун санаа, нийгмийн болон боловсролын

¹ НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхэд бүрийн төрөх эрх: Төрсний бүртгэлийн тэгш бус байдал болон хандлага, НҮБ-ын Хүүхдийн сан, Нью-Йорк, 2013.

хөгжилд сөргөөр нөлөөлөх аюултай үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдийг хөдөлмөр эрхэлж буй хүүхэд гэж үздэг. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 32 дугаар зүйлд “Оролцогч улсууд хүүхдийн эдийн засгийн мөлжлөгт өртөх, боловсрол эзэмшихэд нь саад болох, эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжилд нь аюултай ажил эрхлэхээс хамгаалуулах эрхийг хүлээн зөвшөөрнө...” гэжээ. Мөн “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” тунхаглалд хүүхдийн хөдөлмөрийг устгах 9 стратеги болон хүүхдийг мөлжлөгөөс хамгаалах тухай МХЗ-ийн уриалгыг дурдсан байдаг.

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид, 2003 онд Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколд, 2004 онд Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколд тус тус нэгдэн орсон. Мөн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын үндсэн 8 конвенцийг соёрхон баталсны дотор Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай 138 дугаар Конвенцийг 2002 онд, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 182-р Конвенцийг 2001 онд тус тус соёрхон баталжээ.

Хүүхдийн хөдөлмөрийн бүлэг асуулгад 5-17 насны хүүхдийн хийсэн ажил, хөдөлмөрийн төрөл болон уг ажил, хөдөлмөрт зарцуулсан цагтай холбогдолтой хэд хэдэн асуултуудыг оруулсан. Ингэхдээ эдийн засгийн үйл ажиллагаа (өрхөөс гадуур эсвэл өрхийн аж ахуй, бизнест хөлстэй болон хөлсгүй хийсэн хөдөлмөр) болон гэрийн ажил (хоол хийх, гэр цэвэрлэх, хүүхэд, өндөр настан асрах, түлээ бэлдэх, усанд явах гэх мэт)-ын талаарх мэдээллийг цуглууллаа. Мөн уг бүлэгт хөдөлмөрийн аюултай нөхцлийн талаарх мэдээллийг асуусан юм.^{2,3}

Хүснэгт СР.2-т эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн хувийг насны бүлгээр харуулсан. ОУБТС-ны Хүүхдийн хөдөлмөрийг тодорхойлох арга зүйд хүүхдийн хөдөлмөрт тооцогдох эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон цагийг 3 насны бүлгээр ангилан тодорхойлсон. Насны бүлэг тус бүрт заасан цагаас илүү цагаар сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийг хүүхдийн хөдөлмөр эрхэлж байна гэж тооцсон.

1. 5-11 нас: 1 ба түүнээс олон цаг
2. 12-14 нас: 14 ба түүнээс олон цаг
3. 15-17 нас: 43 ба түүнээс олон цаг

Судалгаанаас өмнөх 7 хоногийн хугацаанд 5-11 насны нийт хүүхдийн 11.1 хувь нь 1 ба түүнээс олон цаг, 12-14 насны нийт хүүхдийн 8.8 хувь нь 14 ба түүнээс олон цаг, 15-17 насны нийт хүүхдийн 5.5 хувь нь 43 ба түүнээс олон цаг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцжээ (Хүснэгт СР.2).

Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн хувь хүйсээр ялгаатай буюу хөвгүүд охидуудтай харьцуулахад эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох хандлагатай байдаг нь Хүснэгт СР.2-оос харагдаж байна. Бүсээр болон хот, хөдөө, байршлаар мөн ялгаатай дүр зураг ажиглагдлаа. Баруун бүсийн хүүхдүүдийн хувьд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох нь хамгийн их байхад Улаанбаатар хотын хүүхдүүдийн хувьд хамгийн бага байв. Тухайлбал, Баруун бүсийн 5-11 насны нийт хүүхдийн 23.3 хувь нь 1 ба түүнээс олон цаг, 12-14 насны нийт хүүхдийн 20.7 хувь нь 14 ба түүнээс олон цаг, 15-17 насны нийт хүүхдийн 11.4 хувь нь 43 ба түүнээс олон цагаар эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон байхад Улаанбаатар хотын хувьд уг үзүүлэлтүүд харгалзан 1.8, 0.8, 1.3 хувь байна. Хөдөөгийн хүүхдүүдийн хувьд хотын хүүхдүүдтэй харьцуулахад илүүтэйгээр эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогийг хүснэгтээс харж болно. Тэр дундаа нийслэлээс хөдөө рүү алслагдах тусам хүүхдүүд эдийн засгийн үйл ажиллагаанд илүү их орох магадлалтай байна.

² НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхдийн хөдөлмөрийн тооцоо тодорхойлолтоос хэр хамааралтай вэ? ОУБТС-ны арга зүйн баримт бичиг №1, Нью-Йорк, 2012 он

³ Өрхөд байгаа 1-17 насны хүүхдүүдээс нэгийг нь санамсаргүй байдлаар сонгон Хүүхдийн хөдөлмөр болон Хүүхдийн хүмүүжил бүлгийн асуулгад хамруулсан (Хавсралт F: Асуулгын хуудас-ыг харна уу.). Хэрэв 5-17 насны хүүхэд сонгогдвол Хүүхдийн хөдөлмөрийн, харин 1-14 насны хүүхэд сонгогдвол Хүүхдийн хүмүүжлийн бүлэг асуулгыг асуусан. Санамсаргүй сонголт хийсэн тул өрхийн түүврийн жинг тухайн өрх бүрт байгаа 1-17 насны нийт хүүхдийн тоогоор үржүүлсэн.

Сургуульд хамрагдалтын байдлаар нь авч үзвэл сургуульд хамрагддаггүй хүүхдүүд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох нь их байна. Тодруулбал, сургуульд хамрагддаггүй 5-11 насны хүүхдүүдийн 18.4 хувь нь сүүлийн 7 хоногт 1 ба түүнээс олон цагаар эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон байхад сургуульд сурдаг хүүхдүүдийн хувьд уг үзүүлэлт нь 10.7 хувь байгаа юм. Мөн сүүлийн 7 хоногт 12-14 насны сургуульд хамрагддаг хүүхдийн 8.2 хувь 14 ба түүнээс олон цаг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон байхад сургуульд хамрагддаггүй хүүхдийн хувьд 35.3 буюу даруй 27.1 пунктээр өндөр байлаа. Энэ хандлага 15-17 насны хүүхдүүдийн хувьд мөн адил байна.

Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн хувь эхийн боловсрол болон өрхийн аж байдлын түвшин дээшлэх тусам буурах хандлагатай байгааг Хүснэгт СР.2-оос харж болно. Мөн өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаагаар авч үзвэл хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох нь нэлээд ялгаатай байна. Өөрөөр хэлбэл, казах тэргүүлэгчтэй өрхийн хүүхдүүд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох нь бусад хүүхдүүдтэй харьцуулахад их байгаа юм.

Хүснэгт СР.3-т гэрийн ажил хийсэн хүүхдийн хувийг насны бүлгээр харууллаа. Дээр дурдсан эдийн засгийн үйл ажиллагаатай адил гэрийн ажил хийсэн цагийн хязгаарыг насны бүлгээр тодорхойлсон. Насны бүлэг тус бүрт заасан цагаас илүү цагаар сүүлийн 7 хоногт гэрийн ажил хийсэн хүүхдийг хүүхдийн хөдөлмөр эрхэлж байна гэж үзсэн.

1. 5-11 нас болон 12-14 нас: 28 ба түүнээс олон цаг
2. 15-17 нас: 43 ба түүнээс олон цаг

Хүүхдийн хөдөлмөрийг тооцоход ашиглагдах гэрийн ажил хийсэн хүүхдийн хувийг авч үзвэл 5-11 насны нийт хүүхдийн 5.4 хувь, 12-14 насны нийт хүүхдийн 11.8 хувь нь сүүлийн 7 хоногт 28 ба түүнээс олон цаг, харин 15-17 насны нийт хүүхдийн 5.0 хувь нь сүүлийн 7 хоногт 43 ба түүнээс олон цагийг гэрийн ажилд зарцуулжээ.

Ерөнхийдөө гэрийн ажил хийсэн хүүхдийн хувь хүйс, бүс, хот, хөдөөгөөр төдийлөн ялгаагүй байна. Зөвхөн, сүүлийн 7 хоногт гэрийн ажил 28 ба түүнээс олон цаг хийсэн 12-14 насны хөдөөгийн хүүхдийн хувь 14.7 байхад хотын хүүхдийн хувь 9.7 байгаа ялгаа байв.

Хүүхдийн нас ахих тусам сургуульд хамрагддаггүй хүүхдийн гэрийн ажилд зарцуулж буй цаг нэмэгдэх хандлагатай байгаа байна. Тодруулбал, 5-11 насны хүүхдийн хувьд сүүлийн 7 хоногт гэрийн ажил 28 ба түүнээс олон цаг хийсэн хүүхдийн хувь сургуульд хамрагдалтын байдлаар ялгаагүй ижил 5.3-6.4 хувь байсан бол 15-17 насныхны хувьд 8.5 пункт (хамрагддаг 4.0 хувь, хамрагддаггүй 12.5 хувь)-ээр ялгаатай байв.

Гэрийн ажил хийсэн хүүхдийн хувь эхийн боловсролын түвшин, аж байдлын түвшин болон өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаагаар харилцан адилгүй байна.

Хүснэгт СР.2 болон Хүснэгт СР.3-т сууриллахаас гадна аюултай нөхцөлд ажиллаж байгаа хүүхдийн мэдээлэлд үндэслэн хүүхдийн хөдөлмөрийн үзүүлэлтийг Хүснэгт СР.4-т нэгтгэн харуулсан. Монгол Улсын 5-17 насны нийт хүүхдийн 17.3 хувь нь хөдөлмөр эрхэлж байв. Энэ насны нийт хүүхдийн 7.6 хувь нь аюултай нөхцөлд хөдөлмөр эрхэлдэг ажээ.

Эрэгтэй (19.3 хувь), 12-14 насны (22.1 хувь) хүүхдүүд хүүхдийн хөдөлмөрт оролцох хандлагатай байгааг хүнэгтээс харж болно. Бүсээр авч үзвэл, Баруун бүсийн 3 хүүхэд тутмын нэг (31.0 хувь) нь хүүхдийн хөдөлмөр эрхэлж байхад Улаанбаатар хотын 15 хүүхэд тутмын нэг (7.2 хувь) нь хөдөлмөр эрхэлсэн байна. 5-17 насны хөдөөгийн хүүхдүүдийн 30.3 хувь нь хөдөлмөр эрхэлж байгааг хотын хүүхдүүдтэй (8.9 хувь) харьцуулахад 3.4 дахин их байгаа юм. Түүнчлэн, төв суурингаас хөдөө рүү алслагдах тусам хүүхдийн хөдөлмөр нэмэгдэж байлаа. Эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшин дээшлэх тусам хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн хувь буурч байна.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг сургуульд хамрагдалтаар нь авч үзвэл нэлээд ялгаатай дүр зураг ажиглагдлаа. Тодруулбал, 5-17 насны сургуульд сурдаггүй хүүхдүүдийн 39.0 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь сургуульд сурдаг хүүхдүүдтэй (16.2 хувь) харьцуулахад 22.8 пунктээр их байгаа юм.

Хүүхдийн хүмүүжил

Аль ч соёлын хувьд хүүхдийг өөрийгөө хянаж удирдах, эерэг зан төлөвтэй болгож төлөвшүүлэх нь хүүхдийн хүмүүжлийн салшгүй нэг хэсэг байдаг билээ. Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг зан үйл, дадал нь тэдэнд ямар ч нөхцөл байдалд сэтгэлийн хөдлөл, үйлдлээ зөв удирдаж, зөрчлийг даван туулах чадвар олгохоос гадна өөрийгөө хүндэтгэх үзэлтэй, бие болон сэтгэлзүйн нэгдмэл байдал, эрхэм чанараа дээдэлсэн бие хүн болж төлөвших нөхцөл болдог. Гэсэн хэдий ч эцэг, эхчүүд хүүхдээ хүмүүжүүлэхдээ хүч хэрэглэх, загнаж сүрдүүлэх зэрэг шийтгэлийн шинжтэй аргуудыг түгээмэл хэрэглэсээр л байдаг. Судалгаануудаас үзэхэд⁴ хүчирхийллийн аргаар хүүхдийг хүмүүжүүлэх нь тэдэнд насан туршийн шарх, гэмтэл, хор хөнөөл үлдээх олон төрлийн сөрөг үр дагавар бий болгодгийг харуулсаар байна. Хүчирхийлэл нь хүүхдийн хөгжих, суралцах чадварт сөргөөр нөлөөлж, хүнтэй харьцах эерэг харилцааг үгүй хийж, өөрийгөө дорд үзэх, сэтгэл санааны зовиур гутралд хүргэн энэ үедээ амиа егүүтгэх ч эрсдэлийг бий болгодог.

“Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” тунхаглалд “хүүхэд аливаа төрлийн хүчирхийллээс хамгаалагдах ёстой...” гэж заасан ба Мянганы тунхаглалд хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, дарамтаас хамгаалахыг уриалсан.

Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орж, конвенцийн үзэл санаа, зарчимд нийцүүлэн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг 1996 оноос батлан хэрэгжүүлж эхэлсэн ба энэ хуулиар хүүхэд бүрийн аливаа төрлийн хүчирхийллээс ангид байх эрхийг баталгаажуулсан билээ.

НҮТС-нд өрхийн асуулгад хариулж буй хүнээс сонгогдсон хүүхдийн тухайд гэр бүлийн насанд хүрсэн гишүүдээс судалгааны өмнөх 1 сард түүнийг хүмүүжүүлэх зорилгоор ямар арга хэрэглэсэн талаарх бүлэг асуултыг асуусан.⁴


Ихэнхи тохиолдолд, өрхүүд хүүхдийг хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн шинжтэй шийтгэлийн аргуудыг хавсран хэрэглэж байна. Нийт хүүхдийн 40.3 хувьд нь сэтгэл санааны шийтгэлийн арга ашигласан бол ойролцоогоор 27.8 хувьд нь бие мах бодийн шийтгэлийн аргыг ашиглажээ. Бие мах бодийн хүнд хэлбэрийн шийтгэлийн аргууд (толгой, чих, нүүр рүү нь цохих, хэд хэдэн удаа хүчтэйгээр цохих)-ыг ашиглах нь ерөнхийдөө бага байгааг нийт хүүхдийн 4.0 хувь нь хүнд хэлбэрийн бие мах бодийн шийтгэл хүлээнэс харж болно.

Хүснэгт CP.5 болон Зураг CP.2-оос харахад судалгааны өмнөх 1 сарын хугацаанд 1-14 насны хүүхдийн 38.0 хувьд нь эцэг, эх болон гэр бүлийн гишүүд хүүхдийг хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн бус арга хэрэглэжээ. Харин 1-14 насны нийт хүүхдийн 49.3 хувь нь сэтгэл зүйн болон бие мах бодийн шийтгэлийн аль нэг хэлбэрээр шийтгүүлсэн байна.

Энэ үзүүлэлт эмэгтэй (хөвгүүд 52.3, охид 46.2 хувь), Зүүн бүсийн (Зүүн бүс 38.5 болон бусад бүс 48.4-51.5 хувь), 1-2 болон 10-14 насны (42.9-43.6 болон бусад нас 53.6-59.2 хувь), казах тэргүүлэгчтэй өрхийн (43.6 болон 49.5-50.1 хувь) хүүхдүүдийн хувьд бусадтай харьцуулахад бага буюу улсын түвшнээс доогуур байна. Бие мах бодийн хүнд хэлбэрийн шийтгэл амссан 1-14 насны хүүхдийн эзлэх хувь 4.0 байгаа нь хүүхдийн хүчирхийлэлгүй орчинд амьдрах, хүчирхийллээс ангид байх эрхийн хэрэгжилтэд анхаарах асуудал байгааг гэрчилнэ.

⁴ Страус, М.А болон Пасчал, М.Ж, “Эжүүдийн үзүүлсэн бие мах бодийн шийтгэл болон хүүхдийн танин мэдэхүйн чадварын хөгжил: 2 үндэстнийг төлөөлөх насны үелрэлийн урт хугацааны судалгаа”, Түрэмгийлэл, буруу хүмүүжүүлэх болон гэмтэл сэтгүүл, 18 дугаар ном, дугаар 5, 2009 он, хуудасны дугаар 459-483; Эриксон, М.Ф болон Эгэланд.Б, “Буруу хүмүүжүүлэхийн бие мах бодийн үр нөлөөний хөгжлийн дүр зураг”, Социологийн шүүмж сургууль, 16 дугаар ном, 1987 он, хуудасны дугаар 156-168; Шнэйдер, М.В, Росс.А, Грахам, Ж.С болон Зиэлински.А, “Do Allegations of Emotional Maltreatment Predict Developmental Outcomes Beyond that of Other Forms of Maltreatment?”, Хүүхдийн хүчирхийлэл, үл тоомсорлолт, 29 дүгээр ном, дугаар 5, хуудасны дугаар, 2005 он, 513-532.

СР.2: Хүүхдийг хүмүүжүүлэх арга, 1-14 настай хүүхдийн хувиар, Монгол Улс, 2013 он



Нөгөө талаас хүүхдийг хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн арга хэрэглэх нь нийтлэг байгаа хэдий ч судалгаанд хамрагдсан нийт хариулагчийн 17.4 хувь хүүхдээ хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэлийн аргыг хэрэглэж болно гэж үзжээ (Хүснэгт СР.6). Хүүхдийн хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэх талаарх хүмүүсийн хандлага тэдний боловсролын түвшнээс бага зэрэг хамаарч байна. Тухайлбал, боловсролгүй болон бага боловсролтой 4 эцэг, эхийн нэг (23.9-29.0 хувь) нь хүүхдээ хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэл оногдуулах нь зөв гэж үзсэн байхад энэ үзүүлэлт техникийн болон тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой эцэг, эхчүүдийн хувьд 13.6-14.2 хувь байгаа юм.

Хүүхдийг хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэл оногдуулж болно гэж үздэг хариулагчийн хувь хүйс болон насны бүлгээр төдийлөн ялгаагүй боловч хот, хөдөө, өрхийн аж байдлын түвшин болон өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаагаар ялгаатай байна. Тодруулбал, казах өрхийн тэргүүлэгчтэй хариулагчийн 23.6 хувь нь хүүхдийг хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэл оногдуулах нь зүйтэй гэж үздэг нь бусадтай харьцуулахад 4.4-6.8 пунктээр өндөр байна.

Эрт гэрлэлт

Залуу охидын хувьд 18 насанд хүрэхээсээ өмнө гэрлэх явдал амьдралд байсаар байна. НҮБ-ын Хүүхдийн сангаас дэлхий дахинд хийсэн судалгаанаас харахад 20-24 насны 64 сая гаруй эмэгтэй 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн буюу хамтран амьдарч эхэлжээ. Эрт гэрлэлтэд нөлөөлдөг хүчин зүйлст хүүхдийн насны лавлагааг гаргадаг тухайн улсын иргэний бүртгэл, насанд хүрээгүй хүний гэрлэлтийн асуудлаарх эрх зүйн тогтолцоо, түүнийг хэрэгжүүлэгч механизм, уг үйлдлийг хөхиүлэн дэмждэг уламжлалт болон шашны ёс заншил зэрэг орно.

Дэлхийн олон оронд санхүүгийн болон нийгмийнхээ талаас ашигтай байж магадгүй гэж үзэн охиноо эрт нөхөрт гаргахыг эцэг, эх нь дэмждэг бөгөөд нөгөө талаар гэр бүлийнхээ санхүүгийн ачааг нимгэлэхийг хүсдэг байна. Гэвч үнэндээ эрт гэрлэлт нь хүний эрхийн зөрчил бөгөөд охидын хөгжилд нөлөөлж, эрт жирэмслэлт, нийгмээс тусгаарлагдах байдалд хүргэн, улмаар бага боловсрол эзэмшин, мэргэжлийн сургалтад хамрагдаж чадаагүйгээс жендэрээс үүдэлтэй ядууралд хүргэдэг.

Гэрлэсэн залуу охид өвөрмөц боловч гол төлөв нийтэд ил байдаггүй бүлэг хүмүүс юм. Өөрсдөө хүүхэд хэвээрээ хэдий ч гэрийн ажилд дарагдсан, хүүхэд төрүүлж, өсгөх үүрэгтэй эдгээр охидын шийдвэр гаргах эрх мэдэл хязгаарлагдмал, сонголт хийх боломж муутай байдаг. Эрт гэрлэлтэд хөвгүүд ч мөн

адил өртдөг боловч үр нөлөө нь оксидод тооны болон эрүүл мэндийн хувьд илүү тусдаг. Хосууд албан ёсоор гэрлээгүй боловч эхнэр, нөхөр болон хамтран амьдрах асуудал ч гэрлэлтийн нэгэн адил хүний эрхийн асуудал юм. Насанд хүрээгүй охин эрэгтэй хүнтэй хамт амьдарч, түүнийг асран халамжилж байгаа бол насанд хүрээгүйгээс үл хамааран насанд хүрсэн эмэгтэй мэт үздэг. Түүнчлэн, тэд албан ёсоор гэр бүл болоогүйгээс өв залгамжлах, иргэншил авах, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх зэрэг нэмэлт асуудалтай нүүр тулгарч, гэрлэсэн оксидоос илүү эмзэг байдалд ордог.

Судалгаанаас харахад хүүхдийг эрт гэрлэхэд хүргэдэг хоорондоо харилцан уялдаатай олон хүчин зүйл байна. Ядуурал, оксидын хамгаалал, гэр бүлийн нэр хүнд, нийгмийн тогтворгүй байдал зэрэг нь оксидыг насанд хүрэхээсээ өмнө гэр бүл болоход хүргэдэг хамгийн гол хүчин зүйлс билээ. Залуу насандаа гэрлэсэн эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртөмтгий байдаг. Хосуудын насны зөрүү эрх мэдлийн хүчирхийлэл болон эрт бэлэвсрэх эрсдэлд нөлөөлнө.


Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүн бүр "чөлөөтэй, бүрэн" гэрлэлтийг зөвшөөрсөн байх эрхийг баталгаажуулсан байдаг. Хосуудын нэг нь амьдралынхаа хамтрагчийн талаарх шийдвэрийг гаргахад хангалттай насанд хүрээгүй байгаа тохиолдолд гэрлэлтийн зөвшөөрөл нь "чөлөөтэй, бүрэн" байж чаддаггүй. Эрт гэрлэлттэй холбоотой өөр нэг асуудал бол оксидын бэлгийн амьдрал эрт эхлэх явдал юм. 18 нас хүрэхээс өмнө гэр бүлтэй болсон эмэгтэйчүүд сүүлд гэр бүл болсон эмэгтэйчүүдээс илүү олон хүүхэд төрүүлэх хандлагатай байдаг. Жирэмслэлттэй холбоотой нас баралт 15-19 насны гэрлэсэн болон гэрлээгүй оксид, ялангуяа, энэ бүлгийн хамгийн залуу оксидын хувьд нас баралтын голлох шалтгаан болдог. Бага насандаа гэрлэж буй оксид гол төлөв өөрөөсөө ахимаг насны эрэгтэйтэй гэр бүл болдог бөгөөд энэ нь тэдний ХДХВ-ийн халдвар авах эрсдэлийг ч нэмэгдүүлдэг. Насны зөрүүтэй байдлаас үүдсэн нөхөн үржихүй болон хүчний тэнцвэргүй байдал нь эдгээр залуу эхнэрүүдийн хувьд бэлгийн харьцаанд ороходоо бэлгэвч хэрэглэх нь маш бага байх нөхцөлд хүргэдэг.

Тус судалгаанд Монгол Улсын оксид, хөвгүүдийн эрт гэрлэлтийг 15 болон 18 насанд хүрэхээс өмнө гэрлэсэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзлэх хувиар илэрхийлж байна (Хүснэгт СР.7 болон СР.7М). Эрт гэрлэсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувийг Хүснэгт СР.7-д, эрэгтэйчүүдийн хувийг СР.7М-д харуулав. Нөхөн үржихүйн насны нийт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд 15 наснаас өмнө гэрлэсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй бага (харгалзан 0.2 болон 0.4 хувь) боловч боловсролын түвшний ялгаатай байдал харагдаж байна. Тухайлбал, боловсролгүй эмэгтэйчүүд болон бага боловсролтой эрэгтэйчүүдийн хувьд 15 нас хүрэхээсээ өмнө гэрлэх нь улсын дунджаас өндөр байгаа юм.

Арван таван нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь бага боловч 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн 20-49 насны эмэгтэйчүүдийн хувь харьцангуй өндөр (6.2 хувь) байна. 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувийг бүсээр авч үзвэл Баруун бүс болон Улаанбаатар хотод (3.2-5.2 хувь) бусад бүстэй (6.5-10.1 хувь) харьцуулахад хамгийн бага байлаа. Энэ үзүүлэлт хот, хөдөө, боловсрол болон өрхийн амьжиргааны түвшнээр ялгаатай байгааг хүснэгтээс харж болно. 15-19 насны 20 эмэгтэй тутмын нэг нь гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай байна.

Хүснэгт СР.8 болон СР.8М-д 15 ба 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн буюу гэр бүлийн харилцаанд орсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эзлэх хувийг хот, хөдөө болон насны бүлгээр харууллаа. 15 ба 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн хувийг насны бүлгээр авч үзэх нь эрт гэрлэлтийн ерөнхий хандлагыг харахад хэрэгтэй байдаг. 15 ба 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувийг насны бүлгээр үзвэл харьцангуй бага, ижил түвшинд байна (Зураг СР.3).

СР.3: Эмэгтэйчүүдийн дундах эрт гэрлэлт, Монгол Улс, 2013 он



Эрт гэрлэлтийг тодорхойлдог өөр нэг үзүүлэлт нь хосуудын насны зөрүү ба үүнийг өөрөөсөө 10 ба түүнээс олон насаар ах хүнтэй гэрлэсэн эсвэл гэр бүлийн харилцаанд орсон эмэгтэйчүүдийн хувиар илэрхийлдэг. Хүснэгт СР.9-д эхнэр, нөхрийн насны зөрүүг харууллаа. Үүнээс харахад Монгол Улсад 15-19 насны гэрлэсэн/ хамтран амьдрагчтай нийт эмэгтэйчүүдийн 3.4 хувь нь өөрөөсөө 10 ба түүнээс дээш насаар ах, 20.0 хувь нь 5-9 насаар ах эрэгтэйтэй гэр бүл болжээ. Харин эдгээр үзүүлэлт 20-24 насны гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувьд харьцангуй бага (3.0 хувь, 12.7 хувь) байна.

20-24 насны, 10 ба түүнээс олон насаар ах нөхөр/ хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийг шинж байдлаар авч үзвэл хот, хөдөө, боловсрол болон өрхийн аж байдлын түвшнээр бага зэргийн ялгаатай байна. Тухайлбал, бага боловсролтой 20-24 насны эмэгтэйчүүдийн 10.5 хувь нь өөрөөсөө 10 ба түүнээс олон насаар ах нөхөр/ хамтран амьдрагчтай байгаа нь улсын дундаж 3.0 хувиас эсрэг дүр зурагтай байна. Өрхийн аж байдлын түвшнээр авч үзвэл дээгүүр түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн хувьд дээрх үзүүлэлт өндөр байв.

Судалгаанд хамрагдсан гэрлэсэн/ хамтран амьдрагчтай 15-19 насны эмэгтэйчүүдийн тоо (үзүүлэлтийн хуваарь) цөөн байгаа тул хосуудын насны зөрүүг илэрхийлсэн үзүүлэлтүүдийг шинж байдлаар шууд авч ашиглаж болохгүйг анхаарна уу.

Эцэг, эхтэйгээ амьдарч байгаа болон өнчин хүүхэд

Хүүхдийн эрхийн конвенцид “хүүхдийн хөгжлийг цогц, нийцтэй байлгахын тулд тэд аз жаргал, хайр, ойлголцолын уур амьсгал бүрдсэн гэр бүлийн орчинд өсөх ёстой” гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Дэлхий дээр сая сая хүүхдүүд эцэг, эх нь нас барсан эсвэл ажиллахаар цагаачилсан зэрэг шалтгаанаар эцэг, эхийн халамж, анхааралгүйгээр өсч торниж байна. Тэдний ихэнх нь гэр бүлийн бусад гишүүдийн халамжид байдаг хэдий ч зарим нь өөр өрхөд амьдарч байгаа юм. Хүүхдийн амьдарч буй өрхийн бүтэц болон асран хамгаалагчтай ямар хамааралтай зэргийг оруулсан хүүхдийн амьдарч буй орчин гэдэг ойлголт нь хүүхдэд зориулсан анхаарал, халамж, тэдний сайн сайхан байдлыг дэмжих зорилготой үйл ажиллагааны үндсэн түлхүүр болно.

Энэ удаагийн судалгаанд эцэг, эхтэйгээ хамт амьдарч байгаа болон өнчин хүүхдийн хувиас гадна төрсөн эцэг эх нь гадаадад амьдарч байгаа хүүхдийн хувь гэсэн үзүүлэлтийг нэмж тооцсон.

Хүснэгт СР.14-т 18 хүртэлх насны хүүхдийн эцэг, эхтэйгээ амьдарч байгаа эсэхийг харууллаа. Монгол Улсын 0-17 насны нийт хүүхдийн 75.2 хувь нь төрсөн эцэг, эхтэйгээ, 16.0 хувь нь төрсөн эхтэйгээ, 1.9 хувь нь төрсөн эцэгтэйгээ хамт амьдарч байна. Түүнчлэн, төрсөн эцэг, эх нь амьд сэрүүн ч 18 хүртэлх насны нийт хүүхдийн 5.6 хувь нь тэдэнтэйгээ хамт амьдардаггүй гэсэн үр дүн судалгаанаас гарсан. Эдгээр хүүхдийн дийлэнх нь өргөмөл хүүхэд байх талтай юм.

0-17 насны нийт хүүхдийн 6.7 хувь нь хагас болон бүтэн өнчин байв. Тэдний 5.4 хувийнх нь ээж нь амьд, 1.0 хувийнх нь аав нь амьд байна.

Төрсөн эцэг, эхтэйгээ амьдардаг хүүхдийн хувь хүйсээр төдийлөн ялгаагүй, харин хүүхдийн нас ахих тусам эцэг, эхтэйгээ амьдрахгүй байх хандлагатай байгаа нь хүснэгтээс харагдаж байна. Тодруулбал, 0-4 насны нийт хүүхдийн 82.2 хувь, 5-9 насны нийт хүүхдийн 76.7 хувь, 10-14 насны нийт хүүхдийн 69.5 хувь, 15-17 насны нийт хүүхдийн 65.7 хувь нь төрсөн эцэг, эхтэйгээ хамт амьдарч байна. Хотын хүүхдүүдийн (71.3 хувь) хувьд төрсөн эцэг, эхтэйгээ хамт амьдрах нь хөдөөгийн хүүхдүүдтэй (81.3 хувь) харьцуулахад доогуур түвшинд байна.

Өнчин хүүхдийн хувь насны бүлгээс бусад шинж байдлаар төдийлөн ялгаагүй байна. Хүүхдийн нас ахих тусам эцэг, эх нь нас барж өнчрөх тохиолдол нэмэгдэж байгааг Хүснэгт СР.14-өөс харж болно.

Энэ удаагийн НҮТС-д эцэг, эхийнх нь хэн нэгэн эсвэл хоёулаа гадаадад амьдарч байгаа хүүхдийн талаар судалсан. Судалгааны ажлууд нэмэгдсээр байгаа хэдий ч эцэг, эх нь гадаадад амьдардаг хүүхдүүдийн хувьд мөнгөн шилжүүлгийн урт хугацаанд үзүүлж буй эдийн засгийн ашигтай тал болон нийгэм, оюун санааны хувьд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх дүгнэлтийг хараахан хийх боломжгүй байгаа юм. Учир нь хүүхдэд үзүүлж буй нөлөөллийн талаар зөрчилдөөнтэй баримтууд байсаар байна.

НҮТС 2013-аас тооцсон Хүснэгт СР.15 нь дан ганц ерөнхий түвшинг харуулахаас гадна шилжих хөдөлгөөний талаарх мэдээллийн дутмаг байдлыг бага хэмжээнд арилгахад туслах юм. Хүснэгт СР.15-аас харахад 0-17 насны нийт хүүхдийн 1.5 хувийнх нь эцэг, эхийн хэн нэг нь эсвэл хоёулаа гадаадад амьдардаг байна. Эцэг, эх нь гадаадад амьдардаг хүүхдийн хувь хүн ам зүй шинж байдлаар төдийлөн ялгаагүй байна. Бүсээр авч үзвэл эцэг, эх нь гадаадад амьдардаг хүүхдийн хувь Улаанбаатар хотод (3.1 хувь), дээгүүр аж байдалтай өрхийн хувьд (4.5 хувь) бусадтайгаа харьцуулахад харьцангуй өндөр байлаа.

Хурдан морь унаач хүүхэд

Монголчууд эрт үеэс тэмдэглэж ирсэн эрийн гурван наадмын нэг бол хурдан морины уралдаан билээ. Хурдан мориныг жижиг биетэй, бага насны хүүхдээр унуулдаг нь нэг талаас өв уламжлал боловч нөгөө талаас хүүхэд хамгааллын асуудал юм. Тиймээс энэ удаагийн судалгаанд хурдан морь унаач хүүхдийн талаар ерөнхий дүр зураг гаргах үүднээс өрхөд байгаа 4-15 насны бүх хүүхдийн хувьд 2012 оны 11 сараас хойших хугацаанд хурдан морь унаж байсан эсэх, хэрэв унаж байсан бол хамгийн сүүлийн уралдаанд оролцоходоо даатгал хийлгэсэн, морины эзэнтэй гэрээ байгуулсан болон урамшуулал авсан эсэх, хамгаалалтын хувцас, хэрэглэл өмссөн эсэх зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг асуусан.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8.2-т “Баяр наадмын хурдан мориныг 7-гоос дээш насны хүүхэд унах бөгөөд ослын даатгалд даатгуулсан байна.” гэж заасан. Хүүхдийн төлөө Үндэсний газар морь унаач хүүхдийн асуудлаар тэр дундаа хурдан морь унаач хүүхдийн насны доод хязгаарыг нэмэгдүүлэх боломж байгаа эсэхийг судалж байгаа юм.

Монгол Улсын хэмжээнд 4-15 насны нийт хүүхдийн 5.2 хувь нь 2012 оны 11 сараас судалгаа хүртэлх хугацаанд хурдан морь унажээ (Хүснэгт СР.16). Өмнө дурдсанчлан, үндэсний их баяр наадамд хурдан морь унах хүүхдийн насны доод хязгаарыг зааж өгсөн хэдий ч бусад төрлийн баяр наадамд зориулсан журам, хууль байхгүйгээс насны хяналтыг тавих боломжгүй байдаг. Энэ нь судалгааны дүнгээс харагдаж байна. Тодруулбал, улсын хэмжээнд 4-6 насны нийт хүүхдийн 0.7 хувь нь хурдан морь унажээ.

4-15 насны хөвгүүдийн 9.6 хувь нь хурдан морь унасан байхад охидын ердөө 0.7 хувь нь хурдан морь унажээ. Бүсээр авч үзвэл Улаанбаатар хотоос (0.6 хувь) бусад бүсэд хурдан морь унаач хүүхдийн хувь 7.2-9.4 хувь байгаа юм. Түүнчлэн, төв суурингаас хөдөө рүү алслагдах тусам хүүхдүүд хурдан морь унах хандлагатай байна. Тодруулбал, нийслэлийн хүүхдүүдийн 0.6 хувь, аймгийн төвийн хүүхдүүдийн 3.5 хувь, сумын төвийн хүүхдүүдийн 6.8 хувь, хөдөөгийн хүүхдүүдийн 11.7 хувь нь 2012 оны 11 сараас хойш хурдан морь унасан байв. Эхийн боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшин дээшлэх тусам хүүхэд хурдан морь унах нь буурах хандлагатай байна.

Мөн Хүснэгт СР.16-д 2012 оны 11 сараас хойш хурдан морь унасан хүүхдүүдийн уралдаанд оролцсон давтамжийг харууллаа. Хурдан морь унасан хүүхдүүдийн дийлэнх буюу 57.4 хувь нь 5-аас цөөн удаа хурдан морь унажээ. Цаашилбал, хурдан морь унаач хүүхдүүдийн 20.9 хувь нь 5-9 удаа, 10.7 хувь нь 10-14 удаа, 2.0 хувь нь 15-19 удаа, 6.4 хувь нь 20 ба түүнээс олон удаа хурдан морь унасан байна.

Хурдан морь унаач хүүхдүүдийн хувьд хамгийн сүүлд ямар наадамд морь унасныг Хүснэгт СР.17-д үзүүлэв. Үүнээс харахад хурдан морь унаач хүүхдүүдийн 57.4 хувь нь сумын, 9.9 хувь нь аймгийн, 5.3 хувь нь бүсийн, 3.2 хувь нь улсын, 24.1 хувь нь бусад төрлийн наадамд хурдан морь унажээ.

Хүснэгт СР.18-д хурдан морь унаач хүүхдүүд хамгийн анх хурдан морь унахдаа хэдэн настай байсныг харуулсан. Хурдан морь унаач хүүхдийн 30.5 хувь нь 7 нас хүрэхээсээ өмнө, 49.3 хувь нь 7-9 насандаа, 20.2 хувь нь 10 ба түүнээс дээш насандаа хурдан морь унажээ. Хурдан морь унаж эхэлсэн голч нас 8.1 байна. Хурдан морь унаж эхэлсэн голч нас шинж байдлаар төдийлөн ялгаагүй байгааг хүснэгт СР.18-аас харж болно.

Хүүхдүүд хурдан морины уралдааны үеэр унаж гэмтэх тохиолдлууд цөөнгүй гардаг тул хамгаалалтын хувцас, хэрэглэл өмсүүлэх нь чухал юм. Судалгаанд хамрагдсан хурдан морь унадаг 4-15 насны нийт хүүхдийн 52.3 хувь нь малгай, 37.3 хувь нь шил, 41.1 хувь нь хантааз, 41.4 хувь нь өвдгөвч, 52.4 хувь нь гутал өмссөн байна. Үүнийг ерөнхийд нь авч үзвэл 73.9 хувь ямар нэг төрлийн хамгаалалтын хувцас, хэрэглэл өмссөн, 22.4 хувь нь дээр дурдсан 5 төрлийн хамгаалалтын хувцас хэрэглэлийг бүгдийг нь өмсжээ. Гэсэн хэдий ч 4 хүүхэд тутмын нэг нь (26.1 хувь) хамгийн сүүлд хурдан морины уралдаан орохдоо ямар ч хамгаалалтын хувцас өмсөөгүй байна.

Хүснэгт СР.19-өөс харахад хамгаалалтын хувцас, хэрэглэлийн хэрэглээ хүйс, насны бүлгээр ялгаагүй, харин бүс, хот, хөдөөгөөр нэлээд ялгаатай байв. Тодруулбал, Баруун болон Хангайн бүсийн хурдан морь унаач хүүхдийн хувьд хамгаалалтын хувцас, хэрэглэлийн хэрэглээ бусад бүстэй харьцуулахад бага байна. Түүнчлэн, хотын хурдан морь унаач хүүхдийн 9.4 хувь нь ямар ч хамгаалалтын хувцас, хэрэглэл хэрэглээгүй, 34.8 хувь нь 5 төрлийн хамгаалалтын хувцас, хэрэглэлийг хэрэглэсэн байхад хөдөөгийн хүүхдүүдийн хувьд дээрх үзүүлэлтүүд харгалзан 30.1 болон 19.3 хувь байгаа юм. Өрхийн аж байдлын түвшин дээшлэх тусам хурдан морь унаач хүүхдийн ямар нэг хамгаалалтын хувцас, хэрэглэл хэрэглээгүй хувь буурч байгаа нь хамгаалалтын хувцас, хэрэглэлийн өртөгтэй холбоотой байх магадлалтай.

Хурдан морь унаач хүүхдийн тал хувь нь хамгийн сүүлийн уралдаанд орохдоо морио эмээлгүй зайдан унасан байна (Хүснэгт СР.20). Мөн 2.8 хувь нь сүүлийн уралдааны үеэр осол, гэмтэлд өртжээ. Морио зайдан унах нь 10-15 насны (59.6 хувь), Баруун бүсийн (70.0 хувь), хөдөөгийн (52.2 хувь) хүүхдүүдийн дунд элбэг байна. Хамгийн сүүлийн уралдааны үеэр осол гэмтэлд өртсөн хүүхдийн хувь Төвийн бүсийн (5.0 хувь), сумын төвийн (6.6 хувь), боловсролгүй эхийн (6.3 хувь), дунджаас доогуур аж байдалтай өрхийн (5.3 хувь) хүүхдүүдийн дунд бусад хүүхдүүдтэй харьцуулахад бага зэрэг өндөр байлаа.

Хурдан морь унаач хүүхдүүдийн нийгмийн хамгааллын асуудлуудын нэг хэсэг нь ослын даатгалд хамрагдсан, морины эзэнтэй гэрээ хийсэн болон урамшуулал авсан эсэх юм. Судалгаанд хамрагдсан хурдан морь унаач хүүхдийн нийгмийн хамгааллын асуудлыг Хүснэгт СР.21-д харуулсан. Хамгийн сүүлийн хурдан морины уралдаанд оролцохдоо унаач хүүхдийн 58.7 хувь нь даатгал хийлгэсэн, 8.1 хувь нь гэрээ байгуулсан, 36.5 хувь нь урамшуулал авсан, харин 25.8 хувь нь ямар ч даатгал, гэрээ, урамшуулалгүй уралджээ. Хурдан морь унаач хүүхдийн нийгмийн хамгааллын асуудал хүйсээр болон хот, хөдөөгөөр төдийлөн ялгаагүй байв. Бүсээр авч үзвэл Зүүн бүсэд хурдан морь унаач хүүхдийн нийгмийн хамгааллын асуудал (даатгалтай 83.1 хувь, гэрээтэй 16.4 хувь, урамшуулалтай 44.5 хувь) бусад бүстэй харьцуулахад хамгийн сайн байлаа.

Хүснэгт СР.1: Төрсний бүртгэл

5 хүртэлх насны хүүхдийн хувь, төрснийг бүртгүүлсэн эсэхээр, Монгол Улс, 2013 он

	Иргэний бүртгэлд төрснийг нь бүртгүүлсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь:				5 хүртэлх насны хүүхдийн тоо
	Төрсний гэрчилгээтэй		Төрсний гэрчилгээ байхгүй	Нийт бүртгүүлсэн ¹	
	Үзсэн	Үзээгүй			
Дүн	82.6	16.4	0.3	99.3	6054
Хүйс					
Эрэгтэй	83.6	15.4	0.3	99.3	3103
Эмэгтэй	81.7	17.4	0.3	99.3	2951
Бүс					
Баруун	78.0	21.0	0.1	99.1	904
Хангай	81.5	17.5	0.4	99.4	1234
Төв	75.3	23.8	0.2	99.3	1061
Зүүн	84.3	14.5	0.6	99.4	453
Улаанбаатар	87.9	11.1	0.3	99.3	2402
Хот, хөдөө					
Хот	87.6	11.5	0.2	99.4	3693
Хөдөө	74.8	23.9	0.4	99.1	2361
Байршил					
Нийслэл	87.9	11.1	0.3	99.3	2402
Аймгийн төв	87.2	12.3	0.2	99.7	1291
Сумын төв	76.6	22.8	0.2	99.5	727
Хөдөө	74.1	24.4	0.4	98.9	1634
Нас					
0-11 сартай	83.1	13.0	0.7	96.8	1300
12-23 сартай	84.1	15.9	0.1	100.0	1180
24-35 сартай	84.1	15.8	0.0	99.9	1236
36-47 сартай	81.9	17.7	0.4	100.0	1180
48-59 сартай	79.9	19.8	0.3	100.0	1157
Эхийн боловсрол					
Боловсролгүй	74.4	24.7	0.7	99.8	334
Бага	76.4	22.6	0.3	99.3	423
Суурь	79.2	19.1	0.8	99.1	894
Бүрэн дунд	83.0	16.0	0.3	99.2	1509
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	80.3	18.6	0.0	98.9	494
Дээд	86.5	12.9	0.1	99.5	2398
Өрхийн аж байдлын түвшин					
Доогуур	71.5	27.0	0.5	99.0	1326
Дунджаас доогуур	84.1	14.9	0.4	99.3	1227
Дундаж	83.2	15.7	0.1	99.1	1159
Дунджаас дээгүүр	85.1	14.0	0.4	99.5	1088
Дээгүүр	90.3	9.2	0.0	99.6	1253
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа					
Халх	83.3	15.8	0.3	99.4	4828
Казах	79.3	17.5	0.0	96.8	256
Бусад	80.2	19.0	0.2	99.4	953

¹ НҮТС-ны үзүүлэлт 8.1 - Төрсний бүртгэл

* Эхийн боловсролын түвшин нь хариулагдаагүй 2 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

** Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа нь хариулагдаагүй 19 ажиглалтыг (жигнээгүй) харуулаагүй.

Нийт болон гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, төрүүлсэн бүх хүүхдийн тоогоор, амьд байгаа болон төрүүлсэн бүх хүүхдийн дундаж тоо, насны бүлгээр, Монгол Улс, 2013 он

Бүх эмэгтэй	Төрүүлсэн хүүхдийн тоо										15-49 насны эмэгтэйчүүдийн хувь	Төрүүлсэн хүүхдийн дундаж тоо ¹	Амьд байгаа хүүхдийн дундаж тоо ²		
	0	1	2	3	4	5	6	7	8	9				10+	
	Дүн													12830	1.9
Бүгд	24.2	19.1	25.2	17.7	8.6	3.1	1.4	0.4	0.2	0.1	0.0	100.0	12830	1.9	1.8
15-19	96.3	3.6	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	100.0	1595	0.0	0.0
20-24	52.2	36.8	9.6	1.3	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	100.0	1765	0.6	0.6
25-29	17.0	35.4	34.1	11.9	1.4	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	100.0	2012	1.5	1.4
30-34	7.7	20.2	37.0	24.8	8.5	1.6	0.3	0.1	0.0	0.0	0.0	100.0	2002	2.1	2.1
35-39	4.0	14.2	31.6	30.3	14.1	4.0	1.5	0.3	0.0	0.0	0.0	100.0	2010	2.6	2.4
40-44	2.1	11.5	32.9	25.8	16.5	6.9	2.8	0.9	0.4	0.2	0.0	100.0	1816	2.8	2.6
45-49	2.4	8.1	24.6	26.6	19.5	9.7	5.7	2.2	0.7	0.2	0.3	100.0	1631	3.2	2.9
									Гэрлэсэн эмэгтэй						
Бүгд	4.5	21.0	32.8	23.6	11.5	4.0	1.8	0.5	0.2	0.1	0.0	100.0	8674	2.4	2.3
15-19	43.1	53.0	3.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	100.0	78	0.6	0.6
20-24	17.8	61.4	18.0	2.5	0.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	100.0	890	1.1	1.0
25-29	6.1	36.5	40.8	14.5	1.8	0.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	100.0	1592	1.7	1.7
30-34	2.7	16.4	40.7	28.3	9.7	1.9	0.2	0.1	0.0	0.0	0.0	100.0	1679	2.3	2.3
35-39	1.7	10.1	33.3	32.8	15.7	4.4	1.6	0.3	0.0	0.0	0.0	100.0	1684	2.7	2.6
40-44	0.7	9.2	31.8	27.7	18.3	7.6	3.1	0.9	0.5	0.2	0.0	100.0	1503	3.0	2.7
45-49	1.6	5.5	24.8	28.2	20.8	9.4	6.3	2.1	0.8	0.2	0.3	100.0	1248	3.3	3.0

¹ НУТС-ны үзүүлэлт CSI12.5 - Төрүүлсэн хүүхдийн дундаж тоо

² НУТС-ны үзүүлэлт CSI12.6 - Амьд байгаа хүүхдийн дундаж тоо

Хүснэгт FE.7: Төрөлт хоорондын зай

Судалгааны өмнөх 5 жилийн хугацааны анхны бус төрөлтийн хувь, өмнөх төрөлтөөс хойших сараар, өмнөх төрөлтөөс хойших голч хугацаа, Монгол Улс, 2013 он

	Өмнөх төрөлтөөс хойших хугацаа (сараар)						Бүгд	Өмнөх төрөлтөөс хойших голч хугацаа (сараар) ¹	Анхны бус төрөлтийн тоо
	7-17	18-23	24-35	36-47	48-59	60+			
Бүгд	5.5	9.1	18.1	14.4	11.8	41.1	100.0	50.7	3884
Бүс									
Баруун	8.8	14.6	23.3	17.3	11.7	24.3	100.0	37.7	641
Хангай	5.2	11.0	18.3	15.3	13.1	37.2	100.0	48.2	810
Төв	4.5	8.5	17.0	12.9	11.5	45.6	100.0	56.2	667
Зүүн	5.9	7.7	15.1	14.6	14.2	42.5	100.0	54.2	300
Улаанбаатар	4.6	6.2	16.9	13.4	10.7	48.3	100.0	58.3	1466
Хот, хөдөө									
Хот	4.5	7.4	16.6	13.4	11.6	46.5	100.0	56.1	2224
Хөдөө	6.8	11.4	20.1	15.8	12.0	33.9	100.0	44.6	1660
Насны бүлэг									
15-19	(*)	(*)	(*)	-	-	-	100.0	(*)	3
20-29	9.0	16.4	28.1	19.1	13.5	13.9	100.0	34.2	1262
30-39	4.1	6.2	14.7	13.0	11.7	50.1	100.0	60.1	2209
40-49	1.9	1.8	5.4	7.8	6.7	76.4	100.0	107.6	410
Өмнөх төрөлтийн хүйс									
Эрэгтэй	5.7	8.7	16.3	16.1	11.6	41.5	100.0	51.1	1949
Эмэгтэй	5.3	9.5	19.9	12.7	11.9	40.7	100.0	50.4	1935
Өмнөх хүүхэд амьд эсэх									
Амьд	5.0	9.0	17.9	14.6	11.9	41.6	100.0	51.4	3770
Эндсэн	22.6	11.7	26.2	8.6	5.8	25.1	100.0	29.9	113
Төрөлтийн дараалал									
2-3	5.5	9.2	17.5	14.8	11.8	41.1	100.0	50.7	3115
4-6	5.8	8.4	20.7	12.7	11.5	41.0	100.0	51.1	742
7+	(4.8)	(10.7)	(11.3)	(20.9)	(11.4)	(40.9)	100.0	(49.1)	27
Гэрлэлтийн байдал									
Гэрлэсэн	5.6	9.3	18.3	14.5	11.8	40.5	100.0	50.2	3700
Гэрлэж байсан	3.2	5.6	13.9	11.8	10.1	55.4	100.0	70.2	147
Огт гэрлээгүй	(7.1)	(4.5)	(18.2)	(14.0)	(14.0)	(42.2)	100.0	(54.6)	38
Боловсрол									
Боловсролгүй	9.7	11.1	21.4	21.4	12.0	24.4	100.0	39.3	237
Бага	8.9	13.7	23.7	14.4	10.7	28.5	100.0	40.2	356
Суурь	5.0	8.9	18.4	13.9	12.3	41.6	100.0	51.0	718
Бүрэн дунд	5.2	9.1	17.0	14.1	11.6	43.0	100.0	51.7	953
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	5.4	9.2	15.8	11.7	7.8	50.2	100.0	60.4	288
Дээд	4.4	7.6	17.1	14.3	12.7	43.8	100.0	54.1	1331
Өрхийн аж байдлын түвшин									
Доогуур	8.3	12.3	21.0	15.9	11.5	31.0	100.0	41.6	968
Дунджаас доогуур	5.5	10.4	20.5	15.5	11.9	36.2	100.0	46.3	802
Дундаж	4.8	8.6	15.6	15.5	13.1	42.3	100.0	52.5	707
Дунджаас дээгүүр	5.1	6.6	16.4	12.0	10.0	50.0	100.0	60.2	650
Дээгүүр	3.0	6.3	15.5	12.6	12.1	50.5	100.0	60.3	758
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*									
Халх	4.6	8.0	17.3	13.8	12.1	44.2	100.0	54.1	3041
Казах	13.9	20.3	26.7	17.3	8.3	13.4	100.0	29.9	191
Бусад	7.5	10.6	19.1	16.7	11.6	34.4	100.0	44.8	640

¹ НҮТС-ны үзүүлэлт CS12.7 - Төрөлт хоорондын зай

* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 9 ажиглалт (жигнэгдээгүй)-ыг харуулаагүй.

() 25-49 ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

(*) 25 хүртэлх ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

Тайлбар: Анхны төрөлтийг тооцоонд оруулаагүй. Ихэр төрөлтийн хувьд төрөлтийн хоорондын зай нь амьд төрөлтөөр төгссөн өмнөх жирэмслэлтээс хойших сараар илэрхийлэгдэнэ.

Хүснэгт FE.8: Төрсний дараа жирэмслэхгүй байх хугацаа

Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн, төрснөөс хойш сарын тэмдгээ үзээгүй, бэлгийн хавьталд ороогүй болон жирэмслэх боломжгүй эмэгтэйчүүдийн хувь, хүүхэд төрүүлснээс хойших сараар, хүүхэд төрүүлснээс хойших голч болон дундаж хугацаа, Монгол Улс, 2013 он

	Хүүхэд төрснөөс хойш эх нь:			Судалгааны өмнөх 2 жилийн хугацааны төрөлтийн тоо
	Сарын тэмдгээ үзээгүй	Бэлгийн хавьталд ороогүй	Жирэмслэх боломжгүй ^a	
Бүгд	32.4	17.9	38.1	2291
Төрснөөс хойших сар				
<2	92.8	82.8	96.6	145
2-3	72.7	39.1	78.7	221
4-5	58.6	20.8	64.8	228
6-7	45.1	13.6	50.9	211
8-9	35.0	9.5	40.3	222
10-11	26.8	7.7	31.8	205
12-13	19.5	5.8	23.5	182
14-15	13.1	7.1	19.1	187
16-17	10.1	7.3	16.6	182
18-19	7.6	9.1	15.8	195
20-21	5.2	6.9	11.3	151
22-23	2.8	4.6	7.4	163
Голч хугацаа ¹	5.8	2.1	6.7	na
Дундаж хугацаа	7.3	3.9	8.7	na

¹ НҮТС-ны үзүүлэлт CS12.8 - Төрсний дараа жирэмслэхгүй байх хугацаа

Тайлбар: Тус тооцоо мэдээлэл цуглуулах үед эхийн өгсөн хариултад үндэслэн тооцогдсон.

^a Төрснөөс хойш сарын тэмдгээ үзээгүй, бэлгийн хавьталд ороогүй тохиолдлуудын аль нэгийг авч үзсэн.

na: утга тооцогдохгүй

Хүснэгт FE.9: Төрсний дараа жирэмслэхгүй байх хугацаа

Судалгааны өмнөх 2 жилийн хугацааны хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн төрснөөс хойш сарын тэмдгээ үзээгүй, бэлгийн хавьталд ороогүй болон жирэмслэх боломжгүй голч хугацаа (сараар), Монгол Улс, 2013 он

	Сарын тэмдгээ үзээгүй голч хугацаа (сараар)	Бэлгийн хавьталд ороогүй голч хугацаа (сараар)	Жирэмслэх боломжгүй ^a	Судалгааны өмнөх 2 жилийн хугацааны төрөлтийн тоо
Бүгд¹	5.8	2.1	6.7	2291
Бүс				
Баруун	4.1	0.6	5.7	315
Хангай	5.6	2.5	7.5	446
Төв	7.4	2.0	8.2	382
Зүүн	4.6	2.0	5.7	156
Улаанбаатар	5.9	2.1	6.4	992
Хот, хөдөө				
Хот	6.0	2.1	6.5	1464
Хөдөө	4.7	2.0	7.4	827
Байршил				
Нийслэл	5.9	2.1	6.4	992
Аймгийн төв	6.1	1.9	6.9	472
Сумын төв	5.8	1.8	8.3	234
Хөдөө	4.4	2.1	7.2	593
Эхийн нас				
15-29	6.2	2.0	7.4	1301
30-49	5.3	2.1	5.9	990
Хөхөөр хооллолт				
Хооллож байсан	5.8	2.1	6.7	2250
Хооллож байгаагүй	(3.0)	(1.9)	(3.0)	41
Гэрлэлтийн байдал				
Гэрлэсэн	5.8	1.9	6.3	2107
Гэрлэж байсан	6.0	14.5	15.5	90
Огт гэрлээгүй	5.6	13.0		93
Боловсрол				
Боловсролгүй	3.2	2.7	4.5	127
Бага	4.5	0.7	5.6	150
Суурь	6.9	2.1	8.8	296
Бүрэн дунд	5.7	2.1	7.2	600
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	7.0	2.9	7.3	170
Дээд	5.9	1.8	6.4	948
Өрхийн аж байдлын түвшин				
Доогуур	3.8	2.2	6.8	483
Дунджаас доогуур	6.8	2.2	7.7	434
Дундаж	5.6	1.9	5.9	459
Дунджаас дээгүүр	6.7	1.9	7.2	428
Дээгүүр	5.5	2.0	6.2	487
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа				
Халх	5.9	2.1	6.8	1843
Казах	3.2	1.9	5.3	86
Бусад	5.3	2.0	6.7	353

¹ НҮТС-ны үзүүлэлт CS12.8 - Төрсний дараа жирэмслэхгүй байх хугацаа

() 25-49 ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

Тайлбар: Голч хугацаа нь мэдээлэл цуглуулах үед эхийн өгсөн хариултад үндэслэн тооцогдсон.

^a Төрснөөс хойш сарын тэмдгээ үзээгүй, бэлгийн хавьталд ороогүй тохиолдлуудын аль нэгийг авч үзсэн.

Хүснэгт FE.10: Цэвэршилт

30-49 насны цэвэршсэн эмэгтэйчүүдийн хувь, насны бүлгээр, Монгол Улс, 2013 он

	Цэвэршсэн эмэгтэйчүүдийн хувь ^{1,а}	30-49 насны эмэгтэйчүүдийн тоо
Бүгд	9.1	7459
Насны бүлэг		
30-34	2.0	2002
35-39	2.5	2010
40-41	4.1	781
42-43	9.2	671
44-45	12.5	693
46-47	23.6	677
48-49	39.8	624

¹ НҮТС-ны үзүүлэлт CS12.9 - Цэвэршилт

^а Судалгааны өмнөх 6 сарын хугацаанд сарын тэмдэг нь үзэгдээгүй, жирэмсэн биш боловч төрсний дараа сарын тэмдэг нь ирсэн эмэгтэйчүүдийн хувь

Хүснэгт FE.11: Анхны төрөлтийн голч нас

Хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, анх хүүхэд төрүүлэх үеийн насаар, огт хүүхэд төрүүлээгүй 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, анх хүүхэд төрүүлэх үеийн голч нас, эхийн насаар, Монгол Улс, 2013 он

	Анх хүүхэд төрүүлэх үеийн нас					Огт хүүхэд төрүүлээгүй эмэгтэйчүүдийн хувь	Анх хүүхэд төрүүлэх үеийн голч нас ¹	15-49 насны эмэгтэйчүүдийн тоо
	15	18	20	22	25			
Бүгд (25-49)	0.1	4.2	20.4	45.9	74.3	6.9	22.1	9471
Насны бүлэг								
15-19	0.0	na	na	na	na	96.3	a	1595
20-24	0.0	2.5	14.6	na	na	52.2	a	1765
25-29	0.0	3.2	14.5	36.4	68.5	17.0	22.4	2012
30-34	0.2	5.5	22.6	42.2	68.9	7.7	22.4	2002
35-39	0.1	4.3	22.5	48.5	74.0	4.0	22.0	2010
40-44	0.3	3.6	21.8	52.2	79.6	2.1	21.8	1816
45-49	0.2	4.4	20.7	52.1	82.6	2.4	21.9	1631

¹ НҮТС-ны үзүүлэлт CS12.4 - Анхны төрөлтийн голч нас

na: Тооцооноос хассан учраас утга тооцогдохгүй

a: Тухайн бүлгийн эхний насанд хүрэхээсээ өмнө эмэгтэйчүүдийн 50-иас бага хувь нь анхны хүүхдээ төрүүлсэн учраас голч нас тооцогдох боломжгүй

ТӨРӨЛТ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛС

Хүснэгт FE.12: Анхны төрөлтийн голч нас, сонгосон үзүүлэлтээр

25-49 насны эмэгтэйчүүдийн анхны төрөлтийн голч нас, насны бүлгээр, Монгол Улс, 2013 он

	Насны бүлэг					Бүгд ¹ (25-49 нас)
	25-29	30-34	35-39	40-44	45-49	
Бүгд	22.4	22.4	22.0	21.8	21.9	22.1
Бүс						
Баруун	23.4	23.4	22.8	22.6	22.8	23.0
Хангай	21.8	21.4	21.6	21.6	21.4	21.6
Төв	22.1	21.8	21.4	21.2	21.2	21.5
Зүүн	21.7	21.5	21.3	21.4	21.4	21.4
Улаанбаатар	22.7	22.9	22.3	22.1	22.3	22.5
Хот, хөдөө						
Хот	22.7	22.9	22.3	22.1	22.2	22.4
Хөдөө	22.0	21.6	21.5	21.3	21.3	21.5
Байршил						
Нийслэл	22.7	22.9	22.3	22.1	22.3	22.5
Аймгийн төв	22.6	22.8	22.3	22.1	22.0	22.3
Сумын төв	22.6	22.0	22.1	21.7	21.7	22.0
Хөдөө	21.6	21.4	21.3	21.2	21.0	21.3
Гэрлэлтийн байдал						
Гэрлэсэн	22.4	22.4	22.0	21.9	21.9	22.1
Гэрлэж байсан	21.8	22.2	21.9	21.4	21.7	21.7
Боловсрол						
Боловсролгүй	20.9	21.5	22.4	20.3	20.9	21.2
Бага	21.1	21.2	20.7	20.2	19.4	20.9
Суурь	21.1	21.0	21.2	20.6	20.8	21.0
Бүрэн дунд	21.7	21.5	21.6	21.8	21.5	21.6
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	21.5	22.0	21.3	21.7	21.7	21.7
Дээд	23.5	24.0	23.5	22.4	22.9	23.3
Өрхийн аж байдлын түвшин						
Доогуур	21.4	21.5	21.3	20.9	21.1	21.2
Дунджаас доогуур	21.8	21.5	21.5	21.6	21.1	21.5
Дундаж	22.9	22.2	22.2	21.8	21.8	22.1
Дунджаас дээгүүр	22.6	22.8	22.1	22.1	22.3	22.3
Дээгүүр	23.3	23.9	23.0	22.5	23.1	23.2
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа						
Халх	22.3	22.3	21.9	21.6	21.7	21.9
Казах	24.1	24.4	23.8	23.4	23.3	23.8
Бусад	22.4	22.3	22.4	22.4	22.4	22.4

¹ НҮТС-ны үзүүлэлт CS12.4 - Анхны төрөлтийн голч нас

ХИИ БҮЛЭГ

ТӨРӨЛТИЙН ТӨСӨӨЛӨЛ

XIII


Хүн амын тоо, бүтцийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл хөгжлийн аливаа бодлого, хөтөлбөр, төлөвлөлтийн суурь мэдээ болдог. Иймд хүмүүс төрөлтийн талаар ямар төсөөлөл, хандлагатай байгааг мэдэх нь чухал ач холбогдолтой юм. Энэ бүлэгт Монгол эрэгтэй, эмэгтэй хүний төрөлтөд хандах үзэл хандлага, хүүхдийн тооны талаарх баримтлалыг харуулахыг зорилоо. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс хүүхдийн зохистой тоо буюу хүүхэдгүй байх үедээ очлоо гэж төсөөлбөл амьдралынхаа хугацаанд хэдэн хүүхэдтэй болох байсан бэ, хамгийн сүүлийн хүүхдээ эсвэл одоогийн жирэмслэлтээ төлөвлөсөн эсэх гэх мэт асуултуудыг асуусан. Түүнчлэн, ирээдүйн болон ойрын хугацаанд хүүхэд төрүүлэх бодолтой, жирэмслэлтээ хязгаарлах хүсэлтэй эсэх зэрэг хүн амын ирээдүйн төрөлтийн түвшинг илэрхийлэхүйц чухал мэдээллийг цуглуулсан.

Хүсч буй төрөлт

Хосууд хүүхэд төрүүлэхийг хүсч байгаа эсвэл жирэмслэхгүй байх бодолтой байгаа нь ирээдүйн төрөлтийн түвшин, хүн амын нөхөн үржихүйн чиг хандлагын талаар чухал төсөөллийг өгдөг бөгөөд гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээтэй холбоотой төлөвлөлтөд энэхүү мэдээлэл ихээхэн хэрэгцээтэй байдаг. Ялангуяа, төрөлтөө хойшлуулах эсвэл бүр хязгаарлах хүсэлтэй эмэгтэйчүүдэд жирэмслэхээс хамгаалах арга хэрэгслийн тохирох үйлчилгээг төлөвлөж, хэрэгжүүлэхэд төрөлтийн төсөөлөлтэй холбоотой мэдээллүүд зайлшгүй шаардагдана. НҮТС-ны асуулгад жирэмсэн болон жирэмсэн биш, умайн гуурсан хоолойгоо боолгоогүй эмэгтэйчүүдээс ирээдүйд нэмж хүүхэд төрүүлэх эсэх, хэрвээ эерэг хариулт өгвөл хэдий хугацааны дараа төрүүлэхийг нь тодруулж асуусан. Тус мэдээллийг нэгтгэж Хүснэгт FeP.1-д харууллаа.

Гэрлэсэн буюу нөхөр/ хамтран амьдрагчтай 15-49 насны эмэгтэйчүүдийн 43.0 хувь ирээдүйд хүүхэдтэй болохоор төлөвлөж байгаагийн 13.8 хувь ойрын 2 жилийн дотор, 27.8 хувь 2 ба түүнээс дээш жилийн дараа, үлдсэн 1.4 хувь хэзээ төрүүлэхээ шийдээгүй байна. Харин 47.8 хувь нь хүүхэд төрүүлэхгүй, 5.1 хувь нь жирэмслэх боломжгүй, үлдсэн 4.0 хувь нь энэ талаар шийдээгүй гэж хариулжээ (Зураг FeP.1). Хариулагч ирээдүйн төрөлтийн талаарх асуултад өөрийгөө жирэмслэхгүй гэж хариулсан, эхнэр, нөхрийн хэн нэг нь мэс засал хийлгүүлсэн бол жирэмслэх боломжгүй гэж томъёолсныг дурьдах нь зүйтэй. НҮЭМС-2008 судалгааны дүнгээр хүүхэд төрүүлэх бодолтой эмэгтэйчүүдийн хувь 35.3, төрүүлэхгүй 52.6 хувь байсан нь хосуудын хүүхэд төрүүлэх хүсэл нэмэгдсэнийг харуулж байна.

Зураг FeP.1: Гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн төрөлтийн төсөөлөл, Монгол Улс, 2013 он



Олон хүүхэдтэй эмэгтэйчүүд төрөлтөө хязгаарлах, харин цөөн хүүхэдтэй эмэгтэйчүүд дахин хүүхэдтэй болохыг хүсэх нь мэдээж бөгөөд энэхүү зүй тогтол судалгаанд оролцогчдын дунд ч мөн ажиглагдлаа. Жишээлбэл, судалгааны үед хүүхэдгүй, жирэмсэн биш эмэгтэйчүүдийн 54.4 хувь нь ойрын 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлэх бодолтой бол 18.4 хувь нь 2 ба түүнээс дээш жилийн дараа хүүхэдтэй болно гэжээ. Харин нэг хүүхэдтэй эмэгтэйчүүдийн ердөө 25.3 хувь нь удахгүй (2 жилийн дотор) хүүхэд төрүүлнэ гэсэн бол 51.1 хувь нь 2 ба түүнээс дээш жилийн дараа хүүхэдтэй болохоо илэрхийлжээ (Хүснэгт FeP.1).

Төрөлтийн төсөөллийн талаарх мэдээллийг эмэгтэйчүүдийн насны бүлгээр ангилж харвал онцлог зүйл ажиглагдлаа (Хүснэгт FeP.2). Тухайлбал, 15-44 насны эмэгтэйчүүдийн 10.9-19.1 хувь нь 2 жилийн дотор ялангуяа, хүүхэд төрүүлэх бодолтой 25-34 насныхан илүү олон байна. 25-34 насны эмэгтэйчүүд ийнхүү хамгийн ихээр хүүхэд төрүүлэх хүсэлтэй байгаа нь өмнөх бүлэгт тайлбарлагдсан төрөлтийн түвшин, хандлагатай нийцэж, цаашид ч тэдний дунд төрөлт өндөр байхаар байна. Харин сурч боловсрох, нийгэмд байр сууриа эзлэх насандаа яваа 15-24 насныхан хамгийн ихээр төрөлтөө хойшлуулах (2 ба түүнээс дээш жилийн дараа хүүхэд төрүүлэх) хүсэлтэй байв.

Хүүхдийн тоогоо хязгаарлах хүсэл


Хүснэгт FeP.3-г хүүхэд төрүүлэх хүсэлгүй буюу ирээдүйд хүүхэд төрүүлэх бодолгүй эмэгтэйчүүдийг амьд байгаа хүүхдийн тоо, шинж байдлын үзүүлэлтээр нь ангилж харуулав. Умайн гуурсан хоолойгоо боолгосон эмэгтэйчүүдийг цаашид хүүхэд төрүүлэх бодолгүй гэж үзсэн.

Гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн 51.0 хувь хүүхэд төрүүлэх хүсэлгүй байгаа бөгөөд НҮЭМС-2008 судалгаатай харьцуулахад (55.2 хувь) буурчээ. Гэхдээ хүүхэдгүй болон 1 хүүхэдтэй эмэгтэйчүүдийн дунд жирэмслэлтээ хязгаарлах бодолтой эмэгтэйчүүдийн хувь НҮЭМС-2008 судалгаатай харьцуулахад (хүүхэдгүй 6.1, нэг хүүхэдтэй 10.6 хувь) өссөн дүнтэй байна. Хөдөөгийн эмэгтэйчүүдийг хотынхтой харьцуулахад илүү ихээр төрөлтөө хязгаарлах буюу хүүхэд төрүүлэхгүй байх бодолтой байна. Ялангуяа, хүүхэдгүй хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд энэ хандлага хотынхоос 2 дахин их байна. Эмэгтэйчүүдийн насны бүлгээр авч үзвэл төрөлтөө хязгаарлах хүсэл 20-24 насныхны дунд хамгийн бага (8.6 хувь) байгаа бөгөөд нас ахих тутамд эрчимтэй нэмэгдэж байна. Боловсролын түвшнээр бага зэргийн ялгаатай байв. Тухайлбал, тусгай мэргэжлийн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн 70.5 хувь нь төрөлтөө хязгаарлах хүсэлтэй байхад, уг үзүүлэлт бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн дунд 50.5 хувь, дээд боловсролтой эмэгтэйчүүдийн дунд 38.4 хувь байлаа. Харин өрхийн аж байдлын түвшин сайжирхад төрөлтөө хязгаарлах хүсэлтэй гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувь нэмэгдэж байна.

Хүүхдийн зохистой тоо

Өмнөх хэсэгт бид эмэгтэйчүүдийн төрөлтийн төсөөллийг дэлгэрэнгүй авч үзсэн. Эмэгтэйчүүдийг хүүхэд төрүүлэх эсэх нь амьд хүүхдийн тооноос хамаарч байгааг ажигласан. Тэгвэл энэ хэсэгт хариулагчаас хүүхдийн зохистой тооны талаар асуусан нэгэн чухал асуудлыг нэгтгэн танилцуулж байна. Хэрвээ эмэгтэй хүүхэдгүй бол "Та хэдэн хүүхэд төрүүлэхийг хүсдэг вэ", хүүхэдтэй бол "Хэрэв та өөрийгөө хүүхэд төрүүлээгүй насандаа эргэж очлоо гэж төсөөлбөл хэдэн хүүхэд төрүүлэхийг хүсэх байсан бэ" гэж асуусан. Хэдийгээр энэ 2 асуулт хийсвэр шинжтэй боловч чухал мэдээллийг бодлого боловсруулагчдад өгдөг юм. Нэгдүгээрт, хүүхэдгүй эмэгтэйчүүдийн хувьд ирээдүйд төрүүлэх хүүхдийн тооны талаар, хоёрдугаарт, ахимаг насны болоод олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийн тухайд төрүүлсэн болон зохистой гэж үзэж байгаа хүүхдийн тооны зөрүүгээр хүсээгүй төрөлтийн талаарх чухал мэдээллийг олж мэдэх бололцоотой.

Зураг FeP.2: 15-49 насны эмэгтэйчүүдийн зохимжит хүүхдийн тоо, Монгол Улс, 2013 он



Нийт эмэгтэйчүүдийн 60.0 хувь нь 3-4 хүүхэдтэй байх нь хамгийн зохистой гэж үзжээ (Зураг FeP.2). Харин 5 эмэгтэй тутмын 1 нь 2 хүүхэдтэй байхыг илүүд үзсэн байна. Гэхдээ энэ үзүүлэлтийг амьд буюу энх тунх байгаа хүүхдийн тоогоор ажиглавал илүү тодорхой хамаарлыг харуулж байна. Олон хүүхэдтэй эмэгтэйчүүд илүү олон хүүхэдтэй байхыг зохистой гэж үзэх хандлагатай байна. Тухайлбал, хүүхэдгүй эмэгтэйчүүдийн 66.4 хувь нь 2-3 хүүхэдтэй, гурван хүүхэдтэй эмэгтэйчүүдийн 67.0 хувь нь 3-4 хүүхэдтэй, харин 6 ба түүнээс олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийн 36.6 хувь нь хэрвээ тэд хүүхэдгүй байх үедээ эргэж очвол 6 ба түүнээс олон хүүхэдтэй болох байсан гэж хариулжээ (Хүснэгт FeP.4).

Гурав ба түүнээс цөөн хүүхэдтэй эмэгтэйчүүд байгаа хүүхдээсээ олон хүүхэдтэй болохыг зохистой гэж үзэж байхад (хүүхдийн зохимжит дундаж тоо 2.7-3.7) 4-өөс олон хүүхэдтэй эхчүүд төрүүлснээсээ цөөн хүүхэдтэй байхыг илүүд үзэж байна (хүүхдийн зохимжит дундаж тоо 4.0-4.5). Нийт болон гэрлэсэн эмэгтэйчүүдийн зохистой гэж үзсэн хүүхдийн дундаж тоо үндсэндээ ялгаагүй бөгөөд нэг хүүхэдтэй гэрлэсэн эмэгтэйчүүд (харгалзан 3.1 болон 3.2)-ийг хүүхэдгүй эмэгтэйчүүдтэй (харгалзан 2.7 болон 2.9) харьцуулахад арай олон тооны хүүхэдтэй болохыг хүсч байна.

Хүүхдийн зохимжит дундаж тоог нийгэм, хүн ам зүй, эдийн засгийн шинж байдлаар нь Хүснэгт FeP.5-д үзүүлэв. Ерөнхийдөө шинж байдлын үзүүлэлтүүдээр ялгаа их биш хэдий ч эмэгтэйчүүдийн нас ахих тутам зохистой гэж үзэх хүүхдийн тоо нэмэгдэж байна. Харин 15-19 насны (2.6), огт гэрлээгүй (2.7), боловсролгүй (2.9) эмэгтэйчүүд цөөн хүүхэдтэй болохыг хүсдэг ажээ.

Төрөлтийн төлөвлөлт

Өмнөх хэсэгт тэмдэглэсэнчлэн, төрүүлсэн болон зохистой гэж үзэж байгаа хүүхдийн тооны зөрүүгээр хүсээгүй төрөлтийн талаар ойлголт авах бололцоотой гэж дурьдсан. Энэ хэсэгт төрөлтийг төлөвлөсөн эсэхийг илүү тодруулж авч үзье. Судалгааны асуулгад мэдээлэл цуглуулахаас өмнөх 2 жилийн хугацаанд төрүүлсэн хүүхэд болон одоогийн жирэмслэлтээ төлөвлөж байж төрүүлсэн эсэх талаар тодруулж асуусан. НҮЭМ-ийн өмнөх судалгаануудад мэдээллийг төрөлтөө хүсч байсан эсэх агуулгаар асуусан бол НҮТС-нд төлөвлөсөн эсэх гэж томъёолсон. Хүсэх гэдэг томъёолол нь эмэгтэйн хариултыг илүү хийсвэр болгох талтай юм. Өөрөөр хэлбэл, хэдийгээр тухайн жирэмслэлтийг хүсээгүй байсан ч төрүүлсэн хүүхдээ бүгд л хайрладаг учраас цаг хугацааны явцад хүсч байсан мэт сэтгэгдэл давамгайлж үлдэх талтай. Харин төлөвлөх гэдэг агуулга нь эмэгтэйчүүдэд шууд утгаараа ойлгогдож, хариултыг илүү бодитой авах бололцоо олгосон байх талтай.

Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн болон судалгааны үед жирэмсэн байгаа 15-49 насны эмэгтэйчүүдийн 80.9 хувь нь жирэмслэлтээ төлөвлөсөн байжээ. Харин 12.5 хувь нь арай хожуу жирэмслэх бодолтой байсан бол үлдсэн 6.6 хувь нь огт төлөвлөөгүй жирэмслэлт байжээ (Хүснэгт

FeP.7). 2-3 хүүхэдтэй эмэгтэйчүүдийн дунд хүсээгүй төрөлт/ жирэмслэлт хамгийн бага (харгалзан 4.7, 5.8 хувь) бол 15-19, 35-39 болон 40 ба түүнээс дээш насныхны дунд хамгийн их (харгалзан 8.3, 8.8 болон 17.6 хувь) байна. Ялангуяа, өсвөр насны (15-19 нас) охидын 91.7 хувь жирэмслэлт, төрөлтөө төлөвлөсөн гэж хариулсан бол энэ үзүүлэлт нь нас ахих тутам нэмэгдэж (20-24 нас 93.6 хувь, 25-29 нас 93.8 хувь) байв.

Хүснэгт Fe.1: Төрөлтийн төсөөлөл

Гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, амьд байгаа хүүхдийн тоо, хүүхэд төрүүлэх эсхээр, Монгол Улс, 2013 он

	Амьд байгаа хүүхдийн тоо ^a							Бүгд
	0	1	2	3	4	5	6+	
Хүүхэд төрүүлэх эсэх								
2 жилийн дотор хүүхэд төрүүлнэ	54.4	25.3	13.2	6.7	3.7	0.5	0.0	13.8
2 ба түүнээс дээш жилийн дараа хүүхэд төрүүлнэ	18.4	51.1	32.2	17.9	3.5	3.0	0.0	27.8
Төрүүлнэ, хэзээ төрүүлэхээ шийдээгүй	2.9	2.5	1.4	1.0	0.2	0.0	0.0	1.4
Огт шийдээгүй	2.5	3.0	4.9	4.7	2.6	2.0	1.0	4.0
Хүүхэд төрүүлэхгүй	11.0	13.9	44.1	64.4	83.3	84.7	94.2	47.8
Мэс засал хийлгэсэн ^b	0.5	0.4	2.5	4.6	6.4	9.2	4.4	3.2
Жирэмслэх боломжгүй	10.4	3.8	1.7	0.7	0.4	0.6	0.0	2.0
Хариулаагүй/ мэдэхгүй	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.3	0.0
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	274	1811	3147	2125	933	268	115	8674

^a Амьд байгаа хүүхдийн тоонд одоогийн жирэмслэлт орсон

^b Эрэгтэйн үрийн суваг, эмэгтэйн умайн гуурсан хоолой боох аргууд орсон

Хүснэгт Үе.1М: Төрөлтийн төсөөлөл (эргэгэй)

Гэргэсэн 15-49 насны эрэгтэйчүүдийн хувь, амьд байгаа хүүхдийн тоо, хүүхэд төрүүлэх эсхээр, Монгол Улс, 2013 он

	Амьд байгаа хүүхдийн тоо ^a						Бүгд
	0	1	2	3	4	5	
Хүүхэд төрүүлэх эсэх							
2 жилийн дотор хүүхэд төрүүлнэ	65.5	33.2	16.3	9.1	2.3	1.2	(0.0)
2 ба түүнээс дээш жилийн дараа хүүхэд төрүүлнэ	16.0	43.6	32.3	17.9	7.6	6.5	(4.8)
Төрүүлнэ, хэзээ төрүүлэхээ шийдээгүй	2.9	2.4	1.8	1.1	1.1	0.0	(0.0)
Огт шийдээгүй	2.0	2.8	5.7	6.5	4.8	3.7	(6.0)
Хүүхэд төрүүлэхгүй	9.1	16.6	42.8	64.3	83.4	88.7	(89.2)
Мэс засал хийлгэсэн ^b	0.0	0.3	0.4	0.3	0.6	0.0	(0.0)
Эхнэр нь жирэмслэх боломжгүй	2.7	0.1	0.3	0.2	0.0	0.0	(0.0)
Хариулаагүй/ мэдэхгүй	1.9	1.1	0.4	0.6	0.2	0.0	(0.0)
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-49 насны эрэгтэйчүүдийн тоо	160	828	1365	877	374	88	45
() 25-49 ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон							
^a Хариулагчийн эхнэр жирэмсэн бол амьд байгаа хүүхдийн тоонд оруулсан							
^b Эрэгтэйн үрийн суваг, эмэгтэйн умайн гуурсан хоолой боох аргууд орсон							

Хүснэгт Үе.2: Төрөлтийн төсөөлөл, насны бүлгээр

Гэртээн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, насны бүлэг, хүүхэд төрүүлэх эсэхээр, Монгол Улс, 2013 он

	Насны бүлэг					Бүгд	
	15-19	20-24	25-29	30-34	35-39		40-44
Хүүхэд төрүүлэх эсэх							
2 жилийн дотор хүүхэд төрүүлнэ	10.9	12.6	16.6	19.1	17.8	11.6	1.6
2 ба түүнээс дээш жилийн дараа хүүхэд төрүүлнэ	61.1	70.8	55.5	38.6	10.5	1.4	0.4
Төрүүлнэ, хэзээ төрүүлэхээ шийдээгүй	0.9	2.4	2.2	1.9	1.1	0.6	0.4
Огт шийдээгүй	10.0	4.9	4.7	6.3	4.7	1.7	0.7
Хүүхэд төрүүлэхгүй	13.9	8.5	19.6	29.4	58.1	76.4	90.5
Мэс засал хийлгэсэн ^a	0.0	0.2	0.4	2.6	4.3	6.1	4.9
Жирэмслэх боломжгүй	3.0	0.7	1.0	2.2	3.6	2.1	1.4
Хариулаагүй/ мэдэхгүй	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.0
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	78	890	1592	1679	1684	1503	1248

^a Эрэгтэйн үрийн суваг, эмэгтэйн умайн гүүрсэн хоолой боох аргууд орсон

Хүснэгт FeP.2M: Төрөлтийн төсөөлөл, насны бүлгээр (эрэгтэй)

Гэрлэсэн 15-49(54) насны эрэгтэйчүүдийн хувь, насны бүлэг, хүүхэд төрүүлэх эсэхээр, Монгол Улс, 2013 он

	Насны бүлэг										Бүгд (15-49)	Бүгд (15-54)
	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49					
Хүүхэд төрүүлэх эсэх												
2 жилийн дотор хүүхэд төрүүлнэ	(*)	17.0	25.2	26.0	22.3	12.3	6.2	18.5	16.5			
2 ба түүнээс дээш жилийн дараа хүүхэд төрүүлнэ	(*)	71.0	52.0	39.9	20.6	6.7	1.8	27.3	24.2			
Төрүүлнэ, хэзээ төрүүлэхээ шийдээгүй	(*)	0.5	2.6	1.6	1.8	1.7	1.0	1.7	1.5			
Огт шийдээгүй	(*)	5.0	6.9	6.4	7.0	3.1	1.1	5.0	4.5			
Хүүхэд төрүүлэхгүй	(*)	6.5	12.6	25.6	46.8	73.8	88.4	46.3	52.1			
Мэс засал хийлгэсэн ^a	(*)	0.0	0.1	0.2	0.4	0.6	0.5	0.3	0.4			
Эхнэр нь жирэмслэх боломжгүй	(*)	0.0	0.2	0.1	0.1	0.4	0.3	0.3	0.2			
Хариулаагүй/ мэдэхгүй	(*)	0.0	0.3	0.2	0.2	1.3	0.7	0.6	0.6			
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0			
Эрэгтэйчүүдийн тоо	6	244	667	703	766	719	632	3737	4224			

(*) 25 хүртэлх ажиллалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

^a Эрэгтэйн үрийн суваг, эмэгтэйн умайн гуурсан хоолой боох аргууд орсон

Хүснэгт FeP.3: Хүүхэд төрүүлэх хүсэлгүй эмэгтэйчүүд

Хүүхэд төрүүлэх хүсэлгүй, гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, амьд байгаа хүүхдийн тоогоор, Монгол Улс, 2013 он

	Амьд байгаа хүүхдийн тоо ^a							Бүгд
	0	1	2	3	4	5	6+	
Бүгд	11.5	14.2	46.6	69.0	89.7	93.9	98.7	51.0
Бүс								
Баруун	(7.5)	14.8	46.2	67.8	84.3	94.7	(100.0)	58.1
Хангай	(21.4)	17.4	50.9	74.5	92.8	98.2	(100.0)	58.6
Төв	(10.4)	15.3	44.9	69.1	90.5	88.4	(95.2)	51.7
Зүүн	(13.9)	21.2	45.1	73.1	90.3	(96.7)	(*)	54.8
Улаанбаатар	8.8	11.7	45.5	64.6	90.1	(92.3)	(*)	43.4
Хот, хөдөө								
Хот	8.4	13.6	46.2	66.6	89.6	92.4	(99.0)	45.9
Хөдөө	18.2	16.1	47.4	72.2	89.8	94.7	98.5	59.3
Байршил								
Нийслэл	8.8	11.7	45.5	64.6	90.1	(92.3)	(*)	43.4
Аймгийн төв	7.4	17.6	47.4	69.8	88.8	92.6	(98.0)	50.3
Сумын төв	(12.4)	11.4	47.2	70.0	88.5	(94.2)	(*)	55.3
Хөдөө	21.1	18.7	47.5	73.1	90.3	94.9	98.0	61.2
Насны бүлэг								
15-19	(*)	13.8	(*)	(*)	(*)	(*)	(*)	13.9
20-24	0.8	3.8	23.1	(25.3)	(*)	(*)	(*)	8.6
25-29	0.0	4.7	21.2	44.8	(74.8)	(*)	(*)	20.0
30-34	(0.0)	3.4	22.6	43.2	80.1	(69.3)	(*)	32.0
35-39	(19.1)	20.5	51.7	71.8	89.5	93.7	(*)	62.3
40-44	(*)	57.7	79.3	87.3	92.6	96.6	(100.0)	82.5
45-49	(68.1)	89.8	95.1	96.8	97.3	97.9	97.4	95.5
Боловсрол								
Боловсролгүй	(*)	18.4	51.8	62.0	(85.0)	(*)	(*)	53.8
Бага	(*)	21.4	40.9	68.4	86.4	(78.4)	(*)	57.6
Суурь	(20.7)	27.0	46.7	69.4	92.8	97.2	97.5	64.4
Бүрэн дунд	12.0	13.2	45.9	69.0	90.2	100.0	(*)	50.5
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	(*)	25.7	68.0	85.1	93.3	95.5	(100.0)	70.5
Дээд	6.7	10.2	41.4	63.1	84.2	(82.7)	(*)	38.4
Өрхийн аж байдлын түвшин								
Доогуур	19.3	22.6	50.2	73.4	92.1	95.4	99.2	63.2
Дунджаас доогуур	(14.9)	14.2	46.6	70.4	90.4	92.0	(97.0)	55.4
Дундаж	(10.8)	13.1	45.7	69.3	87.9	97.7	(*)	49.7
Дунджаас дээгүүр	10.6	11.6	47.4	65.9	88.5	(*)	(*)	47.6
Дээгүүр	6.3	13.0	44.0	65.0	84.7	(*)	(*)	40.1
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*								
Халх	12.4	14.0	46.9	69.6	91.0	94.3	97.8	50.2
Казах	(*)	(12.9)	36.3	54.7	72.3	(92.8)	(*)	51.2
Бусад	(10.3)	15.7	46.7	69.4	90.7	93.3	(100.0)	55.5

() 25-49 ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

(*) 25 хүртэлх ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

Тайлбар: Умайн гуурсан хоолой боолгосон эмэгтэйчүүдийг хүүхэд төрүүлэх хүсэлгүй гэж үзсэн

^a Амьд байгаа хүүхдийн тоонд одоогийн жирэмслэлт орсон

Хүснэгт ҮР.3М: Хүүхэд төрүүлэх хүсэлгүй эрэгтэйчүүд

Хүүхэд төрүүлэх хүсэлгүй, гэрлэсэн 15-49 насны эрэгтэйчүүдийн хувь, амьд байгаа хүүхдийн тоогоор, Монгол Улс, 2013 он

	Амьд байгаа хүүхдийн тоо ^a							Бүгд
	0	1	2	3	4	5	6+	
Бүгд	14.2	19.8	48.0	68.8	87.2	91.8	93.4	52.4
Бүс								
Баруун	(*)	25.8	41.9	69.9	81.5	91.5	(91.0)	59.2
Хангай	(18.1)	21.2	50.2	73.7	91.8	(100.0)	(*)	58.2
Төв	(20.6)	25.7	48.7	64.6	94.9	(87.3)	(*)	54.5
Зүүн	(*)	32.7	59.5	80.5	97.6	(*)	(*)	64.5
Улаанбаатар	5.9	14.7	46.4	63.4	80.6	(*)	(*)	43.5
Хот, хөдөө								
Хот	8.8	17.6	47.7	66.1	85.0	90.4	(94.4)	47.3
Хөдөө	22.8	25.9	48.6	72.2	89.2	92.6	92.9	60.5
Байршил								
Нийслэл	5.9	14.7	46.4	63.4	80.6	(*)	(*)	43.5
Аймгийн төв	(15.9)	24.5	49.7	70.4	91.5	(96.1)	(*)	54.0
Сумын төв	(*)	26.1	48.4	67.9	90.9	(*)	(*)	57.2
Хөдөө	18.1	25.8	48.6	74.0	88.6	95.0	(94.1)	61.9
Насны бүлэг								
15-19	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)
20-24	(*)	4.9	(14.4)	(*)	(*)	(*)	(*)	6.5
25-29	(0.0)	3.4	17.9	30.3	(*)	(*)	(*)	12.8
30-34	(0.0)	5.1	23.2	37.0	65.3	(*)	(*)	25.9
35-39	(*)	31.3	33.7	56.5	79.0	(*)	(*)	47.1
40-44	(24.1)	46.0	70.9	83.6	89.4	(92.8)	(*)	74.3
45-49	(*)	68.7	90.8	88.9	96.5	(97.1)	(*)	88.9
Боловсрол								
Боловсролгүй	(14.9)	25.0	53.6	65.5	(91.4)	(*)	(*)	54.0
Бага	(*)	26.9	40.7	64.8	83.4	(*)	(*)	54.9
Суурь	(32.0)	35.6	48.0	77.1	90.7	(94.8)	(95.5)	63.3
Бүрэн дунд	(6.3)	15.1	44.9	56.9	89.5	(*)	(*)	44.2
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	(*)	21.2	61.2	78.9	91.2	(100.0)	(*)	63.3
Дээд	(7.5)	13.4	44.8	64.9	76.6	(*)	(*)	42.2
Өрхийн аж байдлын түвшин								
Доогуур	21.3	28.5	53.9	73.4	87.4	97.8	(96.1)	63.7
Дунджаас доогуур	(*)	22.6	42.7	69.7	90.9	(82.1)	(*)	54.4
Дундаж	(15.3)	14.4	50.6	71.6	87.1	(90.4)	(*)	52.2
Дунджаас дээгүүр	(3.5)	19.2	48.7	60.6	87.6	(*)	(*)	49.2
Дээгүүр	(3.5)	18.3	44.8	68.3	(75.3)	(*)	(*)	42.6
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*								
Халх	13.4	19.3	48.8	69.3	89.3	(*)	(93.6)	51.8
Казах	(*)	(*)	(20.1)	(59.4)	(65.1)	87.1	(*)	47.9
Бусад	(*)	23.3	48.2	69.2	86.4	(88.1)	(*)	57.2

() 25-49 ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

(*) 25 хүртэлх ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

Тайлбар: Үрийн сувгаа боолгосон эрэгтэйчүүдийг хүүхэд төрүүлэх хүсэлгүй гэж үзсэн

^a Хариулагчийн эхнэр жирэмсэн бол амьд байгаа хүүхдийн тоонд оруулсан

Хүснэгт ҮеР.4: Хүүхдийн зохимжит тоо, амьд байгаа хүүхдийн тоогоор

15-49 насны эмэгтэйчүүдийн хүүхдийн зохимжит тоо, зохимжит дундаж тоогоор, нийт болон гэрлэсэн эмэгтэйчүүдийн хүүхдийн зохимжит дундаж тоо, амьд байгаа хүүхдийн тоогоор, Монгол Улс, 2013 он

	Амьд байгаа хүүхдийн тоо ^a							Бүгд
	0	1	2	3	4	5	6+	
Хүүхдийн зохимжит тоо								
0	2.8	1.1	0.8	1.1	0.9	2.5	1.1	1.4
1	6.9	4.0	1.5	1.8	1.7	0.6	0.0	3.2
2	33.0	22.6	17.5	8.9	11.0	9.5	10.3	19.7
3	33.4	34.7	21.8	22.9	5.9	13.5	10.5	25.6
4	15.1	27.6	45.1	44.1	53.2	16.6	23.4	34.4
5	3.9	7.0	9.0	14.6	15.3	41.1	11.0	9.8
6+	1.3	1.9	3.0	4.7	10.0	13.0	36.6	3.9
Тоон бус хариулт	3.8	1.1	1.2	2.0	1.9	3.2	7.1	2.1
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	2952	2490	3554	2365	1023	308	138	12830
Хүүхдийн зохимжит дундаж тоо^b:								
Бүх эмэгтэйн хувьд ¹	2.7	3.1	3.5	3.7	4.0	4.2	4.5	3.4
15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	2841	2463	3510	2318	1004	298	128	12562
Гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувьд	2.9	3.2	3.5	3.7	4.0	4.2	4.5	3.6
Гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	268	1794	3111	2085	916	262	109	8545

¹ НҮТС-ны үзүүлэлт CS13.1 - Хүүхдийн зохимжит тоо

^a Амьд байгаа хүүхдийн тоонд одоогийн жирэмслэлт орсон

^b Дунжийг тооцохдоо тоон бус хариулт өгсөн эмэгтэйчүүдийг хассан

Хүснэгт FeP.4M: Хүүхдийн зохимжит тоо, амьд байгаа хүүхдийн тоогоор (эрэгтэй)

15-49 насны эрэгтэйчүүдийн хүүхдийн зохимжит тоо, зохимжит дундаж тоогоор, нийт болон гэрлэсэн эрэгтэйчүүдийн хүүхдийн зохимжит дундаж тоо, амьд байгаа хүүхдийн тоогоор, Монгол Улс, 2013 он

	Амьд байгаа хүүхдийн тоо ^a							Бүгд
	0	1	2	3	4	5	6+	
Хүүхдийн зохимжит тоо								
0	2.7	0.8	1.4	1.2	0.6	3.5	(1.0)	1.7
1	3.1	2.9	0.6	0.8	0.2	1.5	(0.0)	1.9
2	28.7	17.5	18.5	4.8	4.4	4.2	(4.8)	18.4
3	36.0	40.7	28.7	35.4	10.3	7.8	(8.2)	32.5
4	17.7	24.6	32.4	32.4	53.3	10.5	(6.5)	26.9
5	4.9	8.9	12.1	18.1	17.1	47.3	(24.4)	11.0
6+	1.4	2.7	3.8	4.4	8.9	20.7	(43.1)	3.8
Тоон бус хариулт	5.5	1.9	2.5	2.9	5.2	4.3	(12.0)	3.7
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-49 насны эрэгтэйчүүдийн тоо	1958	961	1420	891	380	89	46	5745
Хүүхдийн зохимжит дундаж тоо^b:								
Бүх эрэгтэйн хувьд ¹	2.9	3.3	3.5	3.7	4.1	4.6	(5.0)	3.3
15-49 насны эрэгтэйчүүдийн тоо	1851	943	1385	865	360	86	40	5530
Гэрлэсэн эрэгтэйчүүдийн хувьд	2.8	3.3	3.5	3.7	4.1	4.6	(5.0)	3.6
Гэрлэсэн 15-49 насны эрэгтэйчүүдийн тоо	157	812	1331	853	354	84	40	3632

¹ НҮТС-ны үзүүлэлт CS13.1 - Хүүхдийн зохимжит тоо

() 25-49 ажиглалт (жигнэгдээгүй) дээр үндэслэн тооцсон

^a Хариулагчийн эхнэр жирэмсэн бол амьд байгаа хүүхдийн тоонд оруулсан

^b Дунджийг тооцохдоо тоон бус хариулт өгсөн эрэгтэйчүүдийг хассан

Хүснэгт ҮеР.5: Хүүхдийн зохимжит тоо, сонгосон үзүүлэлтүүдээр

15-49 насны эмэгтэйчүүдийн хүүхдийн зохимжит дундаж тоо, Монгол Улс, 2013 он

	Хүүхдийн зохимжит дундаж тоо	15-49 насны эмэгтэйчүүдийн тоо ^a
Бүгд	3.36	12562
Бүс		
Баруун	3.37	1531
Хангай	3.37	2495
Төв	3.48	2010
Зүүн	3.17	912
Улаанбаатар	3.34	5614
Хот, хөдөө		
Хот	3.36	8394
Хөдөө	3.36	4168
Байршил		
Нийслэл	3.34	5614
Аймгийн төв	3.39	2780
Сумын төв	3.45	1348
Хөдөө	3.32	2820
Насны бүлэг		
15-19	2.56	1516
20-24	3.00	1729
25-29	3.21	1982
30-34	3.40	1971
35-39	3.59	1978
40-44	3.76	1791
45-49	3.89	1595
Гэрлэлтийн байдал		
Гэрлэсэн	3.55	8545
Гэрлэж байсан	3.49	1143
Огт гэрлээгүй	2.73	2874
Боловсрол*		
Боловсролгүй	2.88	466
Бага	3.40	546
Суурь	3.22	2388
Бүрэн дунд	3.32	3464
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	3.54	1378
Дээд	3.45	4320
Өрхийн аж байдлын түвшин		
Доогуур	3.27	2232
Дунджаас доогуур	3.34	2351
Дундаж	3.37	2473
Дунджаас дээгүүр	3.44	2719
Дээгүүр	3.36	2787
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа		
Халх	3.36	10249
Казах	3.48	418
Бусад	3.34	1867

¹ НҮТС-ны үзүүлэлт CS13.1 - Хүүхдийн зохимжит тоо

* "Боловсрол" нь хариулагдаагүй 9 ажиглалт (жигнэгдээгүй)-ыг харуулаагүй.

^a Тоон хариулт өгсөн эмэгтэйчүүдийн тоо

Хүснэгт 6P.6: Төрөлтийн төлөвлөлт

Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн (одоогийн жирэмслэлт ороод) 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, төрөлтөө төлөвлөсөн байдлаар, төрөлтийн дараалал, төрөх үеийн эхийн насны бүлгээр, Монгол Улс, 2013 он

	Төрөлтөө төлөвлөсөн байдал			Дүн	Судалгааны өмнөх 2 жилийн хугацааны төрөлтийн тоо
	Хүсч байсан ¹	Арай хожуу	Хүсээгүй		
Бүгд	80.9	12.5	6.6	100.0	3006
Төрөлтийн дараалал					
1	79.0	14.8	6.2	100.0	888
2	82.1	13.2	4.7	100.0	960
3	84.0	10.2	5.8	100.0	714
4+	77.1	10.2	12.7	100.0	444
Эхийн хүүхдээ төрүүлэх үеийн нас					
15-19	70.4	21.3	8.3	100.0	145
20-24	77.3	16.3	6.4	100.0	820
25-29	80.6	13.2	6.3	100.0	857
30-34	85.3	8.8	5.9	100.0	590
35-39	84.4	6.7	8.8	100.0	314
40+	75.7	6.8	17.6	100.0	85
¹ НҮТС-ны үзүүлэлт CS13.3 - Төлөвлөсөн төрөлт					

Хүснэгт ҮР.7: Хүүхдийн тооны талаарх хосуудын байр суурь

Гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, нөхрийн хүсдэг хүүхдийн тоогоор, Монгол Улс, 2013 он

	Нөхрийн хүсдэг хүүхдийн тоо				Дүн	15-49 насны эмэгтэйчүүдийн тоо
	Ижил	Олон	Цөөн	Ярилцаж байгаагүй/ Мэдэхгүй		
Бүгд	63.6	21.2	7.2	8.0	100.0	12830
Бүс						
Баруун	65.2	20.3	7.2	7.3	100.0	1587
Хангай	63.4	19.0	9.0	8.5	100.0	2557
Төв	61.5	20.7	7.8	10.0	100.0	2063
Зүүн	62.2	20.1	8.1	9.7	100.0	926
Улаанбаатар	64.3	23.3	5.8	6.7	100.0	5696
Хот, хөдөө						
Хот	63.4	23.1	6.2	7.4	100.0	8532
Хөдөө	63.9	18.3	8.9	9.0	100.0	4298
Байршил						
Нийслэл	64.3	23.3	5.8	6.7	100.0	5696
Аймгийн төв	61.8	22.7	6.9	8.6	100.0	2836
Сумын төв	61.7	19.8	9.5	9.0	100.0	1389
Хөдөө	64.8	17.5	8.7	9.0	100.0	2910
Боловсрол*						
Боловсролгүй	56.8	18.2	12.3	12.7	100.0	488
Бага	67.3	16.4	6.5	9.9	100.0	563
Суурь	65.2	17.2	8.8	8.8	100.0	2488
Бүрэн дунд	64.2	20.8	6.7	8.2	100.0	3520
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	62.2	18.3	8.1	11.5	100.0	1408
Дээд	63.0	25.2	6.2	5.6	100.0	4361
Өрхийн аж байдлын түвшин						
Доогуур	63.4	17.7	8.8	10.0	100.0	2311
Дунджаас доогуур	63.5	20.1	7.4	9.0	100.0	2412
Дундаж	63.5	21.5	6.5	8.6	100.0	2528
Дунджаас дээгүүр	63.2	22.2	7.9	6.6	100.0	2753
Дээгүүр	64.1	24.4	5.5	6.0	100.0	2826
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа**						
Халх	63.4	21.5	7.2	7.9	100.0	10435
Казах	68.3	17.3	4.7	9.6	100.0	449
Бусад	63.5	20.8	7.9	7.8	100.0	1920

* "Боловсрол" нь хариулагдаагүй 9 ажиглалт (жигнэгдээгүй)-ыг харуулаагүй.

** "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагдаагүй 27 ажиглалт (жигнэгдээгүй)-ыг харуулаагүй.

**XIV
БҮЛЭГ**

ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТ

XIV

Гэр бүл төлөвлөлт нь хувь хүн болон хосууд хүссэн тооныхоо хүүхдийг төлөвлөж төрүүлэх, төрөлт хоорондын зай, хугацаагаа зохицуулах боломжийг олгодог. Энэхүү төлөвлөгөөг жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл (ЖСАХ) болон хүсээгүй үргүйдлийн эмчилгээ, сувилгаагаар дамжуулан хэрэгжүүлдэг. Эмэгтэйн жирэмслэхээ хязгаарлах, жирэмслэлт хоорондын зайгаа зохицуулах чадвар нь түүний эрүүл мэнд, сайн сайхан болоод жирэмслэлтийн үр дүнд чухал нөлөөтэй¹.

Кайр хотноо 1994 онд хуралдсан Хүн ам ба хөгжил олон улсын бага хурал (ХАХОУБХ)-аар нөхөн үржихүйн эрхийг хүний нэг чухал эрх гэж авч үзсэн бөгөөд уг эрхийн хүрээнд хосууд хэдэн хүүхэдтэй болох, хүүхэд хоорондын зайг чөлөөтэй шийдэх эрхийг тунхагласан. Хосууд энэхүү эрхээ хэрэгжүүлэхийн тулд гэр бүлээ төлөвлөхөд шаардлагатай арга, хэрэгсэл болон мэдээллээр хангагдах эрхтэй бөгөөд Засгийн газрууд ЖСАХ-ийг хүн амдаа аль болох хямд үнээр хүргэх үүргийг хүлээсэн.

Өнөөгийн байдлаар түгээмэл хэрэглэгддэг орчин үеийн ЖСАХ-ийг улсын анхан шатны эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан үнэ төлбөргүй олгож байна. Мөн зарим арга, хэрэгслийг хөнгөлсөн үнээр борлуулж байгаагийн зэрэгцээ эрүүл мэндийн даатгалаар зах зээлийн үнийг нь хөнгөлөх эрхийг олгосон.

Энэхүү бүлэгт судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэр дундаа гэрлэсэн эмэгтэйчүүдийн дундах ЖСАХ-ийн мэдлэг, одоогийн хэрэглээ, түүнчлэн цаашдын хандлага, ЖСАХ-ийн хэрэгцээ, гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээлэл авч буй болон одоогийн хэрэглэж байгаа ЖСАХ-ийн эх үүсвэр зэргийн талаар тусгав.

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах Бодлого (2004)-д “Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын төвд байлгана (2.1.1)”, “Хүний нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн чөлөөт сонголт бүхий зохистой төрөлтийг дэмжиж, өвчлөл, нас баралтыг бууруулах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана.” гэж заасан. Үүнээс гадна Засгийн газрын 2012 оны 61 дүгээр тогтоолоор баталсан Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний дөрөв дэх хөтөлбөрийн зорилго нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих замаар монгол хүний хөгжлийг хангах таатай орчинг бүрдүүлж, Мянганы хөгжлийн зорилтыг хангахад оршино гэж тусгасан байдаг. Эдгээр бодлого, хөтөлбөрийн зарим зорилтын хэрэгжилтийг үнэлэхэд судалгааны үр дүн тодорхой ойлголт өгөх нь дамжиггүй.

Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн мэдлэг, хэрэглээ

Гэр бүл төлөвлөлтийн зохистой аргыг сонгон хэрэглэх нь *нэгдүгээрт*, хэт залуудаа болон хэт орой хүүхэд төрүүлэхээс урьдчилан сэргийлэх, *хоёрдугаарт*, төрөлт хоорондын зайг зохицуулах, *гуравдугаарт*, хүссэн тоогоор хүүхэдтэй болох боломж олгодог тул эх, хүүхдийн эрүүл мэндэд тустай. Тиймээс хосуудыг хэт эрт, хэт ойрхон, хэт орой эсвэл хэт олон жирэмслэхээс сэргийлэх талаар мэдээлэл, үйлчилгээгээр хангах нь чухал юм.

Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн талаарх мэдлэгийг судалгааны асуулгад тусгасан арга, хэрэгслийн аль нэгийг сонсож, уншиж байсан эсэхээр тодорхойлсон (хавсралт F-ээс асуулгыг дэлгэрүүлж үзнэ үү). Түүнчлэн, хариулагчаас асуухдаа эхлээд мэдэх аргуудыг өөрөөр нь нэрлүүлэн дараа нь нэрлэлгүй үлдээсэн арга, хэрэгслийн талаар тайлбарлаж өгөхөд мэдэж байвал ЖСАХ-ийн талаар мэдлэгтэй гэж үзсэн.

ЖСАХ-ийг дотор нь орчин үеийн болон уламжлалт гэж ангилсан ба орчин үеийн аргад умайн гуурсан хоолой болон эрэгтэй үрийн суваг боох, ерөндөг, тариа, суулгац, эм, эрэгтэй/эмэгтэй бэлгэвч, диафрагм, лаа, царцмаг болон яаралтай ууж хамгаалах эмийг, уламжлалт аргад хуанлийн дагуу түр

¹ http://www.who.int/topics/family_planning/en/

тэвчих, гадуур тавих аргуудыг хамруулав.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ЖСАХ-ийн талаарх мэдлэгийг хүснэгт FaP.1, FaP.1M-д харуулав. Хүснэгтээс харахад 15-49 насны эмэгтэйчүүд (98.4 хувь), эрэгтэйчүүд (97.1 хувь)-ийн дунд ЖСАХ-ийн ямар нэг арга мэддэг байх нь нийтлэг байгаа юм. Эмэгтэйчүүдийн дийлэнх нь эрэгтэй бэлгэвч (93.7 хувь), эм (93.3 хувь), ерөндөг (91.1 хувь)-ийг мэддэг байна. Харин эрэгтэйчүүдийн хувьд дийлэнх (95.6 хувь) нь эрэгтэй бэлгэвчийг мэдэж байгаа хэдий ч бусад аргуудын хувьд (гадуур тавихаас бусад) эмэгтэйчүүдийнхээс маш бага мэдлэгтэй байлаа. Эмэгтэйчүүд дунджаар ЖСАХ-ийн 8 арга мэдэж байхад эрэгтэйчүүдийн хувьд 6-г мэддэг байна. Доогуур аж байдалтай эсвэл бага боловсролтой эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд ЖСАХ-ийн талаарх мэдлэг харьцангуй бага байв.

Гэрлэсэн, хамтран амьдрагчтай бараг бүх (99.6 хувь) эмэгтэйчүүд жирэмслэхээс сэргийлэх ямар нэгэн аргын талаар мэдлэгтэй байсан бөгөөд дунджаар 8.4 төрлийн арга мэддэг ажээ (Хүснэгт FaP.2). Ялангуяа, тэд ерөндөг (97.1 хувь), эрэгтэй бэлгэвч (95.3 хувь), эм (96.5 хувь) болон тарианы (93.7 хувь) талаар бусад аргуудаас илүү мэдэж байна. Гэрлэсэн/ хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн ЖСАХ-ийн ямар нэг аргын талаарх болон орчин үеийн аргын талаарх мэдлэг тэдний боловсрол, өрхийн аж байдлын түвшнээс бусад шинж байдлаар төдийлөн ялгаа багатайг хүснэгт FaP.2-оос харж болно. Харин уламжлалт аргын талаарх мэдлэг болон мэдэх аргуудын дундаж тоо эмэгтэйн боловсролын түвшин, өрхийн аж байдлын түвшин дээшлэх тусам нэмэгдэж байв.

ЖСАХ-ийг тус бүрээр нь нарийвчлан харвал ерөндөг, эм, тариа, эрэгтэй бэлгэвчийн талаарх мэдлэг хот, хөдөөд ялгаа багатай хэдий ч бусад аргуудын хувьд ялгаа ихтэй байна. Мэддэг арга, хэрэгслийн дундаж тооны хувьд хот, хөдөө болон бүсээр ялгаатай байв. Хотын эмэгтэйчүүдийн хувьд хөдөөгийнхтэй харьцуулахад илүү олон тооны ЖСАХ-ийн арга хэрэгслийг мэдэж байлаа. Мөн уг үзүүлэлт нь Улаанбаатар хотод (9.2) хамгийн өндөр, Баруун бүсэд (7.2) хамгийн бага байв.

Гэрлэсэн/ хамтран амьдрагчтай эрэгтэйчүүдийн ЖСАХ-ийн талаарх мэдлэгийг Хүснэгт FaP.2M-д харуулав. Судалгаанд хамрагдсан гэрлэсэн, хамтран амьдрагчтай 15-49 насны эрэгтэйчүүдийн ЖСАХ-ийн мэдлэг өндөр (98.3), ойролцоогоор 7 арга мэддэг байна. Дээрх эрэгтэйчүүдийн мэдлэгийг шинж байдлаар нь авч үзвэл эмэгтэйчүүдтэй ижил хандлагатай ажээ.

ЖСАХ-ийн мэдлэгээс гадна одоогийн хэрэглээг хүснэгт FaP.3-г эмэгтэйчүүдийн насны бүлгээр үзүүлэв.

Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 54.6 хувь нь одоогийн байдлаар жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байна. Монголд хамгийн түгээмэл хэрэглэгдэг арга нь ерөндөг бөгөөд гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай 4 эмэгтэй тутмын нэг нь (23.5 хувь) хэрэглэдэг. Үүний дараагаар эм орж байгаа бөгөөд гэрлэсэн эмэгтэйчүүдийн 8.7 хувь нь хэрэглэж байв. Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 3.2-8.4 хувь нь эрэгтэй бэлгэвч (8.4 хувь), хуанлийн дагуу түр тэвчих (5.8 хувь), тариа (3.7 хувь), умайн гуурсан хоолойг боолгох (3.2 хувь) аргыг хэрэглэж байна. Бусад аргын хувьд маш бага хэрэглэгддэгийг хүснэгтээс харж болно. Залуу (15-24 нас) болон ахимаг (44-49 нас) насны эмэгтэйчүүдийн дунд ЖСАХ-ийн хэрэглээ харьцангуй бага байлаа.

Түүнчлэн, жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ эдгээр эмэгтэйчүүдийн дунд 48.2 хувь, уламжлалт аргын хэрэглээ 6.4 хувь байна. Жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга хэрэглэдэг гэрлэсэн/ хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн хувийг НҮЭМС-2008 судалгааны дүнтэй харьцуулбал үндсэндээ өөрчлөлтгүй байна (НҮЭМС-2008 судалгаагаар 55.2 хувь байсан). Хүснэгтээс ажиглагдаж байгаа онцлог зүйл нь бэлгийн идэвхтэй буюу судалгааны өмнөх 1 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон эмэгтэйчүүд эрэгтэй бэлгэвч (14.9 хувь) болон эм (9.3 хувь)-ийг гэрлэсэн/ хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү хэрэглэдэг ажээ. Ерөндөгийн хэрэглээ тэдний дунд харьцангуй бага (11.2 хувь) юм.

Хүснэгт FaP.4-д гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн (тэдний нөхөр/ хамтран амьдрагчийнх нь хэрэглэж байж болно) хэрэглэж байгаа ЖСАХ-ийн талаарх дэлгэрэнгүй үр дүнг харууллаа.

ЖСАХ-ийн хэрэглээ Төвийн бүсэд хамгийн бага 51.0 хувь, Хангайн бүсэд хамгийн их 60.0 хувьтай байв. Хот, хөдөөгөөр авч үзвэл, хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд ЖСАХ-ийн хэрэглээ хотын эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр байлаа. Тухайлбал, гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай хотод амьдардаг эмэгтэйчүүдийн 51.5 хувь нь ЖСАХ хэрэглэж байхад хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувьд энэ нь

59.7 хувьтай байгаа юм. Өсвөр насныхны хувьд ахимаг насныхантай (45-49 наснаас бусад) харьцуулахад ЖСАХ-ийг маш бага хэрэглэж байна. 15-19 насны гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн ердөө 29.1 хувь нь ЖСАХ хэрэглэж байхад 20-44 насны эмэгтэйчүүдийн хувьд уг үзүүлэлт нь 47.0-64.9 хувьтай байв. Гэхдээ 45-49 насныхны хувьд ЖСАХ-ийн хэрэглээ их биш (33.1 хувь) байгааг хүснэгтээс харж болно. Эмэгтэйчүүд 2 ба түүнээс олон хүүхэдтэй болсны дараагаар ЖСАХ илүү хэрэглэдэг байна.

Эмэгтэйн боловсролын түвшин ЖСАХ-ийн хэрэглээтэй хамааралтай байлаа. Техникийн болон тусгай мэргэжлийн боловсролтой эмэгтэйчүүдийн дунд (48.2 хувь) ЖСАХ-ийн хэрэглээ хамгийн бага байхад бага боловсролтой эмэгтэйчүүдийн дунд (63.9 хувь) хамгийн их байгаа юм. Зарим жирэмслэхээс сэргийлэх, арга хэрэгсэл (тухайлбал, ерөндөг, тариа, эм, эрэгтэй бэлгэвч, хуанлийн дагуу түр тэвчих)-ийн хэрэглээ эмэгтэйчүүдийн боловсролын түвшнээр ялгаагүй байв. ЖСАХ-ийн хэрэглээ өрхийн аж байдлын түвшинтэй мөн хамааралтай байна. Тодруулбал, ЖСАХ-ийн хэрэглээ дээгүүр түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн дунд (51.8 хувь) хамгийн бага байгаа бөгөөд өрхийн аж байдлын түвшин доошлох тутам ЖСАХ-ийн хэрэглээний түвшин нэмэгдэж доогуур түвшний аж байдалтай эмэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр буюу 61.2 хувьтай байв.

ЖСАХ-ийн хэрэглээг уламжлалт болон орчин үеийнхээр нь ангилж үзвэл зарим нэг онцлог зүйл ажиглагдлаа. Тухайлбал, Улаанбаатарт орчин үеийн аргын хэрэглээ бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн бага (43.4 хувь) бол уламжлалт аргын хэрэглээ энэ бүсэд хамгийн их (8.4 хувь) байна. Хөдөөд уламжлалт аргын хэрэглээ бага байхад хотод орчин үеийн аргын хэрэглээ бага байлаа. Уламжлалт аргын хэрэглээ эмэгтэйчүүдийн нас ахих, амьд хүүхдийн тоо олон болох, боловсролын түвшин болон өрхийн аж байдлын түвшин сайжрахад нэмэгдэж байхад орчин үеийн аргын хэрэглээ өрхийн аж байдлын түвшин буурахад нэмэгдэж байв. Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаагаар авч үзвэл, орчин үеийн аргын хэрэглээ ялгаагүй, харин уламжлалт аргын хэрэглээний хувьд Казах тэргүүлэгчтэй өрхийн эмэгтэйчүүдийн дунд хамгийн бага (2.7 хувь) байлаа.

Хэрэглэж байсан ЖСАХ-ээ сольсон эсэх болон солих болсон шалтгаан нь ЖСАХ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх хөтөлбөрт маш чухал үзүүлэлтүүд болдог. Хүснэгт FaP.5-д хэрэглэж байсан ЖСАХ-ээ ямар шалтгаанаар сольсныг харууллаа.

Судалгаанд хамрагдсан гэрлэсэн/ хамтран амьдрагчтай 8674 эмэгтэйчүүдийн 54.6 хувь нь ямар нэг ЖСАХ хэрэглэдэг байна. Тэдний 2283 (48.2 хувь) нь өмнө нь одоогийн хэрэглэж байгаагаас өөр ЖСАХ хэрэглэж байжээ. Хэрэглэж байсан аргаа солих болсон хамгийн гол шалтгаан нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй (37.5 хувь) гэж үзсэнийх байв. Түүнчлэн, өөр үр дүнтэй арга хэрэглэхийг хүссэн (17.4 хувь), сөрөг нөлөөтэй (14.4 хувь), хэрэглэхэд төвөгтэй (8.1 хувь) зэрэг шалтгаануудыг нэлээд дурдаж байлаа. Ялангуяа, ерөндөг (49.8 хувь), тариа (37.0 хувь) болон эм (41.5 хувь) хэрэглэж байсан эмэгтэйчүүд эрүүл мэндэд тохироогүйн улмаас хамгийн ихээр аргаа өөрчилсөн гэдгээ илэрхийлжээ. Харин бэлгэвч (54.4 хувь) болон уламжлалт арга, тухайлбал түр тэвчих (54.1 хувь) арга хэрэглэж байсан эмэгтэйчүүд өөр үр дүнтэй арга хэрэглэхийг хүссэн учраас аргаа солисон байна.

Мэс ажилбар хийлгүүлэх үеийн нас, хийлгүүлснээс хойшхи хугацаа

ЖСАХ-ийн дотор умайн гуурсан хоолойг боох арга нь нэлээд онцлогтой, мэс заслын аргаар хийгддэг, жирэмслэхээс сэргийлэх магадлал хамгийн өндөр хэдий ч үргүй болох эрсдэлтэй арга юм. Тиймээс умайн гуурсан хоолойгоо боолгох буюу мэс заслын арга хэрэглэсэн хүмүүсийг тусгайлан авч үзэж, тэднийг мэс ажилбар хийлгүүлэх үеийн нас болон хийлгүүлснээс хойших хугацаагаар нь ангилж, хүснэгт FaP.6-д харуулав. Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 2.5 хувь нь жирэмслэхээс сэргийлэхийн тулд мэс заслын арга хэрэглэсэн (Хүснэгт FaP.3) бөгөөд мэс засал хийлгэх үеийн голч нас нь 33.2 байжээ (Хүснэгт FaP.6). Эдгээр үзүүлэлтүүд НҮЭМС-2008 судалгаагаар харгалзан 2.1 хувь болон 32 байв. Мэс ажилбар хийлгэсэн эмэгтэйчүүдийн 24.2 хувь нь 29 ба түүнээс доош, 71.4 хувь нь 30-39, 4.3 хувь нь 40 ба түүнээс дээш насандаа умайн гуурсан хоолойг боох мэс засал хийлгэжээ. 4-7 жилийн өмнө умайн гуурсан хоолойгоо боолгосон эмэгтэйчүүдийн 42.6 хувь нь 35-39 насандаа, 36.7 хувь нь 30-34 насандаа хийлгэж байсан.

Хуанлийн аргын талаарх мэдлэг

Уламжлалт ЖСАХ-ийн дотор хуанлийн арга нь сарын тэмдгийн мөчлөгийн үр тогтох боломжтой үед бэлгийн хавьталд орохгүй байхыг хэлдэг бөгөөд тухайн эмэгтэй өндгөн эс боловсорч, биенээс гадагшлах болон жирэмслэх магадлал хамгийн өндөр мөчлөгийнхөө үеийг зөв тодорхойлох талаар сайтар мэдлэгтэй байх шаардлагатай.

Өмнө дурдаж байснаар, судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 4.3 хувь нь энэ аргыг хэрэглэж байна (Хүснэгт FaP.3). Тэдний дийлэнх (84.9 хувь) нь жирэмслэх боломж өндөртэй мөчлөгийн үеэ зөв тодорхойлсон байхад 14.0 хувь нь буруу мэдлэгтэй, 1.1 хувь нь огт мэддэггүй байв (Хүснэгт FaP.7). Харин өөр төрлийн арга, хэрэгсэл хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тал хүрэхгүй хувь (42.5 хувь) нь зөв мэдлэгтэй, 34.3 хувь нь огт мэдлэггүй байв.

Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга, хэрэгслийн эх үүсвэр

Судалгаанд хамрагдсан орчин үеийн ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдээс арга, хэрэгслээ хаанаас авсан талаар асуусан бөгөөд үр дүнг хүснэгт FaP.8-д харуулав. Мэс засал хийлгэсэн, суулгац тавиулсан эмэгтэйчүүдийн дийлэнх нь (харгалзан 61.7 болон 47.5 хувь) нэгдсэн эмнэлгээс үйлчилгээ авсан бол ерөндөг тавиулсан эмэгтэйчүүдийн 40.6 хувь нь өрх, сумын эмнэлэг, 28.1 хувь нь нэгдсэн эмнэлэг, 27.5 хувь нь хувийн эмнэлэгт хандсан байна. Тариа авдаг үндсэн эх үүсвэр нь сум, өрхийн эмнэлэг (85.1 хувь) бол эм болон бэлгэвчийг ихэнхдээ (харгалзан 52.6 болон 63.4 хувь) эмийн сангаас худалдан авч байна.

ЖСАХ-ийн талаарх мэдээлэлтэй сонголт буюу ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгсөн байдал

Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн зарим арга, хэрэгслийн хэрэглээ нь хэрэглэгчдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үүсгэх тохиолдол байдаг. Гиймээс эрүүл мэндийн ажилтан орчин үеийн аргын талаар хэрэглэгчтэй ярилцаж зөвлөгөө өгөхдөө сөрөг нөлөө болон асуудлуудын талаар мэдээлж, тухайн аргыг хэрэглэж байх үед сөрөг нөлөө эсвэл асуудал гарвал юу хийх талаар дэлгэрэнгүй зөвлөх нь чухал юм. Түүнчлэн арга тус бүрийн хувьд давуу болон сул талыг нь харьцуулан хэлж, хэрэглэгчид тохирох аргыг зөвлөх хэрэгтэй байдаг. Хүснэгт FaP.9-д судалгаанаас өмнөх 5 жилийн хугацаанд хамгийн сүүлд хэрэглэж байгаа орчин үеийн аргынхаа талаар эрүүл мэндийн ажилтнаас зөвлөгөө (сөрөг нөлөөний талаар мэдээлэл авсан эсэх, тухайн аргыг хэрэглэж байх үед сөрөг нөлөө эсвэл асуудал тохиолдвол юу хийх талаар болон бусад аргын талаарх зөвлөгөө авсан эсэх) авсан мэдээллийг харууллаа.

Жирэмсний эрт үеийн хяналтыг судалгааны тайланд 2 янзаар тооцож тусгасныг Хүснэгт MN.2-оос харж болно. Олон улсад мөрдөгдөж буй аргачлалаар жирэмсний эрт үеийн хамрагдалтыг жирэмсний 15 долоо хоногоор тооцдог бол МУ-д энэ үзүүлэлтийг 12 долоо хоногоор авч үзэж байна. Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн нийт эмэгтэйн 78.8 хувь нь жирэмсний эрт үедээ (жирэмсний эхний гурван сартайдаа), 15.9 хувь нь жирэмсний 4-5 сартайдаа, 4.5 хувь нь жирэмсний хожуу үедээ хяналтад (жирэмсний 6 ба түүнээс хойш сар) оржээ. Өсвөр насны (60.7 хувь), хөдөөгийн (72.1 хувь), боловсролгүй (65.5 хувь), өрхийн аж байдал нь доогуур (69.2 хувь), казах тэргүүлэгчтэй өрхийн (70.3 хувь) эмэгтэйчүүд хяналтад эрт үзүүлэх нь бага байна. Түүнчлэн, эдгээр эмэгтэйчүүд жирэмсний хяналтад ч цөөн удаа үзүүлсэн ажээ. Монгол Улсад мөрдөгдөж байгаа аргачлалаар жирэмсний эрт үеийн хяналтыг тодорхойлоход 78.8 хувь гарсан нь ОУ-хаас 2 орчим пунктээр бага байна.

Статистикийн дунджийг илэрхийлэх хэд хэдэн төрлийн аргууд байдгаас тус судалгаанд голч үзүүлэлтийг түлхүү ашигласан. Голч буюу медиан нь хэт ялгаатай (дунджаас хэт их эсвэл бага) ажиглалтуудын нөлөөнөөс ангид байдгаараа бусад төвийн үзүүлэлтүүдээсээ давуу талтай байдаг. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 50 хувь 2.1 сар ба түүнээс доош хугацаанд анх хяналтад үзүүлж байгаа нь НҮЭМС-2008 судалгааны үр дүнгээс (2.9 сар) сайжирсан үзүүлэлт юм. Төв суурин газраас алслагдсан байдал (хөдөө 2.7, сумын төв 2.6, аймгийн төв 2.1, Улаанбаатар 1.9 сар) жирэмсний хяналтад эрт ороход сөргөөр нөлөөлж байгаа бол эмэгтэйчүүдийн боловсролын түвшин (боловсролгүй 2.7, дээд 1.9 сар), өрхийн аж байдлын түвшин (доогуур 2.7, дээгүүр 1.9 сар) сайжрах нь эерэг нөлөөтэй байна.

Жирэмсний хяналтын үйлчилгээ, тусламж

Жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлсэн үйлчилгээний төрлийг Хүснэгт MN.3-д харуулав. Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 96.6 хувь нь жирэмсний хяналтад байхдаа цусны даралтаа хэмжүүлж байсан, 97.6 хувь нь шээсний, 97.7 хувь нь цусны, 95.4 хувь нь БЗДХ буюу үтрээний наацын, 89.9 хувь нь ХДХВ илрүүлэх шинжилгээ өгч, 97.2 хувь нь ЭХО-д харуулж, 98.5 хувь нь жингээ хэмжүүлсэн (хамгийн түгээмэл авдаг үйлчилгээ) байна. Харин 83.5 хувь нь тэмбүүгийн сорил тавиулж, 76.7 хувь нь цээжний зураг авахуулсан нь хамгийн бага авдаг үйлчилгээнд багтаж, түүний чанарт анхаарах шаардлагатайг харуулна. ДЭМБ-ийн зөвлөмжийн хэрэгжилтийг (жирэмсний хяналтын үеийн 3 төрлийн үйлчилгээг авсан - цусны даралтаа хэмжүүлж, шээс болон цусны ерөнхий шинжилгээ өгсөн) үнэлэхэд 94.7 хувь гарсан бол Монгол Улсад мөрдөгдөж байгаа жирэмсний хяналтын үед үзүүлэх ёстой 9 төрлийн үйлчилгээнээс бүгдийг нь авсан (цусны даралтаа хэмжүүлж, шээс болон цусны ерөнхий, БЗДХ буюу үтрээний наац, ДОХ-ын шинжилгээ өгч, жингээ хэмжүүлж, тэмбүүгийн сорил тавиулж, ЭХО-д харуулан цээжний зураг авахуулсан) хувь 65.5 гарлаа. Эмэгтэйчүүдийн шинж байдлаар нарийвчлан авч үзвэл тэмбүүгийн сорил тавиулж, цээжний зураг авахуулсан хувь Баруун

бүсийн (харгалзан 64.1, 42.0 хувь), боловсролгүй (харгалзан 73.9, 57.5 хувь) эмэгтэйчүүдийн дунд харьцангуй доогуур байна. Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс жирэмсний үйлчилгээ, тусламж авахад ихээхэн нөлөөтэй байгааг тус хүснэгтээс харж болохоор байна. Ялангуяа, казах тэргүүлэгчтэй өрхөд амьдардаг эмэгтэйчүүд жирэмсний хяналтын бүх төрлийн үйлчилгээнд тэр дундаа, тэмбүүгийн сорил, ДОХ-ын шинжилгээ болон цээжний зураг авахуулахад тун хангалтгүй хамрагдаж байна.

Жирэмсний хяналтын зөвлөгөө

Судалгааны асуулгад жирэмсний хяналтад үзүүлсэн эмэгтэйчүүдэд өгөх ёстой 18 төрлийн зөвлөгөөг багтаасан бөгөөд эрүүл мэндийн мэргэжилтнүүд дунджаар 12 төрлийн зөвлөгөөг эмэгтэйчүүдэд өгч байна (Хүснэгт MN.5). Жирэмсний хяналтын ядаж нэг төрлийн зөвлөгөөг судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд бараг бүгд буюу 96.4 хувь нь авсан бол бүх төрлийн зөвлөгөө авсан хувь 28.7 байна. Жирэмсний хяналтын бүх төрлийн зөвлөгөө авсан эмэгтэйчүүд Баруун, Төвийн бүс болон Улаанбаатарт улсын дунджаас бага байна. Түүнчлэн, нийслэл, аймгийн төвд бага байгаа нь эмнэлгийн ачаалалтай холбоотой байж болзошгүй юм. Өсвөр болон 20-34 насны, хяналтад хамгийн цөөн удаа үзүүлсэн, боловсролгүй, бага болон дээд боловсролтой, дээгүүр түвшний, казах тэргүүлэгчтэй өрхийн эмэгтэйчүүдийн дунд дээрх үзүүлэлт бага байна.

Эрүүл мэндийн мэргэжилтнүүд төмрийн бэлдмэл, фолийн хүчлийн талаарх зөвлөгөөг хамгийн түгээмэл (87.8 хувь) өгч байхад гэр бүл төлөвлөлтийн талаар хамгийн бага (49.7 хувь) ярилцжээ. Жирэмснийхээ явцыг олон удаа хянуулах тусмаа зөвлөгөө, үйлчилгээ авах нь нэмэгдэж байна. Хяналтын үеийн аль ч төрлийн зөвлөгөөг ажиглахад энэ хандлага тодорхой харагдана.

Жирэмснээ хянуулсан газар

Жирэмсэн эмэгтэйд эмнэлгийн тусламж үзүүлэх журмын дагуу хэвийн явцтай жирэмсэн эмэгтэй хот суурин газарт өрхийн, хөдөө, орон нутагт сумын их эмчийн хяналтад байна. Харин өртөмтгий жирэмсэн эмэгтэй эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн болон бусад мэргэжлийн эмчийн хавсарсан хяналтад байж төрнө. Жирэмсний хяналтад үзүүлэхдээ эмэгтэйчүүд үндсэндээ улсын эмнэлэг, тэр дундаа аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг (34.1 хувь) болон сумын/ өрхийн эмнэлэгт (74.5 хувь) хандаж байна. Сумын төв, хөдөө амьдардаг эмэгтэйчүүд аймгийн нэгдсэн эмнэлэг болон амаржих газар хянуулах нь бага бөгөөд сумынхаа эмнэлэгт ихэнхдээ хянуулж байна. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдэх, өрхийн аж байдлын түвшин сайжрах тутамд тэд илүү чанартай, төлбөртэй эмнэлэгт хянуулах хандлагатай (тусгай мэргэжлийн төв, нэгдсэн эмнэлэг болон хувийн эмнэлгээр үйлчлүүлсэн хувь нэмэгдэж байхад өрх, сумын эмнэлэгт хандсан нь буурч байна) байна (Хүснэгт MN.4). Жирэмсэн үедээ эмэгтэйчүүдийн хянуулахаар хандаж байгаа эмнэлгийн тоог сонирхоход дунджаар 1 эмнэлгээс үйлчилгээ авч байна. Энэ үзүүлэлт шинж байдлын үзүүлэлтүүдээр ялгаа бага ажээ.

Жирэмснээ хянуулахад тохиолдсон бэрхшээл

Жирэмсний хяналтад үзүүлэхэд тохиолдсон бэрхшээлийг Хүснэгт MN.6-д эмэгтэйн шинж байдлаар нь ангилж харуулав. Жирэмсний хяналтад орох үед эмэгтэйчүүдийн 82.7 хувь нь ямар нэгэн бэрхшээл тохиолдоогүй гэж хариулжээ. Харин бэрхшээл тохиолдсон эмэгтэйгээс учирсан хүндрэлийг тодруулахад эмнэлгийн ачаалал их (11.5 хувь), эмнэлгийн мэргэжилтний харьцаа муу (2.6 хувь) гэж дурдсан байна. Төв суурин газар болон Улаанбаатар хотод дээрх хувь хамгийн их байна.

Жирэмсний үеийн хүндрэл

Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 48.3 хувьд нь жирэмсний үеийн хүндрэл тохиолджээ (Хүснэгт MN.7). Тэдний 38.5 хувьд нь толгой өвдөж, эргэх, нүд бүрэлзэх, чих шуугих, даралт ихсэх шинж тэмдгийн аль нэг нь илэрсэн бол 9.6 хувьд нь ураг орчмын шингэн хугацаанаасаа өмнө гарах, 9.2 хувьд нь үтрээнээс цус гарах, 4.0 хувьд нь цусны даралт ихсэж байгаад татаж, ухаан алдах хүндрэл учирчээ.

Жирэмсний үеийн хавсарсан өвчинтэй байсан эсэхийг тодруулахад эмэгтэйчүүдийн 45.2 хувь нь "Тийм" гэж хариулсан байна (Хүснэгт MN.8). Эмэгтэйчүүдэд гол төлөв бөөр, давсаг (29.8 хувь) болон зүрхний өвчин (12.8 хувь) жирэмслэлттэй нь хавсарч тохиолдсон байна. Дээрх 2 үзүүлэлт өрхийн аж байдлын түвшин сайжрах тутам багасах хандлага ажиглагдлаа.

Төмрийн бэлдмэлийн хэрэглээ

ДЭМБ-ын зөвлөмжид эмэгтэй жирэмсэн нь тогтоогдсоноос хойш төрсний дараа 3 сар хүртлээ төмөр, фолийн хүчил агуулсан шахмал өдөр бүр нэг ширхгийг ууж, цус багадалтаас сэргийлэхээр заасан. Судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 83.0 хувь нь төмрийн бэлдмэл хэрэглэсэн бөгөөд дунджаар 63 хоног уужээ (Хүснэгт MN.9). Төмрийн бэлдмэлийн хэрэглээг НҮЭМС-2008 судалгааны дүнтэй (81.0 хувь) зэрэгцүүлэхэд төдийлөн нэмэгдээгүй байна. Баруун бүс, Улаанбаатар болон казах тэргүүлэгчтэй өрхөд амьдардаг, бага болон боловсролгүй эмэгтэйчүүдийн дунд төмрийн бэлдмэлийн хэрэглээ бага юм. Түүнчлэн, жирэмсний хяналтад үзүүлсэн тоо нэмэгдэхийн хэрээр бэлдмэлийн хэрэглээ, хэрэглэсэн дундаж хоног өсч байна.

Жирэмсэн эмэгтэйг хяналтдаа авсан эмч төмрийн бэлдмэлээр хангах журмын хэрэгжилтийг авч үзэхэд 2 эмэгтэй тутмын 1 нь өрх, сумын эмнэлгээсээ авсан бол 5 эмэгтэй тутмын 2 нь эмийн сангаас авчээ (Хүснэгт MN.10). Хүүхдээ тээж байхдаа төмрийн бэлдмэл хэрэглэсэн эмэгтэйчүүдийн дийлэнх нь (53.8 хувь) үнэгүй хангагдсан байна. Төмрийн бэлдмэлээр үнэгүй хангагдах нь төв суурин газраас хөдөө рүү чиглэхэд нэмэгдэж байгаа (байршлаараа 31.2 - 82.0 хувь) бол эмэгтэйчүүдийн боловсролын түвшин (80.2 - 40.6 хувь), өрхийн аж байдлын түвшин сайжрах тутам (82.6 - 25.8 хувь) буурч байна (Хүснэгт MN.11).

ТӨРӨХ ҮЕИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Эхийн эндэгдлийн дөрөвний гурав нь жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалж байна. Төрөлтийг сургагдсан эмнэлгийн мэргэжилтэн удирдах, эх барихын яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдал хангагдсан байх нь эх, нярай эсэн мэнд амаржихад нэн чухал. Мянганы хөгжлийн зорилт болон "Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглалын нэг зорилго нь эхчүүдийг төрөх үедээ эмнэлгийн мэргэжлийн ажилтны хяналтад байх боломжоор хангахыг баталгаажуулах явдал юм. Энэхүү зорилгын биелэлтийг эмнэлгийн мэргэшсэн ажилтны тусламжтай төрсөн эхчүүдийн хувь, эмнэлэг дэх төрөлтийн хувь гэсэн үзүүлэлтүүдээр хэмжиж байна.

Мэргэжлийн эмчийн тусламжтай төрсөн төрөлтийн талаарх мэдээллийг гаргахын тулд НҮТС-нд хэд хэдэн төрлийн асуултуудыг оруулсан. ОУБТС-ны аргачлалын дагуу мэргэжлийн эмч гэдэгт эх барих эмэгтэйчүүдийн эмч, бусад мэргэжлийн их эмч, өрх/ сумын эмч, эх баригч, бага эмч болон сувилагчийг багтаан үзсэн болно. Харин Монгол Улсад мөрдөгдөж байгаа журмаар мэргэжлийн эмчид бага эмч болон сувилагчаас бусад мэргэжилтэнг хамруулсан.

Мэргэжлийн эмчийн хяналтад төрсөн төрөлт

Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд нийт төрөлтийн 98.9 хувь нь (МУ-д мөрдөгдөж буй журмаар тооцоход 97.8 хувь) ур чадвар эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтний хяналтад явагджээ (Хүснэгт MN.12). Энэхүү үзүүлэлт хот, хөдөө, бүс болон эмэгтэйн насны хувьд ялгаагүй буюу нэгэн жигд байна. Доогуур түвшний аж байдалтай өрхийн болон боловсролгүй эмэгтэйчүүд эмнэлгийн мэргэжилтний хяналтад хүүхдээ төрүүлсэн хувь бусдынхаасаа арай бага байв. Ялгаа нь хэдийгээр анхаарал татахуйц биш боловч доогуур түвшний аж байдалтай өрхөд амьдарч байгаа болон боловсролгүй байгаа нь тухайн үйлчилгээний хүртээмжид тодорхой ялгаа үүсгэснийг анхаарахад илүүдэхгүй.

Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд нийт төрөлтийн 71.8 хувь нь эх баригч эмэгтэйчүүдийн эмчийн, 17.6 хувь нь эх баригчийн, 5.5 хувь нь бусад мэргэжлийн их эмчийн, 2.9 хувь нь өрх/ сумын эмчийн хяналтад төрсөн байна. Бүс нутаг болон хот, хөдөөгөөр зарим ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, эх баригч эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад хүүхдээ төрүүлсэн эхчүүдийн хувь Төвийн бүсэд хамгийн өндөр (84.0 хувь) байхад Баруун бүсэд хамгийн бага (54.1 хувь) байна. Мөн хотын эмэгтэйчүүдийн 75.5

хувь нь эх баригч эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад төрсөн байхад хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт 65.4 хувь байгаа юм.

Мэс заслын арга

ДЭМБ-аас мэс заслын аргаар төрсөн хүүхдийн хувийг нийт төрөлтийн 5-15 хувь байлгахыг зөвлөдөг боловч энэ үзүүлэлт манай орны хувьд харьцангуй өндөр буюу 23.4 хувь байна (Хүснэгт MN.12). Улаанбаатарт (27.9 хувь) энэ үзүүлэлт бусад бүстэй харьцуулахад хамгийн их байгаа бол нас ахих (11.6-36.5 хувь), эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдэх (20.1-28.0 хувь), өрхийн аж байдлын түвшин сайжрах (15.0-34.0 хувь) тутамд эмэгтэйчүүд кесар хагалгааг сонгож байна. Мөн хувийн эмнэлэгт явагдаж байгаа 5 төрөлт тутмын 2 нь мэс заслын аргаар үйлдэгдэж байгааг анхаарах шаардлагатай юм. Түүнээс гадна, дийлэнх эмэгтэйчүүд (нийт мэс заслын аргаарх төрөлт (23.4 хувь)-ийн 15.8 хувь)-ийн хувьд мэс заслын аргаар хүүхдээ төрүүлэх эсэх нь өвдөлт явагдаж эхлэхээс өмнө буюу төлөвлөгөөт хагалгаанд оржээ.

Эмнэлгийн төрөлт

Эмнэлгийн төрөлтийн хувийн жинг нэмэгдүүлэх нь эх, нярайн эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах нэг гол хүчин зүйл болдог. Төрөх үеийн эмнэлгийн тусламж, тоног төхөөрөмж, эрүүл ахуйн орчин нь эх болон нярайн өвчлөлт, нас баралтын шалтгаан, халдварын эрсдэлийг бууруулдаг. Хүснэгт MN.13-т судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийг хүүхэд төрүүлсэн газар болон хүн ам, өрхийн шинж байдлын сонгосон үзүүлэлтээр харуулав. Нийт төрөлтийн 98.4 хувь нь эмнэлгийн байгууллагад төрснөөс улсын эмнэлэгт 95.6 хувь, хувийн эмнэлэгт 2.8 хувь нь бүртгэгдсэн байна. Нийт төрөлтийн 0.5 хувь нь гэрийн төрөлт бол 1.1 хувь нь бусад (ихэнх нь гадаадад төрсөн байв) гэж хариулжээ. Бүс нутаг, хот, хөдөөгийн хувьд энэ үзүүлэлт ялгаа бага байна. Харин эмэгтэйчүүдийн боловсролын түвшин ахих, өрхийн аж байдал сайжрах тусмаа хувийн эмнэлэгт хүүхдээ төрүүлэх хандлага нь нэмэгджээ. Гэрийн төрөлт хөдөөд өндөр (1.3 хувь) хэвээр байна. Мөн Баруун (1.3 хувь), Хангай (1.1 хувь), Зүүн (1.1 хувь) бүсэд гэрийн төрөлт улсын дунджаас дээгүүр байна.

Төрөх үеийн тусламж үйлчилгээ ба хүндрэл

Жирэмсний үеийн тусламж үйлчилгээнээс гадна эх, нярайн эндэгдэлд нөлөөлдөг чухал хүчин зүйл нь төрөх үеийн тусламж үйлчилгээ байдгийг дээр дурдсан. Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд мэс заслын бус аргаар хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 60.3 хувьд нь төрөх үеийн хүндрэл тохиолдоход тусламж үйлчилгээ авсан байна (Хүснэгт MN.14). Хүндрэл тохиолдож, тусламж үйлчилгээ авсан хувь Төвийн бүс болон нийслэл, аймгийн төвд харьцангуй өндөр бөгөөд ахимаг насны (35-49 нас) эмэгтэйчүүдийн дунд хамгийн түгээмэл тохиолдсон бол казах тэргүүлэгчтэй өрхөд хамгийн бага байна. Тохиолдсон хүндрэлийг авч үзвэл халуурах (4.8 хувь), хэвийн хэмжээнээс илүү цус алдах (8.0 хувь) болон цусны даралт ихсэж байгаад татаж, ухаан алдах (1.9 хувь) хүндрэл учирчээ. Харин төрөх үед эхэд үзүүлсэн тусламж, үйлчилгээг нарийвчилж харвал хамгийн түгээмэл үзүүлдэг зүйл нь төрөлт эрчимжүүлэх дусал (46.9 хувь) бол дараа нь төрөлт сэдээх эм (мизопростол) хэлэн доор нь тавих (10.2 хувь) үйлчилгээ орж байна. Хүүхдийг багажаар татаж авах явдал төдийлөн түгээмэл биш (хамгийн бага буюу 3.0 хувь) байна.

Хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд төрөх үеийн хүндрэл хотынхтой харьцуулахад илүү тохиолдож байхад (ямар нэг хүндрэл тохиолдсон хувь хотод 10.7, хөдөөд 16.3 хувь) тэдэнд үзүүлж буй зарим нэг тусламж үйлчилгээ хангалтгүй байна (төрөлт эрчимжүүлэх дусал хийлгэх үйлчилгээ хөдөөд бага байна). Түүнчлэн, өрхийн тэргүүлэгч нь казах эмэгтэйчүүдэд хамгийн их хүндрэл тохиолдож байхад хамгийн түгээмэл үзүүлж буй үйлчилгээ болох төрөлт эрчимжүүлэх дуслыг тэд хамгийн бага (28.7 хувь) хэрэглэжээ. Хэвийн хэмжээнээс илүү цус алдах цусны даралт ихсэж байгаад татаж, ухаан алдах явдал ахимаг насны эмэгтэйчүүдэд илүү тохиолдож байгаа бол өндөр боловсролтой эмэгтэйчүүдийн дунд төрөх үеийн хүндрэл учрах нь бага байна. Нөгөө талаар, өрхийн аж байдлын түвшин сайжрахад төрөх үеийн хүндрэл бага тохиолдож, төрөлтийг дэмжих тусламж үйлчилгээ авах явдал нэмэгдэх хандлагатай

юм.

Хэвийн явцтай төрөлт, эрүүл эхчүүдийн дунд төрөх үеийн хүндрэл бага тохиолдож, эмнэлгийн мэргэжилтнээс харьцангуй бага тусламж үйлчилгээ авч байгааг Хүснэгт MN.15-аас харж болно. Тодруулбал, хүүхэд нь хугацаандаа, дундаж жинтэй төрсөн эмэгтэйчүүдийг бусадтай нь харьцуулахад төрөх үеийн хүндрэлд бага өртөж байна. Нөгөө талаар, жирэмсэн үедээ харьцангуй эрүүл байсан эмэгтэйчүүдийн дунд хүндрэл цөөн тохиолджээ.

Хүүхэд төрсөн даруйдаа ямар нэгэн хүндрэл эсвэл бүтэлтгүй бол уйлдаг. Хэрвээ хүүхэд уйлаагүй буюу бүтэлтэй төрсөн тохиолдолд эмнэлгийн мэргэжилтнүүд яаралтай арга хэмжээ авч, эмчилгээ хийх шаардлагатай. Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд төрсөн хүүхдүүдийн 9.4 хувь нь төрсөн даруй уйлаагүй буюу бүтэлтэй төржээ (Хүснэгт MN.16). Тэдний 62.7 хувьд яаралтай арга хэмжээ авч, эмчилгээ хийсэн байв. Төрсөн даруй уйлаагүй хүүхдийн хувь 15-24 насны болон хөдөө амьдардаг эмэгтэйчүүдийн дунд илүү тохиолджээ.

Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжид заагдсан зарим үйлчилгээний талаар судалгааны асуулгад тусгасныг нэгтгэж, Хүснэгт MN.17-д харууллаа. Нярайн төрмөгц дулаан байлгах асаргааны аль нэг төрлийн үйлчилгээг нийт төрөлтийн 94.8 хувьд үзүүлжээ. Үүнээс бүх эх, нярайд заавал үзүүлэх ёстой малгай өмсгөх, арьс арьсаар шүргэлцүүлэх буюу эхийн хэвлий дээр нүцгэн хэвтүүлэх тусламжийг авч үзвэл тус тус 85.6, 73.8 хувьтай байна. Харин нярайн 64.6 хувийг нь дулаацуулах ширээнд байрлуулжээ. Казах тэргүүлэгчтэй өрхөд амьдардаг эмэгтэйчүүдийн дунд дулаан байлгах асаргаа бусад эмэгтэйчүүдтэй харьцуулахад бага хийгдсэн нь анхаарал татаж байна.

Төрсний дараах эх, хүүхдийн хяналт

Төрөх болон төрсний дараах богинохон үе бол эх, хүүхдийн эрүүл мэнд, амь насанд онцгой нөлөөтэй мөч байдаг. Дэлхий дээр жил бүр ойролцоогоор 3 сая хүүхэд төрсний дараах сарын хугацаанд эндэж⁴, тэдний дийлэнх нь эхний 1, 2 хоногт тохиолдож байна⁵. Эндсэн эхийн олонх нь мөн л энэ хугацаанд бүртгэгдэж байна⁶.

Өмнө дурдсанчлан судалгааны асуулгад төрсний дараах эх, хүүхдийн хяналтыг бодитойгоор гаргах зорилготой асуултуудыг анх удаа цогц байдлаар нь тусгасан. Тиймээс төрсний дараах үзлэг, хяналт, хяналтын тоо, хугацаа зэргийг дэлгэрүүлэн судлах боломж бүрдсэн.

Тус судалгаанд төрсний дараах үзлэг, хяналтыг 3 төрлөөр тодорхойлсон болно. Нэгдүгээрт, эх, нярай эсэн мэнд амаржсаны дараа эмнэлэгт байх эсвэл гэрийн төрөлтийн тухайд (манай орны тухайд маш бага тохиолдсон) эх барьсан буюу төрөлтийг удирдсан хүн явахаас өмнөх хугацааны үзлэгийг эрүүл мэндийн үзлэг гэж тодорхойлов. Харин эх, нярай гэртээ гарсан эсвэл гэрийн төрөлтийн хувьд төрөлтийг удирдсан хүн явсны дараах эрүүл мэндийн үзлэгийг гэрийн эргэлт буюу төрсний дараах тусгайлсан үзлэг гэж үзсэн. Эцэст нь, эрүүл мэндийн үзлэг болон төрсний дараах 2 хоногийн доторх тусгайлсан үзлэгийг хамтатган төрсний дараах хяналт гэж тодорхойллоо.

Төрсний дараа эх, нярайн эмнэлэгт байсан хугацааг нийгэм, хүн ам зүйн үзүүлэлтээр нь ангилж, Хүснэгт MN.18-т үзүүлэв. Судалгааны дүнгээс харахад сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн хоёр эмэгтэй тутмын нэг нь төрснийхөө дараа 1-2 өдрийн хугацаанд эмнэлгийн хяналтад байжээ. Нийт эмэгтэйчүүдийн 99.4 хувь нь төрснийхөө дараа эмнэлэгт 12 ба түүнээс дээш цагийн хугацаанд байв. Хот суурин газар тэр дундаа, нийслэлд амаржсан эхчүүдийг олон хоногоор эмнэлэгт байлгах боломж муу (3 ба түүнээс олон өдөр эмнэлэгт байсан хувь 37.3) бол сумын төв, хөдөөд тус үзүүлэлт хамгийн өндөр байна. Түүнчлэн, залуу (40.0 хувь), мэс заслын бус аргаар төрсөн (36.8 хувь) эмэгтэйчүүд цөөн хоногоор эмнэлэгт сувилуулжээ.

⁴ UN Interagency Group for Child Mortality Estimation, 2013. Levels and Trends in Child Mortality: Report 2013

⁵ Lawn JE, Cousens S, Zupan J. 4 million neonatal deaths: When? Where? Why? Lancet 2005; 365:891–900.

⁶ WHO, UNICEF, UNFPA, The World Bank. Trends in Maternal Mortality: 1990-2010. Geneva: World Health Organization 2012.

Эх, нярайг эсэн мэнд тэнхрүүлэх хөтөлбөрүүдэд төрсний дараах хяналтын ач холбогдлыг онцгойлон дурдаад төрсөн бүх эх, хүүхдийг амаржсанаас хойших 2 хоногийн дотор багтаан эрүүл мэндийн үзлэгт хамруулах зөвлөмжийг өгсөн. Төрсний дараа нярайг эмнэлэгт байхад эсвэл гэрийн төрөлтийн тухайд эх барьсан хүн явахаасаа өмнө хүүхдийн эрүүл мэндийг үзсэн тохиолдол судалгааны өмнөх 2 жилийн нийт амьд төрөлтийн 98.5 хувийг эзэлж байна (Хүснэгт MN.19). Энэ үзүүлэлтийг шинж байдлаар нь ангилж үзэхэд мэдэгдэхүйц ялгаа бага байгаа боловч хөдөө амьдардаг, залуу насны, боловсрол бага, доогуур аж байдалтай болон казах тэргүүлэгчтэй өрхийн эмэгтэйчүүдийн дунд бага байх хандлагатай байна. Төрсний дараах тусгайлсан үзлэгийг хугацаагаар нь харвал ихэнх нярайг (51.4 хувь) эхний 7 хоног өнгөрсний дараа, 4 хүүхэд тутмын 1-ийг 3-6 өдрийн дотор эмнэлгийн мэргэжилтэн үзсэн бол 14.3 хувьд үзлэг огт хийгдээгүй байна. Хүүхдийг тусгайлсан үзлэгт хамруулах нь Баруун бүс (30.8 хувь), хөдөө (24.2 хувь), боловсрол бага (20.8-20.7 хувь), доогуур түвшний аж байдалтай (24.0-19.5 хувь) өрхүүдийн дунд бага байна. Хамгийн анхаарал татсан зүйл нь казах тэргүүлэгч өрхүүдэд энэ үзүүлэлт хамгийн бага буюу улсын дунджаас бараг 4 дахин их гарчээ. Төрсний дараах хяналт буюу эхний 2 хоногийн доторх хүүхдийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал 98.6 хувь байна. Шинж байдлаар ажиглагдсан хандлага өмнөх үзүүлэлтүүдтэй адил байна.

Хүүхдийн төрсний дараах анхны тусгайлсан үзлэгт хамрагдсан газар болон үйлчилгээ үзүүлсэн хүний талаарх мэдээллийг Хүснэгт MN.21-т үзүүлээ. Эмнэлгийн мэргэжилтнүүд сүүлийн 2 жилд төрсөн нийт нярайн 31.8 хувийг төрснөөс хойших 7 хоногийн дотор үзсэн бөгөөд (Хүснэгт MN.19) тэдгээр 5 нярай тутмын 4-ийнх эрүүл мэндийг гэрт нь очиж үзсэн нь тун сайшаалтай юм. Үлдсэн 20.1 хувь нь улсын эмнэлэгт, 0.7 хувь нь хувийн эмнэлэгт очиж үзүүлжээ. Гэрт нь очиж үзэх Баруун бүс, хөдөө амьдардаг эхчүүдийн дунд бага бол өрхийн аж байдал сайжрах тутам нэмэгдэх хандлагатай байна. Сумдын эмч нар хөдөө амьдардаг харьяаныхаа эхчүүдийг үзэхийн тулд унаа тэрэг, цаг заваа зохицуулах гээд багагүй хүндрэлтэй тулгарч, тэр бүр тогтмол очиж үзэх боломжгүй байдаг. Тиймээс хөдөөгийн эхчүүд өөрсдөө сумынхаа эмнэлэгт очиж үзүүлдгийг судалгааны дүн гэрчилнэ (улсын эмнэлэгт үзүүлсэн хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувь хамгийн их буюу 35.8 хувь байна). Тусгайлсан үзлэг хийсэн хүмүүсийг тодруулж авч үзвэл 93.4 хувь нь эх барих эмэгтэйчүүдийн эмч/ бусад мэргэжлийн их эмч/ өрх/ сумын эмч/ сувилагч байсан бол 5.1 хувь нь эх баригч, үлдсэн 1.1 хувь нь бага эмч нар ажээ. Хөдөө бага эмч, эх баригчдаа хүүхдээ үзүүлэх явдал түгээмэл бол настай, боловсролтой, дундаж, түүнээс дээгүүр түвшний аж байдалтай эмэгтэйчүүд илүү эх барих эмэгтэйчүүдийн эмч/ бусад мэргэжлийн их эмч/ өрх/ сумын эмч/ сувилагчид үзүүлжээ.

Хүснэгт MN.19 болон Хүснэгт MN.21-т төрсний дараах хүүхдийн хяналттай холбоотой үзүүлэлтүүдийг харуулсан бол Хүснэгт MN.22, Хүснэгт MN.23-д эхийн хяналтын талаар авч үзлээ. Төрсний дараа эхийг эмнэлэгт байхад эсвэл гэрийн төрөлтийн тухайд эх барьсан хүн явахаасаа өмнө эхийн эрүүл мэндийг үзсэн тохиолдол нийт амьд төрөлтийн 95.2 хувь буюу хүүхдийнхээс 3.3 нэгжээр бага байна. Энэ нь зарим тохиолдолд хүүхдийг үзээд эхийг нь үлдээсэнтэй холбоотой. Сонгосон үзүүлэлтээрх ялгаа харьцангуй бага хэдий ч мэс заслын бус төрөлт, боловсролгүй, доогуур аж байдалтай эмэгтэйчүүдийн дунд дээрх үзүүлэлт бага байна. Судалгааны үр дүнгээс анхаарахуйц зүйл ажиглагдсан нь төрсний дараах тусгайлсан үзлэгт хүүхдийг хамруулах нь сайн байсан (83.2 хувь) бол эхийн хувьд дөнгөж 48.4 хувь гарав. Энэ нь эмнэлгээс гарснаас хойш эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн эхэд тавих анхаарал эрс суларч байгааг илтгэнэ. Төрсний дараах эхийн хяналт ч мөн хүүхдийнхээс бага буюу 95.4 хувь бөгөөд шинж байдлаар ялгаа бага байна.

Төрсний дараа 7 хоногийн доторх эхийн тусгайлсан үзлэгийг гол төлөв эрүүл мэндийн мэргэжилтнүүд гэрт (84.7 хувь) нь анх очиж хийж байна. Энэ үзүүлэлт гэрт нь очиж хүүхдийг үзсэн хувиас 5.8 нэгжээр илүү гарчээ. Анхаарал татсан нэг зүйл нь мэс заслын аргаар төрсөн эмэгтэйчүүд өөрөөрөө төрсөнтэй харьцуулахад гэртээ үйлчилгээ авах нь бага юм. Хүүхдийнхтэй нэгэн адил эх барих эмэгтэйчүүдийн эмч/ бусад мэргэжлийн их эмч/ өрх/ сумын эмч/ сувилагч нар үзлэгийг голчлон (94.4 хувь) хийж байна.

Төрсний дараах хяналтыг эх, хүүхдээр хамтатгасан байдлаар Хүснэгт MN.24-д үзүүлэв. Эндээс ажиглахад эх, хүүхдийн аль нь ч төрсний дараах хяналтад хамрагдаагүй хувь 0.8 байгаа бол хоёуланг нь хянасан хувь 94.1 байна. Харин зөвхөн эхийг нь хянасан хувь 0.5 бол хүүхдийг ганцааранг нь хянасан хувь 3.8 байна. Төрсний дараах хяналт огт хийгдээгүй хувь Баруун бүсэд (1.9 хувь), хөдөөд (1.6 хувь), боловсролгүй (2.4 хувь), доогуур аж байдалтай (1.5 хувь), казах тэргүүлэгчтэй өрхийн эмэгтэйчүүдийн

дунд их байна.

Төрсний дараах хяналтын үзлэгийн үеэр эхэд өгч буй зөвлөгөөг Хүснэгт MN.20 -д харуулав. Гэр бүл төлөвлөлт (46.9 хувь), бэлгийн замаар дамжих халдварын (45.4 хувь) талаарх зөвлөгөөг эмэгтэйчүүдэд бага өгдөг ажээ. Харин хөхөөр хооллолт (82.9 хувь) болон нярайн асаргааны (85.2 хувь) талаарх зөвлөгөөг эрүүл мэндийн мэргэжилтнүүд хамгийн түгээмэл өгчээ. Дээрх 2 төрлийн зөвлөгөө хамгийн их хэрэгтэй байж болох 20-иос доош насны залуу эхчүүд бусад насныхантай харьцуулахад харин ч бага авсан нь анхаарал татаж байна. Энэ төрлийн зөвлөгөө авсан эмэгтэйчүүд казах тэргүүлэгчтэй өрхүүдийн дунд цөөн юм.

УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДРЫН ҮЗЛЭГ

Монгол Улсад умайн хүзүүний болон хөхний хорт хавдрыг эрт үед нь илрүүлж оношлох чиглэлээр үзлэг шинжилгээ, ухуулга сурталчилгааны ажил хийгдээд багагүй хугацаа өнгөрч байна. 2007-2008 онд хэрэгжсэн "Эрүүл монгол" хүн хөтөлбөрийн хүрээнд умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ багагүй хийгдсэн ч эмэгтэйчүүдийн энэ талаарх мэдлэг сайн биш, эрт илрүүлэлтийн хувь бага байсаар байна. Тиймээс "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" үндэсний 4 дэх хөтөлбөрт "умайн хүзүүний болон хөхний хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх тандалтыг үндэсний хэмжээнд хийх, өсвөр насны охидыг умайн хүзүүний хавдраас сэргийлэх, хүний папилома вирусийн халдвараас сэргийлэх дархлаажуулалтад дэс дараатай хамруулах" талаар тусдаа заалт оруулсан нь тус судалгаанд умайн хүзүүний хорт хавдрын талаарх модулийг оруулах үндэслэл болсон.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 83.0 хувь нь умайн хүзүүний хорт хавдрын талаар мэдлэгтэй буюу энэ талаар сонсож, уншсан байв (Хүснэгт MN.25). Мэдлэгтэй 4 эмэгтэй тутмын 1 умайн хүзүүний хорт хавдрын талаар сайн мэднэ гэж хариулсан нь бага үзүүлэлт юм. Умайн хүзүүний хорт хавдрын талаарх мэдлэг хөдөөд (79.1 хувь), тэр дундаа Баруун бүсэд (75.6 хувь), залуу насны (58.5-72.6 хувь), хүүхэдгүй (67.4 хувь), огт гэрлээгүй (67.7 хувь) эмэгтэйчүүдийн дунд бага, мэдлэгийн түвшин сул байна (сайн мэднэ гэж хариулсан хувь хөдөөд 20.8, 15-24 насныхны дунд 8.4-14.2, огт гэрлээгүй эмэгтэйчүүдэд 13.3 хувь буюу хамгийн бага байна). Түүнчлэн эмэгтэйн боловсролын түвшин дээшилж, өрхийн аж байдлын түвшин сайжрах тутам мэдлэгтэй эмэгтэйчүүд нэмэгдэх хандлагатай байна.

Умайн хүзүүний хорт хавдрын талаар мэдлэгтэй эмэгтэйчүүдийн 41.7 хувь нь эрт илрүүлэх үзлэгт хамрагдаж байжээ (Хүснэгт MN.26). Энэ дүн НҮЭМС-2008 судалгаагаар дөнгөж 29.7 хувьтай байсан нь сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ багагүй үр дүнд хүрснийг илтгэнэ. Шинж байдлын үзүүлэлтүүдээр авч үзвэл үзлэг хийлгэсэн эмэгтэйчүүдийн хувь хот, Улаанбаатарт амьдардаг, залуу насны болон огт гэрлээгүй эмэгтэйчүүдийн дунд бага байна. Үзлэг хийлгэсэн эмэгтэйчүүдийн 64.9 хувь нь сум, өрхийнхөө эмнэлэгт, 28.6 хувь нь аймаг, дүүргийнхээ нэгдсэн эмнэлэгт, 6.3 хувь нь тусгай мэргэжлийн төв буюу Хавдар судлалын үндэсний төвд, үлдсэн 0.3 хувь нь амаржих газруудад эрт илрүүлэх үзлэг хийлгэжээ. Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийг сум, өрхийн эмнэлгээр дамжуулан 30-аас дээш насныхныг хамруулж хийж байгаа нь эмэгтэйн насны бүлгээр гарсан үр дүнгээс тодорхой харагдаж байна. Тухайлбал, 30-49 насны эмэгтэйчүүдийн дунд үзлэг хамгийн өндөр буюу 58.8 хувь бол 15-29 насныхны хувь 4.6-17.5 хувь байна. Түүнчлэн, дараагийн ажиглагдсан онцлог зүйл нь хөдөөгийн эмэгтэйчүүдийн (47.3 хувь) дунд үзлэгийн хувь хотынхтой (39.2 хувь) харьцуулахад өндөр байна.

ДЭМБ-ын зөвлөснөөр бэлгийн харьцаанд орсон 25-49 насны эмэгтэй 3 жил тутам умайн хүзүүний хорт хавдар илрүүлэх үзлэг хийлгэх шаардлагатай байдаг. Үзлэг хийлгэж байсан эмэгтэйчүүдээс хамгийн сүүлийн үзлэгээс хойших хугацааг тодруулахад 64.0 хувь нь судалгааны өмнөх жилийн хугацаанд, 25.7 хувь нь 12-23 сарын өмнө үзлэгт хамрагджээ (Хүснэгт MN.27). Өөрөөр хэлбэл, үзлэг хийлгэж байсан 10 эмэгтэй тутмын 9 нь сүүлийн хоёр жилийн хугацаанд үзлэг шинжилгээ хийлгэж чаджээ.

Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэг шинжилгээ хийлгэх явдал нэмэгдсэнд шинжилгээ хийх шаардлагагүй гэх ташаа үзэл хандлагыг өөрчилж чадсан явдал эергээр нөлөөлөв (Хүснэгт MN.28). НҮЭМС-2008 судалгаагаар үзлэгт хамрагдаагүй эмэгтэйчүүдийн 56.1 хувь дээрх шалтгаанаар үзлэг хийлгээгүйгээ тайлбарлаж байсан бол энэ удаад 28.2 хувь болтлоо буурчээ. Харин 3 эмэгтэй бүрийн 1 нь нас тохиороогүй гэж хариулсан байна. Ялангуяа, үзлэг шинжилгээнд хамрагдвал зохих 30-аас дээш насныхны дунд ийм үзэл бодол багагүй байгаа (27.6 хувь) нь анхаарал татаж байна.

Хүснэгт МН.1: Жирэмсний хяналтад хамрагдалт

Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйдүүдийн хувь, жирэмснийг хянасан хүнээр, Монгол Улс, 2013 он

	Жирэмснийг хянасан хүн ¹										Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн эмэгтэйдүүдийн тоо		
	Эх барих эмэгтэйдүүдийн эмч	Бусад мэргэжлийн их эмч	Өрх/сумын эмч	Эх баригч	Бага эмч	Сувилагч	Бариагч засалч	Бусад/ харуулаагүй	Хяналтад ороогүй	Дүн		Ур чадвар эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтний хяналтад байсан ^{1, b}	Ур чадвар эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтний хяналтад байсан ^{2, c}
Бүгд	35.8	4.1	54.7	3.4	0.6	0.1	0.1	0.8	0.4	100.0	98.7	98.0	2389
Бүс													
Баруун	19.3	3.1	68.3	5.7	1.0	0.7	0.0	0.9	0.9	100.0	98.2	96.5	336
Хангай	26.6	2.3	63.6	5.4	1.5	0.0	0.0	0.2	0.3	100.0	99.4	97.9	470
Төв	44.4	4.1	46.9	4.3	0.0	0.0	0.0	0.0	0.4	100.0	99.6	99.6	397
Зүүн	35.0	3.5	53.9	5.7	0.9	0.3	0.0	0.7	0.0	100.0	99.3	98.1	160
Улаанбаатар	42.3	5.3	49.4	1.0	0.3	0.0	0.1	1.4	0.3	100.0	98.2	97.9	1026
Хот, хөдөө													
Хот	39.9	4.4	52.8	1.1	0.4	0.0	0.1	1.0	0.4	100.0	98.6	98.2	1519
Хөдөө	28.7	3.4	58.2	7.4	1.0	0.3	0.0	0.5	0.5	100.0	99.1	97.7	870
Байршил													
Нийслэл	42.3	5.3	49.4	1.0	0.3	0.0	0.1	1.4	0.3	100.0	98.2	97.9	1026
Аймгийн төв	35.0	2.7	59.8	1.3	0.6	0.0	0.0	0.2	0.5	100.0	99.3	98.7	493
Сумын төв	35.2	4.6	52.6	5.9	0.7	0.2	0.0	0.7	0.0	100.0	99.3	98.4	246
Хөдөө	26.2	2.9	60.4	8.0	1.1	0.4	0.0	0.4	0.6	100.0	98.9	97.4	624
Эхийн хүүхдээ төрүүлэх үеийн нас													
15-19	41.5	6.0	49.6	1.3	0.0	0.5	0.0	1.0	0.0	100.0	99.0	98.5	108
20-24	30.7	3.9	59.3	3.8	0.7	0.0	0.0	1.0	0.5	100.0	98.5	97.8	652
25-29	33.1	3.5	57.5	4.2	0.7	0.0	0.0	0.5	0.5	100.0	99.0	98.3	705
30-34	39.5	4.4	52.5	2.6	0.1	0.2	0.0	0.6	0.2	100.0	99.2	98.9	538
35-39	44.3	4.8	45.1	1.9	1.6	0.4	0.0	1.7	0.3	100.0	98.1	96.1	301
40-44	38.4	2.9	50.3	5.9	0.0	0.0	1.5	0.0	0.9	100.0	97.6	97.6	83
45-49	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	2
Боловсрол													
Боловсролгүй	21.4	3.1	68.2	4.1	0.7	0.8	0.0	0.8	0.9	100.0	98.3	96.8	132
Бага	26.9	2.6	59.6	5.4	2.3	0.7	0.0	0.7	1.8	100.0	97.5	94.5	159
Суурь	27.7	3.6	60.7	6.4	0.5	0.0	0.0	0.2	1.0	100.0	98.8	98.3	309
Бүрэн дүнд	35.7	3.4	56.6	2.6	0.4	0.0	0.2	0.8	0.2	100.0	98.8	98.4	616
Техникийн болон тусгай мэргэжлийн дүнд	42.6	5.6	47.9	2.1	0.3	0.3	0.0	0.6	0.5	100.0	98.9	98.3	180
Дээд	40.5	4.7	50.4	2.7	0.5	0.0	0.0	1.1	0.0	100.0	98.9	98.4	994
Өрхийн аж байдалын түвшин													
Доогуур	27.0	2.6	62.2	5.8	1.2	0.6	0.0	0.3	0.4	100.0	99.3	97.5	509
Дунджаас доогуур	29.0	3.6	60.4	4.2	0.8	0.0	0.0	0.9	1.0	100.0	98.1	97.2	452
Дундаж	36.6	4.0	53.6	3.9	0.5	0.0	0.0	0.7	0.6	100.0	98.6	98.1	476
Дунджаас дээгүүр	37.0	7.6	53.2	1.4	0.0	0.0	0.3	0.6	0.0	100.0	99.1	99.1	448
Дээгүүр	49.2	2.8	44.7	1.4	0.4	0.0	0.0	1.5	0.0	100.0	98.5	98.2	504
Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа*													
Халх	37.4	4.2	53.5	3.1	0.5	0.1	0.1	0.9	0.3	100.0	98.8	98.1	1916
Казах	17.4	1.9	75.5	0.8	0.0	0.0	0.0	1.0	3.5	100.0	95.5	95.5	92
Бусад	32.8	4.0	56.1	5.7	0.6	0.3	0.0	0.6	0.0	100.0	99.4	98.6	372

¹ НУТС-ны үзүүлэлт 5.5а; МХЗ-ын үзүүлэлт 5.5 - Жирэмсний хяналтад хамрагдалт

² НУТС-ны үзүүлэлт CSI6.1 - Жирэмсний хяналтад хамрагдалт (МУ-д мөрдөгдөж буй аргачлалтын дагуу тооцсон)

* "Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа" нь харуулагдаагүй 9 ажилтат (жингэлтэй)-ыг харуулаагүй.

^a Жирэмсний хяналтад орохдоо нэгдсэн олон хүнд үзүүлсэн бол асуултын хамгийн эхэнд бичигдсэн харуулгыг үндсэн харуулгаар авсан болно.

^b Ур чадвар эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтэнд бариагч/ засалчаас бусад эрүүл мэндийн мэргэжилтэнг хамруулсан.

^c Ур чадвар эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтэнд бага эмч, сувилагч болон бариагч/ засалчаас бусад эрүүл мэндийн мэргэжилтэнг хамруулсан.

Хүсэгт МН.2: Жирэмсний хяналтад үзүүлсэн тоо, анх үзүүлэх үеийн жирэмсний хугацаа

Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйдүүдийн хувь, жирэмсний хяналтад үзүүлсэн тоо, анх үзүүлэх үеийн жирэмсний хугацаагаар, Монгол Улс, 2013 он	Эмэгтэйдүүдийн хувь, хяналтад үзүүлсэн тоо				Жирэмсний хяналтад үзүүлсэн тоо				Эмэгтэйдүүдийн хувь, хяналтад анх үзүүлэх үеийн жирэмсний хугацаагаар				Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн, жирэмсэн үедээ дор хаяж 1 удаа хянуулсан эмэгтэйдүүдийн тоо		
	Хяналтад ороогүй удаа	1 удаа	2 удаа	3 удаа	Хяналтад ороогүй удаа	Дүн мэдэхгүй	Дүн мэдэхгүй	Дүн мэдэхгүй	Хяналтад ороогүй удаа	Эхний 3 сар	4-5 сар	6-7 сар	8 ба түүнээс дээш сар	Хяналтад анх үзүүлэх үеийн жирэмсний хугацаа (гольч сар) ¹	Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн, жирэмсэн үедээ дор хаяж 1 удаа хянуулсан эмэгтэйдүүдийн тоо
Бүтд	0.4	0.6	2.1	4.5	89.6	2.8	100.0	75.1	0.4	78.8	15.9	3.6	0.9	2389	2371
Бүс															
Баруун	1.3	1.3	2.9	10.7	82.4	1.4	100.0	58.4	0.9	67.1	21.6	6.5	2.5	336	329
Хангай	0.3	0.6	3.0	5.7	87.7	2.6	100.0	68.5	0.3	75.6	19.5	3.9	0.7	470	469
Төв	0.4	1.1	1.9	3.3	88.8	4.5	100.0	74.6	0.4	79.3	14.5	4.1	1.6	397	395
Зүүн	0.0	0.0	0.9	2.8	95.9	0.3	100.0	82.3	0.0	76.0	21.2	1.6	0.9	160	160
Улаанбаатар	0.3	0.3	1.7	2.5	92.1	3.1	100.0	82.7	0.3	84.4	12.1	2.5	0.3	1026	1019
Хот, хөдөө															
Хот	0.4	0.2	1.8	2.8	92.0	2.9	100.0	80.2	0.4	82.7	13.6	2.8	0.4	1519	1510
Хөдөө	0.6	1.3	2.7	7.4	85.4	2.7	100.0	66.3	0.5	72.1	20.0	4.9	1.9	870	862
Байршил															
Нийслэл	0.3	0.3	1.7	2.5	92.1	3.1	100.0	82.7	0.3	84.4	12.1	2.5	0.3	1026	1019
Аймгийн төв	0.5	0.1	2.0	3.3	91.7	2.4	100.0	75.0	0.5	79.0	16.5	3.2	0.6	493	491
Сумын төв	0.5	1.7	2.9	3.9	88.7	2.3	100.0	72.4	0.0	72.9	19.2	5.5	1.9	246	245
Хөдөө	0.6	1.1	2.6	8.7	84.1	2.9	100.0	63.8	0.6	71.9	20.4	4.7	1.9	624	617
Эхний хүүхдээ төрүүлэх үеийн нас															
15-19	0.0	1.7	7.4	7.2	80.9	2.8	100.0	51.5	0.0	60.7	30.7	7.4	1.2	108	108
20-24	0.5	0.7	2.8	4.8	88.8	2.4	100.0	74.1	0.5	78.8	15.2	4.5	1.0	652	648
25-29	0.7	0.5	2.2	4.4	88.9	3.4	100.0	74.6	0.5	78.6	16.5	2.8	1.1	705	698
30-34	0.2	0.4	1.0	4.7	90.9	2.8	100.0	78.0	0.2	81.2	13.8	3.2	1.2	538	535
35-39	0.3	0.7	0.9	2.5	92.9	2.8	100.0	79.0	0.3	84.0	12.7	2.4	0.0	301	298
40-44	0.9	0.0	1.2	4.5	91.8	1.6	100.0	85.7	0.9	72.3	21.9	4.0	0.9	83	82
45-49	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	0.0	43.2	56.8	0.0	0.0	(*)	2
Боловсрол															
Боловсролгүй	0.9	0.0	4.7	13.1	77.1	4.3	100.0	57.5	0.9	65.5	25.8	4.8	2.6	132	130
Бага	1.8	1.6	2.5	9.2	83.0	1.8	100.0	62.0	1.8	74.3	18.2	3.9	0.4	159	154
Суурь	1.0	1.6	1.8	7.0	87.7	0.9	100.0	70.3	1.0	74.0	19.8	2.6	2.3	309	305
Бүрэн дунд	0.2	0.4	4.0	3.7	88.3	3.4	100.0	74.9	0.2	77.9	17.0	4.1	0.6	616	613
Техникийн болон гусгай мэргэжлийн дунд	0.5	1.9	1.3	2.4	93.1	0.9	100.0	76.8	0.5	76.2	18.3	2.9	2.1	180	179
Өрхийн аж байдалын түвшин															
Дээд	0.1	0.1	0.8	2.6	93.0	3.4	100.0	80.9	0.0	83.9	11.9	3.4	0.4	994	990
Доогуур	0.4	1.5	3.3	8.4	83.1	3.3	100.0	61.9	0.4	69.2	23.4	4.8	1.8	509	505
Дунджаас доогуур	1.0	0.7	2.8	5.3	87.5	2.7	100.0	70.1	1.0	73.9	17.7	6.3	0.8	452	446
Дундаж	0.9	0.7	1.5	3.0	91.2	2.8	100.0	77.2	0.6	79.3	15.6	2.8	1.2	476	471
Дунджаас дээгүүр	0.0	0.0	2.4	3.6	91.1	2.9	100.0	81.4	0.0	85.1	12.7	1.5	0.5	448	447
Өрхийн тэргүүлэгчийн үлдэс угсаа*															
Халх	0.3	0.5	1.8	3.7	90.6	3.0	100.0	77.7	0.3	79.8	15.5	3.4	0.8	1916	1907
Казах	4.7	3.0	4.9	17.3	67.0	3.0	100.0	38.6	3.5	70.3	15.3	4.5	1.7	92	84
Бусад	0.0	0.2	2.6	5.1	90.3	1.8	100.0	72.3	0.0	76.3	17.8	4.1	1.7	372	371

¹ НУТС-ны үзүүлэлт 5.5b; МХЗ-ын үзүүлэлт 5.5 - Жирэмсний хяналтад хамрагдалт
² НУТС-ны үзүүлэлт CS16.2 - Жирэмсний хяналтад байх хугацаагаар 6 болон түүнээс дээш удаа үзүүлсэн жирэмсэн эмэгтэйдүүдийн эзлэх хувь
³ НУТС-ны үзүүлэлт CS16.3 - Жирэмсний эрт үеийн хяналт (МУ-д мөрдөгдөж буй аргагчдын дагуу тооцсон)
⁴ НУТС-ны үзүүлэлт CS16.4 - Хяналтад анх үзүүлэх үеийн жирэмсний хугацаа (гольч сар)
 * "Өрхийн тэргүүлэгчийн үлдэс угсаа"- нь харуулагдаагүй 9 ажиглалт (ажиглэгдээгүй)-ыг харуулаагүй.

Хүсвэгт MN.3: Жирэмсний хяналтын бүрдэлдүүн

Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн, жирэмсний хяналтад үзүүлэхээ цусны даралтаа хэмжүүлж, шээс болон цусны ерөнхий, БЭДХ буюу үтрээний наас, ДОХ-ын шинжилгээ өгч, жингээ хэмжүүлж, гэмбүүгийн сорил тавиулж, ЭХО-д харуулан цэжгийн зураг авахуулсан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улс, 2013 он

Эмэгтэйчүүдийн хувь

	Цусны даралтаа хэмжүүлсэн	Шээсний ерөнхий шинжилгээ өгсөн	Цусны ерөнхий шинжилгээ өгсөн	БЭДХ буюу үтрээний наашиг шинжилгээ өгсөн	Жингээ хэмжүүлсэн	Тэмбүүгийн сорил тавиулсан	ДОХ-ын шинжилгээ өгсөн	ЭХО-д харуулсан	Цэжгийн зураг авахуулсан	Цусны даралтаа хэмжүүлж, шээс болон цусны ерөнхий, БЭДХ буюу үтрээний наашиг шинжилгээ өгч, жингээ хэмжүүлж, гэмбүүгийн сорил тавиулж, ЭХО-д харуулан цэжгийн зураг авахуулсан ¹	Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн тоо
Бүгд	96.6	97.6	97.7	95.4	98.5	83.5	89.9	97.2	76.7	94.7	2389
Бус											
Баруун	93.7	91.7	91.1	81.2	94.1	64.1	72.0	91.6	42.0	86.1	336
Хангай	94.6	97.3	97.6	93.8	98.8	78.3	81.6	96.4	57.9	92.7	470
Төв	98.9	97.1	98.9	97.7	98.6	86.9	92.3	98.5	77.7	96.4	397
Зүүн	98.9	98.7	99.6	99.1	99.7	96.8	94.5	98.5	78.8	97.1	160
Улаанбаатар	98.0	99.1	99.2	99.3	99.5	88.9	97.8	98.6	96.0	97.5	1026
Хот, хөдөө											
Хот	97.8	99.0	99.2	99.2	99.5	88.0	95.9	98.5	90.0	97.2	1519
Хөдөө	94.6	95.3	95.2	88.7	96.7	75.7	79.4	94.8	53.5	90.4	870
Байршил											
Нийслэл	98.0	99.1	99.2	99.3	99.5	88.9	97.8	98.6	96.0	97.5	83.6
Аймгийн төв	97.5	98.7	99.2	99.0	99.5	86.2	91.8	98.4	77.5	96.7	493
Сумын төв	96.4	97.8	97.8	94.5	96.9	85.9	86.3	97.8	60.2	93.9	246
Хөдөө	93.8	95.0	94.1	86.4	96.2	71.7	76.6	93.9	50.9	89.0	624
Эхний хүүхдээ төрүүлэх үеийн нас											
15-19	90.4	96.2	96.9	94.5	98.5	87.6	87.8	98.5	74.7	86.6	108
20-24	95.2	98.0	97.6	95.7	98.5	85.1	90.7	97.7	76.2	93.8	652
25-29	96.6	97.3	97.2	95.0	98.1	82.1	88.0	96.7	74.8	94.2	705
30-34	98.8	97.7	98.3	94.7	98.2	80.9	90.7	96.8	78.2	97.0	538
35-39	98.0	97.8	98.4	96.9	99.7	85.6	90.9	97.2	78.7	95.8	301
40-44	98.1	98.1	98.1	97.1	98.1	87.6	92.3	96.6	84.1	98.1	83
45-49	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	2
Боловсрол											
Боловсролгүй	92.0	95.5	95.6	89.2	96.2	73.9	77.8	94.5	57.5	88.8	132
Бага	93.1	89.8	90.6	81.5	91.8	60.0	70.3	91.4	47.8	85.3	159
Сурь	95.4	96.5	96.2	90.4	97.2	78.5	82.3	94.4	66.6	92.8	309
Бүрэн дунд Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	96.5	98.3	98.3	97.6	99.2	87.6	92.3	97.9	81.2	95.3	616
Дээд	94.4	98.0	98.4	97.3	98.9	87.8	93.0	99.5	78.2	93.9	180
Өрхийн аж байдалын түвшин											
Доогуур	94.2	99.0	99.2	98.3	99.7	86.9	94.8	98.4	84.0	97.4	994
Дунджаас доогуур	94.7	96.6	96.8	95.5	97.9	82.2	87.8	97.3	72.6	89.3	509
Дундаж	96.5	98.6	98.6	96.4	98.4	83.1	92.8	97.1	79.0	96.0	452
Дунджаас дээгүүр	98.6	99.6	99.6	99.4	99.8	86.5	95.5	99.0	88.8	97.8	476
Дээгүүр	99.3	98.7	99.5	99.7	100.0	92.4	97.3	98.6	91.4	97.7	448
Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа*											
Халх	97.0	98.5	97.0	97.0	99.1	85.9	92.0	97.8	79.3	94.3	67.8
Казах	88.2	77.0	79.9	70.5	83.2	40.3	48.6	81.2	45.7	72.4	92
Бусад	96.7	97.9	96.4	93.1	98.8	82.4	88.6	97.7	71.7	93.9	62.9

¹ НУТС-ны үзүүлэлт 5.6 - Жирэмсний хяналтын бүрдэлдүүн

² НУТС-ны үзүүлэлт CS16.5 - Жирэмсний хяналтын бүрдэлдүүн: Хамрагдал зохих бүх үйлчилгээг авсан (МУ-д мөрдөгдөж буй аргачлалыг дагуу тооцсон)

* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс угсаа" нь хариулагчдаагүй 9 ажилтат (өнгөтгөлдүүг)-ыг харуулав.

Хүснэгт MN-4: Жирэмсний хяналтад үзүүлсэн газар

Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн, жирэмсэн үедээ хяналтад үзүүлсэн 15-49 насны эмэгтэйдүүдийн хувь, үйчлилгээ авсан газраар, Монгол Улс, 2013 он

	Жирэмсний хяналтад үзүүлсэн газар										Хяналтад үзүүлсэн газрын дундаж тоо	Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн эмэгтэйдүүдийн тоо
	Тусгай мэргэжлийн төв		Улсын эмнэлэг		Хувийн эмнэлэг		ТББ-ын эмнэлэг		Хяналтад ороогүй			
	Тусгай мэргэжлийн төв	Нэгдсэн эмнэлэг	Амаржих газар	Сумын/орхийн эмнэлэг	Улаанбаатарын оргой/өргүй эмнэлэг	Хувийн эмнэлэг	Аймаг/сумын оргой/өргүй эмнэлэг	ТББ-ын эмнэлэг	Хяналтад ороогүй	Хяналтад үзүүлсэн газрын дундаж тоо		
Бүгд	2.7	34.1	0.7	74.5	2.9	0.8	0.2	0.4	1.2	2389		
Бүс												
Баруун	1.6	17.0	0.0	88.3	0.8	0.9	0.2	0.9	1.1	336		
Хангай	0.7	23.4	0.0	90.6	0.2	0.6	0.2	0.3	1.2	470		
Төв	2.5	34.6	1.1	74.5	1.9	1.9	0.0	0.4	1.2	397		
Зүүн	2.5	38.4	0.0	88.1	0.3	1.0	0.0	0.0	1.3	160		
Улаанбаатар	4.2	43.7	1.2	60.6	5.6	0.3	0.4	0.3	1.2	1026		
Хот, хөдөө												
Хот	3.3	41.7	0.9	65.7	4.3	0.8	0.3	0.4	1.2	1519		
Хөдөө	1.8	20.8	0.2	90.0	0.5	0.6	0.0	0.5	1.1	870		
Байршил												
Нийслэл	4.2	43.7	1.2	60.6	5.6	0.3	0.4	0.3	1.2	1026		
Аймгийн төв	1.4	37.6	0.5	76.4	1.5	1.9	0.3	0.5	1.2	493		
Сумын төв	2.3	26.4	0.7	85.2	0.8	0.7	0.0	0.0	1.2	246		
Хөдөө	1.6	18.5	0.0	91.8	0.4	0.6	0.0	0.6	1.1	624		
Эхийн хүүхдээ төрүүлэх үеийн нас												
15-19	2.1	38.8	1.1	73.6	1.3	0.7	0.0	0.0	1.2	108		
20-24	1.9	32.9	0.5	75.1	2.6	0.8	0.5	0.5	1.1	652		
25-29	2.7	33.1	0.2	77.8	2.1	0.8	0.1	0.5	1.2	705		
30-34	2.6	33.6	0.9	73.2	3.6	1.0	0.0	0.2	1.2	538		
35-39	4.8	36.2	1.7	70.8	4.9	0.0	0.4	0.3	1.2	301		
40-44	4.0	41.0	0.0	66.4	1.5	0.9	0.0	0.9	1.1	83		
45-49	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	2		
Боловсрол												
Боловсролгүй	0.7	21.0	0.0	93.9	0.0	0.8	0.0	0.9	1.2	132		
Бага	0.6	17.3	0.4	88.4	0.0	1.3	0.0	1.8	1.1	159		
Суурь	1.2	24.6	0.7	85.4	0.2	0.0	0.0	1.0	1.1	309		
Бүрэн дунд	2.6	34.0	1.0	75.0	1.2	0.4	0.3	0.2	1.1	616		
Техникийн												
болон тусгай	2.0	38.6	0.6	71.3	1.1	0.5	0.0	0.5	1.1	180		
мэргэжлийн												
дунд												
Дээд	4.1	40.7	0.6	66.7	5.9	1.2	0.3	0.0	1.2	994		
Өрхийн аж байдалын түвшин												
Доогуур	1.2	21.8	0.3	90.8	0.3	0.6	0.0	0.4	1.2	509		
Дунджаас доогуур	2.3	28.9	0.5	79.1	0.2	0.7	0.0	1.0	1.1	452		
Дундаж	2.1	31.9	0.6	76.5	1.3	0.8	0.3	0.6	1.1	476		
Дунджаас дээгүүр	5.3	40.7	1.1	68.2	1.2	0.3	0.3	0.0	1.2	448		
Дээгүүр	3.0	47.4	0.9	57.8	11.0	1.3	0.5	0.0	1.2	504		
Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа*												
Халх	2.9	34.8	0.7	73.1	3.2	0.6	0.3	0.3	1.2	1916		
Казах	1.4	24.4	0.0	80.6	0.0	0.0	0.0	3.5	1.1	92		
Бусад	2.5	32.5	0.6	79.9	2.0	1.7	0.0	0.0	1.2	372		

* "Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа" нь харуулагдаагүй 9 ажиглалт (жигнэлдээгүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт МН-5: Жирэмсний хяналтын зөвлөгөө
Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхдэд төрүүлсэн, жирэмснээ хянуулахдаа зөвлөгөө авсан 15-49 насны эмэгтэйдүүдийн хувь, зөвлөгөөний төрлөөр, Монгол Улс, 2013 он

Жирэмсний хяналтын зөвлөгөө	Жирэмсний хяналтын зөвлөгөө												Бүх зөвлөгөө авсан эмэгтэйдүүдийн хувь	Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхдэд төрүүлсэн, жирэмсний хяналтад үзүүлсэн									
	Жирэмсний хяналтын зөвлөгөөг авч холбогдон	Жирэмсний үеийн хоололт	Хорт зуршил (архи, тамхин)	Жирэмсний эмгэг байдал/ няуутай шинжүүд	Тэтгэмж авах	Төрийн бэлтгэл, төрийн хүчинлэг	Зүлбэлт, дүүтүү төрөгөөс сөрөнгөх гэхүй	Эрхтэн тогтоонооны эмгэг	Төрөлт	Жирэмсний хожуу хорлодо	Хоч арьцах гэхүй	Төрөгтөл бэлтгэх гэхүй			Идүү тээлт	Төрөх үеийн өвчлөлт	Төрөний дараах үе	Нярайн асаргаа	Гэр бүл төлөвлөлт	Бэлтгэлийн замаар дамжих халдвар	Авсан зөвлөгөөний дундаж тоо	Ядаж нэг зөвлөгөө авсан эмэгтэйдүүдийн хувь	Бүх зөвлөгөө авсан эмэгтэйдүүдийн хувь
Бүгд	80.8	76.0	75.2	78.3	72.8	87.8	73.3	62.1	74.2	70.2	69.1	73.6	57.3	51.7	60.0	68.6	49.7	58.4	12	96.4	28.7	2380	
Бүс																							
Баруун	77.1	70.7	69.5	73.3	66.8	85.4	67.1	56.1	72.2	68.2	66.0	69.1	53.8	48.4	60.3	69.6	47.7	55.1	12	94.2	24.3	333	
Хангай	82.9	78.0	79.6	80.7	76.3	91.3	75.6	61.7	78.0	73.9	74.4	76.7	60.6	56.2	67.5	77.4	54.3	66.2	13	97.1	34.4	469	
Төв	79.5	77.1	71.9	76.2	73.8	90.5	74.4	60.2	75.9	69.0	68.6	75.8	55.0	49.5	60.7	70.1	47.0	58.7	12	97.3	25.4	395	
Зүүн	87.1	83.0	83.9	86.5	80.9	91.9	79.3	70.5	86.5	81.6	80.6	85.3	62.0	62.8	73.7	79.8	62.9	73.1	14	97.0	39.9	160	
Улаанбаатар	80.5	75.4	74.9	78.3	71.4	85.4	73.0	63.7	70.6	67.9	66.0	70.9	57.0	49.9	54.1	61.9	47.2	53.4	12	96.3	27.0	1023	
Хот, хөдөө																							
Хот	81.1	76.0	74.9	77.9	71.8	86.3	72.4	62.3	72.0	68.6	66.9	71.4	55.7	50.2	55.9	64.6	47.5	54.2	12	96.3	26.6	1514	
Хөдөө	80.3	76.2	75.8	79.0	74.5	90.6	74.9	61.8	78.2	73.0	72.8	77.4	60.0	54.4	67.1	75.5	53.6	65.8	13	96.4	32.3	866	
Байршил																							
Нийслэл	80.5	75.4	74.9	78.3	71.4	85.4	73.0	63.7	70.6	67.9	66.0	70.9	57.0	49.9	54.1	61.9	47.2	53.4	12	96.3	27.0	1023	
Аймагын төв	82.3	77.2	74.8	77.0	72.6	88.1	71.3	59.5	74.7	70.2	69.0	72.5	53.0	50.8	59.8	70.3	48.1	55.7	12	96.4	25.8	491	
Сумын төв	82.3	76.3	77.9	83.9	76.5	91.7	76.0	63.0	78.4	72.1	72.3	82.7	61.1	55.1	71.7	76.8	54.5	69.3	13	98.0	30.7	246	
Хөдөө	79.5	76.1	74.9	77.0	73.7	90.1	74.5	61.3	78.2	73.4	73.0	75.3	59.6	54.2	65.3	75.1	53.2	64.4	13	95.8	32.9	620	
Эхийн хүүхдээ төрүүлэх үеийн нас																							
15-19	74.6	68.4	64.3	69.6	69.7	86.4	66.8	56.6	76.3	62.7	69.3	70.5	52.7	48.9	60.7	70.7	52.3	58.5	12	94.5	28.2	108	
20-24	82.2	75.4	77.6	81.2	77.3	88.2	73.1	60.5	74.6	70.3	71.4	76.3	59.1	54.2	61.0	70.7	48.1	61.5	13	97.5	26.7	648	
25-29	80.4	73.0	75.8	76.6	71.8	86.8	71.8	67.5	73.0	68.3	67.5	70.0	54.1	48.3	58.7	66.7	47.5	55.0	12	95.8	26.3	701	
30-34	83.2	77.1	72.1	75.7	69.2	88.1	71.8	61.4	72.5	69.7	67.2	73.4	58.6	50.1	59.4	68.2	50.8	57.6	12	96.6	31.3	537	
35-39	82.3	82.1	77.8	82.8	72.6	88.4	77.3	70.6	77.8	75.5	70.2	76.7	57.4	56.4	59.2	68.9	53.0	58.0	13	95.2	33.2	301	
40-44	88.1	88.0	77.4	80.3	73.0	92.4	85.6	65.1	77.1	79.1	71.2	75.7	65.6	58.3	68.2	78.8	56.6	68.8	13	100.0	30.9	82	
45-49	74.6	61.7	66.2	68.5	62.8	81.1	57.2	50.8	63.7	56.0	59.9	63.5	46.0	41.2	50.8	62.7	42.4	51.3	11	92.3	18.3	297	
Жирэмсний хяналтад үзүүлсэн тоо*	1-4	70.9	61.7	66.2	68.5	67.0	73.6	61.0	74.3	70.3	67.7	72.2	58.2	55.1	61.8	69.4	51.4	59.3	12	96.1	28.6	467	
5-6	78.9	76.0	76.6	76.9	70.8	89.1	74.5	62.4	76.1	71.2	70.0	74.0	57.0	51.5	61.7	69.9	51.4	59.2	13	97.3	28.4	788	
7-9	81.8	77.8	75.1	80.0	74.8	88.7	77.9	66.7	76.0	74.3	72.4	77.4	61.2	54.0	60.8	69.5	49.6	59.7	13	96.9	32.5	759	
10+	84.6	79.5	78.2	80.9	75.0	88.5	77.9	66.7	76.0	74.3	72.4	77.4	61.2	54.0	60.8	69.5	49.6	59.7	13	96.9	32.5	759	
Боловсрол																							
Боловсролгүй	73.1	68.4	69.4	62.9	64.8	87.8	66.3	48.5	70.4	66.8	62.6	69.5	58.4	46.2	55.3	70.6	48.8	56.8	11	95.0	24.9	131	
Бага	77.4	71.1	72.6	75.2	69.3	86.3	66.3	60.6	74.8	66.0	68.9	70.2	52.0	47.0	64.0	73.9	48.4	57.3	12	92.2	23.8	156	
Суурь	80.0	77.6	76.3	81.0	76.6	88.3	75.1	66.0	76.9	76.4	74.8	78.1	64.4	58.0	65.7	74.0	54.5	65.5	13	97.1	35.6	306	
Бүрэн дунд	81.1	74.8	76.8	79.2	73.5	88.5	74.5	62.5	75.2	68.9	71.5	73.4	59.2	51.8	59.1	70.2	49.0	60.6	12	95.7	29.1	614	
Техникийн																							
болон тусгай мөргөжлийн дунд	82.8	80.0	74.8	83.4	80.0	93.0	77.7	65.1	80.3	72.3	72.4	77.6	60.2	55.1	66.8	74.7	51.5	66.5	13	100.0	33.2	179	
Өрхийн аж байдал																							
Дунд	82.0	77.4	75.1	78.4	71.4	86.6	73.3	62.2	72.1	69.9	66.0	72.7	54.0	50.6	57.6	63.7	48.7	53.8	12	96.7	26.7	994	
Доогуур	77.9	75.6	76.0	76.6	74.4	89.9	73.9	61.6	77.4	72.2	72.1	75.9	58.6	53.1	64.3	74.4	52.2	63.3	13	95.9	30.4	507	
Дундаас доогуур	82.0	76.9	75.4	78.3	72.3	88.0	71.1	60.5	75.7	70.1	71.0	74.7	59.7	52.4	61.7	73.0	48.8	64.4	13	96.9	28.8	448	
Дундаж	81.8	77.1	76.7	81.3	75.0	91.2	74.5	62.9	76.7	71.6	72.3	75.5	57.2	49.9	61.2	70.1	51.4	61.6	13	97.4	30.9	473	
Дундаас дээгүүр	85.2	76.4	79.6	82.4	76.1	87.4	77.9	67.1	74.3	73.9	69.1	75.6	58.5	55.8	59.6	66.4	49.5	57.2	13	97.4	30.5	448	
Дэлгэр	77.6	74.5	68.9	73.4	66.5	82.9	69.6	58.9	67.4	63.8	61.2	66.8	52.6	47.9	53.4	59.4	46.4	46.2	11	94.6	23.2	504	
Өрхийн тэргүүлэгчийн үндэс үеэс*																							
Халих	81.6	77.1	76.2	79.7	73.8	88.8	74.3	62.6	74.5	70.8	69.4	74.3	58.1	52.0	59.7	68.8	50.5	59.0	13	97.0	29.1	1910	
Казах	70.1	63.8	64.3	65.9	59.5	75.7	58.6	56.9	65.2	61.5	58.7	65.9	52.7	52.9	54.3	57.2	48.7	44.6	11	85.7	23.6	89	
Бусад	79.4	73.9	73.3	74.5	70.9	86.3	72.2	61.0	75.2	69.4	70.3	72.3	54.7	50.3	63.5	70.7	45.9	58.8	12	96.2	27.7	372	

* "Өрхийн тэргүүлэгчийн үндэс үеэс" нь харуулжээгүй 9 ажиглагч (ажиглагчгүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт МН.6: Жирэмний хяналтад үзүүлэхэд тохиолдсон бэрхшээл

Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн, жирэмсэн үедгээ хяналтад үзүүлсэн 15-49 насны эмэгтэичүүдийн хувь, хянуулахад тохиолдсон бэрхшээлээр, Монгол Улс, 2013 он

	Мөнгө, санхүүгийн				Жирэмний хяналтад үзүүлэхэд тохиолдсон бэрхшээл				Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн, жирэмний хяналтад үзүүлсэн эмэгтэичүүдийн тоо		
	Мөнгө, санхүүгийн	Эмнэлгээс хол	Ажил ихтэй, зав байхгүй	Бүртгэлгүй	Эмнэлгийн мэргэжилтний харьцаа муу	Эмнэлгийн ачаалал их	Бусад	Бэрхшээл тохиолдоогүй	Дүн		
Бүгд	0.1	0.8	0.3	0.3	2.6	11.5	1.7	82.7	100.0	2380	
Бүс											
Баруун	0.0	2.9	0.2	0.0	1.4	2.8	1.0	91.6	100.0	333	
Хангай	0.0	0.0	0.0	0.4	2.0	5.3	0.8	91.5	100.0	469	
Төв	0.0	0.8	0.2	0.5	2.0	4.6	0.7	91.1	100.0	395	
Зүүн	0.6	0.0	0.0	0.5	0.4	7.4	0.4	90.8	100.0	160	
Улаанбаатар	0.1	0.7	0.5	0.3	3.8	20.4	2.9	71.2	100.0	1023	
Хот, хөдөө											
Хот	0.2	0.5	0.5	0.3	3.5	16.2	2.1	76.7	100.0	1514	
Хөдөө	0.0	1.4	0.0	0.3	1.1	3.1	1.0	93.0	100.0	866	
Байршил											
Нийслэл	0.1	0.7	0.5	0.3	3.8	20.4	2.9	71.2	100.0	1023	
Аймгийн төв	0.2	0.1	0.3	0.4	2.7	7.6	0.4	88.3	100.0	491	
Сумын төв	0.0	0.8	0.0	0.7	0.8	4.8	1.8	91.0	100.0	246	
Хөдөө	0.0	1.7	0.0	0.2	1.2	2.5	0.7	93.9	100.0	620	
Эхний хүүхдээ төрүүлэх үеийн нас											
15-19	0.0	0.0	0.0	0.7	0.7	11.9	1.1	85.6	100.0	108	
20-24	0.0	1.0	0.1	0.3	2.1	11.9	1.4	83.2	100.0	648	
25-29	0.3	0.6	0.3	0.2	3.1	12.1	2.0	81.2	100.0	701	
30-34	0.0	1.0	0.3	0.2	3.1	10.7	1.8	83.0	100.0	537	
35-39	0.0	1.1	0.3	0.4	2.1	11.5	1.5	83.0	100.0	301	
40-44	0.0	0.0	1.7	2.7	2.4	7.5	2.9	82.8	100.0	82	
45-49	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	2	
Боловсрол											
Боловсролгүй	0.7	2.6	0.0	0.0	1.7	1.3	1.0	92.7	100.0	131	
Бага	0.9	1.8	0.0	0.0	0.8	2.1	0.5	93.8	100.0	156	
Суурь	0.0	0.9	0.0	1.0	1.4	5.3	0.7	90.7	100.0	306	
Бүрэн дунд	0.0	0.6	0.3	0.0	2.2	10.3	1.9	84.8	100.0	614	
Техникийн											
болон тусгай мэргэжлийн	0.0	1.5	0.0	1.1	1.6	6.6	0.0	89.1	100.0	179	
дунд											
Дээд	0.0	0.4	0.5	0.3	3.8	17.8	2.5	74.6	100.0	994	
Өрхийн аж байдлын түвшин											
Доогуур	0.3	1.7	0.0	0.4	1.4	1.8	0.5	93.9	100.0	507	
Дунджаас доогуур	0.2	0.5	0.0	0.2	1.5	8.8	1.4	87.3	100.0	448	
Дундаж	0.0	1.5	0.5	0.7	1.2	12.1	1.6	82.4	100.0	473	
Дунджаас дээгүүр	0.0	0.4	0.5	0.2	3.8	15.8	2.3	77.1	100.0	448	
Дээгүүр	0.0	0.0	0.4	0.2	4.9	19.1	2.8	72.5	100.0	504	
Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа*											
Халх	0.1	0.8	0.2	0.4	2.7	12.2	1.8	81.8	100.0	1910	
Кавказ	0.0	1.3	0.9	0.0	1.8	5.2	0.0	90.8	100.0	89	
Бусад	0.0	1.0	0.4	0.0	2.5	9.6	1.6	84.9	100.0	372	

* "Өрхийн гэрүүлэгчийн үндэс угсаа" нь харилцалгагүй 9 ажиглагч (жигнэлгээгүй)-ыг харуулаагүй.

Хүснэгт MN.7: Жирэмсний хүндрэл

Судалгааны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн, жирэмсний хүндрэл тохиолдсон 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, тохиолдсон хүндрэлээр, Монгол Улс, 2013 он

